

ӨНӨ МӨНХӨӨР

10 жилийнхээ ойг
тохиолдуулан шинэчлэн
найруулсан хувилбар

ХӨТ ЛӨГ ДӨХҮЙ



Өнөөгөр ч,
өнө мөнхөг ч
үнэ цэнэтэй
байх амьдрал

ЖОН БИВЭР



"ӨНӨ МӨНХӨӨР ХӨТ ЛӨГ ДӨХҮЙ"
СУРГАЛТЫН DVD ХАВСАРГАВ

Эрхэм хүндэт найз минь,

Дуулал 90:12 дээр Мосе Бурханд хандан: “Амьдралын маань өдөр хоногуудыг бидэнд зааж өгөөч” хэмээн хашхирсан байдаг. Бид газар дээр хэд наслалаа ч - энэ тоо өнө мөнхийн дэргэд юу ч биш юм. Гэхдээ бид дээрээс олгогдсон нярвын эрх үүргээ чухам юу ч биш гэлтэй энэ ахархан амьдралдаа хэрхэн гүйцэтгэснээрээ л хожим цаг хугацаанаас халин, өнө мөнхлөлд очихдоо шагнуулах эсэхээ шийдүүлнэ.

Миний бие өдий наслахдаа Ариун Сүнснээс “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын үг шиг амьдрал өөрчлөгч, хүчирхэг илчлэлийг хүлээж аваагүй гэж хэлэхэд болно. Энэ үнэнийг ойлгосон Чуулган, удирдагч, итгэгч нар хаанчлалд цоо шинэ зорилго, сэтгэлгээ, шийдвэрээр үйлчилнэ. Тиймээс энэ үнэнийг танд хэлэх нь миний хувьд хүндэтгэл билээ.

Энэ ном бол дэлхий даяарх итгэл нэгт удирдагч та нарыгаа гэх сэтгэл зүрхний минь тасархай юм шүү. Заавал уншиж судлаарай. Өөрөө мэдээд зогсохгүй, энэ болоод бусад бүх ном, сургалтын материалыг маань таньж мэддэг хүн бүртээ заавал хүргээрэй. Номынхоо хуудас бүрээс үнэнийг олборлохдоо, Бурханаас танд болоод таны амьдралд зориулсан аугаа төлөвлөгөө, зорилгыг олж аваад, өөрийн болгох болтугай.

Найз минь, энэ үнэн миний амьдралыг сууриар нь өөрчилсөн шигээ таны амьдралыг ч өөрчлөх болтугай. Өнө мөнхийн талаарх илчлэлийг хичээнгүй мөшгисөн хүний амьдрал, гэр бүл, үйлчлэл хэзээ ч урьдын янзаараа үлдэхгүй. Энэ үгээр та ч, таны удирдлага дорх хүмүүс ч өөрчлөгдсөн тухай гэрчлэлийг тэсэн ядан хүлээе.



Жон Бивэр
JohnBevere@ymail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

ӨНӨ МОНХООР

ХАТ-ЛАГ-ДОХҮЙ



≡ ЖОН БИВЭР ≡

Амьдралын аахар шаахар асуудалд түүртээд, амин чухал зорилгоо гээх энүүхэнд. Тиймээс өнө мөнхийн өөрчлөлтийн төлөө Жон Бивэрийн *Өнө мөнхөөр хөтлөгдөхүй* номоор өдөр бүр өөртөө ташуур өгч, санаж сэргж, боловсорч яв.

— ГРЭЙГ ПРОШЕЛ, Life.Church чуулганы пастор, #Struggles:
Following Jesus in a Self-Centered World номын зохиолч

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй ном нь амьдралынхаа зорилгыг хайж яваа хүний эрлийн үзүүр юм. Үүнийг уншсан хүн дахиж хэзээ ч өнөөдрөөрөө амьдрахгүй. Заавал унш!

— ЖОН СИ. МАКСВЕЛ, шилдэг борлуулалттай номын зохиолч, илтгэгч

Миний анд Жон Бивэрийн бичсэн, арван жилийнхээ ойтой золгож буй *Өнө мөнхөөр хөтлөгдөхүй* ном нь амьдрал бол амьсгаатай явах тоотой хэдэн өдөр биш гэдгийг бидэнд дахин сануулжээ. Амьдралаа дээд дуудлагатайгаа эгнээж чадсан хүн л сая амар тайван, найдварыг олдог.

— СТИВЕН ФУРТИК, Elevation чуулганы пастор, *Нью Йорк Таймсын* шилдэг борлуулалттай номын зохиолч

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй номдоо Жон Бивэр өнө мөнхийг харж амьдрах нь ямар чухал болохыг Бичээсийн ул суурьтай тайлбарлажээ. Жоны энэ хичээлээр Христ доторх итгэгчид “өнөөдөр” гэдэг энэ өдрөө илүү цэц ухаан, ухамсартай амьдардаг болно гэдэгт итгэж байна.

— ЖОЙС МЭЙЕР, шилдэг борлуулалттай номын зохиолч, Библийн багш.

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй ном нь хүн төрөлхтний оршихуйн хамгийн аугаа “нууцлалын” нэг болох өнө мөнх гэдэг сэдвээр ёстой л түс тас ярьжээ. Библийн энэ л цэц ухааныг Жон Бивэр Библийг нарийн атлаа тодорхой, няхуур атлаа ойлгомжтой заадаг сурамгай ураараа чадамгай тайлж, уншигч бидний өөрөөсөө давж өнө мөнхийг харах нүдийг нээжээ.

— БРАЙН ХЬЮСТОН, Hillsong чуулганы тэргүүн пастор

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй ном нь мөнхийн өвийг байгуулж, Бурханы хаанчлалыг тэлэх санаатай хүний жил бүр уншиж байх ёстой ном мөнөөс мөн. Жон Бивэр маань уншигчийг мөнхөд орших өөрчлөлтийн төлөө газар дээрх цаг хугацаа хэмээгч хамгаас үнэт баялгаа тултал нь ашиглахыг Библийн ул суурьтай шахаж шаарджээ. Би л хувьдаа энэ номыг орчин цагийн сонгодог бүтээл гэнэ!

— КРИС ХОДЖЕС, Church of Highlands чуулганы тэргүүн пастор, *Fresh Air and Four Cups* номын зохиолч

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй номдоо Жон Бивэр өнө мөнхлөл нь үлгэр биш, харин өнөөдрийн шийдвэр бүрээр чинь хэлбэршиж байдаг, эцсийн амьсгалаар чинь эхлэх бодит явдал болохыг харуулжээ. Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэв!

— МАРК БАТТЕРСОН, *Нью Йорк Таймсын* шилдэг борлуулалттай *The Circle Maker* номын зохиолч, National Community Church чуулганы удирдах пастор

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй номын зохиогч Жон Бивэр уншигчийг ямагт өнө мөнхийг харж амьдрахыг ятгаж байна. Эрхэм найзын маань номыг заавал уншаарай.

— ЖЕНТСЕН ФРАНКЛИН, Free Chapel Gainesville, GA чуулганы тэргүүн пастор, *Нью Йорк Таймсын* шилдэг борлуулалттай номын зохиолч

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй ном нь хүний цаг хугацааны талаарх ойлголтыг, цаг хугацааг хэрхэн зарцуулах үзэл бодлыг өөрчилнө. Таныг өдөр бүр аргацаах биш, амьдарсан шиг амьдрах зорилгоор цэнэглэх Библийн үнэнийг Жон үнэнхүү чадмагаар заажээ.

— ТИ. ДИ. ЖЭЙКС, *Нью Йорк Таймсын* шилдэг борлуулалттай номын зохиолч, TDJ Enterprises CEO

Янзтай! Салахын аргагүй, хүчирхэг, даруусгагч ном. Суурин дээрээ л уншиж дуусгалаа. Хүн бүр уншиг. Зориуд цаг гаргаад!

— БИИЛ МККАРТНИ, Promise Keepers байгууллага

ӨНӨ МӨНХӨӨР

10 жилийнхээ ойг
тохиолдуулан шинэчлэн
найруулсан хувилбар

ХАТ-ЛАГ-ДОХҮЙ



*Өнөөдөр ч,
өнө мөнхөг ч
үнэ цэнэтэй
байх амьдрал*

≡ ЖОН БИВЭР ≡

Driven By Eternity (Mongolian) by John P. Bevere
Special 10th Anniversary Edition
MessengerInternational.org
Originally published in English as Driven By Eternity
ISBN: 978-1-937558-03-1
© 2017 Messenger International

Additional resources in Mongolian by John and Lisa Bevere
are available for free download at:
CloudLibrary.org

To contact the author : JohnBevere@ymail.com
This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Printed in Mongolia

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй (Монгол хэлээр) Жон Бивэр
10 жилийн ойн шинэчлэн найруулсан хувилбар
MessengerInternational.org
Англиар анхлан Driven By Eternity нэрээр гарсан
ISBN: 978-1-937558-03-1
© 2017 Messenger International

Жон болон Лиза Бивэрийн Монгол хэл болон бусад хэл дээрх материалуудыг дараах
цахим хуудаснаас үнэ төлбөргүй татаж авах боломжтой
CloudLibrary.org

Зохиогчтой холбогдох эмэйл: JohnBevere@ymail.com
Энэ номыг ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОХ ба Зохиогчоос өгч буй БЭЛЭГ юм.

Монгол улсад хэвлэв

Энэхүү номоо:

*Өнө мөнхийн төлөө эцэж цуцахаа ч мэдэхгүй
хүмүүсийн амьдралыг байгуулахаар хөдөлмөрлөж буй
хүн бүрт зориулав. Битгий бууж өгөөрэй.*

*Тэр удахгүй ирэх агаад ирэхдээ шагналаа аваад айсуй!
“Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс
Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.”*

ИОХАН 17:3

АГЧУЛГА

Номын заавар	13
Өмнөх үг	15
Танилцуулга	17

I-р Хэсэг

Бүлэг 1: Мөнхийн	21
⇒ Бүлэг 2: Аффабел хэмээх хаанчлал: Энделийн амьдрал	35
⇒ Бүлэг 3: Аффабел хэмээх хаанчлал: Шүүхийн эхний өдөр ...	53

II-р Хэсэг

Бүлэг 4: Үхэгсдийн мөнхийн гэр	75
Бүлэг 5: Мэхлэгдэгчийн шүүх	93

III-р Хэсэг

Бүлэг 6: Том ухралт	119
Бүлэг 7: Суурь	141

IV-р Хэсэг

⇒ Бүлэг 8: Аффабел хэмээх хаант улс: Шүүх өдөр II	153
Бүлэг 9: Тэнгэр	173
Бүлэг 10: Христийн шүүх сэнтий	191

5-р Хэсэг

Бүлэг 11: Бурханд зориулсан гэр	205
Бүлэг 12: Бурханаар дуудагдсан	217

6-р Хэсэг

Бүлэг 13: Үржил	239
Бүлэг 14: Хувь хүний нөлөө	261
Хавсралт: Яаж аврагдах вэ?	275
Номын зүүлт	277

НОМЫН ЗААВАР

Энэ номыг бусад ном шиг л уншиж судлана. Гэхдээ хувиараа юмуу бүлгээрээ уншиж судлах хүмүүст зориулж номоо зургаан хэсэгт хуваасан бөгөөд хэсэг бүрийн төгсгөлд хэлэлцэх асуулт оруулсан байгаа. Нийт зургаан долоо хоног судлах зориулалттай боловч, та бүхэн заавал үүнд баригдалгүй, өөрсдийнхөө хурдаар яваарай.

Тэгэхээр, номоо дараах байдлаар 6 хэсэгт хуваасан болно:

1-р хэсэг:	Бүлэг 1-3
2-р хэсэг:	Бүлэг 4-5
3-р хэсэг:	Бүлэг 6-7
4-р хэсэг:	Бүлэг 8-10
5-р хэсэг:	Бүлэг 11-12
6-р хэсэг:	Бүлэг 13-14

Хэрэв та энэхүү номоо “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” цогц сургалтын хөтөлбөрөөр нь судлаж байгаа бол, долоо хоног бүрийн видео хичээлээ үзэх юмуу сонсож дуусгаад, дараа нь тухайн хэсгийн хэлэлцэх асуултын дагуу хоорондоо ярилцаарай. Харин тухайн хэсгийнхээ номын бүлгийг гишүүд чинь ирэхээсээ өмнө уншчихсан байх хэрэгтэй. Видео хичээл нь ч нийт 6 хэсэг учраас, долоо хоног бүр нэг видео хичээл үзнэ.

“Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын сургаалыг Жон “Аффабел хэмээх хаанчлалын” тухай сургаалт үлгэр мэт түүхээр уран яруу дүрслэн харуулжээ. Ер бусын хаан Жэйлин тэргүүтэй гол дүрүүд нь угтаа хүн бидний бодит амьдралыг илчлэн харуулсан юм.

“Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” сургаалын эрч хүчтэй, ухааруулагч дүрслэл, амьдралаас сэдэвлэсэн зохиомол дүрүүд нь уншигч танд Бурханы хаанчлалын нууц, оньсыг ухаарч ойлгоход чинь туслана. Аффабелийн түүхийг номын 2,3,8-аар бүлгээс уншаарай. Энэ түүхийг хуудсан дээр ➤ тэмдгээр тэмдэглэсэн байгаа. Түүнчлэн

энэхүү түүхийг “Аффабел” сонсдог жүжиг болгон мэргэжлийн төвшинд найруулан тавьсан болно. Дэлгэрэнгүйг: CloudLibrary хаягаас авна уу.

За амжилт!

ӨМНӨХ ҮГ

Хэзээ нэгэн өдөр бид бүгдээрээ Бурханы өмнө ганц ганцаараа зогсоно. Харин бид үүнд бэлэн үү? 2Петр 1:10 дээр Бичээс биднийг “Тиймээс ах дүү нар аа, дуудлага ба сонголтоо бататгахын тулд бүр ч илүү хичээнгүй бай. Учир нь та нар эдгээрийг үйлдэж л байвал хэзээ ч бүдрэхгүй” хэмээн ятгажээ. Энэ ишлэл дэхь гол үг нь “бататгах” юм.

Жишээлбэл, та аль нэг зүйлийн талаар өөртөө баттай явж байгаад, эндүүрснээ хожим ойлгож байсан уу? Ёстой муухай мэдрэмж төрдөг. Би ч бас бусад эрчүүдийн л адил нэг бус удаа зам, заавар, хийх дараалал, томъёо, арга барил гэх мэт юмс дээр “Би мэджийн” хэмээн мэдэмхийрч яваад, адаг сүүлд нь буруудснаа ухаарч, мөнөөх төсөл, угсралт, томъёогоо бүр эхнээс нь яг зааврын дагуу хийж явсан. Хэлэх ч үг олдохгүй! Хайран шатахуун, цаг, эд хөрөнгө, мөнгө төгрөг. Уг нь би зөв гэдэгтээ баттай байсан ч, байдал дээрээ буруу байжээ.

Тэгвэл өнө мөнхийн тал дээр би ингэж алдмааргүй байна.

Үнэндээ миний бичсэн номууд дундаас надад энэ ном шиг цочроо өгсөн ном байхгүй. Энэ ном арван жилийн өмнө анх хэвлэгдснээсээ хойш миний амьдралаас гадна үй олон хүний амьдралыг өөрчилснийг би мэднэ. Би анхнаасаа л энэ номын хуудас бүрт бичигдсэн үнэнийг хүмүүст үтэр түргэн хүргэх ёстой гэдэг ухаарлын жинг тээсэн билээ. Сайн мэдээний нярав хүнийхээ хувьд бусдыг нигүүлслээр хийгээд үнэнээр өнө мөнхөд бэлтгэхээс илүү том дуудлага бидэнд байхгүй. Таныг өнө мөнх рүү баттай алхаасай л гэж хүсч байна.

Бахь байдгаараа явсаар, Бүтээгчийнхээ өмнө очбол, хэдий ухаарсан ч, дахиж эхлүүлэхэд оройтсон байна. Тиймээс боломж байгаа дээр нь яг одоо энэ номын үнэнийг ахин дахин уншиж ухаар. Ариун Сүнс таныг Бурханы өршөөл, нигүүлслээр мөнхөд өөрчилж, хүчин чадалд чинь тултал явуулна.

Хүндэтгэсэн,
Жон Бивэр
2017 оны 5-р сар

ТАНИЛЦУУЛГА

Тэгэхээр, өнө мөнхлөл (мөнхийн оршихуй, орон зай, мөнхийн амьдрал) гэж юу болоод үе үеийн хүн төрөлхтний анхаарлыг татна вэ? Үнэндээ энэ нь хувь хүнд гэлтгүй, улс үндэстэнд ч нөлөөлдөг зүйл юм. Шинэ зууны босгон дээр Австралид Артур Стэйс гэгч нэгэн золгүй эр төржээ. Дэлхийн I Дайнаас Их Хямралын хооронд мань эрд бага гарын гэмт хэрэг үйлдэж, архидан согтуурахаас өөр амьдрал гээд байх юм байсангүй. Гэтэл 1930 оны 8-р сарын 6-нд тэрбээр Есүстэй уулзсанаар амьдрал нь нэг мөр өөрчлөгджээ. Төдөлгүй Артур нэгэн пастор “Чаддаг бол Сиднейн бүх гудмаар өнө мөнх гэж хашхирахсан!” хэмээн уйлж байхыг харжээ. Артур энэ үгийг мартсангүй.

Артур үүрийн гэгээтэй уралдан босоод, цаг гаруй залбираад, 5.00-5.30-ын хооронд гэрээсээ гаран, Бурханы зүгчилж байгаа газарт очоод, Сидней даяар явган хүний зам дээр гуч алхаад л “өнө мөнх” гэдэг үгийг хэдэн цагаар ч хамаагүй бичдэг болжээ. Түүний энэ ажил хорь гаруй жил Сидней хотынхоны хувьд оньсого болов. “Мянга мянган хүнийг зог тусч, хэсэг зуур эсвэл насан турш утга учрыг нь эргэцүүлэхэд хүргэдэг энэ ганц үгийг хэн бичээд байна аа? Их л эрх хүчийг эзэгнэсэн, нөлөөтэй, нууцлаг хүн байж таараа.” Гэхдээ энэ таавар 1956 онд л тайлагдсан юм.

Артурыг таалал төгссөнөөс хоёр жилийн дараа буюу 1967 онд Дуглас Стюарт гэдэг Сиднейн яруу найрагч тэр зураач - номлогчийн ганц үгийн талаар ийнхүү шүлэглэсэн байдаг:

Артур Стэйс хэмээх нууцлаг, бүрэг найрагч
Ганц л үг бидэнд захижээ.
ӨНӨ МӨНХ гэдэг үг чихэнд нь
Тэнгэрийн уянга, тамын чарлаан шиг хадсан учраас
Эргээд тэр бидэнд энэ үгийг
Эрин цаг, орон зайг сүлбэн
Хангинах хонх мэт номложээ.

Артурын ганц үгт номлол Австрали улс даяар нөлөөлсөн юм. Артурын номлолыг Ридли Смит гэдэг архитектор зэс хавтан дээр

сийлэн, Сиднейн төв талбайд мөнхлөсөн бөгөөд тэрхүү дурсгалыг хожим Сиднейн Олимпийн нээлтийг зурагтаар дамжуулах үеэр бас шинэ мянганыг угтсан Сидней Боомтын гүүрэн дээрх ёслолын буудлагаар тэнгэрт сийлэн харуулахад нь нийт дөрвөн тэрбум хүн харсан билээ.

Өнө мөнхийг хүн төрөлхтөн үеийн үед сонирхсоор ирсэн. Үүнийг сонирхдоггүй үндэстэн, овог аймагтан, хүйстэн гэж байхгүй. Учир нь хүн өөрөө зүрхэндээ өнө мөнхийг тээж төрдөг юм. Тиймээс Бүтээгч маань өнө мөнхийн талаар юу хэмээснийг олж мэдэх нь ухаалаг хэрэг болно. Эцсийн эцэст Бурханы Үг “Өдрүүд эхлэхээс авахуулан Би Тэр юм. Мутраас минь аварч чадах хэн ч байхгүй. Би үйлдвэл хэн буцааж чадах вэ?” (Исаиа 43:13) гэдэг. Иймээс л та ч бас энэ номыг уншиж суугаа бус уу? Тиймээс эхлэхээсээ өмнө залбиръя:

Бүхнийг Бүтээгч, Ертөнцийн Эзэн, мөнхийн Бурхан минь ээ, би Тан дээр Таны Хүү Есүс Христийн нэрээр ирж байна. Энэ өдөр Та бидний харах нүд, сонсох чихийг тослож, зүрхэнд маань үгээ нэвчээж, ухааруулаач. Таны Ариун Сүнс үгүй бол, амьдралд маань хандсан Таны хүсэл, замыг би олж мэдэхгүй. Би энэ амьдралдаа ч, мөнхийн амьдралдаа ч Таны сэтгэлд таалалтай, мэлмийд баясалтай амьдрахыг л хүснэ. Тиймээс явах замыг минь төдийгүй, хүсэл сэтгэлээ над илчлээч. Учир нь Тэнгэрийн Аав Таныгаа танин мэдэх нь мөнхийн амьдрал билээ. Гайхамшигт итгэмжтэй чанар, нигүүлсэл, өршөөлд тань баярлалаа. Амень.

За ингээд, гагцхүү Ариун Сүнсний хүчээр л хийх ер бусын аялалаа эхлүүлбэ.



ᠤᠯᠤᠰ ᠬᠡᠭᠡᠨ

МОНХИЙН

*Иймээс бид мэргэн зүрх олж авахын тулд
Өдрүүдээ тоолохыг бидэнд зааж өгөөч!
...Бидний гарын үйлсийг бидний төлөө бат тогтоогооч!
Тийм ээ, гарын маань үйлсийг бат тогтоогооч!
— Дуулал 90:12, 17*

Хүн бүр үнэ цэнэтэй амьдрахыг хүсдэг. Энэ нь ч зөв бөгөөд бурханлаг хандлага юм. Мосе ч үүний төлөө л залбирсныг дээрээс харж болно. Тэрбээр эхлээд цаг хугацаагаа үрэн таран хийхгүй байх цэц ухааныг гуйсан. Амьдралд алдагдсан олон зүйлийг сэргээж болдог ч, гагцхүү үрлэгдсэн цаг хугацааг хэн ч, хэзээ ч эргүүлж чадахгүй. Жаргах нартай хамт хорвоогийн нэг өдөр хэзээ ч эргэж ирэхгүйгээр одно.

Мосе энэ залбирлаа “Бидний гарын үйлсийг бат тогтоогооч!” гэдэг үгээр өндөрлөжээ. Бүр баттай болгох гэсэн шиг давтаж хэлсэн байна. Яагаад тэр вэ? Мосед санамжийн ч, хэлний ч бэрхшээл байгаагүй. Үнэндээ энэ нь Еврей хэл бичгийн хэв маяг юм. Үгийн давтамжаар тухайн утга санааг онцлон бататгадаг гэсэн үг. Жишээлбэл Англи хэл дээр аль нэг үг, утгыг онцлохдоо тодруулах, ташуу бичих, доогуур нь зурах, ТОМООР бичих юмуу анхаарлын тэмдэг тавьдаг. Тэгвэл бичих үгдээ туйлын хянамгай ханддаг зантай Еврей бичээчид тухайн үгийн утгыг хэтрүүлсэндээ биш, харин батжуулсандаа давтдаг ажээ. Тэгэхээр, үүнээс бид Бурхан бидэнд амжилтыг зүгээр нэг хүсдэг биш, харин бүр улайран хүсдгийг мэдэж болно. Учир нь Бурхан Өөрөө үүнийгээ батлан бичүүлжээ.

Бурхан биднийг амжилттай төдийгүй, ач холбогдолтой амьдруулахыг хүснэ! Үүнийг эхлээд бид биш, харин Бурхан

Өөрөө хүссэн бөгөөд энэ тухайгаа ч Бичээстээ байнга хэлдэг. Тухайлбал Дэд хууль 30:9 дээр “ЭЗЭН Бурхан чинь чиний гарын аливаа ажил үйлсийг тэтгэнэ (амжилттай болгоно)” гэжээ. Зарим ажил үйлсийг биш, харин аливаа ажил үйлсийг гэсэн байгаа биз!

Мөн Иошуа 1:8 дээр “Хуулийн энэ номыг амнаасаа салгалгүй байж, өдөр шөнөгүй үүнийг бясалган, үүн дотор бичигдсэн бүхнийг сахин биелүүл. Тэгвэл чиний зам өөдөлж, чи амжилтад хүрэх болно” гэсэн.

Бурханлаг цэц ухаан л жинхэнэ амжилтанд хүргэнэ. ТиЭлБи Библийн Сургаалт үгс 19:8 дээр “Өөрийнхөө сайн сайхныг хайрлагч нь цэц ухааныг хайрладаг бөгөөд амжилтанд хүрнэ” гэдэг. Цэц ухаан бидэнд мэдлэг, зөв цагт зөв сонголт хийх чадвар өгдөг. Цэц ухаан нь зөвхөн нарийн ухаантай байх явдал биш юм. Эзэнээс эмээж явдаг бүх хүнд цэц ухаан хэрэгтэй бөгөөд цэц ухааныг Христийн дотроос л олно. Хэрэв та өнө мөнхийн ач холбогдолтой амьдрал бүтээхийг зорьж байгаа бол, үүнийг гагцхүү бурханлаг цэц ухаанаар л хийнэ. Энэ ном ч үүнийг л заана.

Цэц ухаан амжилтыг дагуулдаг. Амжилт нь мөнхийн сэтгэл ханамж, шагнал авчирна. ЭнАйВи Библийн Сургаалт үгс 9:12 дээр “Цэцэн байваас, цэц ухаан чинь чамайг шагнана” гэдэг. Бурхан таныг амжилттай байлгахыг хүсэхээр барахгүй, шагнахыг хүсдэг ажээ. ТиЭлБи Библийн Дуулал 37:18 дээр мөн л “Бурханлаг хүмүүсийн үйлдсэн сайн үйлсийг Эзэн өдрөөс өдөрт ажигладаг бөгөөд тэдэнд мөнхийн шагнал өгдөг” гэжээ.

Сүүлийн жилүүдэд чуулганы чамгүй хувь нь Бурханы бидэнд өгөхийг хүсдэг амжилтыг л дөвийлгөн ярих болжээ. Энэ нь ч зөв. Гэхдээ амжилтыг бид ихэвчлэн Бурханы үзэл бодлоор биш, нийгмийн үнэлэмжээр дүгнэчих гээд байдаг. Мөнхийн биш, зуурдын үзлээр хардаг гэсэн үг. Тэгээд үүнээсээ болж хараа, ойлголт маань бүрэлзэж, адагтаа тэс өөр юм хөөгөөд явчихдаг.

Хожмын нэг өдөр бид бүгдээрээ ертөнцийн Шүүгч Есүс Христийн өмнө зогсоно. Хэрэв бурханлаг цэц ухаанаар ариг гамтай амьдарсан бол, мөнхийн шагнал авна. Харин санаатай юмуу санаандгүйгээр буруу замаар орсон бол, нэг бол шийтгүүлнэ эсвэл мөнхөд хаягдана. Тиймээс яг одоо Бурханы хүслийг олж мэдэхийн төлөө хэдхэн цаг зарцуулах нь танд л тустай болов уу хэмээн санана.

Таныг “өнөөдөр төдийгүй, өнө мөнхөд үнэ цэнэтэй байх амьдралаар амьдруулах” нь энэ номын хамаг зорилго юм. Харин хэрхэн амьдрахыг Библи маш тодорхой заасан. Мөнхийн юмсаар хөтлөгдөж амьдрах гэж байгаа бол, энэ нь чухам юу болохыг эхлээд мэдэх хэрэгтэй.

ӨНӨ МӨНХЛӨЛ

Дараах хоёр бичээсийг маш анхааралтай уншина уу:

“Үүрд мөнхийг зах зухаас нь ч ойлгох хүн байхгүй.”
(Иов 36:26 TLB)

“...Тэр тэдний зүрхэнд үүрд мөнхийг суулгажээ.”
(Номлогчийн үгс 3:11)

Үүрд мөнх буюу өнө мөнх гэж юу вэ? Яг юу гэж тодорхойлох вэ? Яг юу гэж ойлгох вэ? Нэг толь бичигт хязгааргүй цаг хугацаа 1 гэсэн бол, өөр нэгэн толь бичигт цаг хугацаанаас ангид орших нөхцөл байдал 2 гэжээ. Яагаад нэг толь бичиг нь үүрд мөнхийг цаг хугацаанд баригдах нөхцөл гэсэн байтал, нөгөө нь цаг хугацаанаас гадна орших нөхцөл гэнэ вэ? Яагаад хэн ч энэ талаар дуугарахгүй байна вэ? Хэрэв шинжлэх ухааны ном дээр манай гаригийн аль нэг зүйлийг хоёр өөрөөр тодорхойлсон байвал, бөөн маргаан мэтгээн дэгдэхгүй гэж үү? Жишээлбэл загасыг нэг ном дээр “усанд амьдардаг сээр нуруутан” гэсэн байтал, нөгөө номд нь “усны гадар амьдардаг” гэчихсэн байвал, бид аль нэгийг нь нэн даруй буруутгана биз дээ? Тэгвэл бид яагаад үүрд мөнхийг тэс өөрөөр тодорхойлсон хоёр толь бичгийн аль нэгийг нь шалгаж, хэрэглээнээс хасахгүй байна?

Яагаад гэвэл өнө мөнхийг оюун ухаанаар ойлгох боломжгүй юм. Бидний оюун ухаан өнө мөнхийг ухаарах чадваргүй, хязгаартай эд.

Тайлбарлая л даа. Яг одоо энэ ертөнц хаа дуусдгийг төсөөлөх гээд үз. Төгсгөл цэг, хязгаарыг нь гэсэн үг. Төсөөлж байна уу? Тэгвэл ертөнцийн төгсгөл нь яг юу байна? Хана байна уу? Юугаар хийсэн хана байна? Аль хэр зузаан байна? Ертөнц ханын гадна

талаар төгсөж байна уу? Тэгвэл ханын цаана юу байна? Сансар огторгуй үргэлжилж байна уу? Тийм бол, энэ чинь ертөнцийн үргэлжлэл болоод явчих биш үү? Тэгвэл төгсгөл нь яг хаана байна? Эсвэл та ертөнцийг зах хязгааргүй гэж бодож байна уу? Зүгээр л энэ тухай бодоод үз.

Эсвэл ёроолгүй нүхний талаар бод. Тэр нүхэнд ёроол байхгүй учраас ёроол нь хэзээ ч үзэгдэхгүй, ёроолд нь хэзээ ч хүрэхгүй. Зүгээр л мөнхийн мөнхөд унаад л байна. Тэгвэл энд нэг биш, бүр хоёр ойлгомжгүй зүйл гарч байна: нэгдүгээрт - ёроолгүй нүх гэж юу вэ, хоёрдугаарт - хэзээ ч төгсөхгүй уналт гэж юу вэ? Зөгнөлт киног санагдуулам эдгээр юмс нь үнэхээр ойлгогдошгүй боловч, Библи яг ийм газрын талаар долоон удаа өгүүлдэг.

Тэгвэл хүнийг бүтээсэн Бурханы тухай бодъё. Яг одоо Бурханы “эхлэлийг” - за яг үнэндээ бол “эхлэлгүй чанарыг” төсөөлөх гээд оролд. Бичээс Бурханыг “өнө мөнхөөс өнө мөнхөд” хэмээн дүрслэдэг. Тэгвэл Бурханыг хэн ч бүтээгээгүй, Бурхан хэзээ ч төрөөгүй юм бол, Тэр яаж яваад Бурхан болчихов? Яаж Бурханы дүрийг олов?

Үнэндээ Тэр явсаар явсаар яваандаа Бурхан болчихоогүй юм. Учир нь Дуулал 90:2 дээр Дуулаач “Уулс бий болохоос ч өмнө, Таныг дэлхий ба ертөнцийг төрүүлэхээс ч өмнө, Үүрдээс үүрд мөнх хүртэл Та Бурхан” гэсэн байдаг. Энэ тухай тунгаагаад үз. Гэхдээ тунгаах тусам, ухаан бодол чинь улам л ээдэрч, эцэстээ цөхөрнө. Учир нь Иов ном “Хэн ч өнө мөнхийг зах зухаас нь ч ойлгож чадахгүй” гэсэн буюу.

Зүрхэндээ тээж төрсөн

Тэгвэл хүний төрөлх оюун ухааны ойлгож барахгүй тэр үнэнийг Бүтээгч маань бидний зүрхэнд суулгаж өгчээ. Хүн төрөхдөө л өнө мөнхийг зүрхэндээ тээж төрдөг учраас, зүрх маань л өнө мөнхийг ойлгодог ажээ. Тиймээс л Бичээс “Мунхаг нэгэн зүрхэндээ “Бурхан байдаггүй” гэж хэлдэг (Дуулал 14:1) гэсэн юм. “Мунхаг нэгэн тархиндаа “Бурхан байдаггүй” гэдэг” гэж хэлээгүй байгаа биз? Бурханыг няцаадаг атеист хүмүүс ч зүрхэндээ өнө мөнхийг тээж төрсөн учраас, Бурхан байгаа гэдгийг тэд зүрхээрээ мэдэж л байгаа. Зүрх нь тас хөлдчихөөгүй бол шүү дээ.

Манай нэг найз хэдэн жилийн өмнө улаан атеист байлаа (эсвэл тэр өөрөө л тэгж боддог байсан байх). Тэгээд Есүсийн тухай юу ч сонсохгүй. Нэг удаа бүр ажлынхаа газрын хүний гараас Библийг нь булааж аваад, газар хаян дэвслэж, тэр хүнийг ч, Библийг нь ч хараагаад: “Өөрийн гэх бодолгүй мануухай” гэж доромжилжээ.

Төдөлгүй улаан атеист найзын маань цээжээр хүчтэй өвддөг болов. Мэс засалчид өвчнийг нь оношлохоор цээжийг нь задласнаа тэр даруй буцааж оёод, түүнийг ганц хоногоос илүү амьдрахгүй гэжээ.

Найз маань тэр шөнө орондоо хэвтэж байхдаа, мөдхөн өнө мөнхийн газар руу явах гэж байгаагаас бас тийм ч таатай газар очихгүй гэдгээ ухаарчээ. Бичээсийг нэг нүдээрээ ч харж, нэг чихээрээ ч сонсдоггүй хүн энэ тухай яаж мэдэв? Өнө мөнхийг зүрхэндээ тээж төрсөн учраас л тэр. Бичээс хүн төрөлхтний талаар “Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг агаад Бурхан тэдэнд үүнийг ил болгосон юм” (Ром 1:19) гэдэг.

Тэр шөнө найзын маань зүрх зогссон юм. Тэрбээр биеэсээ гарч, тас харанхуй дунд газарджээ. Сүүмийх ч гэрэлгүй, яг л биедээ өмсчихсөн мэт аймшигтай хүнд, өтгөн харанхуй. Тэрбээр хэр удааныг бүү мэд - хэсэг унаж байснаа гэнэт аймшигтай тарчлан чарлалдах сүнснүүдийн чимээ сонсогдож эхлэх яг тэр эгшинд найзыг маань нэгэн ер бусын хүч тэр тамын хаалгаас угзран авч, тэрбээр биедээ буцаж оржээ. Зүрх нь ч цохилж эхлэв.

Маргааш нь тэр өөрийнхөө таньдаг цорын ганц Христэд итгэгч хүнээ дуудуулсанд, итгэгч найз нь ирээд, Есүс Христийн авралын сайн мэдээг ярьж өгөхөд, өвчтэй найз маань Есүс Христийг амьдралынхаа Эзэн бөгөөд Аврагчаар хүлээн авч, итгэгч найзаараа эдгэрлийн төлөө залбируулжээ. Гурван долоо хоногийн дараа найз маань эмнэлгээс гарсан юм. Найз маань амьд гайхамшиг байсан бөгөөд мөнхийн шагналаа авахаар одох хүртлээ дахиад арван жил амьдарч билээ.

Найз маань атеист байхдаа Бурхан байхгүй гэж хэлсэн ч, өнө мөнхийн тухай зүрхэндээ мэдсээр л байжээ. Гэтэл нөгөөтэйгүүр тэнэг хүн Бурханыг ухаанаараа няцаагаад зогсохгүй, зүрхэндээ эсэргүүцдэг учраас, эрүүлээр сэтгэх аргагүй болтлоо дорддог. Түүнд юу ч нэмэр болохгүй. Ухаанаараа итгэнэ гэдэг нэг хэрэг.

Үүнийг өөрчилж болно. Харин зүрхээ тас хатууруулна гэдэг тээ өөр зүйл юм. Ангерийн Библийн шинэ толь бичигт “Бурханаас айж эмээхийг огт мэддэггүй, Бурханы зөвтгөлийн мөнхийн зарчмыг үл тоосон ч, яах ч үгүй гэж боддог бас тэгж амьдардаг хүнийг Бичээс “тэнэг хүн” гэдэг”³ гэжээ.

Тэнэг хүн Бурханыг ухаанаараа хүлээн зөвшөөрч болох ч, Бурхан байдгийг зүрхээрээ няцааж, яг Бурхан байхгүй мэт амьдардаг. Бурханаас айж эмээж буй хүний зүрхэнд л Ариун Сүнс ажилладаг. Айж эмээх сэтгэл байхгүй бол, бидэнд ямар ч найдвар үлдээгүй гэсэн үг. Паул “Ах дүүс ээ, Абрахамын гэр бүлийн хөвгүүд ээ, та нарын дунд буй Бурханаас эмээгчид ээ! Энэхүү авралын үг нь та бидэнд илгээгдсэн юм” (Үйлс 13:26) гэсэн. Гагцхүү Бурханаас эмээдэг хүмүүс л мөнх амийн үгийг сонсож чадна.

Өнө мөнхийг тодорхойлбоос

Өнө мөнхийг хүн ухаанаараа ойлгохгүй ч, зүрхээрээ мэддэг. Тиймээс одоо миний хэлэх тодорхойлолтыг зүрхээрээ сонсоорой. Үнэндээ энэ номоос нэг ч атугай юм сурья гэж байгаа бол, зүрхээрээ хүлээж авах хэрэгтэй. Яаж тэр вэ? Нэгдүгээрт - бид Ариун Сүнсгүйгээр юу ч хийж чадахгүй учраас, Түүнээс тусламж хүсэн, заавар зөвлөгөө гуй. Ариун Сүнс таны гархинд биш, дотоод жинхэнэ хүнд чинь хүрэлцэнэ. Хоёрдугаарт - зүрх чинь үнэнээс гогдох үед үүнийгээ тунгаан бод. Номоо бушуухан дуусгах гэж бүү яар. Тэгвэл маш бага ашиг хүртэнэ.

Бурханы мөнхийн үгийн нөлөөг тултал нь хүлээж авахын тулд энэ хоёр зарчмыг дагаарай. Тэгвэл та мөнхөд өөрчлөгдөнө. Дуулал 119:11 дээр Давид “Таны эсрэг нүгэл хийхгүйн тулд Үгийг тань зүрхэндээ би хадгалав” гэсэн. Ухаанаараа ойлгохын тулд бүү унш. Тэгвээс амархан мартагдаж, хурдан гээгдэнэ. Харин эргэцүүлэл, залбирлаар Бурханы Үгийг зүрхэндээ хадгал.

Өнө мөнхлөл гэдэг эцэс төгсгөл байхгүй, үүрдийн зүйл. Гэхдээ энэ нь цаг хугацаанд хамааралгүй учраас, хэзээ ч дуусдаггүй цаг хугацаа гэж ойлгож болохгүй. Цаг хугацаа нь үүнд захирагддаг. Өнө мөнхийг мөнх үргэлжлэх цаг хугацаа гэж ойлгобол, дүр зургийг бүрэн эхээр нь харахгүй байгаатай адил болно.

Өнө мөнхийг бид Бурханаас Өөрөөс нь л хамгийн сайн харж

чадна. Зах зухаас нь л дурьдахад - Бурхан хязгааргүй хүч, мэдлэг, цэц ухаан, ойлголт, алдартай. Тэр Өөрөө оршигч. Тэр мөнхийн мөнхөд Бурхан хэвээрээ л байна. Түүнийг “Мөнхийн Аав” гэдэг. (Исаиа 9:6)

Үүнийг Ёнгийн үгчилсэн орчуулгад “Өнө мөнхлөлийн Аав”⁴ гэдэг. Мөн 1Тимот 1:17 дээр “Өнө мөнхлөлийн Хаан” гэдэг. Өнө мөнхийн бүхэн Түүнд оршино, өнө мөнхлөл нь өөрөө Түүнд оршино. Түүнээс гадна байгч бүхэн зуурдын бөгөөд хувьсан өөрчлөгддөг. Хичнээн сайн, сайхан, хүчтэй, настай харагдаж байсан ч, эцэстээ үгүйрэн алга болно. Тэр бүү хэл газар дэлхий, ертөнц ч өөрчлөгдөнө. Гагцхүү Бурхан л өөрчлөгдөхгүй.

Еврей 1:10-12 дээр:

“Эзэн, Та эхэнд дэлхийг суурилуулсан, Тэнгэрс ч мутрын тань бүтээл билээ. Тэд мөхөх боловч Та үлдэнэ. Тэд бүгд хувцас адил элэгдэнэ. Та тэднийг бүтээлэг мэт ороож Тэд хувцас адил бас өөрчлөгдөнө. Харин Та хэвээрээ, Таны он жилүүд эс төгсөнө” гэдэг.

Бурхан хэзээ ч өөрчлөгдөхгүйгээр үл барам, мөнхөд нэг янзаараа байна.

Учир нь “Бүх махбод болбоос өвс мэт бөгөөд Бүхий л алдар нь өвс ногооны цэцэг мэт. Өвс хатдаг, цэцэг ганддаг. Харин Эзэний үг мөнхөд оршино.” Энэ нь та нарт тунхаглагдсан үг мөн. (1Петр 1:24-25)

Бурхан мөнхийн учраас Түүний үг ч мөнхийн юм. Тэр худлаа ярьж ч чадахгүй, Түүний үг ч зөрчигдөхгүй. Үгүй аваас бүх зүйл тэр аяараа сүйрэх байсан. Учир нь Тэр гэрэл бөгөөд Үгээрээ бүх юмсыг тогтоодог юм. Түүний хэлсэн Үг хэзээ ч өөрчлөгдөхгүй. Эс бөгөөс Тэр мөнхийн байж чадахгүй. Энэ бол бидний амьдралыг сүндэрлүүлэх баттай суурь юм.

Мөнхийн шүүх

Өнөөдөр олон хүн амьдралаа мөнхийн зүйл дээр биш (Бурханы Үг дээр биш), харин Бурханы талаарх соёлын үзэл бодол,

уламжлал, үнэмшил, мэдрэмж дээр босгож байна. Тэдний дунд итгэгч хүмүүс ч дүүрэн бий. Ямар нэг зуурдын юмыг мөнхийн үнэн хэмээн итгэж үнэмших нь үнэхээрийн аймшигтай явдал. Ингэж итгэдэг хүний суурь нь эвдэрчээ л гэсэн үг. Тэд хэзээ мөдгүй сүйрэх нь тодорхой. Тэд худал зүйлд итгэж, мэхлэгджээ.

Би ийм худал хуурмагт автчихсан хичнээн хүнтэй уулзаж учирч явснаа хэлж мэдэхгүй. Зарим нь Бурханд, Бурханы Хүүд итгэдэг гэдэг ч, тэдний итгэж байгаа Бурхан нь Бичээст илчлэгдсэн Бурхан яавч биш байдаг. Энэ залилан үүгээр зогсохгүй. Бурханы мөн чанартай таарахгүй гэдгийг нь хэлсээр байтал, яаж тэд тархиндаа ургуулан бодсон зүйлдээ, нийгмийн урлан бүтээсэн санаанд итгэж чадаж байна аа? Иохан 12:48-49 дээр Есүс:

Намайг голж, үгийг минь хүлээж эс авагчийг шүүх шүүгч бий. Хэлсэн үг минь эцсийн өдөрт түүнийг шүүнэ. Учир нь Би Өөрөөсөө яриагүй, харин юу хэлж, юу ярих тушаалыг Намайг илгээсэн Эцэг Өөрөө өгсөн юм” хэмээн айлдсаар байтал шүү.

Дэлхийн суурь тавигдсан тэр өдрөөс л товлогдсон Шүүх Өдөр гэж бий. (Үйлс 17:31-ийг үзнэ үү) Тэр өдөр ямар нэг шинэ зүйл илчлэгдэхгүй, харин бүх юмс хэдийнээ хэлэгдсэн Үгээр дэнслүүлэх болно. Тэр өдөр биднийг өдгөө бидэнд байгаа Бурханы Үг шүүнэ. Тэр бол мөнхийн бөгөөд эцсийн Шүүх юм. Тэр Шүүхийн шийдвэрийг найрахгүй, өөрчлөхгүй, давж заалдахгүй. Тиймээс бид Бурханы айлдсан Үгийг барагцаалж амьдрахын оронд, баттай мэдэж, яс дагаж амьдарсан нь өлзийтэй бус уу?

Тэр өдрийн Шүүх нь мөнхийн Шүүх юм. (Еврей 6:2) Бурханы Үгээр амьдарсан эсэхээр маань шийдэгдэх тэр өдрийн шийдвэр л бидний үүрд мөнхийн тавиланг шийднэ! Тэр мөнхийн Шүүхээс гарах шийдвэр хэзээ ч өөрчлөгдөхгүй.

Гэтэл итгэгчид ч тэр, итгэгч бус хүмүүс ч тэр - ямар ч сэрэмжгүйгээр тэрхүү товлогдсон шүүх рүүгээ ойртож явна. Тэд Библид огт байхгүй худлаа юмст хоосон найддаг. Зарим нь Бурхан тэдний нүгэл буяныг дэнслэж үзээд, буян нь нүглээ дарж байвал, ерөөгдөнө гэж боддог. Гэтэл өөрийгөө дахин төрсөн хэмээн мэдэгддэг зарим хүмүүс “Есүс тэднийг аварсан болохоороо хэзээ ч шүүхгүй, бүх төрлийн шүүхээс чөлөөлнө” гэж үздэг. Шүүх өдөр

энэ хүмүүс л хамгийн ихээр цочирдох байх даа. Мөн бүх зүйл өршөөгдөнө гэж итгэдэг ч хүмүүс байна. Тэр хүмүүс Бичээст огт байхгүй өршөөлд итгэдэг.

Дээрх итгэл үнэмшил нь Шинэ гэрээнд байдаг ч үгүй, Шинэ гэрээ ийм юм заадаг ч үгүй. Хүмүүсийн зохиосон иймэрхүү үй олон зуурдын итгэл үнэмшил нь Шүүх өдөр сүйрнэ. Шүүхийн өдөр хүмүүс бөөн бөөнөөрөө айж цочирдох нь гарцаагүй. Гэхдээ миний бодлоор итгэдэггүй хүмүүс гэхээсээ илүү итгэгч хүмүүс л хамгийн ихээр цочирдох байх даа.

Шүүхийн өмнө итгэл дүүрэн зогсох

Гэхдээ бид Шүүх өдрийг айдасгүй, итгэл дүүрэн угтах боломжтой:

Үүгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг. (1Иохан 4:17)

“...хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг” гэсэн байгааг анхаарна уу? Бидний дотор төгс (төгөлдөр) болгогдсон Бурханы хайр л биднийг Шүүх өдөр итгэл дүүрэн байлгах гол түлхүүр ажээ.

Тэгэхээр, яг үүн дээр л чуулганы олон хүн мэхлэгддэг. Тэд Бурханы хайрыг мөнхийн бус, зуурдын юм шиг боддог. Нийгэмд ч, чуулганы багагүй хувьд ч таалагдаж, сайшаагддаг сайн сайхан, хайрын тухай ойлголт бий. Гэхдээ тэр нь хүний хэмжүүрээр хэмжигддэг бөгөөд Бурханы хайртай тэрсэлддэг зүйл юм. Амьдрал дээр түгээмэл байдаг хэд хэдэн жишээ хэлье л дээ.

“Бид хоёр бие биедээ аймаар хайртай... тэгээд удахгүй гэрлэнэ.” Гэрлээгүй атлаа эр эм хоёр болсон хүмүүс голдуу ингэж хэлдэг. Гэрлэхгүйгээр эр эм болох нь нүгэл мөн. Мэдээж тэд алсдаа ном журмаараа гэрлэхийг би үгүйсгэхгүй. Гэхдээ амьдрал дээр харж байхад ийм хүмүүс гэрлэхээсээ илүү гэрлэхгүй салах нь элбэг байдаг. Тэд “Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр нь ч бүү бузартаг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ” хэмээн Еврей 13:4 дээр хэлсэн тодорхой анхааруулгыг мартжээ. Бичээч “чуулганд явдаггүй янхан эрчүүдийг болон завхайрагчдыг”

гэж хэлээгүй байгааг анхаарна уу. Энэ үг нь чуулганд явдаг, явдаггүй - ингэж амьдардаг бүх хүнд хамаатай юм.

Мөн ажил бизнесээ ахиулахыг хүссэн бизнес эрхлэгч нар бараа бүтээгдэхүүн нь худалдан авагчид ашигтай учраас, яльгүй худлаа ярих гэмгүй гэж боддог. Тэгээд: “Тийм ээ, энэ яг ч шударга явдал биш л дээ. Гэхдээ ингэж байж л бизнес урагшилна. Угаасаа манай бараа худалдан авагчид ашигтай” гэж хэлдэг. Гэхдээ нэгдүгээрт - худлаа ярих нь нүгэл, хоёрдугаарт - энэ бизнес нь ингэж хэлж байгаа хүндээ л ашигтай байдаг. Тэд Илчлэлт 21:8 дээр хэлсэн анхааруулгыг мартсан уу? “...бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм.”

Зарим нь “Би түүний тухай үнэнийг л хэлсэн” гэдэг үгээр түрүү барин, хамтран зүтгэгч, найз, даргынхаа талаар хов жив, гүтгэлгэ зэрэг сөрөг юмс ярьдаг. Гэхдээ та 100 хувь үнэн хэлсэн байсан ч, мөнхийн жишгээр бол буруудах ажээ. Та санаж байгаа бол, Ноагийн отгон хүү Хам аавыгаа согтуу толгойлоод, чармай нүцгэн хэвтэж байгааг ах нартаа хэлэхдээ, үнэнийг л хэлсэн бус уу? Гэвч тэрбээр аавыгаа үл хүндэтгэсэнээсээ болж, үр удам дээрээ үе дамнасан хараал авчирсан юм. Цуурч, гүтгэдэг хүмүүс Иаков 5:9 дээр “Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүлдчихгүйн тулд бие биеийнхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч үүдэн дээр зогсож байна” гэж хэлсэн байдгийг мартаа юу?

Ийм жишээ дуусахгүй. Эдгээр нь бүгд Бурханы хүсэлтэй сөргөлддөг.

Хамгийн аймшигтай нь яг ингэж амьдардаг, айхтар гэм хоргүй мэт үг хэлдэг хүмүүс нь гаднаасаа харахад чуулганд явдаг, эелдэг боловсон зан байдалтай, үлгэр жишээ иргэд шиг л харагдана. Гэхдээ тэд мөнхийн шүүхээр яаж хэмжигдэх бол?

Түүрэн бид Бурханы хайрыг төгс болгуулах (төгөлдөршүүлэх) талаар хэлсэн Иоханы үгийг үзсэн:

“Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга. Харин Түүний үгийг сахидаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ. Үүгээрээ бид Түүний дотор байгаагаа мэднэ. (1Иохан 2:4-5)

Бурханы төгс болгогдсон (төгөлдөршсөн) хайр л биднийг Шүүгчийн өмнө итгэл дүүрэн зогсооно гэдгийг санаарай. Гэхдээ

нийгмийг дагалдан баяссанаар биш, харин Бурханы тушаалыг сахин биелүүлснээр л Бурханы хайр төгс болгогддог гэдгийг Иохан тодорхой хэлжээ. Ева сайн мууг мэдүүлэгч мэдлэгийн модны муу чанарт нь татагдаагүй, харин сайн чанарт нь татагдсныг бүү мартаарай! “Тэгээд тэр эмэгтэйг хартал уг мод нь ...нүд булаам... сайхан харагдсан тул жимснээс нь авч иджээ.” (Эхлэл 3:6) Хүний гаргалгаа нь Бурханы мөнхийн хайртай сөргөлдсөн гоо үзэмж, сайн сайхныг бүтээдэг.

Бичээс түүнчлэн Бурханы тушаалыг хэсэгчлэн дагадаг хүн Шүүх өдөр итгэл дүүрэн зогсож чадахгүйг мэдэгддэг. Бид Бурханы Үгийг бүрэн эхээр нь нарийн чанд сахин биелүүлсэн цагт л Бурханы хайр төгс болгогдоно. Тиймээс л Бурхан бидэнд нигүүлсэл өгдөг. Нигүүлсэл биднийг Бурханд тааламжтай замаар Бурханы Үгийг бүрэн дагах хүчтэй болгодог. “Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм.” (Еврей 12:28)

Хамгийн гол нь нийгмийн тааллыг юмуу хүний гаргалгааг хайх биш, харин Хаан маань юу хүсч, харж байгааг мэдэх хэрэгтэй. Ийм учраас л Бурхан бидэнд “Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санааныхаа шинэтгэлээр өөрчлөгдөж байгтун! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр таалал юу болохыг таних болно” (Ром 12:2) гэжээ. Нийгэмд таалагддаг зүйл Бурханы мөнхийн хүсэлтэй зөрчилдөж болно.

Одоо тайлбарлая. Би яг одоо амралтын өдрүүдээр хорь гаруй мянган хүнд номлохоор Сингапурын нэгэн зочид буудалд сууж байна. Би энэ сайхан улсад олон удаа ирж байсан. Түүнчлэн Нидерланд гэдэг сайхан улсад ч хэд хэдэн удаа Сайн мэдээ номлосон. Тэгэхээр Нидерландад марихуан гэдэг хар тамхийг хуулиар зөвшөөрдөг учраас, иргэд нь ч шийтгэлээс айлгүй, чөлөөтэй хэрэглэдэг. Харин Сингапурт - маш өчүүхэн хэмжээний ч хамаагүй - ямарваа нэгэн төрлийн мансууруулах бодис авч явсан хүнийг шууд баривчилж, маш хүнд шийтгэдэг буюу үнэндээ дүүжлэн цаазаар авдаг! Сингапурт буухад гаалийн нэвтрэх бичиг дээр “Мансууруулах бодис тээвэрлэгч нар Сингапурын хуулиар цаазлуулах ялтай!” гэж бичсэн байдаг.

Тэгтэл марихуан тогтмол хэрэглэдэг нэгэн Нидерланд залуу Сингапурт ирээд, Синга найзуудынхаа дунд нөгөөдөхөө гаргаж

ирээд: “Найзууд аа, энэ тун сайхан эд. Тайвшруулна, таашаал өгнө, гутрал гуниг сарниана. Татаж үзэх үү? Надад жаахан бий шүү” хэмээн дайлаад газар дээрээ баривчлагджээ.

Залуу шоконд оров. Тэгээд хамгийн түрүүнд цагдаа нараас: “Та нар намайг ялаа гэж баривчилж байгаа юм?” гэж асууна.

Шүүх өдөр болов. Нидерланд залуу шүүгчийн өмнө өөрийгөө үл ойлголцлоос болж баривчлагдсан тул удахгүй суллагдана гэдэгтээ итгэл дүүрэн зогсоно. Гэтэл шүүгч түүний ялыг мэдүүлэн, шүүхийн тогтоол уншив.

Шоконд орсон Нидерланд залуу: “Эрхэм шүүгч ээ, манай улсад найзуудаа марихуанаар дайлж болдог ш дээ” гэж хэлнэ.

Гэтэл шүүгч: “Чи Нидерландад биш, Сингапурт байна. Энэ улсад хар тамхи хэрэглэх хуулиар хориотой!” гэж хариулна.

Нидерланд залуугийн хамаг итгэл үхэв. Түүнд хэлэх үг ч олдсонгүй, хэрэглэх арга ч үлдсэнгүй. Тэрбээр Сингапурын дээд шүүхийн өмнө ямар ч өмгөөлөлгүй зогсоно.

Намайг хэдэн жилийн өмнө Сингапурт ирэхэд, нэгэн Америк залуу машин хорлон сүйтгэсэн хэргээр баривчлагдаад байсан юм. Түүнийг баривчилж, яллаад, хэд хэдэн удаа ороолгох шийтгэл оноож билээ. Тэр нь химийн бодис шингээсэн хулсан саваа мэтийн багажаар хүний хонгыг ороолгож, хэзээ ч арилашгүй гэмтэл учруулах шийтгэл юм. Залуугийн шийтгэлийг арай л хүндэдсэн гэж үзсэн учраас, хөнгөлж өгөхийг Америкийн ерөнхийлөгч өөрийн биеэр хүсээд ч, бараагүй юм. Тэр залуу Сингапур улсын хуулийг зөрчсөн учраас, шийтгэлээ хүлээх л ёстой байв.

Тэгвэл бид нэгэн өдөр бүгдээрээ ертөнцийн хамгийн дээд шүүхийн өмнө зогсоно. Тэр шүүхийн шийдвэр нь мөнхийн бөгөөд эцсийн шийдвэр юм. Мэдээж олон хүн амьдралынхаа шийдвэрийг сонсоод, шоконд орно. Гэхдээ заавал ингэх албагүй юм.

Та бэлэн байна уу? Бид ертөнцийн Шүүгчийн өмнө итгэл дүүрэн очих боломжтой гэдгийг Бурханы Үг хэлсэн. Энэ ном ч таныг үүнд л бэлтгэхийн тулд бичигдсэн юм. Нидерланд залуу Сингапурт нэвтрэхээсээ өмнө бэлтгэлээ базааж, хууль журамтай нь танилцсан бол, үхлийн ял авахгүй байсан. Тэгвэл бидний хувьд Шүүх сэнтийгээс мөнхийн шийдвэр сонсохоосоо өмнө шүүхдээ бэлэн байх шиг чухал зүйл бий гэж үү?

Шагнал

Өнө мөнхлөлд нэгээс олон шүүх бий: итгэгч бус хүмүүсийн шүүх, итгэгч хүмүүсийн шүүх, тэр бүү хэл тэнгэрэлч нарын шүүх гэж бий. Шийдвэр нь ч өөр өөр байна. Тэр өдөр цөллөг, шийтгэл бас шагнал байна. Бид энэ талаар дараа дараагийн бүлгээрээ дэлгэрүүлж үзнэ. Гэхдээ хамгийн гол нь тэр шүүхийн шийдвэр нь мөнхийн гэдгийг бүү мартаарай. Үүнээс илүү яаж цохон тэмдэглэхээ би мэдэхгүй байна. Гэхдээ тэр шийдвэр хэзээ ч дуусахгүй гэдгийг ойлгохыг хичээнэ үү! Тиймээс л Бурхан бидэнд Өөрийнх нь үгийг сахин биелүүлэх нь шагналтай гэдгийг урьдчилан сануулдаг юм. I Коринт 9:24-27 дээр Паул ингэж хэлжээ:

Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар ялахын тулд гүйцгээ. Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй, харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог.

Паул “би зорилгогүй гүйдэггүй” гэжээ. ЭнЭлТи Библи дээр “Би алхам бүртээ зорилго тээн, зорилгоо руугаа л чиглэн гүйдэг” гэдэг. Хүн бүр яг л ингэх ёстой. Ялахын төлөө тодорхой бөгөөд зорилготой гүйх ёстой. Бид өрөөлтэй биш, өөртэйгээ л уралдаж байна.

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй

Шүүх сэнтийн өмнө бүх зүйл цагаатгагдана гэж бодож болохгүй. Бурхан хүн бүрт хүслээ тодорхой хэлчихсэн учраас, бид шалтаг тоочих аргагүй. Шүүх өдөр өөрийгөө бусдаас арай л гайгүй хэмээн итгэв ч, өнө мөнхөөр хөтлөгдөөгүй, амьдраагүй хүмүүс гарч ирнэ. Тиймээс л би номоо “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” гэж нэрлэсэн юм.

Хөтлөгдөх гэдэг үг нь “сэрээхээс” гадна “зааварчлах, хянах, чиглүүлэх” гэсэн утгатай. Өөр бас “хөдөлгөх хүчээр дүүргэх” гэж тодорхойлж болно. Газар дээр юу бидний амьдралыг хөтлөж, хөдөлгөж

байна вэ? Мөнхийн зүйл үү эсвэл зуурдын зүйл үү? Тэр нь тэнгэрлэг цэц ухаан дээр суурилсан уу? Эсвэл бид өөрсдийгөө бусадтай харьцуулсаар байна уу? Бид аль нэг сургуулийн номоос сонссон бялдуучлал, уламжлал, домогт автсан уу? Амьдралаа босгосон суурь маань Бурханы Шүүх сэнтийн өмнө тэсээд гарах уу эсвэл мөнхөд сүйрэх үү? Биднийг ямар жишгээр шүүхийг бид хэдийнээ сурсан: “Хэлсэн үг минь эцсийн өдөрт түүнийг шүүнэ.” (Иохан 12:48)

Шүүхийн өмнө Есүс Христийн өмнө зогсохдоо, маш олон итгэгчид үнэхээр шоконд орно. Шинэ гэрээний сургаалыг бүрэн эхээр нь суралгүй, дуртай хэсэгтээ л итгэж, сэтгэл амарсан хүмүүс гарна. Тиймээс би танаас “Та мөнхийн шүүхийн шийдвэрээ сонсчихоод, юуг ч өөрчлөх боломжгүй болсон хойноо үнэнийг мэдмээр байна уу эсвэл хожим ямар жишгээр шүүгдэхээ одоо мэдмээр байна уу?” гэж асуумаар байна.

Дараагийн бүлгийг эхлүүлэх ишлэлийг бид номынхоо явцад байн байн давтах учраас, анхааралтай уншиж, сайтар тогтоогоорой. Тэгээд наймдугаар бүлэгт ишлэлээ дүгнэх боловч, энэ талаар номоо дуусан дуустал ярих болно. Тэгэхээр үндсэндээ ном маань тэр чигээрээ энэ л ишлэлийг тойрон эргэлдэх юм. Түүнчлэн сургаалынхаа явцад ишлэлээ өөртөө байнга давтсаар байгаарай.

Энэ номд гарах бараг бүх үнэнийг би өөрийн биеэр Бурханаас сурсан болно. Бурханы үнэний бичил дуран авай дор Ариун Сүнсээр нягтлуулсан олон алдаагаа би та бүхэнтэй хуваалцана. Үүнийг уншаад та Бичээст улам гүн нэвтрэх хүслээр дүрэлзэж, Шүүх өдөр таныг хөдлөшгүй зогсоох бат суурь байгуулах болтугай. Түүнчлэн манай нийгэмд газар авч, эрчүүд, эмэгтэйчүүдийг Аврагчаас нь улам улам холдуулж байгаа, алдартай буруу ойлголтоос дэлгэж тавина. Та шоконд орж, айж, заримдаа бүр сахилгажуулагдана. Гэхдээ эдгээр нь бүгд амлалт, найдвар, тайвшралыг дагуулдаг.

Та зоригтой бол, үнэнийг хүсдэг бол, Бурханыг хайрладаг бол цаашаа явцгаая. Харуусахгүй шүү! Гэхдээ эхлээд дараах ятгалгыг зүрхэндээ хүлээж авна уу:

Түүний нигүүлслээр зөвтгөгдсөнөөр бид мөнх амийн найдварын дагуу өвлөгчид болох юм. Энэ бол итгэмжит үг. Эдгээр зүйлийг итгэлтэй яриасай гэж би чамаас хүсэж байна. Тэгвэл Бурханд итгэсэн нь сайн үйлс сахихдаа хянуур болох юм. Энэ нь сайн бөгөөд хүмүүст тустай. (Тит 3:7-8)

АФФАБЕЛ ХЭМЭЭХ ХААНЧЛАЛ: ЭНДЕЛИЙН АМЬДРАЛ

Есүс тэдэнд олон зүйлийг сургаалт зүйрлэлээр заажээ.


Тэр сургахдаа ийн айлдав.

— Марк 4:2

Эрт урьдын цагт манай дэлхийтэй төстэй боловч, олон талаараа ялгаатай өөр нэгэн дэлхий байжээ. Тэр дэлхий дээр тус тусдаа улс гэж байхгүй, харин Аффабел хэмээх нэг л том хаанчлал байв. Хэдийгээр тэр дэлхийд ганц л хаанчлал ноёрхдог ч, хаанчлалын удирдагч нар нь зөвхөн нийслэлдээ л байрлаж, тэндээсээ л хаанчлалаа захирна. Тэр нийслэлийг нь Аугаа их Аффабел хот гэнэ. Харин бүгдээрээ зүгээр л Аффабел гэж нэрлэе.

Үлгэрийн хотын хааныг Жэйлин гэдэг. Ард олон нь Жэйлин хаандаа ёстой л сөгдөн жаргадаг байв. Хаан ч ард олноо яндашгүй ихээр хайрлана. Жэйлин хүчирхэг бөгөөд цэцэрхэг атлаа бас хошин бөгөөд эелдэг хаан байв. Тэрбээр эрхмийн дээд хаан боловч эгэл дотно нэгэн байлаа. Жэйлиний дэргэд байгаа хүн хааныхаа сайн сайханд жаргаж, амьдрал нь дэвжин дээшилдэг байв. Жэйлиний хэтийн бодол, алсын хараа гайхам бөгөөд хүмүүсийн үйлдлийн цаадах зүрхний сэдлийг нь мэдэх чадвартай ажээ.

Жэйлиний аав нь Аффабелийг үндэслэн байгуулсан учраас, иргэддээ “үндэслэгч эцэг” хэмээн хүндлэгдэнэ. Аав нь хаанчлалаа байгуулаад, хүү Жэйлиндээ шилжүүлжээ. Харин Жэйлин хаанчлах их үйл хэрэгтээ хотынхоо бүх иргэдийг гар бие оролцуулна. Түүний эрх мэдэл, засаглал нь шатлан захирах системээр хэрэгждэг байв.



Аффабел нь зуун хорин найман мянган акр газар сунайж тэлсэн, маш том хот ажээ. Хүн ам олонтой ч, дээд зэргийн зохион байгуулалттай учраас суурьшлийн даац хэтрэх асуудал хэзээ ч гарахгүй. Аффабелд захын суурингууд ч бий, жирийн хорооллууд ч бий, эдлэн газартай тансаг орд харшууд ч бий.

Аффабелийн баруунтаа тал газарт эгэл бор ажилчдын энгийн даруу сууцууд бий. Гэхдээ тэдний эгэл даруу сууц нь манай дэлхийн хувьд орд харш л гэмээр. Тал газрын оршин суугчид нь хар бор ажил хийдэг ч, үнэндээ Аффабелд орж чадсандаа талархаад бардаггүй ажээ.

Хойд хийгээд Өмнөд хязгаарын нуруудад уран бүтээлчид аж төрнө. Тэд бөгөөс чадварлаг, бүтээлч, уран хөгжимчид, бичээчид, урлаач, дизайнерууд юм. Тэд мөнөөх ажилчдаас хавьгүй том, гоёмсог сууцуудтай өргөн чөлөөнд амьдарна.


Харин хотын хамгийн гол шигтгээ нь зүүн дүүрэг байлаа. Ёстой нүд унагаж, уулга алдмаар. Уран гоёыг уралдуулсан, үнэт чамин өргөө сууцуудтай тэр газрыг Хааны ордон гэнэ. Энд Хаан Өөрөө ажил албаа гүйцэтгэн, амьдран сууна. Мөн энд л хааны хамгийн ойрын хүрээний хүмүүс аж төрж, ажил үүргээ явуулж бас нөхөрлөнө.

Хааны ордон нь Их далайг хаяалан дүнхийх хадан дээрх эрдэнэс мэт үзэгдэнэ. Сэвшээ салхиар туугдах далайн пургиа хотын өнгө төрхийг байн байн сэргээнэ. Далайн усыг гоо үзэсгэлэнгээрээ гагцхүү Хааны цэцэрлэгт л гүйцэгдэх цасан цагаан эргүүд хашина. Харин хааны цэцэрлэг нь хааны ордонг эмжин хөвөрсөн, энд тэндгүй өнгө өнгөөр алагласан газар юм. Аффабел нь яахын аргагүй хүн бүрийн сэтгэлийг сорсон нутаг байлаа. Өргөө сууцууд нь ч үзэсгэлэн сайхнаараа гагцхүү Хааны ордонд л гүйцэгдэнэ.

Аффабелийн төвд амийн мод ургана. Энэ модны гайхамшигт жимснээс гагцхүү хааны итгэмжит албатууд л хүртэх эрхтэй. Жимс нь амттай, алган дээрээ тавихад дурлам төдийгүй, анхилуун элдээ гайхамшгийн хүчтэй байв.

Энделийнхэн

Аффабелийн тал газраас баруун зүг Адонга хөлгүй их мөрөн хүртэл бараг зуу гаруй километр газар сунасан Гадаад цөл бий. Харин Адонга мөрний цаад эрэг дээр Эндел гэдэг онцгой муж



байна. Аффабелийн шинээр мэндэлсэн хүүхэд бүрийг Эндел мужид авчирч, долоо ч хонож амжаагүй нярайг хааны асрагч нар халамжиндаа авна. Тэгээд залуу Энделчүүдийг таван нас хүрмэгц Энделийн сургуульд оруулж, арван жил сургана. Хүүхдүүд тэнд Аффабелийн амьдралд суралцаж, аугаа Жэйлиний талаар сурна.

Жэйлин хаан таван жил тутамд Энделд өөрийн биеэр сэм ирээд, зөвхөн хааны асрагч нар болон сургуулийн багш нартай уулзаж, сургуулиа гэсэн, сурагчдаа гэсэн зүрх сэтгэлээсээ хуваалцдаг байжээ. Бусад нь хэдийгээр Жэйлинийг хараагүй ч, тэрбээр ямар хаан болохыг Энделийн хаанаас ч харж болохоор байв.


Энделийн арван жилд сурагчид ирээдүйн амьдралдаа бэлтгэгдэнэ. Арван таван нас хүрсэн хүүхдүүд хэсэгхэн хугацаанд сурсан эрдмээ хэрэгжүүлэх дадлагад гарах бөгөөд хүн бүрт тодорхой хэмжээний баялаг, үүрэг хариуцлага даалгагдана. Тэд ч дөнгөж эхлэж буй амьдралдаа хэрхэн эзэн болж, эх үүсвэрээ захиран зарцуулснаараа ирээдүйн амьдралаа буюу тэднийхээр бол зуун тавин жилээ хаана, хэрхэн амьдрахаа шийдэх юм. Хэдийгээр шалгалтын улирал нь яг таван жил боловч, сурагчид үүнийг мэддэггүй байжээ. Тэд арван жилээс хэтрэхгүй гэдгийг л мэднэ. Энэ хугацаа дуусмагц тэд амьдралдаа хийсэн сонголтынхоо төлөө тайлан тооцоогоо тавихаар хааны өмнө очно.

Шалгалтын хугацаа нь сурагчдын үнэнч чанарыг шалгадаг байв. Жэйлиний тушаалыг үгээрээ ч, үйлдлээрээ ч дагасан сурагчид нь хаандаа захирагдаж амьдарсан учраас, хийсэн сонголтдоо зохих шагналаа хүлээн авч, Аффабелийн иргэд болно.

Харин тэрслэж, шалгалтын хугацаанд зөвхөн өөрийнхөө төлөө амьдарсан сурагчид нь Ганц хэмээх хөсөр газар цөлөгддөг байжээ. Ганц нь тас харанхуй, ганцаардал цөхрөлийн хөсөр газар бөгөөд тэнд тэрслүү хүмүүс насан турш хоригдож, тарчилдаг ажээ.

Энэ газар цөлөгдсөн эхний хүн нь Ганцыг үүсгэсэн хар санаат эзэн Дагон юм. Тэр олон жилийн өмнө Жэйлинтэй арцалдан, хорт явуулгаараа Энделийг тэр аяар нь бузарлажээ. Гэхдээ Жэйлинээс урваагүй Энделийнхэн нь Дагоны хар хүчнээс мултарч чөлөөлөгдсөн бол, Жэйлинээс нүүр буруулагсад нь Дагоныхоо хар саварт үлдсэн байна.

Их хаан Жэйлин энэ хорон явуулгыг лавшрахаас өмнө таслан зогсоож, Аффабелийн шударга ёс, нийгмийн дэд бүтцийг



хамгаалах үүднээс нэгэн тушаал буулгажээ. Жэйлинийг хаанаар өргөмжлөхөөс татгалзаж, Дагоны замыг дагагсад нь Ганц хэмээх хөсөр газарт насан турш үлдэх тавилантай.

За одоо жинхэнэ түүх маань эхлэж байна. Бид Энделийн таван сурагчийн амьдралыг үзнэ. Тэднийг Бие даагч, Мэхлэгдэгч, Бүрэг, Аминч, Өгөөмөр гэнэ. Одоо тэдэнтэй нэг бүрчлэн танилцъя.

Бие даагч

Бие даагч бол Аффабелд үнэхээр байдагт эргэлзэж явдаг нэгэн. Тэр хэзээ ч үзэгдэж харагддаггүй атлаа өөртөө үнэнч байхыг шаардаж, баахан “хууль журмаа” сахихыг тулгадаг “Жэйлин гэгчид” ч эргэлздэг. Тэрбээр энэ бүхэн нь түүнийг болон сурагчдыг хяналтандаа байлгах гэсэн багш нарын арга гэж хардана. Тийнхүү Бие даагч байдаг үгүй нь ч мэдэгдэхгүй үлгэрийн энэ хаанчлалын тухай сонсохоос зэвүүцсэндээ хичээлээ байнга таслана.

Бие даагч Аффабелд итгэдэг бусдыгаа шоолж, харин өөрөө Жэйлиний хуульд баригдалгүй, өөрөө өөртөө эзэн байхыг хүснэ. Гэхдээ сэтгэлд нь нийцсэн үг байвал, дуртайяа дагана. Тэр энэ үзэл бодлоо ч бусдаас нуулгүй, ил тод хэлнэ.

Мэхлэгдэгч

Мэхлэгдэгч бол Аффабелд итгэдэг нэгэн. Тэрбээр хаан Жэйлинд болон Түүний амлалтад тун дуртай. Аман дээрээ сургуулийн хичээл, дүрэм журмыг зөвшөөрдөг ч, амьдрал дээрээ харин дагахгүй. Тэр хааны, хааны сургаалын талд гэдгээ дуртайяа мэдэгдэж, сургуулийн зугаатай үйл ажилд оролцдог ч, өөрт ашиггүй ажилдаа хуруугаа ч хөдөлгөхгүй. Тэр Жэйлиний дагалдагч шиг амьдардаггүй. Гэхдээ хүчтэй зан чанартай учраас, бусдыг араасаа амархан дагуулна. Тэрбээр шалгалтын хугацааны дараа шүүгдэх талаараа хэзээ ч нухацтай бодож үзээгүй.

Мэхлэгдэгч, Бие даагч хоёр Жэйлиний тал дээр санал зөрдөг ч, бусдаараа бууз хуушуур шиг хоёр. Бие даагч ч Мэхлэгдэгчийн хөгжилтэй, сэргэлэн занд дуртай, дээрээс нь өөртэй нь ашиг сонирхол төстэй учраас хамт байх дуртай.

Бүрэг

Таван найз дундаас хамгийн гавшгайч нь Бүрэг. Хичээлдээ идэвхитэй, онцсайн сурдаг, байнга л сурагчдын нийгмийн идэвхи санаачилгыг хөгжүүлсэн шинэ ажил санаачилдаг. Хэн ч харсан Бүрэг л Жэйлиний хамгийн сайн сурагч байв.


Аминч

Аминч Жэйлинийг бас Аффабелийг байдаг гэдэгт итгэдэг бөгөөд энэ тухайгаа ч ил тод хэлдэг. Тэрбээр Жэйлинийг мундаг удирдагч, шударга шүүгч, өөрт нь үнэнч байсан хүмүүст нигүүлсэнгүй ханддаг гэж итгэнэ. Тийм боловч Жэйлиний сургаал, зан чанарын тодорхой хэсгүүд дээр л анхаардаг учраас Жэйлин хайраар дүүрэн, нигүүлсэнгүй хаан боловч, нөгөөтэйгүүр шударга, ариун удирдагч гэдгийг нь мартжээ. Тэрбээр Мэхлэгдэгч, Бүрэг, Өгөөмөр гурвыг Жэйлиний хаанчлалд ногоон гэрлээр орно гэж итгэдэг ч, эсэргүү Бие даагчийг харин яах бол хэмээн эргэлзэж явдаг.

Аминчийн хувьд Жэйлинийг амаараа хүлээн зөвшөөрдөг бас ноцтой зөрчил гаргаагүй хүн л Аффабелд орно гэж итгэнэ. Гэхдээ энэхүү Жэйлиний “хөгжөөн дэмжигч” маань амиа хичээхдээ бас өөртөө ашигтай юманд хөдлөхдөө л гаргууд ажээ. Аминч хэдийгээр сайн санааны үйлс хийдэг ч, яг аминдаа тулбал өөртөө л ашигтай шийдвэр гаргана.

Өгөөмөр

Эцэст нь Өгөөмөр гэдэг залуу хатагтайг танилцуулъя. Тэрбээр Жэйлиний үгийг үнэн голоосоо дагана. Зарчмыг нь сураад зогсохгүй, тушаал бүрийн цаад санаа зоргыг олж мэдэхээр судлаж, Жэйлиний хүслийг танин мэдэхэд олон цаг зарцуулна. Олон цагаар суралцаж, сургуулийнхаа болон нийгмийнхээ сайн сайхны төлөө өөрийгөө бүрэн зориулдаг гэсэн үг. Арван таван нас хүрээд, хааныхаа хүслийг биелүүлэх хэсэгхэн хугацаа олдоно гэдгийг тэрбээр сайн мэднэ. Өгөөмөр Жэйлиний алдрын төлөө амьдрах ганц л зорилготой бөгөөд энэ зорилгод нь саад хийхийг юунд ч зөвшөөрөхгүй.



Өгөөмөр Жэйлинд хайртай бөгөөд түүнтэй уулзах өдрийг тэсэн ядан хүлээнэ. Өгөөмөр Жэйлиний сайн сайхны талаар байнга бусдад ярьж өгдөг. Тиймдээ ч үүнээсээ болж заримдаа ад шоо үзэгддэг ч, тэрбээр хэзээ ч бууж өгөхгүй.

Төгсөгчид

Дээрх таван Эндел залуу арван таван нас хүрэв. Төгсөлтийн баяр болж, энэ тав маань өөр хоёр мянган хүүхдийн хамт сургуулиа төгсөв. Сурагч бүрт онцгой даалгавар даалгаж, зохих хэмжээний гарааны хөрөнгө олгожээ. Хувь хэмжээг нь Жэйлин өөрөө шийдсэн бөгөөд төгсөлтийн өдөр багш нараар нь дамжуулан сурагч нарт гардуулав.


Харин манай тавын хувьд: Бие даагчид тавин таван мянган итгэмжлэл, Мэхлэгдэгч, Бүрэг хоёрт тус бүр дөчин мянган итгэмжлэл, Аминчид хамгийн их буюу далан таван мянган итгэмжлэл, Өгөөмөрт хорин таван мянган итгэмжлэл олгогджээ. Ийнхүү мөнгө хүлээж авсан залуу иргэд маань сүүлийн даалгавраа хүлээн аваад, амьдралд хөл тавилаа.

Бизнесмэн

Бие даагч хэдийгээр хичээлдээ суудаггүй байсан ч, ганц хоёр эрдэм толгойд нь үлджээ. Тэгээд үе үе “сургуульд нь заадаг тэр балайрал үнэн байвал яана” гэж бодогдоно. Тиймээс сургуулиа төгсөөд гар хоосон хоцрохгүйн тулд нэгийг боджээ.

Дугтуйтай итгэмжлэл хүлээн авч байхдаа Бие даагчийн гар салгалж байв. Тэгээд дугтуйгаа нээн, хүлээж авсан итгэмжлэлээ үзээд, итгэж ядсан бас уужирсан сэтгэлээ үзүүлэхгүй гэж байдгаараа дарав. Дараа нь Бүрэгээс арван таван мянгаар илүү, Өгөөмөрөөс хоёр дахин ихийг хүлээж авснаа мэдээд бүр ч ихээр хөөрчээ. Тэгээд “Хөөрхий Өгөөмөр, Бүрэг хоёр! Ямар ч хэрэггүй баахан хичээл сураад л, сураад л... тэгээд ийм жаахан шан авах гэж” хэмээн боджээ.

Энэ явдал Бие даагчид Жэйлин гэж огт байхгүйг бүр ч батлав. Тэгээд тэр мөнгө нь сурагчдын олон жилийн өмнө алга болсон аав, ээжүүдийн гэрээслэсэн мөнгө юм байна гэж боджээ. Түүнчлэн сургуулийн удирдлага залуу сурагчдаа бие даасан бодол



сэтгэлгээтэй байлгахаас сэргийлэн хянаж байхын тулд “Жэйлиний” тухай зальжин түүх зохиожээ хэмээн ургуулан дүгнэв.

Хэдэн долоо хоног төгсөлтөө тэмдэглэсэн Бие даагч итгэмжлэлээ асар хурдан үрж байгаадаа зовниж, бизнес эхлүүлэхээр шийджээ.


Бие даагч машин борлуулж эхлээд, өөрийгөө гайгүй сайн борлуулагч болохыг олж мэдэв. Бизнес нь ч гайхам амжилт дагуулав. Олон төгсөгчид итгэмжлэлээрээ Бие даагчаас шинэ, хуучин машин худалдаж авав. Тэгээд санхүү нь үржих тусам Бие даагч бизнесээ өргөжүүлж, бизнес нь ч цэцэглэлээ. Баялаг нь арвижих тусам Бие даагчийн ажил ч, амьдрал ч огцом дээшлэв. Төдөлгүй тэрбээр мөнгө нь нэр нөлөөний гайхмаар хүч гэдгийг ухаарч, мөнгөөр аз жаргалыг ч худалдаж авч болно хэмээн барджээ. Гэрлийн хурдаар арвижих хөрөнгө, дээшлэх амьдралын хэв маяг нь охидыг соронздож байгаа нь Бие даагчийг улам хөөргөв.

Бие даагч долоо хоног тутмын олон нийтийн уулзалтдаа очдоггүй байсан ч, нийгмийн төсөлд хандивладаг дэмжлэгийг нь хүртдэг олон хүн түүнийг өндрөөр үнэлдэг байлаа. Энэ хөдөлмөрч Эндед залуугийн амьдрал ёстой л цэцэглэж байв.

Барилгачин ба бүтээн байгуулагч

Мэхлэгдэгч Бие даагчтай нийлэн хэдэн долоо хоног төгсөлтөө тэмдэглэв. Тэрбээр бусад шигээ их итгэмжлэл хүлээж аваагүй ч, ядаж Өгөөмрөөс ихийг хүлээж авсандаа бахтай байлаа. Энэ явдлаар түүний “Жэйлин бол зарим нэг юмсыг тоодоггүй, асар нигүүлсэнгүй хаан” гэсэн эрэмдэг үзэл улам л батжив.

Сургуульд нь болохгүй гэж заасныг мэдсээр байж Мэхлэгдэгч сургуульдаа үерхэж байсан хэд хэдэн охинтойгоо унтав. Тэрбээр Жэйлинд болон Түүний хаанчлалд бүрэн итгэж л байвал, энэ мэтийн зүйлийг нэг их сүртэй зүйл гэж үздэггүй байлаа. Тэгээд “Би Жэйлинд үнэнч хэвээрээ байж, хүмүүсийг ноцтой гомдоохгүй л байвал, хаан бид хоёрын харилцаа хачин сайн байна” гэсэн амьдралын зарчим зохиожээ. Жэйлин хүмүүсийг төгс биш гэдгийг бас хүмүүст өөрийн гэсэн хэрэгцээ байдгийг мэднэ хэмээн Мэхлэгдэгч бодно. Тэгээд өөрт нь бүх зүрхээрээ итгэдэг хүмүүсийн алдаа эндлийг Шүүх өдөр Жэйлин өршөөл, нигүүлслээрээ зүгээр л уучилчихна гэдэгт итгэл дүүрэн байв.



Төгсөлтөөс хэдэн долоо хоногийн дараа Мэхлэгдэгч өөрийн бизнесээ эхлүүлж, барилгачин болжээ. Эхлээд худалдан авагч олох гэж зүдрэв. Учир нь түүний барьсан загварын байшин төгс байсан ч, дэндүү үнэтэй учраас хүмүүс ийм тансаг байшинг худалдаж авч дийлэхгүй байв. Тиймээс аргаа барсан Мэхлэгдэгч үнээ буулгажээ.


Одоо Мэхлэгдэгч худалдан авагч нарт урьдын л адил тансаг загварын байшин үзүүлж, урьдын л адил амлалт өгөв ч, бодит байдал дээр амласнаасаа эсвэл үзүүлснээсээ маш муу материал ашиглах болжээ. Үнэндээ түүний ашигладаг зарим материал нь Энделийн барилгын код, жишгийг зөрчдөг байв. Харин Мэхлэгдэгч тэдгээр хуулийг гаргасан хуульчдыг дэмий л хийрхэж байна гэж үзнэ. Тэрбээр өөрийнхөө материалыг байгалийн ямар ч нөхцлийг ажрахгүй давна гэдэгт итгэлтэй байв. Мэхлэгдэгчийн барьсан орон сууц тун дажгүй үнээр зарагддаг учраас, захиалгаа гүйцэхээ больж, бизнес нь ч цойлов.

Хэдэн жилийн дараа Мэхлэгдэгч газрын наймаа руу орохоор шийджээ. Учир нь тэр худалдан авагч нарын санал гомдлоос залхав. Харин газрын наймаа нь зарагдаа л бол, гүйцээ. Урсгал зардал, засвар үйлчилгээ гэх юм байхгүй.

Тэгээд акр тутам мянган итгэмжлэлийн үнэлгээтэй газар олоод, ухаангүй баярлав. Үнэндээ итгэхийн аргагүй ашигтай санал байжээ. Гэтэл судлаад үзэхнээ, тэр газар нь үерийн голомт байв. Гэхдээ үүнийг нь Мэхлэгдэгчийн хүрээний цөөхөн хэдэн хүн л мэднэ. Мэхлэгдэгч хотын захиргаанд ажилладаг Бие даагчийн танилыг хахуульдаад, геологийн ямар ч сорил шинжилгээнд оруулалгүйгээр газрын зөвшөөрлөө авч чаджээ. Тэгээд ч өнөөдрийг хүртэл ямар ч үер буугаагүй учраас, асуудалгүй л гэсэн үг. Залуу бизнесмэний амьдрал дурайж байв.

Багшийн туслах

Төгсөлтийн дараа Бүрэг нэг сумаар хоёр туулай буудахаар хэсэг найз охидтойгоо дэлгүүр хэсчээ. Нэгдүгээрт - найзуудтайгаа зугаацах. Хоёрдугаарт - шинэ ажилдаа зориулж хувцас, гоёл чимэглэл худалдаж авах. Бүрэгт Энделийнхээ сургуульд багшлахаас өөр бодож санаж, хүсч мөрөөдөх юм байсангүй. Тиймээс Бүрэг ирэх тав дахь өдөр ажлын ярилцлагад орох гэж байлаа.



Гэтэл зугаалгын хоёр дахь өдөр нь Бүрэгийн найз Ховжив Хутгуур гэдэг найз нь Бүрэгийг сургуулийнхаа нэг сурагчтайгаа унтсан гэж багшдаа хэлснийг шивнээд амжив. Үүнийг дуулсан Бүрэгийн уур дүрэлзэв. Энэ цуу ярианаас болж тэрбээр туслах багшийн ажлаа ч алдаж мэдэхээр байлаа. Энэ нь ямар ч үнэний оргүй, хоосон цуурхал байв. Тэрбээр сургуульд байхдаа харин ч хамгийн журамтай охин байжээ. Гэтэл Хутгуур цэвэр агаархал дайсагналаасаа болж ийм явуургүй загнасныг Бүрэг мэдрэв.

Бүрэг галзуурах шахжээ. Тэрбээр Хутгуурын хорон явуулгын тухай нэг ч марталгүй, хэдэн өдөр бодов. Тэгээд хийсэн зүйлийнх нь хариуг өгөхөөр шийджээ.

Ажлын ярилцлагын өдөр Бүрэг ажилдаа тэнцсэн бөгөөд үүндээ ч итгэж ядаж байв. Багш нь ч тэр цуурхалыг сонссон гэдгээ хүлээгээд, гэхдээ шалгалт явуулсны эцэст худлаа болох нь нотлогдсныг батлан хэлжээ.

Бүрэг ажилдаа ороод зогсохгүй, өөрийнхөө хамгийн хайртай, хамгийн мундаг багш нарын нэг болох Дүр эсгэгчийн туслахаар очив. Дүр эсгэгч бол нилээд хэдэн жил залуу Энделчүүдэд багшилж байгаа хорин тавтай залуу ажээ. Учир нь багш нар бусад шигээ хорин насандаа биш, харин гучин насандаа шүүгддэг байв. Бүрэг ийм алдартай багштай ажиллах болсондоо айж баярлах хослон байлаа.

Хичээлийн шинэ жил эхлэж, бүх юм хачин сайхан өрнөж байсан ч, Бүрэг Хутгуурт өс санасаар л байлаа. Амьдрал нь хичнээн сайн сайхан байсан ч, Бүрэг Хутгуурын урвалтыг мартаж чадсангүй.

Гэхдээ энэ бүх сайны цаана өөр нэгэн урвалт исэлдэж байв. Дүр эсгэгч гэж ямар хүн болох нь нэрнээс нь л илэрхий мэт. Тэрбээр гэгээн цагаан багшийн дүртэй ч, амьдрал дээр тэс өөр хүн байжээ. Дүр эсгэгч хүндээр гэгсгээгдэх ёстой хүн байв. Учир нь багш хүнийхээ хувьд тэрбээр Жэйлинтэй нүүр нүүрээ уулзсан байлаа.

Нэгэн орой Бүрэг, Дүр эсгэгч хоёр хоёулханаа байж таараад, Дүр эсгэгч Бүрэгийг оролдож эхлэжээ. Бүрэг ч цочирдож, дургүйцэндээ тэр даруй гүйгээд явчихав. Дүр эсгэгч ч бууж өгөлгүй, хэдэн долоо хоног Бүрэгийг элдвээр эргүүлжээ. Гэтэл төдөлгүй Бүрэгийн хандлага ч зөөлөрч, мундаг мэдлэгтэй багшид сэтгэл алдав. Үнэндээ Бүрэг Дүр эсгэгчийн анхаарал халамжинд дуртай байлаа. Дүр эсгэгч ч туйлын эелдэг, зөөлөн, дээрээс нь жигтэйхэн царайлаг залуу байв. Тэгээд Бүрэг дотроо нилээд

зөрчилдсний эцэст ариун биеэ Дүр эсгэгчид өгч, тэдний дунд янаг амрагийн явдал буцлав.

Бүрэг урьд нь хэзээ ч ийм хайр сэтгэл, дур хүслийн оргилуун мэдрэмж үзээгүй бөгөөд Дүр эсгэгчийг харах тоолонд хамаг зүрх нь булгилна. Бүрэг Дүр эсгэгчид ухаангүй дурласандаа мөнөөх гомдлын шархаа хэсэг мартагнасан ч, дотроо Хутгуурт хонзогносоор л явжээ.

Гэтэл дөрвөн сарын дараа Дүр эсгэгч гэнэт Бүрэгийг хаячихсан тул Бүрэг галзуурахын даваан дээр очив. Тэр шалтгааныг нь мэдэхийг хүсч байлаа. Тэрбээр бүхнийг ахин дахин эргэцүүлж, Дүр эсгэгчээс хариу нэхэж байв. Тэгсээр сүүлдээ Дүр эсгэгч Бүрэгийн талаарх нөгөө Хутгуурын яриаг олж сонссоноо хүлээсэн ч, үнэндээ энэ нь түүний сэтгэл хувирсаны жинхэнэ шалтгаан биш байв. Хэрэг дээрээ Дүр эсгэгч зүгээр л Бүрэгийг сонирхохоо болиод, хэдийн өөр охинтой жиг ургуулсан байжээ. Энэ ирээдүйтэй сайхан залуугийн ятгалга, өдөөлтийг эсэргүүцэх охид байсангүй.

Бүрэг Дүр эсгэгчийг жигшин зэвүүцэж байлаа. Тэр Дүр эсгэгчийг өдөр бүр харж тэсэхээ байсан тул багшийн ажлаасаа гарчээ.

Хэдэн өдөр хилэгнэснийхээ дараа Бүрэг дөчин мянган итгэмжлэлийнхээ үлдэгдлээр гоо сайхны салон нээжээ. Тэгээд Жэйлиний заавал очиж байгаарай хэмээн сургасан сургуулийнхаа долоо хоног тутмын уулзалтанд явахаа больжээ. Бүрэг хоёр нүүртэй хүмүүсийг харахыг хүссэнгүй. Тэр уулзалтад дандаа л тийм хүмүүс ирдэг юм шиг санагджээ.

Бүрэгийн зүрх өдөр ирэх тусам хатуурсаар байв. Тэр сургуулийнхаа талаар, Жэйлиний талаар юу ч ярихаа болив. Өмнө нь урсдаг байсан халуун сэтгэл нь идэвхигүй, шүүгч зангаар солигджээ. Бүрэг Жэйлинд үнэнч хэвээрээ гэж хэлдэг ч, Дүр эсгэгч шиг өөдгүй хүнийг сургуулийнхаа багшаар ажиллахыг зөвшөөрсөнд нь Жэйлинийг буруутгаж байв.

Шалгалтын өдрүүд дуусах үед Бүрэг асар их гомдолтой, хорслоор дүүрэн эмэгтэй болоод байсан ч, үүнийгээ эрс няцаасаар байлаа. Тэрбээр үлдсэн амьдралаа дайснаасаа өшөө авахад л зориулжээ.

Эндел хотын дарга



Харин одоо Аминч. Аминч тийм их мөнгө хүлээж авсандаа итгэж ядаж байлаа. Тэгээд баярласан ч, ямар ч утгагүй наргиан цэнгээнээс хол яв гэсэн Жэйлиний сургаалыг мэддэг байв. Аминч хэдэн өдөр амарч аваад, хөрөнгө оруулалт хийж эхлэжээ. Түүний арилжаа наймаа ашиг өгч, эхлэл хөрөнгөө маш хурдан үржүүлэв. Санхүүгийн чадалтай хүний танилын хүрээ ч өргөжив.


Аминч Энделийн хамгийн сайхан дүүрэгт тансаг байшин худалдан авч, гэртээ Энделийн хамгийн нэр нөлөөтэй, эрх мэдэлтэй хүмүүсийг урьжээ. Засгийн газрын гишүүн, мэргэжлийн тамирчин, бизнесмэн тэргүүтэй эрхмүүд түүний цайллагат уригдан ирэв. Аминч холбоо харилцаагаа маш хурдан зузаатгаж байлаа.

Гурван жилийн дараа Аминч Эндел хотын даргад нэр дэвшин, санхүүгийн нөлөө, нийгмийн харилцаа холбоогоороо маш амархан ялав. Тэгээд албандаа очоод маш олон асуудал шийдэх үүрэгтэй болсноо ухаарчээ. Тэдгээрийн нэг нь сургуулийн асуудал байлаа. Сурагчдын тоо эрс нэмэгдэж байгаа учраас сургуульд илүү том барилга хэрэгтэй болжээ. Энэ нь газар худалдаж авах, барилгачдыг олох, барилга бариулах санхүүгийн үүсвэр, сургуулийн үйл ажиллагааг явуулах бүх төрлийн зардлын асуудал гэсэн үг юм.

Тиймээс хамгийн түрүүнд сургуульд зориулж мөнгө босгох хэрэгтэй байв. Долоо хоног тутмын уулзалтаар Аминч илүү их мөнгө шаардлагатай байгааг мэджээ. Тэгээд хандивын аяны төгсгөлд тэрбээр дөнгөж мянган итгэмжлэл өгсөн байв.

Дараа нь хамгийн хүнд шийдвэр тулгарав. Сургууль эцэстээ нэг газар худалдаж авах мөнгөтэй болжээ. Газар нь ч дажгүй, үнэ нь ч боломжийн. Гэтэл өөр нэгэн их дэлгүүр бас тэр газарт санаархжээ. Тэгээд хотын захиргаа санал хуваагдав. Сургууль нь ашгийн бус байгууллага учраас ямар ч татвар төлөхгүй. Харин дэлгүүр өндөр татвар төлөхөөс гадна хотын иргэдэд зориулж ажлын орон тоо нэмэгдүүлнэ.

Хотын захиргаа санал тэнцсэн учраас, эцсийн шийдийг хотын дарга гаргах ёстой болов. Аминч хэцүү байдалд оржээ. Их дэлгүүрийн эзэн түүний сонгуулийн ажлыг дэмжин, их хэмжээний мөнгө хандивлаж, түүний төлөө нэр нөлөөгөө үзүүлсэн. Тэмдэглэлт өдрүүдээр гэрт оронд нь ч байнга зочилдог.



Тэгээд Аминч их дэлгүүрт саналаа өгөөд, энэ шийдвэр нь ажлын орон тоо, хотын татварын санг нэмэгдүүлэх учраас Энделийн нийт ард иргэдэд ашигтай гэдэг үгээр өөрийгөө зөвтгөжээ. Харин Энделийн сургуульд Аминч одоогийн байраа томсгох зэрэг өөр арга зам хайхыг зөвлөсөн ч, энэ нь боломжгүй гэдгийг мэдэхийн дээдээр мэдэж байлаа. Аминчийн сонголт Жэйлиний үнэнч дагалдагч нарыг гомдоосон ч, олон нийт ерөнхийдөө түүний талд байв.

Аминчийн хоёр жилийн сонгуулыг хугацаа дуусах дөхөж, шинэ сонгууль ойртсон байлаа. Тэгээд араа бодсон Аминч Энделийн сургуульд хувиасаа таван мянган итгэмжлэл хандивлаад, сургууль барих өөр тохиромжтой газар олж өгөхөө амлав. Үүгээрээ ч Жэйлиний олон дагалдагч нарын итгэлийг эргүүлж олжээ. Тэгээд ч энэ залуу удирдагч хоёр дахь удаагаа ч ядах юмгүй сонгогдохоор харагдаж байв.


Рестораны эзэн

Өгөөмөр төгсөхдөө, багш нартаа талархан хорин таван мянган итгэмжлэлийнхээ гурван мянгыг нь сургуулийнхаа талбайг засахад зориулж хандивлаад, үлдсэн хорин хоёр мянгаар нь ресторан нээжээ.

Өгөөмөр хоол хийх үнэн дуртай байв. Дээрээс нь бизнес сэтгэлгээтэй учраас Өгөөмөрийн хувьд бэлэг авъяасаараа нийгэмдээ үйлчлэх хамгийн сайн арга зам нь рестораны бизнес болж таарав. Тэгээд тэр газрын хамгийн алдартай тогооч нарыг хөлслөх чадалтай болжээ. Хоолны талаарх мэдлэгээ ашиглан, шилдэг цэс гаргав. Ресторан нь ч тэр даруй алдаршжээ.

Өгөөмөр ресторанаараа шагнал авсан ч, алдар гавьяаг нь Жэйлиний цэц ухаанд л өргөдөг байв. Тэрбээр зурагтын нэвтрүүлэгт орохдоо, ямагт багш нартаа талархаж, ажилчдаа магтан сайшаана. Тэр өөрийгөө магтаж, амжилтаараа онгирахыг тэвчихгүй. Энэ бүхэн Жэйлиний ач гавьяа гэдгийг Өгөөмөр сайн мэднэ.

Өгөөмөр баялгаараа нийгэмдээ бас сургуульдаа байнга тусладаг байв. Сургуулийнхаа цайны газрыг ч хоол хүнсээр хангана. Харин оройн цагаар ядуу зүдүү хүмүүсийг үнэгүй халуун хоолоор дайлна. Өгөөмөр рестораныхаа хорин таван хувийг сургуульдаа хандивлахаар шийдсэн байв. Таван жилийн эцэст тэрбээр хоёр зуун мянган итгэмжлэлтэй болсон байлаа.



Өгөөмөр ямагт хичээнгүй хөдөлмөрлөж, ядарсан зүдэрсэн хүмүүст тусладаг байв. Мөнгөөр туслахаас гадна Жэйлиний цэц ухаан, амжилтын зарчмаас байнга хуваалцана. Тэрбээр Жэйлиний ачаар л өдий хүрснээ тус хүргэж байгаа хүмүүстээ байнга хэлнэ.

Өгөөмөрийн ресторан амжилттай байсан ч, Аминч түүнийг гэртээ зохиодог хүлээн авалтдаа хэзээ ч урьсангүй. Өгөөмөр нийгэмд ч удирдан манлайлсангүй. Хүмүүс түүнийг Жэйлиний улаан фэн гэж үздэг байв. Гэхдээ энэ нь Өгөөмөрийн урмыг хугалж, сааруулсангүй. Тэрбээр чадуу буурай хүмүүст тусласаар л байлаа. Тэрбээр сургуулийнхаа долоо хоног тутмын уулзалтад тогтмол очиж бас сайн санааны үйлсэд дуртайяа оролцдог байв. Өгөөмөр тун амжилттай бүсгүй болжээ.

Шүүх өдөр


Шалгалтын эцсийн өдөр ирэв. Шүүгдэхээ мэдэж байсан хүмүүс таван жил нь хэдийнээ өнгөрсөн учраас, дараагийн таван жилдээ багтаж шүүгдэхээ мэдэж байсан ч, ийм хурдан болчих юм чинээ хэн ч санасангүй.

Тэр өдөр жирийн л нэг өдөр шиг эхлэсэн ч, тэс өөрөөр төгсжээ. Шөнө дүлээр Аффабелийн хааны харуулууд хоёр мянган төгсөгчийг шүүрээд аваад явжээ. Энэ нууц ажиллагаа бусад бүх Энделчүүдийг унтаж байх хойгуур болов.

Тэдгээр хоёр мянган залуусыг Адонга мөрөн доогуурх нүхэн гарцаар гаргаад, нүцгэн цөл дээгүүр дахин хоёр хоног аялав. Аялалын хугацаанд тэргүүн харуул тэдний хоол хүнс, унд тэргүүтэй бүх хэрэгцээг хангаж явлаа.

Харуулууд эелдэг боловч дуугүй байв. Тэд даалгавар дээрээ л анхаарч байлаа. Хэдийгээр тэд зарим асуултад хариулах боловч, заримд нь хариулахаас татгалзаад: “Цаг нь болохоор мэдэгдэнэ” гэхээс өөр юм хэлсэнгүй. Гэвч энэ нь аялагчдын сониуч занг бүр л ихээр хөдөлгөнө.

Энделчүүд олон жил хүсэн хүлээсэн Аффабел хот руугаа явж байхдаа цөлийн хүнд бэрхийг мэдэрсэн ч үгүй. Гурав дахь өдрийн үүр цайхад, тэд уулан дээр газардав. Тэндээс өглөөний нарны цацрагууд шидэт хотын дүрсийг сийлэн харуулж байлаа. Аффабел тэдний бодсоноос ч сүрлэг ажээ.



Хотод ойртох тусам, гайхамшигт төрх нь улам л тодрон тодорсоор байлаа. Тэдний зогсож байгаа талаас ч Аффабел нь юутай ч эгнэшгүй үзэгдэнэ. Эндэл нь энэ их хотын захын дүүргээс ч өчүүхэн ажээ.

Энделийн залуус хотын төв рүү ороод, Аффабелийн бүх зүйл нь гайхмаар амьд болохыг мэджээ. Шувууд нь жиргэдэг биш, харин ярьдаг шидэт газар! Гайхамшигт уянгалаг жиргээгээрээ тэд энэ хотын гоо үзэсгэлэнг магтан алдаршуулдаг ажээ.

Гэхдээ хааны харуулуудын ярьдаг морьдыг хэдийн харсан Эндэлчүүд үүнд нэг их гайхсангүй. Тэдгээр шидэт морьд нь өөр хоорондоо төдийгүй, эзэдтэйгээ ч ярих юм гэнэ. Морь эзэн хоёр салшгүй үнэнч нөхөд ажээ. Аффабелийн бүх амьтад ярих, дотносох, баярлах чадвартай нь өдгөө илэрхий болжээ.


Залуу Эндэлчүүд харсан зүг бүртээ уулга алдам харшуудыг үзэв. Үнэндээ тэд Аффабелийг шүүрс алдан бишрэхээс өөр яаж ч чадсангүй. Агаар нь л гэхэд сэргээмээр - хүний оюун санааг шинэтгэн, эцэж ядарсан биеийг нь тэнхрүүлэм шидтэй. Хотыг сүлжин мяралзах ус нь тэднийг бас л гайхшруулаад авав. Учир нь тэр ус амьд мэт биетэй ажээ. Агаарт шидэт эгшиг хөвөлзөж, баяссан сэтгэлийг дүүрэн, дүүрэн амар амгалангаар тайвшруулна. Өдийхэн ургамлаас авахуулаад агаар хүртэл - бүх зүйл нь амьд мэт, амьдрал өгөх чадвартай мэт харагдана. Энэ шидэт газрын эд эс бүр нь халгин цалгиж байв.

Залуус аугаа хотын гудмаар алхангаа, гар хуруугаа сунган тааралдсан бүхнээ барьж илбэж үзнэ. Ийшээ тийшээ зоргоороо гүйлдмээр байвч, яг одоогоор ингэж болохгүй гэдгийг мэдэж байв.

Харуулууд Эндэлчүүдийг дагуулсаар нүсэр том хүлээлгийн танхимд оруулаад эр, эмээр нь тусгаарлав. Тэр нь нэг захаас нөгөө зах нь үзэгдэхээргүй цэлгэр том байшин ажээ. Гантиган хананууд нь хэдэн зуун мянган хүнийг өлхөн багтаахих зайтай юмсанж.

Хүлээлгийн хэсэгт Эндэлчүүдийг хаантай уулзахад нь бэлтгэн анхилам усанд угаал үйлдүүлж, нөмрөг өмсгөв. Тэд Энделийн тоостой хувцсаа дуртайяа тайлж хаялаа. Хуучин хувцас нь тэр үзэсгэлэнт хотод огт тохирохгүй, навсгар байв. Аффабелд амьдрах гэсэн Эндэл хүн бүрийн амин хүсэл нь хувцас болон нэхэгджээ. Тэдэнд яг л гэртээ ирчихсэн мэт санагдаж байв.

Усанд орж, хувцасласны дараа эрчүүд эмэгтэйчүүдийг дахин нийлүүлээд, зоог бариулав. Тийнхүү тэд тансаг саруул танхимд



идэж ууж, нөхөрлөв. Зоогийн дараа Эндэлчүүдийг дахин тусгаарласан бөгөөд энэ удаа нэрсээр нь тусгаарлажээ. Өгөөмөр, Аминч тэргүүтэй таван зуу гаруй залууг баруун танхимд оруулав. Харин Бүрэг, Мэхлэгдэгч, Бие даагчийг үлдсэн мянга таван зуун залуугийн хамт зүүн танхимд оруулав. Танхим бүрийн дээр нэр сийлээтэй байхыг залуус анзаарчээ. Тэдгээр нь Эндэлчүүдийн мэдэхгүй хэлээр бичигдсэн, сонин нэрс байлаа. Баруун танхимыг Амийн танхим, зүүн танхимыг Шударга ёсны танхим гэх ажээ.

Шударга ёсны хийгээд Амийн танхим

Зүүн танхимд орохдоо Бие даагч ихэд тавгүйтэж, бараг л үхэнгээ алдаж байлаа. Тэрбээр сургуульдаа Жэйлиний талаар хагас хугас сонссон зүйлээрээ өөрийгөө тайвшруулах гэж оролдов ч, хий манарахаас өөр юу ч орж ирсэнгүй. Дэмий л сургуулиа тоогоогүйдээ харуусна.

Мэдээж түүний буруу байж. Жэйлин ч, хот нь ч жинхэнэ ажээ. Тэрбээр юу юугүй залгих гэж байгаа айдсаа даран, Жэйлин бол өршөөнгүй, нигүүлсэнгүй, хайрын хаан гэдгийг л санахыг хичээнэ. Бие даагч зогсоо зайгүй зулгааж байгаа Жэйлиний шүүгч, ариун чанарыг бодохыг ч хүссэнгүй. Тэр нийгмийнхээ сайн үйлсийг дэмждэг сайн иргэн байснаа санаад, өөрийгөө дахин тайтгаруулах гэж оролдлоо.

Бие даагч гүн амьсгал аваад, хамт байгаа хүмүүсээ харав. Энделийн хамгийн адгийн хүмүүстэй байгаагаа анзааралгүй өнгөрч чадсангүй. Хулгайч зэлгийч, залилагч, архичид. Тэнд нэг бол бараг ажил хийдэггүй эсвэл өөрийнхөө төлөө л ажилладаг хүмүүс дүүрэн байв. Бие даагч улам айж, бачуурч унахын даваан дээр Бүрэгийг олж харах нь тэр. Тэгээд сая нэг юм нүдээ анин, амьсгаа дарав. Бие даагч Бүрэгийг Жэйлинийг дагадаг, ангийнхаа хамгийн гавшгайч, идэвхитэй охин байсныг саналаа. Тэгээд сургуульдаа багшилсан гэдгийг нь ч сонссон. Тиймээс Бүрэг түүнтэй нэг танхимд байгаа нь сайны дохио байлаа.

Бие даагч Бүрэг рүү очих гэтэл Мэхлэгдэгчийг мөргөчихөв. Энэ ч бас сайн мэдээ! Бие даагч хэдийгээр Бүрэгтэй холбоо тасарсан ч, Мэхлэгдэгчийг хүчтэй итгэгч гэдгийг сайн мэдэж байлаа. Тэр хоёр Жэйлиний талаар зөндөө маргалддаг байсан ч,

Бие даагч хуучин найзаа хараад сэтгэл онгойв.

Дуу шуутай, өөдрөг Мэхлэгдэгчтэй хөөрөлдөх зуураа Бие даагчийн айдас аажмаар сарниж байлаа. Жэйлиний өршөөл тэдний бодсоноос ч том ажээ. Энэ бүхнийг Бие даагч хэзээ ч төсөөлж, итгэж явсангүй. Тэдний алдарт багш Дүр эсгэгч ч тэднээс холгүй зогсоо харагдана. Тэгээд Бие даагч бүх зүйл сайн сайхан болно гэдэгт итгэж эхлэсэн ч, Өгөөмөр, Аминч хоёр харагдахгүй байгаад жаахан зовниж байлаа. Түүнчлэн тэрбээр зарим хүн өрөөний буланд суугаад уйлж байгааг анзаарахгүй өнгөрч чадсангүй. Гэхдээ магадгүй тэд Жэйлиний сайн сайханд баярласандаа уйлж ч байгаа юм билүү, хэн мэдлээ?

Нөгөө танхимынхан ч бөөн хөл хөөрцөг болж байлаа. Төгсөлтөөс хойш уулзаагүй найз нөхөд уулзалдан баярлана. Бүгд л Жэйлинтэй учрах гэж байгаадаа догдлоно! Тэдний хувьд жинхэнэ зорилго, амласан хувь тавиландаа хөл тавин орох цаг нь иржээ.


Бүгд л гайхамшигт хотын талаар шаагилдана. Тэд Аффабелийг Энделээс сайхан газар гэдгийг мэдэж байсан ч, ийм сайхан байх юм чинээ санасангүй. Ийм сүр жавхлантай газар насан турш амьдарна гэдэгтэй итгэж ядмаар. Ийм газрын цэвэрлэгч нь байсан ч яахав. Энэ танхимд байгаа хүн болгон Жэйлинийг дагаснаа мэдэж байсан ч, цаг явах тусам амьдралаа улам л нухацтай эргэцүүлнэ. Тэд үнэхээр итгэмжтэй байлуу? Удахгүй бүх зүйл тайлагдана. Тэд хаанаа хүлээх зуураа айх догдлох хослон байв.

Эхлээд Амийн танхимынхан шүүгдэнэ. Гэхдээ бүгдээрээ эхлээд Шударга ёсны танхимын талаар үзээд, дараа нь Амийн танхимынханы түүхийг үзье.

Дуудагдсан нь

Их үд. Шударга ёсны танхимынхан нэг үеэ бодвол тайвширцааж, бүх зүйл сайхан болно гэдэгт итгэнэ. Тэд эргэлзээтэй эсвэл мэдэхгүй зүйлсээ таягдаж хаяад, Жэйлиний нигүүлсэлд найдан, тайвширчээ.

Мянга таван зуун Энделчүүдээс хамгийн түрүүнд Бие даагч дуудагдав. Хааны дөрвөн харуул Бие даагчийг Аугаа их шүүх танхим руу дагууллаа. Бие даагч айдсаа нуухын тулд танхимаас гарахдаа өөртэй нь харц тулгарсан харуул руу инээмсэглэн, нүдээ ирмэсэн ч, харуул түүнийг огт тоогоогүйд гайхав.



Араас нь танхимын хаалга хаагдмагц, Бие даагчийг дахин мөнөөх түмэн бодол нь нөмөрч аван, зүрх нь бөмбөр шиг дэлдэж эхлэв. Бүр харуулуудад ч сонсогдохоор чанга байсан тул, Бие даагч тэднээс зовлоо. Гэхдээ харуулууд сонссон ч, тоосонгүй. Бие даагч Мэхлэгдэгчийг дэргэдээ байсан ч болоосой гэж бодно. Тэр шүүхийн өмнө ганцаараа зогсохыг хүссэнгүй. Бие даагчийн итгэлтэй байдал үтэр түргэн үхэж байв.

Аугаа их танхимд орохоос өмнө нэг харуул нь Бие даагчийг шүүх хурлын протоколтой товч танилцуулав. Гэхдээ Бие даагч юу хэлээд байгааг нь ч ойлгох тэнхэлгүй, дэмий л толгой дохино. Судасных лугшилт чихнийх нь хэнгэргийг хагалах нь уу гэлтэй хүчтэй дэлдэнэ. Бие даагч шүүхийн үйл явцтай танилцаж дуусмагц, Шүүх танхимын хаалга нээгдэв.

Бие даагч бэмбэгнэн чичирсээр, нүсэр том танхимын босгыг давлаа. Түүний мөнөөх зангирсан ихэмсэг хөмсгөөр нь бөөн бөөн хөлс бөнжигнөж, ухаан нь балартаж, муурч унахын даваан дээр байв!

АФФАБЕЛ ХЭМЭЭХ ХААНЧЛАЛ: ШҮҮХИЙН ЭХНИЙ ОДОГ

Есүс хурсан олонд сургаалт зүйрлэлээр энэ бүхнийг айлдсан бөгөөд сургаалт зүйрлэлгүйгээр юуг ч тэдэнд ярьсангүй. Энэ нь эш үзүүлэгчээр хэлүүлсэн нь биелэгдэхийн тулд бөгөөд ингэхдээ «Би сургаалт зүйрлэлээр амаа нээнэ. Би ертөнцийн сууриас эхлэн Нууцлагдсан зүйлсийг хэлнэ» гэсэн байна.

— Матай 13:34-35


Түүхээ үргэлжлүүлэхээсээ өмнө айсуу шүүхийн талаар хэлсэн Есүсийн Өөрийнх нь үгийг цохон тэмдэглэмээр байна. Иохан 12:48 дээр Есүс “Намайг голж, үгийг минь хүлээж эс авагчийг шүүх шүүгч бий. Хэлсэн үг минь эцсийн өдөрт түүнийг шүүнэ” гэж мэдэгджээ. Тэгэхээр, бид Түүний сэнтийн өмнө Ариун Бичээс хэмээх ганц жишгээр шүүгдэх ажээ.

Иймээс одоо гарах Шүүхийн үйл явц дунд Жэйлиний айлдах үг бүрийг индексээр тэмдэглэсэн байгаа. Тэдгээр индекс нь янз бүрийн орчуулгаас авсан Бичээсийг төлөөлөх бөгөөд аль бичээсийн ямар ишлэл болохыг нь номынхоо арын хуудсаас олж болно. Жэйлиний дийлэнх үг нь гол дүрүүдийнхээ нөхцөлд нийцүүлэн сонгож авсан Бичээсийн хэсгүүд болно.

За үүнийг мэдсэн болохоор одоо эргээд Аффабелдээ орьё.

Бие даагч шүүгдсэн нь

Аугаа их танхим нь Бие даагчийн бодсонтой зүйрлэшгүй гайхам байв. Хэрэв Бие даагчид нөгөө үлдсэн мянга таван зуун хүндээ



энэ танхимыг дүрслэн өгүүлэх завшаан олдсон бол, тэрбээр үүний сүр барааг юу гэж тайлбарлахаа мэдэхгүй, дэмий л ээрэх байлаа. Учир нь энэ барилгыг бараадах архитектур Энделд нэг ч байхгүй. Танхимд зуун мянгаад хүн суужээ. Бие даагч нэгэн зэрэг ийм олон хүнийг хэзээ ч үзээгүй юмсанж.

Бие даагч урагш алхалж явахдаа, Аффабелийн иргэдийн зүс царайг сэм ажиглалал, гэрэлтсэн тунгалаг царайтай, язгууртан төрхтэй улс байв. Бие даагч тэдний ер бусын гоо үзэсгэлэнд татуулаад авах шиг л цочив. Яг л өөр ертөнцөөс ирсэн улс шиг! Гэтэл тэд амийн модны жимснээс хүртсэндээ ийнхүү өөрчлөгдсөн байв.

Бие даагч: “Эд нар үнэхээр Энделчүүд гэж үү?” хэмээн бодно. Гэтэл түүний нүдэнд нэгэн танил царай тусав. Түүний нэрийг Сайнаа гэх. Сайнаа Бие даагчаас эгч бөгөөд царай муутайгаасаа болж байнга л адлагддаг байжээ. Гэтэл одоо хачин гоё хүүхэн болжээ. Царай зүс нь танигдах атлаа Энделийн ямар ч хүнээс илүү хөөрхөн болчихсон харагдана. Үнэндээ Бие даагчийн харсан хүн болгон - бүр хамгийн царай муутай нь ч Энделийн хамгийн царайлаг хүнээс ч гоо ажээ.


Бие даагч анхныхаа цочирлоос гарсныхаа дараа тэнд зогсох бүх хүн урагшаа хараад байгааг анзаарав. Тэгээд үгээр хэлж, үзгээр бичихийн аргагүй үзэгдэл олж харжээ.

Тэр нь сэнтий байлаа. Гэхдээ дүрслэн өгүүлэхийн аргагүй сүр жавхлантай сэнтий! Бие даагч сэнтий дээр залран суугаа нэгэнээс хараа салгаж чадсангүй. Тэгээд тэрхэн эгшинд сэнтийд залран суугаа тэр хүний нөлөөгөөр л Аффабел тийм сүр жавхлантай байгааг ухаарчээ. Бие даагч дотроо “Жэйлин!” гэж хэлэв. Тэгснээ нэг нүдээрээ ч үздэггүй байсан нэгэндээ учир зүггүй итгэчихэв.

Жэйлин маш гоо үзэсгэлэнтэй боловч, яг тэр эгшинд төмөр нүүрээ харуулжээ. Гайхамшигтай бөгөөд аймшигтай гэвэл зохино. Бие даагч Жэйлиний дүр төрхөд татагдаж байсан ч, ойргом тусам зүрх нь үхэж байв. Түүний нөгөө омог бардам зан юу ч үгүй үйрчээ. Одоо тэр яана аа?

Бие даагч Жэйлинийг өршөөнгүй удирдагч гэдгийг өөртөө ахин дахин сануулж, тайван байхыг хичээсэн ч, тийм ч таатай шийдвэр сонсохгүй гэдгээ мэдрэн, баахан зөрчилдөнө.

Бие даагч урагш дөхсөөр, нэгэн нарийн тавцан дээр гарч зогсох тушаал сонсов. Сэнтий дээрээс Жэйлин түүн рүү харна. Тэрбээр



зорилгодоо шийдэмгий бөгөөд олонд хандан ийн айлдруун: “Би болбоос тархийг (бодол, мэдрэмж, зорилгыг) хийгээд зүрхний цөмийг өвчдөг нэгэн бөгөөд хүн бүрт үйлдлийнх нь дагуу зохих ёсоор нь (үйлсийнх нь шагналыг) төлнө.”¹

Бие даагч бусдынхаа хамт Жэйлиний айдварыг сонсож байтал, Жэйлин гэнэт түүний нүд рүү эгц хараад: “Одоо чи нярвынхаа ажлыг тайлагна”² хэмээн тушаав.

Бие даагч золтой л харвачихсангүй. Гэтэл гэнэт холограм дүрс тодроод, Бие даагчийн Эндед дэхь сургуулийн анхны өдрөөс авахуулаад өчигдөр хүртэлх амьдралынх нь дүрсийг тоглуулж эхлэв. Тэр олон гэрч нарын өмнө Бие даагчийн үйлс, үг, сэдэл бүр харагдав. Бие даагч “Жэйлиний мэлмийгээс нуугдах бүтээл гэж үгүй бөгөөд Түүний мэлмийн өмнө алган дээр тавьсан мэт хаалтгүй, нүцгэн, ил тод бөгөөд Түүнээс хамааралтай буюу”³ гэдэг илчлэл нь үнэхээр үнэн болохыг үзээд зүрх үхлээ.

Бие даагч өөрийнхөө мунхаг, ёрын муу, аминч амьдралыг хараад айв. Олны өмнө ийм байдалд орсон нь Бие даагчийн хувьд санаанд оромгүй, ичгүүртэй, цочирдом байв. Эндедд үл тоогдох юмс нь энэхүү сүр жавхлантай шүүгчийн өмнө, Аффабелийн язгууртнуудын өмнө ой гутам байлаа. Бие даагч үйлдлээсээ эмээв. Яаж ийм жолоогүй, шийдчихсэн, тэнэг байж чадав аа? Гэхдээ Бие даагч дотроо онгичсоор онгичсоор нэгэн найдвар олж харав - тэрбээр муугаасаа илүү сайныг үйлдсэн санагджээ.

Амьдралынх нь дүрс тоглогдож дуусмагц, Бие даагч их бага хэмжээний зэмлэл, шийтгэл хүлээхээ мэдэрсэн ч, жаахан уужраад байлаа. Түүний хувьд Аффабелд л орчихбол, хамаг хэрэг нь бүтнэ. Жэйлин түүний сайн үйлсийг харгалзах байлгүй дээ.

Тэгтэл Жэйлин Бичээчээсээ: “Бие даагчийн нэр Амийн номд байна уу?” гэж асуув.

Гэтэл Бичээч шууд л: “Байхгүй, эзэнтээн” гэлээ.

Тэгтэл Жэйлин: “Бие даагч чамд муу ёрын мөн чанараар амьдарсан гэдэг ял тулгав. Чи ганц хэмээх хөсөр газар цөлөгдөж, насаараа итгэл найдваргүй, тас харанхуй ганцаардалд тамлагдаж амьдарна” хэмээн айлдах нь тэр.

Нус нулимстайгаа хутгалдсан Бие даагч: “Яагаад эзэн?” гэж асуув.

“Чи Надад итгээгүй. Би бол Тэр гэдэгт итгээгүй хүн нүгэлдээ

үхэж дуусна гэж багш нар чинь чамд заасан”⁴ Түүнчлэн тэд “Авралд хүргэх цорын ганц нэрээс өөр нэр тэнгэрийн дор хүмүүст өгөгдөөгүй болой”⁵ гэж заасан.

Бие даагч өөдөөс нь: “Гэхдээ Эзэн Жэйлин минь, миний сайн үйлс яах болж байна аа? Сайн үйлс маань муугаас минь жинтэй бус уу?” гэв.

Харин Эзэн Жэйлин: “Хуулийг их бага зөрчих нь огт ялгаагүй. Жэйлиний бүх хуулийг сахидаг хүн ганц л хуулийг зөрчихөд бүх хуулийг зөрчсөн хүнтэй яг ижилхэн болно”⁶ гэлээ.


Бие даагч зүрхээ чангалан: “Тэгвэл хэн аврагдаж чадах уу?” гэж асуув.

Жэйлин энэ асуултад шууд хариулалгүй, Аффабелийн нэгэн эмэгтэй иргэн рүү дохилоо. Тэрбээр Жэйлиний дэд захирагч болтой. Учир нь тэрбээр Жэйлинийхтэй адил боловч, арай жижиг сэнтийд сууж байв. Тэгээд эмэгтэй ингэж яриу: “Багш нар чинь чамд заагаагүй гэж үү? Жэйлин чамайг итгэхэд чинь онцгой тааллаараа аварсан. Харин чи үүнийг нь ойшоогоогүй. Энэ бол Жэйлиний бэлэг байсан. Аврал бол буян хийсний шагнал биш. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхаж чадахгүй.”⁷

Ингэмэгц Жэйлин түүний араас: “Эртээ урьд би Энделийн иргэдийн хуулийг зөрчсөн нүгэл бүрийн төлөөсийг төлсөн. Миний өмнө нүгэлгүй байж чадах эсвэл өөрийгөө зөрчлөөс авран сэргээж чадах нэг ч хүн байгаагүй. Гэхдээ би та нарт хайртай учраас та нарын өрийг өөрийн биеэр төлсөн юм. Тиймээс Миний аврал нь юугаар ч олж авашгүй бэлэг юм. Аффабелийн иргэний эрхийг сайн үйлсээр олж авах боломжгүй байсан. Гагцхүү надад итгэсэн хүн л энэ эрхийг авна. Би чамайг аварсаар байтал чи намайг няцаасан” хэмээн айлдав.

Хэлэх үггүй болсон Бие даагч хэсэг чимээгүй байснаа: “Тийм байх нь ээ” гэж бувтналаа. Тэр юу юугүй цөхрөлийн гүн ангалд хаягдах гэж байгаагаа мэдрэн, зуурчих юм олж ядан: “Тэгвэл миний хийсэн буян юу ч биш юм гэж үү?” хэмээн санаашрав.

Жэйлин түүнд: “Үхсэн нь юу ч мэдэхгүй. Тэдэнд ямар ч шагнал байхгүй, тэд дурсагдах ч үгүй хэмээн бичигдсэн байдаг. Амьдралдаа хийсэн бүхэн нь, хайрласан, үзэн ядсан, атаархсан бүхэн нь хэрэггүй болсон. Тэд юуны ч хэсэг биш болсон.”⁸ Учир нь муу ёрд ирээдүй байхгүй. Тэдний гэрэл үлээгдэнэ”⁹ хэмээн айлдлаа.



Жэйлиний үгд цочирдсон Бие даагчид хэлэх юм байсангүй. Тэр хичээлээ тасласандаа харамслаа. Хичээлээ сурсан бол, үнэнийг сонсоод, энэ аймшигт алдаанаас сэргийлж болох байжээ.

Гэтэл гэнэт Бие даагчид нэгэн бодол харван орж ирсэн нь түүнийг өдөржин тайтгаруулсан мөнөөх бодол байлаа. Тиймээс Бие даагч дахин зориг ороод: “Тийм ээ, Таны зөв. Гэхдээ Жэйлин хаан минь, та бол нигүүлсэнгүй хаан! Та нигүүлсэнгүй байж яаж намайг цөлөх билээ?” гэлээ.


Жэйлин түүнд: “Тийм ээ, би нигүүлсэнгүй хаан. Тиймээс л би чамайг цөлж байна. Чи Эндед дэхь замаараа амьдрахаар шийдэхдээ, харанхуйн хар санаат эзэн Дагоны мөн чанарыг нэг мөр сонгосон. Би чиний ёс бус зан чанараар энэ аугаа хотын цэвэр байдлыг бузарлуулахыг зөвшөөрбөл, яаж нигүүлсэнгүй, үнэн байж чадах билээ. Би Аффабелийн ариун байдалд хор уршиг учруулна. Чиний сонгосон мөн чанар удалгүй дахин ил гарч, тийнхүү мянга мянган цэвэр амьдралыг устгах байсан. Чи өөрөө амьдрах замаа сонгосон. Тийнхүү чи дагахаар шийдсэн Дагонтайгаа яг адилхан шийтгүүлнэ. Хэрэв би чамд Дагонд хандснаасаа зөөлөн хандбал, Би өөрөө шударга бус удирдагч болно. Харин би тийм биш!” гэж хариулжээ.

Дараа нь Жэйлин бүх хүмүүст хандан аавынхаа эртний бичээсээс иш татав. “Бичээст үгийг жигшсэн нэгэн нь устгагдана. Харин тушаалаас эмээсэн нэгэн нь шагнуулна” гэдэг¹⁰ гэлээ.

Үүний дараа нөгөө аймшигт үйл явдал болов. Хаан зарц нартаа: “Түүний гар хөлийг хүлээд, гадаад харанхуйд аваачиж хая. Тэр тэнд уйлж шүдээ хавираг. Учир нь олон хүн дуудагдсан ч, цөөн хүн сонгогдсон”¹¹ хэмээн айлдлаа.

Харуул Бие даагчийг хүлж, танхимын хажуугийн хаалга руу авч явахад, Бие даагч аймаар муухай тарчлан бархирав. Тэнд байсан мянган мянган хүн ширхэг ч чимээ гаргасангүй. Тэд амьдралаа ухаангүй цалгардуулсан нэгэний мөнхийн шийтгэлийг гунигтай харж зогсоно.

Бие даагчийг байшингаас гаргаад, өөр нэгэн том хүлээлгийн өрөөнд оруулав. Тэнд цөлөгдсөн хүмүүсийн ялыг гүйцэтгэхээсээ өмнө хорьдог, мянга мянган жижиг, төмөр торнууд байна. Торны хаалган дээр ингэж бичжээ:



Түүний тушаалыг үйлдэгсэд ерөөлтэй еэ. Тэд амийн модонд хүрэх эрх олж, хотын хаалгаар орно. Харин гадна нь нохой, ховсдогч нар, бэлгийн донтнууд, алуурчид, шүтээнд мөргөгчид тэргүүтэй худал хуурмагийг хайрлаж, үйлдэгсэд байна.¹²

Бие даагч тэр үгийг гөлрөв. Түүний дотор хилэн буцлав. Яг энэ эгшинд тэрбээр өөрийнхөө сонгосон муу ёрын мөн чанартаа бүрэн эзлэгдэж, муу ёрын мөн чанар нь түүнд байсан бүх сайн сайхан чанарыг залгижээ. Эгшин зуур Бие даагч яг л галзуу нохой шиг болов. Одоо хааны нөлөө байхгүй болсон болохоор Бие даагч ямар ч авралгүй, нэг мөр сүйрчээ.


Мэхлэгдэгч Жэйлиний өмнө

Олон цаг өнгөрч, Шударга ёсны танхимаас олон ч хүн дуудагдав. Харин ээлжээ хүлээн суугаа хэдэн зуун хүний дунд Мэхлэгдэгч, Бүрэг, Дүр эсгэгч гурав байна. Хэзээ ёзооны өөдрөг Мэхлэгдэгч бусаддаа их найдвар төрүүлж байлаа.

Хаалга нээгдэж, хааны дөрвөн харуул дахин гарч ирээд, энэ удаа Мэхлэгдэгчийг дуудах нь тэр. Мэхлэгдэгч пал хийгээд л явчихав. Түүний цаг иржээ. Тэрбээр сандарснаа нуухын тулд сурсан зангаараа: “За залуус аа, миний ээлж ирэх шив!” гэлээ.

Мэхлэгдэгч протоколтой товч танилцаад, Шүүх танхимын хаалгаар нэвтэрч, гол гарцаар сэнтий рүү дагалдан алхлаа. Мэхлэгдэгч яг л Бие даагч шиг зүйлийг мэдрэв. Тэр ч бас танхимын хэмжээ, гоо үзэсгэлэнг бишрэн, иргэдийнх нь хөөрхөн сайхныг гайхлаа. Тэрбээр танхимын голоор алхаж явахдаа, Энделийн сургуулийг өөрөөс нь ганц хоёр жилийн өмнө төгссөн таньдаг царайнуудыг харав. Мэхлэгдэгч Бие даагчийг бодвол сургуулийнхаа уулзалтыг хэзээ ч тасладаггүй байсан учраас, тэр дундаас нилээд олон хүнийг таньж байв.

Тэр дунд Мэхлэгдэгчийн сайн мэдэх нэгэн хүн харагдсан нь Энделийн сургуульд хэзээ ч сурч байгаагүй Ёсбус гэгч байв. Ёсбус нийгмийн хог шаар болсон хүмүүсийн нэг байжээ. Нүд нь орой дээрээ гарсан Мэхлэгдэгч: “Тэр энд юу хийжаагаан?” гэж бодлоо. Хааны харуул Мэхлэгдэгчид Ёсбустай ярьж болно гэсэн дохио өгөв.



Мэхлэгдэгч Ёсбус дээр очоод: “Чи чинь Ёсбус уу даа?” гэлээ.

Нөгөө хүн: “Би өмнө Ёсбус байлаа. Харин Жэйлин эзэн миний нэрийг Эвлэрэл болгосон” гэв.

Гэтэл Мэхлэгдэгч өөдөөс нь шууд л: “Чи энд яаж ороов? Чи чинь манай хотын хэцүүхэн хүний л нэг байсан шүү дээ. Сургуульд ч хэзээ ч сураагүй. Жэйлинийг ч хэн хэнээс илүү эсэргүүцдэг байсан” гэж тулгалаа.

Харин Ёсбус: “Тэр үнэн. Гэхдээ үнэндээ бол би өөрийгөө, өөрийнхөө хийснийг үзэн яддаг байсан юм. Би сургуульд сураагүй учраас эртний бичээсийн талаар, Жэйлиний өгдөг амьдралын тухай хэзээ ч сонсоогүй. Гэтэл нэг удаа Өгөөмөрийн ресторанд үнэгүй хоол идсийм. Тэр үед долоохон хоногийн дараа шүүгдэнэ чинээ санаагүй юм. Өгөөмөр миний зовлонг мэджээ. Тэгээд надтай нэг зүйлийн талаар ярина гэсэн болзолтойгоор үнэгүй хоолоор дайлсан. Өгөөмөр надад Жэйлиний талаар, түүний сайн сайхан, аврал, Аффабел гэдэг энэ газрын талаар бүтэн хоёр цаг ярьсан” гэж хариуллаа.

Дараа нь Эвлэрэл: “Өгөөмөр надад Жэйлинд амьдралаа өргөхөд хэзээ ч оройтохгүй, ямар ч болзолгүйгээр уучлагдаж, Жэйлиний хаанчлалын иргэн болж болно гэсэн. Жэйлиний хайр намайг хайлуулж, тэгээд би үлдсэн бүх амьдралаа түүний эрх мэдэлд өргөсөн юм. Эндэлд би Жэйлинд долоохон хоног үйлчилсэн ч, үүнийгээ үнэн голоосоо хийсэн. Дарамтлаж дээрэмдсэн хүмүүс дээрээ очоод, өршөөл уучлал гуйж, авснаасаа ихийг эргүүлж төлсөн” гэлээ.

Мэхлэгдэгч хэлэх үггүй болов. Тэр харуул руу хартал, харуул түүнд зөвшөөрөл олгон дохив. Эвлэрэл буцаад байрандаа орж, Мэхлэгдэгч сэнтий рүү үргэлжлүүлэн алхлаа.

Мэхлэгдэгч саяын яриаг бодсоор явав. Тэр Жэйлиний өршөөлийг мэддэг ч, арай ч ийм өршөөнгүй гэж санаагүй ажээ. Саяын хүн чинь түүний мэдэх хамгийн адгийн хүн шүү дээ. Гэтэл одоо язгууртан болчихсон явж байдаг. Тиймээс Мэхлэгдэгч өөрийгөө Жэйлинд тийм бат итгэдэг юм чинь, гарцаагүй ерөөгдөнө гэдэгтээ уламчиг итгэв.

Мэхлэгдэгч сэнтийн өмнө очоод Бие даагчтай адилхан “Нярвнхаа ажлыг тайлагна” гэдэг тушаал сонсов.

Тэгээд сургуулийнхаа эхний өдрөөс өчигдөр хүртэлх

Энделийнхээ амьдралыг холограм дүрсээр үзэв. Сургуульдаа итгэмжтэй явж, олны өмнө Жэйлинд хайртайгаа зарлаж байгаагаа харах үнэхээрийн баяр бахдалтай байлаа.

Гэхдээ төдөлгүй Мэхлэгдэгчийн дотор харанхуйлав. Тэр үнэхээр жигшмээр амьдарчээ. Мэхлэгдэгч өөрийнхөө амьдралыг зад өмөөрдөг байсан ч, Жэйлин хэмээх шидтэй шүүгчийн өмнө бас цэвэр ёс суртахуунтай язгууртан гэрч нарын өмнө хормой хотынх нь явдал ил болох үед Мэхлэгдэгч нүүр хийх газаргүй болж, нүхэнд шургамаар санагдлаа.

Түүний үйлдэл төдийгүй, сэдэл ч ил болов. Жэйлин яаж эдгээрийг мэдэв ээ? Тэр яаж хэний ч мэдэхгүй зүйлсээр Мэхлэгдэгчийг шүүдэг байна аа? Мэхлэгдэгчийн тас нуусан зүйлс ч ил гарав. Түүний орон сууцны арилжаа, газрын наймааны ашгийн төлөөх бизнесийн тачаал нь бүгдэд мэдэгдэв. Хүссэнээ авахын тулд байнга хэрэглэдэг зусар үг, хов жив нь ч илрэв. Түүний хийсэн бүхэн нь улам ихийг олох гэсэн хүслээр хөтлөгджээ.

Мэхлэгдэгч юм бүрийг өөрийнхөө арга замаар л хийж, бүхнийг өөртөө авахыг л хүсжээ. Үүнийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ Мэхлэгдэгч “Би Жэйлинд итгэдэг, түүний тал юм чинь амьдралд иймэрхүү юм байх шүү дээ” гэдэг үнэмшлээр сэтгэлээ засдаг байжээ.

Мэхлэгдэгчийн амьдралыг гүйлгэж үзсэний дараа Жэйлин бичээч рүүгээ хараад: “Мэхлэгдэгчийн нэр Амийн номд байна уу?” гэж асуулаа.

Бичээч: “Байхгүй, эзэнтээн” гэж хариулав.

Гэтэл Жэйлин: “Мэхлэгдэгч, чи намайг үгүйсгэсэн ялтай. Чи ганц хэмээх хөсөр газар цөлөгдөж, насаараа итгэл найдваргүй, тас харанхуй ганцаардалд тамлагдаж амьдарна” гэх нь тэр.

Мэхлэгдэгч цочсондоо хөшив. Тархинд нь: “Ийм байх ёсгүй. Энэ бол алдаа, алдаа! Жэйлин би танд итгэдэг! Би таныг яаж няцаагаав?” гэсэн түмэн бодол эрээлжилнэ.

Тэгээд Мэхлэгдэгч: “Би таныг яаж няцаагаав?” гэж хашхирлаа.

Харин Жэйлин: “Багш нар чинь та нарт Жэйлиний хуулийг мэддэг боловч, амьдрах арга замаараа няцаадаг хүмүүсийн талаар анхааруулаагүй гэж үү?”¹³ гэлээ.

Гэвч Мэхлэгдэгч мөчөөгөө өгөлгүй: “Гэхдээ их хаан минь, би таны сургуульд явсан. Эрдэм номдоо ч шамдаж суралцсан. Би

олон үйл ажилд идэвхитэй оролцсон. Таныг ч эзэн хэмээн дууддаг байсан!” хэмээн хашхирлаа.

Гэтэл Жэйлин тэр даруй: “Чи намайг эзэн гэсэн атлаа үгийг нь яагаад дагасангүйв?”¹⁴ Шашинлаг яриатай хүн бүр жинхэнэ бурханлаг хүмүүс байдаггүй гэж хэлснийг минь сонсоогүй юу? Намайг эзэн гэж дуудавч Аффабелд орж чадахгүй олон хүн байна гэдгийг би хэлсэн. Тэд миний аавыг дуулгавартай дагасан эсэхээрээ л шүүгдэхийг би хэдийн анхааруулсан. Шүүх өдөр олон хүн “Эзэн минь, эзэн минь, бид таны нэрийг хэрэглэж, таны тухай бусдад хэлсэн гэвч, би тэдэнд “Зайл, учир нь та нарын үйлс муу ёрын гэж хариулна”¹⁵ гэдгээ хэлсэн” гэлээ.

Мэхлэгдэгч галзууртлаа уурлав. “Гэхдээ надад итгэл бий. Би танд итгэсэн. Таны үгийн дагуу би аврагдах учиртай!”

Жэйлин тэвчээртэй боловч, хатуу байн, чуулсан иргэд рүү харснаа, дэд сэнтий дээр суусан нэгэн сургуулийн багш руу хараад: “Чи ангидаа зааснаа Мэхлэгдэгчид уншиж өгөөч” гэлээ.

Нөгөө хүн эртний ариун бичээсээс уншиж өгөв: “Хүндэт ах эгч дүүс ээ, үйлдлээрээ батлахгүй аваас би итгэлтэй хэмээн ярих нь ямар ашигтай гэж? Ийм итгэл түүнийг аврах уу? Дан ганц итгэлтэй байх хангалтгүй. Сайн үйлсээр батлагдахгүй итгэл нь үнэндээ итгэл огт биш юм. Энэ нь үхмэл бөгөөд ямар ч ашиггүй болой. “Гэхдээ зарим нь итгэлтэй, зарим нь үйлстэй байдаг” хэмээн маргах хүн гарбал, би “чи сайн үйлсгүй бол, би итгэлийг чинь харж чадахгүй ч, би өөрийнхөө итгэлийг чамд сайн үйлсээрээ харуулъя” хэмээн хариульюу. Ганцхан Жэйлин байдаг гэдэгт итгэх нь хангалттай гэж бодоо юу? Тэгвэл, үүнд чинь чөтгөрүүд ч итгэдэг бөгөөд сүрдэн чичирдэг юм. Тэнэг ээ, сайн үйлс төрүүлэхгүй итгэл нь ямар ч хэрэггүй¹⁶ гэдгийг чи хэзээ сурах вэ?”

Үүний дараа Жэйлин “Чи өөрийгөө итгэлтэй гэв үү? Итгэл нь зохих дуулгавартай үйлдэлтэй хамсахгүй аваас, итгэл огт биш юм. Итгэдэг гэж хэлэх хангалтгүй. Учир нь чөтгөр ч итгэдэг. Гэхдээ тэд аврагдахгүй нь лавтай. Жинхэнээсээ итгэдэг хүмүүс муу ёрын үр жимс ургуулахаа больж, шинэ мөн чанараараа амьдардаг. Гэтэл чи харанхуйн эзэн Дагоны үр жимсийг ургуулсаар байсан нь надад зүрхнээсээ захирагдаагүй болохыг чинь л хэлнэ” гэлээ.

Мэхлэгдэгч энэ бүх үгийг шингээх гэж зүдрэв. Тэгээд өөдөөс нь: “Тэгвэл тэр Ёсбус гэгч яагаад энд байж байдаг билээ? Би тэрнээс

дээр байсан. Та яаж түүнийг үлдээгээд, намайг хасч чадаж байна аа? Та шударга бус шүүж байна!” гэв.

Жэйлин түүнд: “Та нар эзэн шударга бус гэдэг. Сонс. Би шударга бус уу, чи шударга бус уу? Муу хүн муугаасаа эргэж, зөвийг үйлдбэл сүнсээ аварна гэж чамд сургаагүй гэж үү? Тэр хүн амьдралаа эргэцүүлэн бодоод нүглээсээ эргэж, сайн сайхан амьдрахаар шийдсэн юм. Тэрбээр хэрхэвч үхэлгүй, заавал амьдарна”¹⁷ гэлээ.

Уур нь хүрч, хилэгнэсэн Мэхлэгдэгч: “Гэхдээ би олон хүнд таны тухай ярьсан. Та мэднэ. Тэр бүү хэл таны сургуульд сайн дураараа заасан!” гэж хашхирлаа.

Жэйлин одоо төмөр нүүрээ харуулан: “Миний хуулийг эшлэж, амлалтыг маань тунхаглахаа боль. Учир нь чи миний сахилгажуулалтыг үл тоож, хуулийг үл хэрэгсэж, хулгайчтай гар нийлж, цагаа ёс бус муу ёрын хүмүүстэй өнгөрөөсөн. Чиний амнаас хараал, худал, бохир үг урсдаг. Чи ахан дүүгээ гүтгэдэг. Намайг дуугүй байсан болохоор чи намайг тоохгүй байна гэж бодсон. Харин одоо шийтгэлийн цаг ирж, чиний эсрэг энэ бүх ялыг тулгаад байна”¹⁸ гэв.

Мэхлэгдэгч чив чимээгүй зогсоно. Тархи нь задрах шахавч, түүнд өөрийгөө өмгөөлөх нэг ч үг үлдсэнгүй.

Хэсэг хугацааны дараа хаан зарц нартаа: “Түүний гар хөлийг хүлээд, гадаад харанхуйд аваачиж хая. Тэр тэндээ уйлан шүдээ хавираг”¹⁹ гэлээ.

Хааны харуул ойртож ирмэгц, хилэндээ шатсан Мэхлэгдэгч Жэйлинг, харуулуудыг, Аффабелийн иргэдийг харааж зүхэн, догшрон эсэргүүцэл үзүүлэв. Түүний дөнгөж сая ил гарсан үнэн мөн чанар нь өөрт нь байсан бүх сайн сайхныг залгижээ.

Мэхлэгдэгчийн гар хөлийг хүлээд, танхимаас гаргахад тэр зогсоо зайгүй хараал урсгав. Бие даагчийн адил тэрбээр ялын гүйцэтгэл хүртэл төмөр торонд хоригдлоо.

Мэхлэгдэгчийг танхимаас гарсан хойно Жэйлин цугласан гэрч нарт: “Өөрийнхөө нүдэнд цэвэр авч, бохиросоо цэвэрлэгдээгүй гүйинхэн байх”²⁰ хэмээн айлдав.

Бүрэг Жэйлиний өмнө шүүгдэв



Шударга ёсны танхимд зуу хүрэхгүй хүн үлджээ. Тэдний дунд Бүрэг, Дүр эсгэгч хоёр сууна. Бүрэг Дүр эсгэгчээс аль болох хол суувч, дотроо үзэн ядсаар байлаа. Дүр эсгэгч ч Бүрэгээс зайлсхийнэ.

Хааны дөрвөн харуул орж ирээд, Бүрэгийг дуудав. Тэр хаашаа очих бол гэхээс сандрав ч, Дүр эсгэгчээс холдож байгаадаа баярлалаа. Бүрэг бусдынхаа л адил аугаа танхимын үүдэнд ирээд, протоколтой танилцаад, замчлуулав.

Бүрэг Аффабелийн иргэдийн дундуур өнгөрөхдөө, түүнээс өмнө Энделээс явсан хэдэн хүнийг олж харжээ. Тэдний дийлэнх нь сургуульд байхдаа Бүрэг шиг итгэлээ гал халуун, ил тод харуулж байгаагүй. Бас Аффабелд орчих юм чинээ санаагүй хүмүүс ч тэнд зогсож байгаад Бүрэг гайхав.

Бүрэг сэнтийд ойртож очоод, эргэн тойрон дахь дэд сэнтийнүүдийг харав. Тэнд гарцаагүй хаанчлалын удирдагч болмоор багш нар тэргүүтэй хүмүүс сууж байсан ч, нөгөөтэйгүүр бас Энделд дорой буурайд тооцогддог байсан иргэд ч сууж байгаад Бүрэг бүр ч гайхлаа. Мөн баян чинээлэг амьдарсан хүмүүс ч байх юм. “Яаж баян хүмүүс ийм хүндэтгэлийн суудалд суудаг байна аа?” хэмээн тэр дотроо бодлоо.

Гэтэл түүний хариултыг Жэйлиний “Нярвынхаа ажлыг тайлагна” гэсэн дуу таслав.

Холограм дүрс Бүрэгийн амьдралыг харууллаа. Бүрэг сургуульд байсан үеэ сэтгэл догдлон үзнэ. Тэр сайн дурын ажил, хичээлээс гадуурх ажил, ангийн даргынхаа ажлыг сайн гүйцэтгэжээ. Бас зоригтой, хичээнгүй байсандаа ч бахдав. Гэхдээ Хутгууртай тохиолдсон нөгөө явдал гарч ирмэгц Бүрэгийн царай хувираад явчихав. Тэр уучлахаас тагталзжээ. Бүрэгийн зүрхний нөхцөл байдал ил гарсан бөгөөд тийм ч таатай байсангүй.

Тэгтэл араас нь Дүр эсгэгчтэй амрагласан явдал гарч ирэв. Бүрэг түүнтэй явалдсандаа хэзээ ч гэмшээгүй. Тэр өөртөө ямар ч буруу нялзаалгүй, бүгдийг Хутгуур, Дүр эсгэгч рүү чихжээ. Тиймээс өөрийнхөө үйлдэлд хариуцлага хүлээгээгүй. Амьдралынх нь дүр зургууд хөвөрсөөр, түүний уур, хорсол, өс хонзон үржсээр байгааг Бүрэг харав. Бүрэг зарим асуудлынхаа их

биеийг шийдэж байснаас биш, уг үндсийг нь хэзээ ч шийдээгүй. Үүнээсээ болж Бүрэг Хутгуур, Дүр эсгэгч хоёрыг буруутгахаар барахгүй, угтаа энэ бүх зовлондоо Жэйлинийг буруутгаж эхлэжээ. Жэйлин яаж Дүр эсгэгч шиг хүнийг сургуульдаа багшлуулж чадав аа? Бүрэгийн үл уучлал, зэвүүцэл бул чулуу шиг хатуу бас хөдлөшгүй байв.

Тойм дууссаны дараа Бүрэг бусдад сайн сайхныг үйлдэх сэтгэлгүй, хорсолтой эмэгтэй гэдэг нь ил болжээ. Гэхдээ энэ бүхэн нь тэр олон гэрч нарын өмнө ил болчихоод байхад ч, Бүрэг өмнө нь Жэйлинд хайртай байсан учраас, одоо ерөөгдөх учиртай гэдэгтээ итгэл дүүрэн байлаа. Бүрэг жаахан зэмлүүлэхээс л айснаас биш, түүнийг юу хүлээж байгааг огт гадарласангүй.

Жэйлин бичээчдээ хандан: “Бүрэгийн нэр Амийн номд байна уу?” гэж асуулаа.

Бичээч: “Байхгүй, эзэнтээн” гэв.

Тийнхүү Жэйлин шүүлтээ буулгав: “Бүрэг чамд зөвөөс дайжиж, надаас урван тэрслэсэн гэдэг ял тулгаж байна. Тиймээс чи үлдсэн амьдралаа Ганц хэмээх хөсөр газар цөлөгдөж, насаараа итгэл найдваргүй тас харанхуй ганцаардалд тамлагдаж амьдарна.”

Бүрэгийн гайхшийг үгээр дүрслэхийн аргагүй. Бүрэг хэн хэнээ илүү цочирдов. Ийм юм байх ёсгүй! Энэ хар дарсан зүүд учраас, сэрэх ёстой! Андуу ташаа явдал гарчээ.

Тэгээд итгэж ядан: “Жэйлин, та намайг Ганц хэмээх хөсөр газарт хаягдана гэсэн үү?” гэсэнд, хаан:

- “Тийм ээ Бүрэг ээ, чи зөв сонсож” хэмээн хариулав.

- “Энэ чинь юу гэсэн үг вэ? Би танд итгэдэг. Сая та миний амьдралаас өөрөө ч харлаа. Итгэлээ ч батлан сайн амьдарсан. Тийм ээ, миний зүрх хатуурсан, хайр минь үхсэн. Гэхдээ тэр чинь миний буруу биш. Тэр чинь Хутгуурийн буруу, Дүр эсгэгчийн буруу. Тэдний урвалтаас болж л би хөрсөн.”

Гэтэл Жэйлин түүнд: “Багш нарынхаа заасан миний анхааруулгыг чи мартсан гэж үү? Муу ёр ийнхүү тархаж олон хүний хайр хөрнө. Харин эцсээ хүртэл тэссэн хүн аврагдана. Гэтэл чи эцсээ хүртэл тэссэнгүй” гэж хэллээ.

Бүрэг өөдөөс нь: “Гэхдээ Жэйлин эзээн, би танд итгэдэг учраас л зөвт болсон. Би гэрчлэхээ больсон ч, хүн аврагдсан л бол авралаа мөнхөд хадгална гэж итгэдэг байсан. Зарим багш нар

ч ингэж заадаг байсан. Тэд хэн ч намайг таны мутраас салгахгүй гэж заадаг байсан” гэлээ.

Жэйлин түүнд: “Тийм ээ, тэр үнэн. Хэн ч чамайг миний мутраас салгахгүй. Гэхдээ би хэзээ ч “Чи өөрөө надаас явчихаж чадахгүй” гэж хэлээгүй. Энэ сонголтыг хийх хүч нь ганцхан чамд л байсан. Чи эртний ариун бичээсийг уншаагүй гэж үү? “Эзэн ба Аврагч Жэйлинийг мэдэх мэдлэгээрээ л муу ёрын хүчээс зугтсан атлаа эргээд тэрнийхээ боол болдог хүмүүс хамгийн золгүй еэ. Учир нь эцэстээ тэд эхнийхээсээ ч дор байдалд очдог. Тэд зөвийн замыг мэдсэн атлаа ариун тушаалаас эргэсэнд орвол анхнаасаа зөвийн замыг мэдээгүй байсан бол хавьгүй дээр байхсан.”²² Би тэднийг зөвийн замыг хэзээ ч мэдээгүй байсан бол дээр байхсан гэж хэлсэн. Учир нь тэд аврагдаагүй байснаасаа ч дор байдалд очдог. Авралыг алдах боломжгүй гэдэгт чи яаж итгэж чадав аа? Алдаж боломгүй бол, яаж тэд эхнийхээсээ дор байдалд орох билээ?

Чи яагаад миний үгийг гуйвуулсан багш нарыг сонсдог билээ? Би бүх хүнд зөвийн замыг мэдүүлэхийн тулд маш тодорхой бичсэн. Тийм байтал чи яагаад мэхлэгдэв? Чи миний үгд итгэсэн бол, зүрхэн дэхь хорсолтойгоо нүүр тулах л байсан. Гэтэл чи авралаа алдахгүй гэсэн хуурамч баталгаандаа сэтгэл амарч, ямар ч хараа хяналтгүйгээр хорслыг үржүүлжээ. Түүнээсээ болж чи одоо сэрэмжилж болох байсан ялд унаад байна” гэв.

Бүрэг: “Гэхдээ миний хийсэн сайн сайхан яах болж байна?” хэмээн гувшив.

Эзэн Жэйлин: “Би эш үзүүлэгчээрээ дамжуулан “Зөв хүмүүс нүглийн зам руу эргэж, нүгэлтэн мэт амьдарбал тэд амьдрах ёстой гэж үү? Үгүй ээ, мэдээж үгүй! Тэдний өмнөх сайн сайхан нь мартагдаж, тэд нүглийнхээ төлөө үхнэ. Гэтэл та нар “Эзэн шударга биш байна!” гэдэг. Намайг сонс! Би шударга бус уу, та нар шударга бус уу? Зөв хүмүүс сайн замаасаа эргэж, нүгэлт юмс үйлдбэл тэд үүнийхээ төлөө үхэх болно.”²³ Яг л бичигдсэн шигээ. Чиний сайн сайхан хийгээд сайн үйлс мартагдаж, нэг нь ч чиний төлөө тооцогдохгүй” гэжээ.

Уйлан гиншсэн Бүрэг: “Гэхдээ эзээн, хэрэв би таныг аврагчаар тунхаглах юм бол, нэр маань Амийн номд бичигдэнэ гэсэн. Тэгээд яахаараа миний нэр байдаггүй билээ? Яаж арилдаг билээ?” гэв.

Эзэн Жэйлин тэвчээртэй хэр нь хөдлөшгүйгээр: “Өмнө хэлснийг

сонсоогүй юу? “Эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдана.”²⁴ Бүх шүүхийг даван гарсан хүмүүс бол ялсан хүмүүс юм. Түүнчлэн би “Ялагч нь цагаан хувцсаар гоёх бөгөөд би түүний нэрийг Амийн номоос арчихгүй”²⁵ гэж хэлсэн билээ. Хэрэв би ялагчийн нэрийг Амийн номоос арчихгүй гэж хэлсэн бол, ямар ч нэрийг арчиж болдог нь тодорхой байна. Эс бөгөөс би “Намайг эзэнээрээ тунхаглабал, нэр чинь Амийн номд мөнхөд бөхлөгдөнө” гэж хэлэх байсан” гэв.

Бүрэг: “Тэхдээ та яаж намайг Ганц хэмээх газар руу илгээж чадаж байна аа?” хэмээн цурхиран уйлсаар.

Жэйлин нэгэн дэд захирагчдаа хандан: “Энделийн бүх иргэдийн мэдэх эртний бичээсийн хэсгээс уншиж өгнө үү” гэлээ.

Дэд захирагч: “Ойлголтын замаас гаждаг хүн үхэлтэй хамт хажуулна”²⁶ хэмээн уншлаа.

Бүрэг юу ч хэлсэнгүй. Хаан зарцдаа: “Түүний гар хөлийг хүлээд, гадаад харанхуйд аваачиж хая. Тэр тэндээ уйлан шүдээ хавираг. Олон хүн дуудагдсан ч, цөөн хүн сонгогдсон” гэж айлдав.

Хааны харуулыг дөхөж ирэхэд Бүрэг Жэйлинийг харааж эхлэв. Тэрбээр хорслынхоо харгислалд, хоёр дахиа үхсэн нүгэлт мөн чанартаа эзлэгджээ. (Иуда 12-ыг үзнэ үү)


Бүрэгийн гар, хөлийг хүлээд танхимын хажуугаар гаргаад, мөнөөх торонд аваачиж хийв. Танхимаас гармагц хааны харуул гэрч нарын чуулганд хандан:

“Эрхэм нөхөд өө, бид үнэний бүрэн мэдлэгийг хүлээж авсан хойноо нүгэл үйлдсээр байвал, энэ нүглийг төлөх өөр ямар ч тахил байхгүй. Тэдэнд Жэйлиний аймшигт шүүх, дайснаа залгих улаан галаас өөр хүсэн хүлээх юм юу ч байхгүй болно. Учир нь “Өшөөг би авна, өстөнд би хариуг нь өгнө” хэмээн айлдсан нэгэн нь бас “Эзэн өөрийнхөө хүмүүсийг шүүнэ” хэмээн айлдсан юм. Амьд Жэйлиний гарт орох шиг аймшигтай юм үгүй”²⁸ хэмээн дуудав.

Дүр эсгэгчийн шүүх

Шударга ёсны танхимаас хамгийн сүүлд Дүр эсгэгчийг дуудлаа. Тэр Жэйлиний хуулийг хэдийн мэдэх учраас шүүхээс таатай юм сонсохгүйгээ гадарлаж байв.

Дүр исгэгч Шүүх танхим руу хөтлөгдөж явахдаа ухаан



балартаж, харуулаар тулж түшүүлж байж л Жэйлиний Шүүх сэнтийн өмнө ирэв. Тэгээд амьдралаа тоймлон харж, нэр нь Амийн номд байхгүй гэдэг золгүй үгийг сонслоо.

Жэйлин шударга хоолойгоор: “Дүр эсгэгч чи зөвөөс дайжин урваж, бүдрүүлэх чулуу болсныхоо төлөө яллагдаж байна. Чи Ганц хэмээх хөсөр газар цөлөгдөж, тэнд хамгийн аймшигтай шийтгэл, тарчлааныг үзнэ” гэлээ.

Дүр эсгэгч үүнийг сонсоод, үхэнгээ алдан: “Гэхдээ эзэн минь, би таны сургуулийн багш байсан. Би таны үйл хэрэгт өөрийгөө зориулсан” гэв.

Жэйлин түүнд: “Чи багш байсан. Гэхдээ чи заасан номоо уншдаггүй байсан хэрэг үү? “Эрхэм ах эгч дүүс ээ, та нараас олон хүн багш бүү болог. Учир нь заадаг нь Жэйлиний хамгийн хатуу хуулиар шүүгдэнэ”²⁹ гэдэг үгийг мэдэхгүй юу?” гэв.

Дүр эсгэгч: “Би яаж бүдрүүлэх чулуу болсын?” гэлээ.

Энэ удаа Жэйлин төмөр нүүрээ үзүүлээд: “Чи олон бяцхан хүүхдүүдийг бүдрүүлж, нэг мөр унагасан. Бүрэг бол тэдний нэг нь л юм. Түүнийг чиний халамжинд даатгасан. Би чамд түүнийг хамгаалах эрх мэдэл өгсөн байтал, чи энэ эрх мэдлийг өөрийнхөө төлөө ашигласан. Чи дур хүслээ хангахын төлөө Бүрэг тэргүүтэй олон хүнд халдсан. Хэдийн нэгэн найзаасаа гомдлын шарх аваад байсан түүнийг чи эдгээх ёстой байсан атал оронд нь ашигласан. Чи түүний итгэлийг бузарласан. Харин одоо тэр Ганц хэмээх газарт хаягдаад байна. Мэдээж чи “надад итгэсэн энэ бяцхан хүүхдүүдээс нэгийг нь ч атугай бүдрүүлэхэд хүргэсэн хүн хүзүүндээ хад дүүжлээд далайд хаягдсан дээр”³⁰ гэж хэлсэн миний сэрэмж үгийг санаж байгаа биз” гэлээ.

Дүр эсгэгч: “Жэйлин, би Ганцад хаягдахаа мэдлээ. Гэхдээ яагаад хамгийн аймшигтай шийтгэл гэж? Яагаад надад ийм хатуурхана вэ?” хэмээн уйллаа. Би таны зарц байсан. Би итгэдэг хүн. Би таныг тоодоггүй Бие даагч шиг байгаагүй. Гэтэл яагаад энэ вэ?” гэлээ.

Гэтэл Жэйлин энэ удаа улайдсан төмөр шиг нүүр харуулаад: “Чи яагаад ингэж асууна? Чи эртний бичээсийг мэддэг ч байсан, заадаг ч байсан. Гэхдээ чамд дахин сануулъя. Эртний бичээс тодорхой хэлсэн. “Гэхдээ зарц нь “Эзэн мөд ирэхгүй” хэмээн бусад зарц нараа дээрэлхбэл... эзэн нь санаандгүй байтал гэнэт ирээд,

зарцаа тасдаж хаяад, итгэмжгүй хүмүүстэй хамт цөлнө.” Зарц нь маш хатуу шийтгүүлнэ. Учир нь тэр алба үүргээ мэдэж байсан ч, хийхээс татгалзжээ. Харин өөрийгөө буруу юм хийж байгааг мэдэхгүй хүмүүс арай зөөлөн шийтгүүлнэ. Ихийг хүлээж авсан хүнээс их, багыг хүлээж авсан хүнээс бага шаардагдана”³¹ хэмээв.

Жэйлин цааш нь: “Бие даагч алдаа зөрчлөө сайн мэдээгүй. Та хоёрт хоёуланд нь ухаарал, мэдлэг байсан. Тэр хатуу шийтгүүлсэн ч, чинийхээс хөнгөн байна. Харин чиний хувьд би чамд харанхуйн гүнийг бэлдсэн байгаа”³² гэлээ.

Тэгээд дараа нь харуулд: “Түүний гар хөлийг хүлээд гадаад харанхуйд аваачиж хая. Тэр тэнд уйлан шүдээ хавираг. Учир нь олон хүн дуудагдсан ч, цөөн хүн сонгогдсон”³³ гэв.

Хааны харуул дөхөж ирэхэд Дүр эсгэгч Жэйлин рүү, харуулууд руу, Аффабелийн иргэд рүү гутаан доромжилсон хараалын үгс урсгав. Тэр хүч түрэмгийлэхээр барахгүй, мулт үсрэн Жэйлин рүү дайрах гэж үзжээ. Түүний жинхэнэ мөн чанар бүрэн ил гарав. Хоёр нүүртэй байдал нь Дүр эсгэгчийн доторх аль сайныг залгижээ. Дүр эсгэгчийн гар хөлийг хүлээд, хажуугийн хаалгаар гаргах хооронд тэр харааж зүхсээр л байв. Тэгээд нөгөө мянга таван зуун хүний хамт шууд Ганц руу цөлөгдлөө.


Дүр эсгэгчийг танхимаас гармагц хааны харуул номоо хаагаад: “Таны шүүх хамгийн шударга. Тэд зохих шангаа хүртсэн” хэмээн тунхаглав.

Гэтэл тахилын ширээнээс: “Таны шүүх үнэн бөгөөд шударга!”³⁴ гэсэн дуу гарлаа.

Ганц хэмээх хөсөр газар

Хааны харуулууд мянга таван зуун ялтныг Ганц хэмээх хөсөр газар руу хоёр долоо хоног зөөсөөр, Их галын цөлд авчрав. Энд газрын гаваас хуйхлам халуун олгойдож, тэсэхүйеэ бэрх байв. Ийнхүү амь тэмцэж явтал, гэнэт газрын хаанаасыг бүү мэд алсаас нэгэн дүнсүйсэн том байгууламж зэрэглээтэн үзэгдэв. Ялтнууд ойртож ирмэгцээ “Ганц хэмээх хөсөр газар” гэсэн хаягийг уншлаа.

Тэд байгууламжийг ойроос шинжингээ, тэр нь ганц том хаалгаас өөр ямар ч үүд, орц, цонхгүй болохыг мэджээ. Ялтнуудыг хаалгаар ормогц, хэдэн арван мянган ялтны аймшигтай чарлаан



угтав. Тэр ялтнууд хааны харуулыг үзээд “Хичнээн удах ёстой юм бэ? Бидний төлөө хаанаас өршөөл гуйж өгөөч. Бид энэ шийтгэлийг цаашид тэвчихгүй нь!” хэмээн бархиралдлаа.

-“Тэд хэр удаж байгаа юм?” хэмээн Бие даагч харуулаас асуув.
-“1-129 жил.”

Мэхлэгдэгч шоконд оров. Сүүлийн хоёр долоо хоног өрнөсөн юмс нь хар дарсан зүүд эсвэл айлгах тактик байсан гэдэгт тэр найдсаар байжээ. Тэгээд тэр мөнөөх харуулаас: “Би үнэхээр энд үлдсэн амьдралаа өнгөрөөх юм гэж үү?” гэж асуутал,

-“Тийм ээ, Энделд анхааруулсан шүү дээ” гэдэг хариулт сонсов.

Илүү хүнд шийтгэлтэй хүмүүсийг нь бүр ч халуун төмөр байшинд хийсэн байлаа. Үнэнийг мэдээгүй ч, цөллөгдөх хэмжээний хэрэг хийсэн хүмүүсийг тэр том байгууламжийн арай доох нь хэсэгт хорьжээ. Энэ газар зуун жил байтугай ганц хоног ч тэсэхийн аргагүй байв.

Дүр эсгэгчийн очих газар ямар аймаар байхыг төсөөлөхийн аргагүй - байшингийн дээд хэсэгт хоригдсон хүмүүсийн хувь тавилангаас долоон дор байна! Дүр эсгэгчийг газар доорх гянданд, халуун хүхэрт хаданд хорив. Үнэр танар гэж тэсэхийн аргагүй, агааржуулагч ч байхгүй, Ганцын хамгийн халуун цэг. Тэр газар нь байгууламжинд биш, харин газрын гавд байдаг ажээ. Тэр бол яахын аргагүй хамгийн аймшигтай зовлон, тамлалын газар аж. Энд Дүр эсгэгч гав ганцаараа тарчилна. Энэ газар Дүр эсгэгчтэй яг адилхан ялтай хүмүүс энд тэндгүй ганцаар тарчлах ажээ.

Ялтнуудын ялыг гүйцэтгэсний дараа хааны харуул гарахаар явав. Түүний ардуур аварга том төмөр хаалга хаагдмагц, байгууламж дотор ёлтойх ч гэрэлгүй, тас харанхуй боллоо. Дотор буй золгүй сүнснүүд 125 орчим жил энэ тас харанхуй, ганцаардалд тамлагдана. Цорын ганц гэрэл үздэг өдөр нь жилд нэг удаа шинэ хоригдлуудыг авчирдаг энэ өдөр юм. Гэхдээ бүгд биш, зөвхөн хаалгатай ойрхон байгаа нь л гэрэл харна. Дүр эсгэгч шиг хүмүүс дахиж хэзээ ч өдрийн гэрэл үзэхгүй. Тасын тас харанхуй нь түүний шийтгэл ажээ.



Эргэцүүлэл


Энделийн энэ дөрвөн иргэн үнэнийг сонсоогүйгээ насан турш харуусахаар болжээ. Ганцаараа байхдаа тэд Энделд бэлэн зэлэн байсан Жэйлиний үгийг үл тоосноо бодон бодон, харуусан харуусна. Цаг хугацааг эргүүлж, хувь тавилангаа өөрчлөх завшаан олддогсон бол, тэд үүний төлөө юу ч хийхэд бэлэн. Тэд тухайн үед алдартай байсан, олонхийн үзэл санааг сонсохгүй байхгүй явдаа! Залруулж болдогсон бол, тэд дор бүрнээ тэнэг үзэл санаагаа таягдан хаяад, хэзээ ч өөрчлөгдөхгүй, хэзээ ч зөрчигдөхгүй тэр эртний бичээст суралцах байсан.

Дээрээс нь тэд Аффабелийн мартахын аргагүй гоо үзэсгэлэнд голоо тасартал харамсана. Амь тэмцэн тарчилж байгаа тэдний бодолд хэсэгхэн зуур амтлаад өнгөрсөн үзэсгэлэнт Аффабел дурайсаар. Тэгэх тусам улам л тарчилна. Шатам халуун, хурц улиан, Ганцын харанхуйлал нь гашуун үнэнийг улам л томруулсаар. Тэд тэр сайхан амьдралыг сонгож болох л байсан. Гэвч мунхаг зангаараа үл тоожээ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БҮЛЭГ 1-3

1. Энэ номыг уншиж эхлэхээсээ өмнө та амжилтыг юу гэж үздэг байсан бэ? Энэ үзэл бодол чинь таны зорилго, үнэт зүйлс, дадал хэвшил дээр хэрхэн тусдаг байсан бэ? Энэ хэсгийг уншаад үзэл бодол чинь хэрхэн өөрчлөгдөх юмуу батажсан бэ?
2. Өнө мөнхийн талаар эргэцүүлэн бодвол, мөнхийн хувь тавилангаа шийдүүлэх Шүүх өдөр итгэл дүүрэн зогсох хүн гарахгүй байх. Гэтэл энэ боломжтой гэдгийг 1Иохан 4:17 дээр амласан. Энэ талаар бид номоо дуусан дуустал ярих болно. Гэхдээ сая сурсан зүйл дээрээ үндэслэн бодвол, тэр итгэл дүүрэн байдал хаанаас төрдөг гэж бодож байна?
3. Энэ хэсэгт та Аффабел хэмээх хоттой танилцлаа. Энэ хотоор дэлхийн амьдрал хийгээд мөнхийн хувь тавилангийн хоорондох харилцааг төлөөлсөн болно. Энэ хаанчлал, засаглалын юу нь таны сонирхлыг хамгаас татав? Юу нь таныг хамгаас гайхшруулж эсвэл баярлуулав? Тэр хэсгүүдийг Бичээс хэрхэн батлаж байна?
4. Энделийн оршин суугчдын талаар ярья. Эхний дөрвөн шүүлт танд ямар санагдав? Тэдний хувь тавиланг арай өөрөөр эргэх байх гэж найдаж байсан уу? Гийм бол, яагаад?
5. Цаашаа явахаасаа өмнө таны сэтгэлийг зовоож байгаа асуудал эсвэл асуумаар байгаа асуулт байвал хэлнэ үү.



ᑭ-ᑭ ᑭᑭᑭᑭ

ҮХЭГСДИЙН МӨНХИЙН ГЭР

*“Шавь нар нь энэ сургаалт зүйрлэл ямар
утгатай болохыг Түүнээс асуухад Тэр
—Бурханы хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн
юм. Харин бусдад нь Би сургаалт зүйрлэлээр ярьдаг.
Тийм болохоор тэд харавч эс ойлгон,
сонсовч үл ухаарах билээ” хэмээв.
—Лук 8:9-10*

Дараагийн дөрвөн бүлэгт бид түүхээ түр завсарлаад, Бие даагч, Мэхлэгдэгч, Бүрэг, Дүр эсгэгчийн шүүхээс сурсан үнэний талаар ярилцана. Үүний дараа Аминч, Өгөөмөрийн тухай үзээд, номоо дуусан дуустал тэдний амьдралаас сурсан үнэний талаар ярилцана. Номын маань хамгийн сайхан хэсэг нь Есүс Христийг дагадаг хүмүүсийн мөнхийн шагналын талаарх сэдэв юм.

Суурь үнэн

Манай түүхэнд гарч байгаа Жэйлин нь Есүс Христ, харин хаан аав нь Аугаа хүчирхэг Бурхан юм. Дагон нь Сатан бол, Энделийн амьдрал нь дэлхий дээрх хүний амьдралыг, Аффабел нь Бурханы тэнгэрийн улсыг төлөөлнө. Ганц хэмээх хөсөр газар нь Есүс Христийн аврагч нигүүлслийг хүлээж аваагүй хүн бүр мөнхөд хаягдах Галт нуур юм. Харин өмнөх бүлэгт гарсан хүмүүс нь янз бүрийн байдлаар мөнхөд яллагдах хүмүүсийг төлөөлнө. Бурханы Үг энэ талаар маш тодорхой ярьдаг.

Тийм ээ, та “мөнхөд яллагдах” хэмээн зөв уншлаа. Энэ үгийг бичихээр бэлтгэж байхдаа миний бие Бичээсийн “мөнхийн

шүүлт” гэсэн хэсгийг уншигчид яаж ойлгуулахаа мэдэхгүй, нилээд зөрчилдөж билээ. Үүнийг анхааралтай уншина уу:

“Тиймээс Христийн тухай балчир ойлголтыг орхиж, төлөвшилд тэмүүлцгээе. ... мөнх шийтгэлийн тухай (та нарын аль эрт, хэзээний бүрэн мэдсэн байх ёстой) сургаалуудын суурийг дахин дахин тавихгүй байя.” (Еврей 6:1-2)

Би “мөнхийн шүүх болон шийтгэл” нь Христийн хамгийн энгийн сургаал гэдгийг тодруулах үүднээс бусад таван суурь доктриныг нь зориуд орхисныг та анзаарсан байх.

Хамгийн энгийн гэдгийг нэг толь бичигт “үндсэн, суурь, ерөнхий хэсэг”¹ гэжээ. Энэ нь аливаа зүйлийг байгуулахын өмнө барьж байгуулсан байх ёстой, амин чухал хэсэг буюу суурь ажээ. Үүнийг боловсролын системээр тайлбарлая л даа. Бага ангид бид нэн түрүүнд унших, бичих, бодох зэрэг үндсэн чадвараа олж авдаг. Эдгээр суурь чадваргүйгээр бид хэзээ ч зүй ёсны боловсрол олж авахгүй. Тэгвэл итгэгч хүний хувьд ч ялгаагүй. Хэрэв бид мөнхийн шүүхийн талаар баттай ойлголт олж авахгүй бол, Христ дотор зүйтэй амьдрал босгон байгуулж чадахгүй. Яг л уншиж, бичиж, бодож чадахгүйгээр боловсролоо дээшлүүлэх гэж оролдохтой л адил юм болно.

Гэвч өдий хүртэл аялж үйлчлэхдээ миний бие маш олон итгэгчид - тэр дундаа Есүс Христийн үнэнч дагалдагч нар ч - энэ талаар юу ч мэдэхгүй явдгийг харсан билээ. Бичээч “та нарын аль эрт, хэзээний мэдсэн байх ёстой” гэж хэлсэн байгааг харсан уу? Бичээч биднийг энэ сэдэвтэй танилцаад өнгөрсөн байх ёстой гээгүй, харин бүрэн гүйцэд мэдсэн байх ёстой гэжээ. Эдгээр нь яг л уншиж, бичиж, бодохтой адил бидний итгэлийн хамгийн наад захын энгийн мэдлэг болохыг “аль эрт, хэзээний” гэдэг үгсээс мэдэж болно.

“Мөнхийн шүүх” нь ямар учраас Христэд итгэх эрүүл саруул амьдралын хамгийн энгийн доктрин болохыг бид тун удахгүй сурна. Үүнийг ойлгохгүй бол, бидний цааш цаашдын яриа ч ойлгоход бэрх болж, та “Ямар ч утга алга?” гэж бодохдоо ч тулж мэднэ.

Там - хийсвэр зүйл үү бодит зүйл үү?

Би энэ номоо бичихээсээ өмнө “бидний гаргаж байгаа шийдвэр бүр маань хожим бидний амьдралын талаар Ертөнцийн Шүүгчийн гаргах тогтоолд нөлөөлж байдгийг “өнөөдрөөрөө л амьдардаг” энэ үеийнхэнд хэрхэн ойлгуулах билээ?” хэмээн өдрийн бодол, шөнийн зүүд болж билээ. Тэгээд хэдэн өдөр зөрчилдөн, залбирч байтал нэгэн бодол харвасан юм. Есүс хүмүүст сүнслэг үнэнийг ойлгуулахдаа түүхээр ярьдаг байсан шүү дээ! Ингэж л Аффабелийн түүх маань мэндэлсэн юм.

Тэгээд Аффабел дэхь хүн бүрийн шүүхийн талаар мөн Ганц хэмээх хөсөр газар дахь мөнхийн шийтгэлийн талаар бичиж байхдаа, би дотроо дагжин чичирч байлаа. Үнэндээ би 3-аар бүлгийн адаг хэсгийг Бүтэн сайны орой гэр рүүгээ нисэх замдаа бичиж таарсан юм. Тэр өдөр би гурван удаа номлоод байв. Туслахууд маань нам унтах хойгуур би зогсоо зайгүй бичсэн. Шөнө дунд гэртээ ирээд би, Галт нуур хэмээх үгээр хэлэшгүй, аймшигт газарт дуусах тэдгээр хүмүүсийн төлөө айгаад, унтаж ч чадаагүй. Есүсийн хэлснээр бол дийлэнх хүмүүс тийшээ орох ажээ:

“Хавчиг хаалгаар ор. Учир нь сүйрэлд хөтөлдөг хаалга нь ужуу, зам нь өргөн юм. Олонх нь түүгээр тийш ордог. Амь өөд хөтөлдөг хаалга нь хавчиг, зам нь нарийн юм. Цөөнх нь түүнийг олдог.” (Матай 7:13-14)

Тэр шөнө орондоо хэвтэж байхдаа, би хэдэн жилийн өмнө Өмнөд Африкийн хамгийн өндөр хараа хамгаалалттай эрэгтэйчүүдийн хориход сайн мэдээ номлосон явдлаа саналаа. Огиудас хүрмээр үнэр танар, хүн тогтохын аргагүй орчин нөхцөл, хооронд нь хуруу хүрэхгүй зайтай өрсөн давхар орнууд, хорь гучин эрчүүдтэй умгар өрөөнүүд... ямар аймшигтай газар гэж бодно. Ханаар нь дүүрэн бэлгэвч өлгөөтэй! Би Америкийн хэд хэдэн шоронд үйлчилж явсан. Гэхдээ Африкийн шорон шиг тийм аймшигтай нөхцлийг хэзээ ч үзээгүй. Хажууд нь манай шоронгууд хотын захын амралтын газар юм уу даа.

Тийм аймаар гянданд амьд хүн дөч, тавин жил байтугай, долоо хоног ч тэсэмгүй. Гэтэл дийлэнх хоригдол нь насаараа хоригдох

ялтай. Есүст итгэдэггүй тэдгээр хүмүүсийн аврал эрсэн, цөхөрсөн хашхираа нь царайнаас нь илт байлаа. “Нэг өдөр үхээд эндээс чөлөөлөгдөнө дөө” гэсэн бодлыг нь би ч сонсож байв. Гэхдээ нөгөөтэйгүүр, тэд үхэлтэй хамт угтах амьдралаас бас айна. Тэд үнэхээр ямар ч найдваргүй, гарцгүй байдалд оржээ. Нэгэн цагт тэд эрх чөлөөтэй байсан. Гэтэл одоо насаараа ийм аймшиг дунд тарчилж байдаг.

Гэхдээ тэр үед надад “Энэ хүмүүс хичнээн аймшигтай газар байгаа ч, энэ газар нь тамын дэргэд бас л диваажин юм даа” гэж бодогдож билээ. Тэдэнд торт цонхоор тусах гэрэл байна. Гэтэл тамд хэзээ ч унтрахгүй халуун галаас өөр бөртийх гэрэл ч үгүй, ханьсах хүн ч үгүй. Галт нууранд хаягдсан сүнснүүд хэзээ ч амсхийж чадахгүй, мөнхийн мөнхөд зогсоо зайгүй тарчилна! Тэдэнд “Нэг л өдөр эндээс гарна даа” гэсэн найдвар байхгүй. Тэд мөнхөд шийтгүүлнэ!

Энэ нь Есүсийн хамгийн энгийн сургаал байсан учраас л, Тэрбээр тамын тухай байнга ярьдаг байжээ - өнөөдөр бидний индрийн араас дуугардгаас хавьгүй их! Есүс эцэс төсгөлгүй, гав ганцаар тарчлах тамын тухай яриагаараа биднийг сүрдүүлсэн биш, харин Сайн хоньчныхоо хувьд хонин сүргээ хайрлан хамгаалах гэсэндээ л сэрэмжлүүлжээ. Учир нь Есүс бидний төлөө үйлдсэн, заасан бүхнээ хайраар хийсэн юм. Тэгвэл өнөөдөр бид тамын талаар амаа хамхиснаараа хүмүүст тус хүргэж байна уу? Энэ маань жинхэнэ хайр мөн үү?

Бичээс тамыг хэд хэдэн янзаар нэрлэдэг. Тухайлбал шеол (Хуучин гэрээний нэр), Хайдас, булш зэрэг нь үхлийн дараах түр хорихын нэрс бол, Гехенна болон Галт нуур нь мөнхийн тамын нэрс юм. Эдгээр түр болоод мөнхийн хорих газрын талаар тун удахгүй дэлгэрэнгүй тайлбарлана.

Там нь нийгмийн ярьдаг шиг зохиомол газар биш, харин бодитой газар болохыг Бичээс хэлдэг. Тооллого 16-р бүлэгт ард түмний нүдэн дээр газар ангайж, гурван гэр бүлийг биетээр нь шеол залгисан түүх бий. Шинэ гэрээнд Антихрист болоод хуурамч эш үзүүлэгч нарыг “... шатаж буй хүхэртэй галт нуурт амьдаар нь хаяв” (Илчлэл 19:20) гэдэг. Тэднийг үхчихсэн хойно сүнснийг нь тамд хаясан биш, харин бие сүнстэй нь амьдаар нь Галт нуурт хаяжээ.

Лазар ба баян хүн

Лук номд Есүс, өдөр бүр гэрийнх нь үүдэнд хэвтэж байдаг гуйлгачинг хүн гэж тоолгүй, амиа л бодож амьдарсан нэгэн баян хүний бодит түүхийг ярьдаг. Тийм ээ, энэ бол бодит түүх юм. Учир нь Есүс түүхээ “нэгэн баян хүн байжээ” хэмээн эхлүүлсэн. Хоёрдугаарт - Есүс Абрахамыг дурьдаж бас гуйлгачинг нь Лазар хэмээн тодорхой нэрээр дуудсан. Тэгвэл сургаалт үлгэртээ Есүс хүмүүсийн нэр усыг ашиглаж, бодит хүмүүсийг дурьдаж байгаагүй.

Лазарыг үхэхэд тэнгэрэлч нар түүнийг Абрахамын өвөр дээр аваачиж тавьсан. Энэ нь Есүс хүмүүст тэнгэрт буюу Бурханы оршихуйд нэвтрэх зам гаргаж өгөхөөс өмнө, Хуучин гэрээний ариун хүмүүсийн хувьд тайтгарлын газар нь байжээ. Гэтэл баян хүн үхээд Хайдаст оржээ.

“Тийнхүү тэр Үхэгсдийн оронд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлж, тэртээд байгаа Абрахамыг болон Түүний өвөр дэх Лазарыг харав. Тэгээд тэр “Абрахам эцэг ээ, намайг өршөөгөөч. Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг. Учир нь би энэ галд амь тэмцэн зовж байна” гэж хашхирчээ.” (Лук 16:23-24)

Баян хүн асар их тарчилсныг харж байна уу? Өөр орчуулга дээр амь тэмцсэн, тамлагдсан, тарчилсан гэдэг. Товчхондоо үлэмж зовжээ. Там бол мэдрэгддэг тамлалын газар юм. Дараа нь баян эр Абрахам, Лазар хоёрыг таньж, тэр хоёр ч баяныг таньсан. Тамд хүмүүс сэтгэн бодох чадвартай, мэдрэмжтэй, хүсэлтэй, биетэй, мэдэрхүйтэй - яг л хүн төрхөөрөө байна. Баян эр харж, сонсож, зовиурлаж байсан. Мөн “ядаж хэлээ сэрүүцүүлчих юмсан” гэсэн хүслээс нь баян эр биетэй байгааг харж болно. Тамд бие ч, сүнс ч сүйдгийг Есүс айлдсан. (Матай 10:28) Өөрөөр хэлбэл хүний бие зогсоо зайгүй галд хуйхлуулж, өтөнд идүүлж тарчлах ажээ.

Түүнчлэн баян хүн Ганц хэмээх хөсөр газрын ялтнууд шиг өршөөл эрсэн. Там бол хэзээ ч, хаашаа ч зугтах аргагүй газар! Тэндхийн хүмүүс жаахан ч атугай тайтгарлыг хязгааргүй хүсэх боловч, хэн ч тэднийг гаднаас орж ирээд тайтгаруулахгүй. Гэхдээ тэд энэ бодит байдалд хэзээ ч итгэж чадахгүй мэт. Учир нь Абрахам тэр баянд: “... эндээс наана чинь очих, наанаас чинь энд ирэхийг

хүсэгчдийн хэн ч ирж, очиж үл чадах тийм гүн ангал чи бидний дунд тогтжээ” хэмээн сануулахаас өөр аргагүй болсон. (Лук 16:26) Тамыг үзсэн нэг хүнийг би мэднэ. Түүний үзсэн хүмүүс бүгд “Тэвчихгүй нь ээ!” хэмээн бархирч байсан тухай тэрбээр хожим ярьж билээ. Дээрх ишлэлд ч тэр баян хүн яг ингэж хашхирсан.

Абрахам: “Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авахад Лазар ч тэрчлэн муугаа авсныг чи санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна. ...” гэжээ. Гэтэл баян хүн: “Эцэг минь, тэгвэл түүнийг миний эцгийн гэрт илгээхийг би танаас гуйя. Би таван дүүтэй. Энэхүү тарчлалын газар тэднийг ирүүлэхгүйн тулд Лазар тэдэнд сануулаг” хэмээн гуйжээ. (Лук 19:25, 27-28)

Та “зовлонгоо хуваалцах” гэдэг үгийг мэдэх байх. Тэгвэл энэ тохиолдолд энэ үг хэрэгжихгүй нь болтой. Баян хүн яагаад бусдыгаа өөр дээрээ ирүүлэхийг хүсээгүй вэ? Тамд “ханиндаа” гэсэн ойлголт байхгүй. Тамд үдэшлэг цэнгүүн болдог хэмээн төсөөлж явдаг хүмүүс байдаг. Бас найз нөхөдтэйгээ цугтаа орно ч гэж боддог хүмүүс бий. Энэ үнэн юм бол, баян хүн дотныхоо хүмүүсийг араасаа ирүүлэхийг хүснэ биз дээ? Гэтэл тэр бусдыгаа ирүүлэхгүйн төлөө арга баран гуйсан шүү дээ. Там нь ямар ч найдвар үгүй, ганцаардал гансралын газар. Мөн мөнхийн санамжийн газар юм. Миний бодлоор мөнхийн харуусал гэдэг хамгийн аймаар тарчлаан байх даа.

Гэхдээ дүү нарынхаа төлөө гуйсан баяны гуйлтад Абрахам юу гэж хариулсныг үзнэ үү:

“Тэдэнд Мосе ба Эш үзүүлэгчид байгаа. Дүү нар чинь тэднийг сонсог” гэхэд баян: “Үгүй, Абрахам эцэг минь, үхэгсдээс хэн нэг нь тэдэн уруу явбал тэд гэмших болно” гэв. Гэтэл Абрахам түүнд: “Хэрэв тэд Мосе ба Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ” гэжээ. (Лук 19:29-31)

Энд маш хатуу үнэнийг хэлжээ. Олон хүн Сайн мэдээний үнэ цэнийг өөртөө болоод өрөөлд батлан харуулахын тулд ер бусын юм хүсдэг. Гэтэл Есүс Бурханыг эцсээ хүртэл бүрэн дагах шиг итгэл төрүүлдэг зүйл үгүй болохыг л заажээ. Намайг бүү ташаа ойлгоорой.

Гайхамшиг үзсэн ихэнх хүмүүс нэг хэсэгтээ алмайрч өөрчлөгддөг ч, харамсалтай нь зүрхэнд нь насан туршийн итгэл бүрэлддэггүй.

Намайг зугаа цэнгэлд дуртай, өсвөр насны дэггүй хүү байхад, аав маань Чарльз Хестоны тоглосон Арван тушаал гэдэг кино үзүүлсэн юм. Би газар ангайж, хүмүүсийг там залгиж буй үйл явдлыг тэр том дэлгэцээр бүлгийтлээ үзээд, үнэн голоосоо айж, тэр киноноос цоо шинэ хүн болоод гарч билээ. Тэгээд долоо хоног л нэг их цэмцийсэн амьтан яваад, буцаад л бахь байдагтаа орсон юм. Яагаад? Яагаад гэвэл би Бурханы нигүүлслээр өөрчлүүлэхийн тулд Бурханы Үгийг сонсоогүй, зам мөрөө гэмшээгүй, Есүст амьдралаа бүрэн өргөөгүй байв.

Найз, бид хоёр өөр нэгэн гайхамшиг үзэж байсан ч, тэр явдал ч намайг өөрчилж чадаагүй юм. Харин коллежийн маань нэг найз өрөөнд минь орж ирээд, Есүс Христийн Сайн мэдээг буюу Бурханы Үгийг ярьж өгөх үед л миний амьдрал өөрчлөгдөж билээ. Бичээс ч бидэнд: “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17), “Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дахин төрсөн билээ” (1Петр 1:23) хэмээн онцлон хэлсэн буюу. Тиймээс л бид амьдралдаа тохиолдсон явдлуудаа биш, харин Бурханы Үгийг номлох ёстой юм.

Гэхдээ нэгэнт энэ тухай ярьсан болохоор бас нэгэн чухал зарчмыг хэлэлгүй өнгөрч болохгүй: Хэрэв амьдралд маань тохиолдсон явдал Бурханы Үгийг гүйцэлдүүлэн дэмжиж байвал, тэдгээр нь гайхамшигтайгаас гадна хэрэгтэй юм. Гэрчлэл нь Сайн мэдээг хүргэхэд чухал үүрэгтэй. Гэхдээ эцсийн эцэст хүн Бурханы Үгийг хүлээн авч, итгэснээр л мөнхөд амьдардаг.

“Би яагаад ийшээ явж байгаа юм бэ?”

Харин одоо би танд бидний Бичээсээс ярилцсан зүйлийг маань бүрэн болгох нэг гэрчлэл ярьж өгье. Нэгэн орой гэргий бид хоёр найзынхаа зочны өрөөнд сууж байтал, тэр бидэнд хүүхэд байхад нь тохиолдсон нэг явдлын талаар ярьсан юм. Тэрбээр Карибт өссөн бөгөөд нэг удаа борооны улирлаар барилга барихад зориулж борооны ус хуримтлуудаг нүхэнд уначихжээ. Ах нь үсэрч ороод дүүгээ аврах гэж оролдсон ч чадаагүй тул буцаж гараад, тусламж

дуудахаар гүйжээ. Найз маань сэлж чаддаггүй байж. Тусламж ирэх үед найз маань үхээд хэдийн хагас цаг гарантаа болчихсон байв. Тэрбээр биеэсээ гарахдаа, бүхий л бие мэдрэмжтэйгээ байсан тухайгаа ярьж билээ. Тэгээд маш хурдтай доошоо гүн харанхуй руу татагдаж эхлэжээ. Бүр нүүрнийхээ өмнө дэлгэсэн алгаа ч харж чадахааргүй бас яг л өөр дээрээ өмсчихсөн юм шиг гүн, хүнд харанхуй байсан тухай яриу. Тэрбээр: “Надад үнэхээр аймаар байсан. Тэгээд “Үүнээс аймаар юм гэж байхгүй” гэж л бодогдсон. Гэвч доошлох тусам, улам л их айдас төрсөөр байсан. Би дэлхий дээр хэзээ ч тэгтлээ айж үзээгүй. Үгээр хэлэхийн аргагүй айдас” хэмээн ярьж билээ.

Тэгээд цааш нь: “Тэгтэл би гэрэл ёлтойхыг хараад, там руу явж байгаагаа мэдсэн. Тэгээд: “Би яагаад ийшээ явж байгаа юм бэ? Би чинь итгэгч шүү дээ!” гээд л хашхирч эхлэсэн” гэж ярьсан юм. Найзын маань аав, ээж хүчтэй итгэгчид байсан ч, найз маань аав ээжийнхээ шахалтаар цуглаанд суухаас цаашгүй байжээ.

Тэгтэл тэрбээр айдас, тарчлааны чимээ сонсож эхлэжээ. Тэрбээр: “Жон, Лиза, дотор арзайм чарлаан гэж байдаг. Гэтэл цус царцмаар аймшигтай чарлаан гэж бас байна. Би яг тийм чарлаан сонссон” гэж хэлснийг би тод санаж байна.

–“Тэгтэл би нэг хайрстай адгуустай нүүр нүүрээрээ тулсан. Тэр надад: “Нааш ир. Чи минийх” гэж хэлсээр байсан.

Би тэр адгуустай тулалдсан. Эхлээд би айсандаа юу ч хэлж чадахгүй байсан ч, сүүлдээ: “Намайг тавь, намайг тавь!” гэж чарласан.

Тэгтэл гэнэт би биедээ эргээд орчихсон хашхирсаар, миний хоолойд хүрсэн эмчийн хурууг хазчихсан. Энэ тухай надад (намайг өөрт тохиолдсон явдлыг ярьсны дараа) ээж маань хэлсэн юм. Ээж маань тэр үеэр мэс заслын өрөөний гадна суугаад (эмнэлэг дээр) Бурханд: “Аав аа, хэрэв Та миний хүүг эргүүлж авчирбал, би Танд хүүгээ нэг мөсөн өргөе!” гэж залбирсан гэсэн” хэмээн ярьж билээ. Тэгээд найз маань Карибт үйлчлэл эхлүүлсэн анхны хүмүүсийн нэг болсон юм.

Та найзын маань түүхэнд эргэлзэж болно. Гэхдээ олон хүн яг ийм түүх ярьдаг. Эмч нарын нүдэн дээр үхээд сэхсэн тохиолдол ч олонтаа гардаг, энэ талаар судалгаа хийсэн хүн ч цөөнгүй байдаг.

Тэдний нэг нь нэн ялангуяа үхээд сэхсэн хүүхдүүдийг нарийн судласан Мэлвин Морз гэдэг эмч юм. Доктор Морз хоёр бүлэг хүүхдүүдийг судлажээ. Эхний бүлэгт нь хүнд өвчтэй боловч,

үхэлд хүрээгүй 123 хүүхэд байжээ. Тэд бол хиймэл амьсгалын аппаратанд залгаатай, эрчимт эмчилгээнд эсвэл хүнд эмийн эмчилгээнд байдаг, гурваас арван зургаан насны хүүхдүүд ажээ. Гэхдээ тэдний нэг нь ч биеэсээ гарсан тохиолдол байхгүй.

Хоёр дахь бүлэг нь дээрхтэй ойролцоо насны 12 хүүхдээс бүрдэж байв. Тэд живэх, машины осолд орох, зүрх нь гэнэт зогсох зэрэг тохиолдлоор бүгд биеэсээ гарч үзсэн байв. Зарим нь хэсэг зуур биеэсээ гараад, эмч нар тэднийг сэхээн амьдруулах гэж юу юу хийснийг хожим дүрслэн ярьжээ.

Та найзыг маань хий юм үзжээ гэж хэлэх байх. Гэхдээ тэр хүмүүсийн харсан зүйл нь хий үзэгдэл биш гэдгийг тэр хүүхдүүд дээр хийсэн судалгаа ч батладаг. Тэгээд ч клиник үхлээр гуч гаруй минут тасарчихсан хүн хэзээд нь хий юм үзэж харах билээ?

Хайдас болон Галт нуур

Дээрх найзаас минь гадна миний өөр хэд хэдэн найз ч Хайдас гэдэг түр хоригдох тамыг үзсэн юм. Энэ нь аврагдаагүй хүмүүсийн мөнхийн гэр биш, харин Аугаа их цагаан сэнтийн шүүх болтол хоригдох түр хорих там юм. Аугаа их цагаан сэнтийн шүүхийн дараа хүн, чөтгөр, нүгэлт тэнгэрэлч нарын мөнхөд цөлөгдөх эцсийн газар нь Галт нуур болно. Үүнийг Бичээсээс ч тодорхой харж болно.

Цагаан өнгөтэй агуу сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов. Дотроо байсан үхэгсдийг тэнгис гаргаж өгөв. Үхэл ба Үхэгсдийн орон өөрсдийн доторх үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэгбүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв. Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Мөн амийн номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав. (Илчлэл 20:11, 13-15)

Эндээс Хайдаст буюу түр хоригдох тамд байсан хүмүүс бүгд шүүхийн өмнө ирж байгааг харж болно. Шүүх дууссаны дараа буруу хэрэг болгон, хууль ёсгүй явдал үйлдэгсэд, чөтгөрүүд, нүгэлт тэнгэрэлч нар тэгээд Хайдас өөрөө ч Галт нуурт хаягдах ажээ.

Галт нуурын үзэгдэл

Гэргий бид хоёрын нэгэн Грек найз бий. Түүний гэргийг Баярхөөр гэдэг бөгөөд гэр бүлээсээ Эзэнд үйлчилж яваа гурав дахь үеийн үйлчлэгч. Баярхөөрийн эмээ нь Грект төрж өссөн хүн агаад хүүхэд байхаасаа л Бурханыг хайж эхлэжээ. Гэтэл хавь ойрынх нь хүмүүс охины асуултыг элэглэн шоолдог байж. Охин чуулганд явахыг хүссэн ч, “Бурхан гэж байдаггүй юм аа, наад дэмийрлээ зогсоо” гэсэн үг л сонсчээ.

Нэгэн удаа охин Грек наадмаар тосгоныхоо талбай дээр найзуудтайгаа ардын бүжиг бүжиж байтал, нэгэн дуу хоолой “Эфросини, чи мөнхийн бүжгийг хай” гэж хэлэх шиг болжээ.

Охин зог тусаад: “Хэн бэ?” хэмээн гайхшрав. Тэгээд бүжгээ зогсоогоод, учрыг нь олохоор гэр рүүгээ гүйжээ. Охин гүйж явахдаа, нуруун дээр нь ямар нэг хүнд юм хүчтэй дарахыг мэдэрч гэнэ.

Гэртээ очмогцоо Эфросини шууд өрөөндөө ороод, өвдөглөн суугаад, асгартал уйлж эхлэжээ. Охин тэр дуу хоолойтой ярихыг хүсэв. Түүнтэй хэн ярив? Түүнд хэлсэн тэр үг ямар учиртай үг вэ? Тэр дуу түүнд юу хэлэхийг хүсээ вэ? Охиныг эдгээр асуулт шаналгасан ч, энэ нь нэг их удаан үргэлжилсэнгүй. Эфросинийг шалан дээр сөхөрч суухад, түүнийг залгихаар өрөөнд нь гал орж ирэх шиг болжээ. Охин гэдрэг унаад үзэгдэл үзэв.

Үзэгдэл дотор тэнгэрэлч шиг цагаан хувцастай нэгэн түүнийг өргөж авч яваад, сүүмийсэн гэрэлтэй газар аваачаад үлдээчихэв. Охин сайтар ажигласнаа Голгот дахь үйл явдлыг гэрчлэн харж байгаагаа ойлгожээ.

Эзэн загалмай дээр өлгөөтэй... шархнаас нь цус урсаад л... Эзэний царайнаас аймшигтай зовлон тарчлаан үзэгдэнэ.

Яг үүнтэй зэрэгцэн Эфросини алс холоос жихүүцмээр чарлаан хадахыг сонсжээ. Охин тэр чарлаан хаанаас хадаж байгааг мэдэхээр эргэтэл, загалмай хийгээд цаана буй газрын хооронд газрын гаваас том том галан давалгаагаар хэрхрэх агуу том ангал байхыг үзэв. Энэ бол галан тэнгис ажээ. Үй түмэн хүний чарлаан шиг дуу сонсдоно. Тэд Бурханыг харааж байлаа. Гэтэл нэгэн хүч охины толгой дээрээс тэр ангал руу доош дараад, мөнөөх танил дуу: “Энэ бол чиний очих гэж байгаа газар” гэж хэлжээ.

Охин үхтэл айж, уйлан хайлан өршөөл эрэв. Тэгээд өмнө

мэдэрч байсан нөгөө жиндээ дарагдан, загалмайн хөлд сөхрөөд, нилээд удаан суужээ. Гэтэл хайр, энэрлээр дүүрэн мөнөөх дуу дахин: “Тэр чиний төлөө үүнийг хийсэн! Тэр чиний төлөө үхсэн! Уучлал гуйж, чиний төлөөх Түүний тахилыг хүлээж авбал, чи галт нуур руу явахгүй!” гэжээ.

Үүнийг сонсоод Эфросини цурхиран уйлж, хэлснээр нь үйлдэн, уучлал гуйтал түүний дээрх дарамт өргөгдөн, өнхөрсөөр загалмайн хөлд хаягджээ.

Эфросинийг толгойгоо өргөтөл, өмнө нь сүр жавхланта хувцастай Есүс зогсож байв. Тэрбээр охиныг аваад, хамгийн үзэсгэлэнтэй ногоон уулан дээр аваачжээ. Одоо охин Эзэнтэйгээ шууд ухаан ухаанаараа харилцаж байлаа. Охин асуугаад л, Эзэн хариулаад л. Гайхамшигтай байв! Охин Эзэнээс хаашаа явж байгаагаа асуутал, Эзэн “Тэнгэрийн Аавтай чинь уулзуулахаар” гэж хариулжээ.

Тэднийг уулын оргил дээр ирэхэд, хаалганы цаанаас гэрэл цацарч байв. Эргэн тойрон дахь цэцэгс, моддоос тэнгэрийн үзэсгэлэнт аялгуу, дуу эгшиглэнэ. Тэд оргил дээр гараад, хаалгаар оров. Үгээр хэлэшгүй гоо үзэсгэлэнтэй, гайхамшигтай байв!

Тэгээд тэд шууд сэнтий рүү очив. Бурханы царай халхлагдсан байсан тул Эфросини Бурханы царайг үзэж чадаагүй ч, аварга том номыг бас үүлнээс сунгаатай гар байхыг үзжээ. Тэгтэл тэр гар бичиж эхлэв. Охин юу бичсэнийг нь харахаар тонгойсноо, Амийн номд өөрийнх нь нэрийг бичсэн байхыг үзээд мэл гайхав! (Гэхдээ тэрбээр тухайн үедээ Амийн ном байсныг нь мэдээгүй юмсанж)

Тэнгэрийн Аав нь Эфросинигийн нэрийг Амийн номд бичээд “Тэр бүлдээ тавтай морил!” гэж хэлээд, охины духыг нь үнэрлэжээ. Тэгтэл тэнгэрэлч нар үлэмж баярлалдан дуу дуулан, тойрон бүжиж эхлэв! Тэнгэрэлч нар бүжихдээ охины нэрийг дуулцгааж байлаа. Охин ч бас тэдэнтэй нийлэв. Гэхдээ тэнгэрэлч нар охиныг аврагдсанд нь баяр хөөр болон тэмдэглэж байсныг охин бүр сүүлд нь л ухаарчээ.

Хэсэг хугацааны дараа Эзэн Эфросинид, одоо түүний дэлхий рүү буцах цаг нь болсон бөгөөд түүнд их хувь тавилан зэхсэн тухайгаа хэлээд, түүнийг Өөрийнх нь нэрийн төлөө гал мэт амьдралыг туулах боловч, Бурхан түүнтэй үргэлж хамт байж, энэ бүхнийг дуусахаар нь түүнийг Өөр дээрээ дахин авна гэжээ.

Яг тэр үед Эфросини буцаад өрөөндөө ирчихсэн байв. Охин тэнгэрийн аялал нь тийм хурдан дууссанд гонсойсон ч, түүнд өөр сонголт байсангүй.

Эфросинид тохиолдсон явдлын талаарх мэдээ тосгоноор нэг тарах үед түүний хавчлага эхлэжээ. Энэ хавчлага нь итгэлээсээ няцахгүй бол сүхдэж ална гэсэн аавынх нь сүрдүүлгээр эхлэв. Гэхдээ Эфросини өөрийн биеэр үзсэн зүйлээ худлаа хэмээн няцааж чадахгүйгээ хэлжээ.

Ийнхүү хавчлага нь ширүүсэн ширүүссээр нэгэн орой Эфросинигийн дүү охин нь эгч дээрээ ирээд өглөөгүүр хүмүүс гэрт нь ирээд, Эфросинийг Грекийн ортодокс сүм байдаг тосгоны төв талбайд аваачаад, сүмээс гаргаж авчирсан Мариагийн гуутай дүрд мөргөж үнсэхийг шаардах бөгөөд мөргөхгүй аваас эгч рүү нь шатахуун цацаад, галдан шатаах гэж байгааг хэлжээ.

Эфросини хүмүүсийг арай ч ийм юм хийхгүй байлгүй гэж бодсон ч, энэ явдал үнэн байж таарав. Учир нь тэр шөнөдөө Эзэний тэнгэрэлч унтаж буй Эфросинийг мөрөн дээр нь товшин сэрээгээд, хувцаслаад үүдэн дээрээ гараад ир гэжээ. Охин үгэнд нь орж, довжоон дээрээ гаргал, хэн нэг нь түүнийг газраас өргөхийг мэдрэв. Тэрбээр бодитоор хэдэн километрийн цаана байдаг, зэргэлдээх тосгон руу шилжүүлэгджээ.

Төсөөлөгдөшгүй тамлал

Эфросини Хайдасыг үзээгүй, харин “хоёр дахь үхэл” гэгддэг Галт нуурыг үзжээ. Тэрбээр Есүс Христийг чин зүрхээрээ дагах сонголт хийсэн учраас хувь тавилангаа өөрчилсөн юм. Бичээс:

Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм (Илчлэл 21:8) гэдэг.

Энэ нь “гал ба хүхрээр шатагч нуур” гэдгийг анхаарна уу. Хүхэр нь өндөр халуунд шатдаг, маш муухай үнэртэй, метал бус бодис юм. Тамыг үзсэн хүмүүс тэндхийн үнэрийг “гэвчихийн аргагүй” гэж дүрслэдэг. Үнэндээ үхлийн энэ газрыг үзсэн хүмүүс тэнд мэдрэгддэг аймшгийг хүний хэлээр дүрслэн тайлбарлах боломжгүй гэдэг юм.

Түүнчлэн хоёр дахь үхэл гэдэг хэллэгийг анхаарна уу. Есүс “Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун. (Энэ

нь Тэрбээр энэ үгээ итгэгч бус хүмүүст хандаж хэлээгүй гэсэн үг) Ялагч нь хоёр дахь үхлээр гэмтэхгүй” (Илчлэл 2:11) гэж хэлсэн.

Есүс чуулганд ийм үг хэлэх учиргүй гэж бодож байна уу? Гэвч галт нуурт гурван төрлийн хүмүүс орохыг дээрх ишлэлд хэлснийг анхаарна уу. Эхнийх нь Түүнийг дагахаа больсон хүмүүс, хоёр дахь нь Түүнд итгэмжгүй байсан хүмүүс, гурав дахь нь Түүнтэй хэзээ ч нийлээгүй нүгэлтнүүд юм. Тэгэхээр, эхний хоёр төрөл нь чуулганд явдаг хүмүүс болж таарч байна.

Манай түүхэнд гарсан эхний гурван хүнийг санаж байна уу: Бүрэг, Мэхлэгдэгч, Бие даагчийг? Хоёр нь Энделийн сургуульдаа маш идэвхитэй байсан. Энэ нь тэд чуулгандаа идэвхитэй байсан гэсэн үг юм. Энэ талаар бид удахгүй дэлгэрүүлж ярина.

Хоёр дахь үхэл гэдэг нь мөнхийн мөнхөд Галт нуурт хаягдах тамлал юм. Мөнхийн мөнхөд гэдэг нь төгсгөлгүй, амралтгүй, чөлөөгүй, үүрд мөнх гэсэн үг болохыг бид эхнийхээ бүлгээр үзсэн. Зарим нь энэ зовлонг эрт орой хэзээ нэгэн цагт төгсгөл болно гэж бодож байж болох ч, Бурхан тэгж хэлээгүй. “Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна.” (Илчлэл 20:10)

Энэ зовлон хэзээ ч дуусахгүй гэдгийг баттай ойлгуулахын тулд Есүс Өөрийнх нь үгийг дагадаггүй хүмүүсийн тухай: “Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм” (Матай 25:46) гэж айлдсан байдаг.

“Мөнхийн шийтгэл” гэдэг үгийг анхаарна уу. Өөрөөр хэлбэл тэр шийтгэл хэзээ ч дуусахгүй, мөнхийн шийтгэл юм. Есүс мөн:

“Нүд чинь чамайг бүдрүүлвээс ухаж хая. Хоёр нүдтэйгээ тамд (Гехенна) хаягдсанаас өрөөсөн нүдтэйгээ Бурханы хаанчлалд орох нь чамд дээр” гэж хэлсэн. (Марк 9:47)

Есүс энд ч бас Галт нуурын (Гехеннагийн) тухай ярьж байна. Одоо энэ үгийг өөр орчуулгад юу гэж хэлсэн байдгийг үзье:

“Нүд чинь чамайг итгэлээ алдахад хүргэх гээд байвал, аваад хаячих! Хоёр нүдтэйгээ тамд хаягдсанд орбол, ганц нүдтэйгээ Бурханы хаанчлалд орох нь чамд дээр буюу. Тэнд “тэднийг идэх өт нь хэзээ ч үхэхгүй, тэднийг хуйхлах гал нь хэзээ ч унтрахгүй.”” (Марк 9:47-48)

Тэднийг идэх өт нь хэзээ ч үхэхгүй, эцэс төгсгөлгүй мэрсээр байна. Үүнийг амьдралтай жишиж үзье. Хүнийг үхэхэд, бие нь өт хорхойнд идэгдэж дуусаад, яс нь л үлддэг. Төдөлгүй өт хорхой нь ч өөрөө үхдэг. Гэтэл Гехенна дахь өт хорхой нь хэзээ ч үхэхгүй. Учир нь тэдний идэш нь хэзээ ч үгүйрч дуусахгүй юм. Тамыг үзсэн нэг хүн галын дөлд тамлагдаж байгаа хүмүүсийн хэзээ ч үгүйрч алга болохгүй биеийг бэлцийсэн том өтнүүд хэзээ ч идэж дуусахгүйгээр мэргэж байгааг харсан байдаг.

Тийм ээ, та яг зөв ойлгож байна - там бол үнэхээр төсөөлөхийн аргагүй газар! Гэхдээ бид нэг зүйлийг мэдэх хэрэгтэй. Бурхан тамыг анхнаасаа хүнд зориулж бүтээгээгүй. Энэ аймшигт газар хаягдсан хүмүүст Есүс юу гэж хэлснийг үзнэ үү:

“Хараагдагсад аа, Надаас зайл. Дявол болоод түүний тэнгэрэлч нарт бэлтгэсэн мөнх галд ор.” (Матай 25:41)

Галт нуур нь хүнд биш, харин дьяволд болон түүний нүгэлт тэнгэрэлч нарт зориулагдсан юм. Гэвч дьявол хүмүүсийг олноор нь мэхлэн, өөртэйгээ хамт мөнхийн шийтгэлд оруулсаар байна. Манай түүхэнд ч бас яг ийм явдал гардаг. Дагоны нөлөөнд олон хүн орсон тул Жэйлин ганц Дагон дээр буулгах гэж байсан уур хилэнгээ тэдгээр хүмүүс дээр ч буулгахаас өөр аргагүй болсон. Эс бөгөөс Жэйлин өөрөө шударга бус нэгэн болно.

Мөнхөд сайн сайхан амьдрах

Өмнөх бүлгээрээ бид Жэйлиний уур хилэнг тодорхой харсан. Илчлэл 14:10-11 дээр “...тэр хүн Бурханы уур хилэнгийн дарсыг мөн уух болно. Энэ нь Түүний уур хилэнгийн аяганд шингэлэлгүй хольсон дарс юм. Тэр хүн ариун тэнгэрэлч нар ба Хурганы өмнө гал, хүхэр дотор зовж тарчилна.

Тэдний зовлон тарчлалын утаа үеийн үед суунаглана. Араатанд ба түүний хөрөгт мөргөгсөд, түүний нэрийн тэмдгийг хүлээн авсан алив хүн өдөр ч, шөнө ч амрахгүй” гэжээ.

“Мөнхийн мөнх” гэдэг үгийг дахин бодоод үз. Нэгдүгээр бүлэгт бид үүрд мөнхийн талаар ярилцсаныг санаж байна уу? Бид “хэзээ ч дуусахгүй” гэдэг ойлголтыг ухаарах гэж оролдсон.

Үүнийг хүн ухаанаараа ойлгож чадахгүй ч, зүрхээрээ ойлгож чадна. Тиймээс л Бурхан Өөрийг нь сонсохгүй байгаа бүхэл бүтэн нэг үеийнхэний төлөө:

Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээж, Миний бүх тушаалыг сахин тэд бас тэдний хүүхдүүд үүрд сайн сайхан байх болтугай! (Дэд хууль 5:29) хэмээн гашуудсан байдаг.

Үүрд гэдэг үгийг анхаарна уу. Ай хөөрхий, энэ хүмүүс мөнхөд тогтох өнө мөнхөөр амьдрахгүй яв даа!

Түүнчлэн Бурхан “үргэлж... Миний тушаалыг сахин” гэжээ. Бурхан “хэсэгтээ... Миний тушаалыг сахин” гэж хэлээгүй. Түүнчлэн “үргэлж... Миний зарим нэг тушаалыг сахин” гэж хэлээгүй. Бид Бурханы бүх тушаалыг цаг үргэлж сахих ёстой!

Та яг одоо: “Би Бурханы бүх тушаалыг цаг үргэлж сахиагүй. Тэгэхээр, шүүхээр яллагдах нь ээ” гэж бодож байгаа байх. Тийм ээ, таны зөв. “Бүх хүн Бурханы зөвийн жишигт хүрээгүй бөгөөд шүүхээр яллагдана” гэдгийг Бурханы хууль ч баглан хэлдэг. Бурханы өмнө зогсоод: “Би Таны хаанчлалд зохистой амьдарсан учраас мөнхөд шийтгүүлэх ёсгүй” гэж хэлж чадах нэг ч хүн байхгүй.

Энэ бүх уналт нь анх цэцэрлэгт байсан нэг хүн Бурханы үгийг зориуд зөрчсөнөөс л болжээ. Ийнхүү тэрбээр нүглийн мөн чанарыг өвлөсөн юм. Тэрбээр урван тэрслэлээрээ Сатаны ноёрхол дор орж, түүний боол болжээ. Түүнд өөрийгөө аврах юмуу чөлөөлөх ямар ч арга байгаагүй. Тэгээд хүн аав, ээжийгээ дуурайж төрдөг жамаар Адам, Ева хоёрын үр удам болсон хүн төрөлхтөн тэр чигээрээ тэр хоёрын нүгэлт мөн чанарыг өвлөж авчээ.

Хүн энэ бүхнийхээ төлөө хариуцлагаа үүрэх ёстой байсан ч, Бурхан хүн - биднийг хайрласандаа энэ байдлаас минь аврах Аврагчийг илгээхээ амласан юм. Тэр Аврагч нь Есүс Христ болой. Түүнийг онгон бүсгүйгээс төрөхийг хэдэн зуун жилийн өмнө зөгнөсөн байдаг. (Исаиа 7:14) Түүний Аав нь Бурхан бол, ээж нь Давидын удмын Мариа хэмээх онгон охин байв. Хэрэв аав, ээж хоёр нь хоёулаа хүн байсан бол, Есүс Адамын мөн чанарыг өвлөн, нүглийн боол болж төрөх байжээ. Тийнхүү төгс амьдралаар амьдарч чадахгүй учраас, хүн төрөлхтнийг ч аварч чадахгүй байв. Тэгвэл Есүс яагаад эмэгтэй хүнээс төрөх ёстой байсан бэ? Учир нь нүглийг хүн үйлдсэн учраас, хариуцлагыг нь

хүн л өөрөө хүлээх ёстой байв. Тиймээс л Есүс зуун хувь Бурхан бас зуун хувь хүн байсан юм.

Есүс загалмай дээр хадуулахдаа, хүний бүх нүглийг Өөр дээрээ авч, үхтэлээ цусаа урсган, хүний нүглийн төлөөсийг төлжээ. Гэхдээ Есүс төгс зөвт амьдралаар амьдарсан учраас, Аав нь Түүнийг үхлээс амилуулаад, Өөрийнхөө баруун гарт суулгасан юм. Эш үзүүлэгч бас Есүсийн өвөг - Давид хаан Есүсийн загалмайн үхлийн дараа юу болохыг тэртээ мянгаад жилийн өмнө зөгнөсөн байдаг. Давидын энэ үгийг Пентекост өдөр Петр эшлэн тунхагласан юм.

“Тэр эш үзүүлэгч байсан учраас түүнд Бурхан андгайлсанчлан өөрийнх нь үрээс сэнтийд нь залахыг мэдээд, Христийн амиллыг угтан харж, “Тэр Үхэгсдийн оронд (Хайдаст) орхигдсонгүй, махбод нь ч ялзралыг үзсэнгүй” гэжээ. Энэ Есүсийг Бурхан амилуулсан, бид бүгд үүний гэрч нар мөн.” (Үйлс 2:30-32)

Есүс биднийг чөлөөлөхийн тулд үхлээс амилуулагдсан. Петр Есүсийг Хайдаст үлдээгүй гэж хэлсэн байгааг анхаарна уу. Энэ нь Есүс тэнд очсон гэсэн үг юм. Есүс бүх хүнийг авах ёстой мөнхийн шийтгэлээс нь чөлөөлөхийн тулд бүх хүний төлөө үхлийг буюу тамыг үзжээ. Өдгөө бид амиа бодсон амьдралаасаа татгалзаж, амьдралаа тэр чигээр нь Есүсийн Эзэний эрх мэдэлд өгвөл, бидний төлөө цусаа урсгаж, үхлийг үзсэн Түүний үйлс нь нэг талаараа биднийг буцааж худалдаж авах төлөөс, нөгөө талаараа Бурханы өмнө зөвтгөх зөвтгөл болж байгаа юм. Бид Түүний өмнө зөвт хэмээн тооцогдож, Шүүх сэнтийн өмнө итгэл дүүрэн зогсож чадна. Бурханыг магтаарай!

Ийм учраас л бидэнд “Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно” (Ефес 2:8-9) хэмээн анхааруулжээ.

Хэрэв та Эзэнийхээ эрх мэдэлд захирагдалгүй, гэмт замаараа дур мэдэн амьдарч явснаа Бурханы өмнө хэзээ ч гэмшиж яваагүй бол, яг одоо номынхоо арын хуудсанд байгаа хавсралтыг нээгээрэй. Тэнд таныг аврах Бурханы төлөвлөгөөг тайлбарлаж, Есүс Христийг өөрийнхөө Эзэн ба Аврагчаар хэрхэн хүлээж авахыг заасан байгаа.

Сүүлийн хэдэн хуудсаараа бидний ярьсан зүйлсийг итгэгчид

сайн мэддэг. Гэхдээ тэд дараагийн хэдэн бүлгээр үзэх зүйлсийн талаар бараг юу ч мэддэггүй гэж хэлж болно. Тиймээс ч Бичээсийн хувьд хамгийн энгийн тооцогддог эдгээр үнэнийг үзээд олонх нь шоконд орох байх. Түүнчлэн мөнхийн шийтгэлийн талаарх үнэн нь яагаад итгэгч бүрийн эрүүл саруул өсөлтийн амин чухал суурь болдгийг дараа дараагийн бүлгээрээ үзье.

МЭХЛЭГДЭГЧИЙН ШҮҮХ

*Ийм зүйлсийг үйлддэг хүмүүс дээр буух Бурханы шүүлт нь
үнэний дагуу байдгийг харин бид мэднэ.*

—Ром 2:2

Есүс биднийг хайрласандаа л анх Сатанд болон түүний хамсаатнуудад зориулж бий болгосон нүглийн мөнхийн шийтгэлээс аврахаар ирсэн билээ.

Бодоод үз. Эзэн анх хүн төрөлхтнийг ан амьтад, шувууд, шавьж, далайн амьтад хийгээд агаар ус - дэлхий дээрх бүх юмстай нь төгс төгөлдөр бүтээсэн. “Өөрийнх нь буй болгосон бүгд нэн сайн болсныг Бурхан харлаа.” (Эхлэл 1:31) Дараа нь Эзэн энэ бүх бүтээлээ “эзэн нь болж яваарай” хэмээн хүнд гардуулжээ. Дуулаач: “Тэнгэрс бол ЭЗЭНий тэнгэрс, Харин дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгчээ” (Дуулал 115:16) гэдэг. Өөрийгөө төдийгүй, бүх бүтээлийг Бурханы хамгийн том дайсан Люсиферээс хамгаалах нь Адамын үүрэг хариуцлага байв.

Бурхан Өөрийг нь хайрлаж, дагаж, Өөртэй нь харилцаа тогтоох чөлөөт хүсэлгүй роботуудыг бүтээхийг хүсээгүй. Тиймээс л Бурхан Адамд цэцэрлэг доторх зүйл зүйлийн модод дундаас нэгэн модыг онцлон заагаад: “Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж болохгүй. Түүнээс идсэн тэр өдөртөө л чи зайлшгүй үхнэ! (Эхлэл 2:16-17) гэжээ.

Бурхан энд махан биеэр үхэх тухай яриагүй юм. Учир нь Адам тэр өдрөөс хойш нилээд урт наслаж байж өөд болсон. (Гэхдээ энэ нь ч бас дуулгаваргүй зангийнх нь л үр дагавар байв) Эзэн энд “үхнэ” гэж хэлэхдээ, хүн Бурханы амиас таслагдаж, Люсиферийн мөн чанарыг өвлөх тухай л хэлжээ.

Гэтэл хэсэг хугацааны дараа Люсифер Евад Бурханы мөн чанарыг муучлан дөнгөөд, эмэгтэйн анхаарлыг бусад бүх моддоос салган, хориотой ганц модон дээр тусгаж чаджээ. Эмэгтэй модыг үнэхээр сайн сайхан, ач тустай, таатай гэж хармагцаа аваад идчихсэн. Яагаад гэвэл Ева одоо Эзэнийг өглөгч биш, харамч нэгэн гэж үздэг болжээ. Гэхдээ хүн төрөлхтөн энэ үедээ ч хараахан нүгэлд унаагүй байв. Харин Евагийн нөхөр тэр модны жимснээс хүртэх үед л Бурханы бүтээл нүгэлд унаж, үхлийн мөн чанарыг өвлөсөн юм. Тиймээс Адамын нүгэл хавьгүй ноцтой байв. Учир нь эмэгтэй мэхлэгдсэн бол, харин эрэгтэй нь мэхлэгдээгүй - тэр бүгдийг мэдэж байсан юм. (1Тимот 2:14-ийг үзнэ үү)

Үүнээс болж Адам төдийгүй, түүний хариуцаж байсан бүх бүтээл үхлийн мөн чанартай болжээ. Адамыг урван тэрслээгүй байхад ан амьтад мах ч иддэггүй, үхлийг ч үздэггүй байсан. Хар шуурга, газар хөдлөлт, хуй салхи, гамшиг, өвчин, хортон гэж байгаагүй. Энэ бүхэн нь Бурханы даалгасан зүйлсийг хамгаалж чадаагүй хүний нүглийн урхагаар бий болжээ.

“Учир нь бүтээл өөрийнхөө хүслээр бус, харин өөрийг нь захирсан Түүний улмаас хоосонд захирагдсан боловч найдвар дор бүтээл өөрөө ч мөн ялзралын боолчлолоос чөлөөлөгдөж, Бурханы хүүхдүүдийн алдрын эрх чөлөөнд очих юм.”
(Ром 8:20-21)

Байгаль өөрийнхөө сонголтоор бус, харин Бурханд дуулгаваргүй загнасан хүний нүглээс болж харагджээ. Нарийндаа бол өөрт нь даалгасан зүйлийг хамгаалж чадаагүй Адамаас болж харагдсан. Адам байгаль дэлхийг төдийгүй, өөрийгөө, гэргийгээ, үр удмаа Бурханаас таслагдах Люсиферийн хараалд тушаасан юм. Аймшигтай урвалт байгаа биз!

Энэ үед Бурхан: “Миний хайрлаж, ерөөж, төгс бүтээсэн хүн төрөлхтөн Намайг биш, Люсиферийг сонгов. Бүгдийг нь Галт нуурт хаячихаад, Бүгдээрээ (Аав, Хүү, Ариун Сүнс гурав) бүхнийг дахин шинээр эхлүүлье. Бидэнд үнэнч байж, Биднийг хайрлаж, Биднээр хайрлуулах өөр нэг ертөнц бүтээчихье” гэж хэлж болох л байсан.

Энэ нь ч туйлын шударга шийдвэр болох байлаа. Гэтэл Эзэн биднийг хайрласандаа л сайн дураараа “дагаар орсон” нүглийн

хүлээсээс маань биднийг чөлөөлөх Аврагчийг илгээхээ амласан билээ. Тэр Аврагч нь Бурханы газар тэнгэрийг хамтран бүтээлцсэн Хүү нь байв. Өөрөөр хэлбэл Хүү Өөрөө ширхэг ч нүгэлгүй боловч, биднийг эхнээсээ эцсээ тултлаа хайрласандаа л нүгэл, үхлийн маань аймшигтай төлөөсийг бидний өмнөөс төлжээ. Энэ хайрыг ойлгох арга байхгүй.

Голготын хамаг учир ийм л ажээ. Тиймээс итгэгч хүмүүс итгэгч биш хүмүүсийн: “Бурхан хүмүүст тийм л их хайртай юм бол, яагаад сайн мэдээ сонсоогүй хүмүүсийг тамд хаяж чаддаг байна аа?” гэсэн үгд таг дуугүй зогсохыг нь хараад би гайхдаг. Тэгж ярьж байгаа хүмүүст би шууд л: “Энэ чинь Бурханы биш, бидний буруу” гэж хэлдэг. Есүс хүн төрөлхтнийг чөлөөлөхөөр аймшигтай төлөөсийг нь төлсөн. Дараа нь энэ Сайн мэдээг сонссон хүмүүсийг дэлхий даяар яваад, “Есүс биднийг чөлөөлсөн!” гэдгийг бүх хүнд хэлээрэй гэсэн. Тиймээс Сайн мэдээ нь Бурханы биш, бидний хариуцлага!

Бурханы мөн чанарыг авах

Есүс бидний нүглийн шийтгэлийг төлөөд зогсохгүй мөн бидэнд яг Өөртэй нь адилхан мөн чанартай болох боложмийг нээж өгсөн юм. Хүн амьдралаа Есүст өргөхдөө нүглийн боол байхаа больж, цоо шинэ бүтээл болдог.

“Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!”
(2Коринт 5:17)

Бид Есүс Христийг Эзэнээ болгохдоо яг бодитоор үхдэг. Бурханы мэлмийд бидний хуучин мөн чанар Христтэй хамт цовдлогдон үхэж, Бурханы мөн чанартай, цоо шинэ хүн мэндэлдэг. Бид ингэж л төрдөг. Ийнхүү бид хуучин мөн чанараасаа чөлөөлөгдсөн. Бичээс: “Тиймд бид үхэл уруу баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм. ... Ингэхдээ хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй, бидний нүглийн биеийг хүчингүй болгохын

тулд хуучин хүн маань Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг. Учир нь үхсэн нь нүглээс чөлөөлөгдсөн. Хэрэв бид Христтэй хамт үхсэн бол мөн Түүнтэй хамт амьдрах болно гэдэгтээ бид итгэдэг” (Ром 6:4, 6-8) хэмээн маш тодорхой хэлжээ. Тиймээс өдгөө бид Адамын урван тэрслэлээс болж боолчлогдсон мөн чанараараа биш, Христийн мөн чанараар амьдарч чадна.

Христэд итгэдэг хүн итгэдэггүй хүний амьдралыг жигшин зэвүүцэх нь мунхаг юм. Тэр хүний сүнслэг ДНХ нь нүгэлтэй учраас, тэрбээр түүнийхээ дагуу л амьдрах нь аргагүй. Харин “итгэгч” нэртэй хүн тогтмол бас зоргоороо нүгэл үйлдэх нь жирийн бус явдал буюу жинхэнэ аймшиг юм. “Итгэгч” гэдэг үгийг хашилтад хийсэн маань учиртай. Учир нь нүгэл үйлддэг тэр хүн аман дээрээ Есүсийг өөрийнхөө Аврагч, Эзэн гэж хэлдэг ч, хэрэг дээрээ Есүс түүний Аврагч Эзэн огт биш байж мэдэх юм. Яагаад гэвэл Есүс үнэхээр л түүний Аврагч Эзэн юм бол, тэрбээр Есүсийн мөн чанараар л амьдрах ёстой. Есүс ч үүнийг тодорхой хэлсэн:

“Үүнчлэн сайн мод бүр сайн жимс гаргадаг бол муу мод муу жимс гаргадаг. Сайн мод муу жимс эс гаргана, муу мод ч сайн жимс эс гаргана. Сайн жимс гаргадаггүй аливаа модыг огтоолж галд хаядаг. Тэгэхээр та нар тэднийг үр жимсээр нь танина.”
(Матай 7:17-20)

Есүс ямар нэг салаа утгатай, ээдрээтэй юм яриагүй. Модны үр жимсийг гаргагч эх үүсвэр нь жимс өөрөө биш, харин модны мөн чанар нь юм. Гэхдээ үр жимснийх нь чанараар модны чанасаар мэдэж болно.

Сайн нэрсний модноос л сайхан нэрс гарна. Харин хортой нэрс гарсан байвал, мод нь ч ялгаагүй хортой ажээ. Үр жимс нь модныхоо баталгаа буюу гэрчилгээ болно. Тиймээс л хүн жинхэнэ итгэгч мөн эсэхийг хэл яриа, шашинлаг дүр төрх эвсэл бүр Христийн цуглаанд их бага очдогоор нь биш, харин үйл хэргээр нь танина гэдгийг Есүс хэлжээ. Түүнээс амь биеэ үл хайрласан, хаанчлалын төлөө гэсэн үр жимс гарч байна уу эсвэл элч Иоханы бичсэн шиг амиа хичээсэн, дэлхийг хайрласан жимс гарч байна уу?

“Хорвоо хийгээд хорвоогийн юмст бүү дурла. Хэн нэг нь хорвоод дурладаг бол түүнд Эцэгийн хайр алга. Учир нь хорвоод

байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ хорвоогоос юм. Хорвоо хийгээд түүний хүсэл тачаал өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлдэгч нь мөнхөд оршму.”
(1Иохан 2:15-17)

Лиза бид хоёр энэ үнэнийг хөвгүүддээ ойлгуулах гэж нилээд юм болсон доо. Хөвгүүд маань Христчин сургууль төгссөн юм. Гэтэл аав ээжийгээ даган чуулганд тогтмол явдаг, өөрсдийгөө итгэгч гэдэг ангийнх нь хүүхдүүд Бурханы хүсэлд дурлахын оронд өөрийнхөө л төлөө амьдарч, Христээс тэс өөрөөр авирлахыг хөвгүүд маань хардаг байлаа.

Энэ бол түгээмэл байдаг нэг л жишээ. Аман дээрээ Христэд итгэдэг гэж хэлдэг ч, амьдрал дээрээ тэс өөр үр жимс ургуулдаг ийм хүмүүс гэр бүл, бизнесийн ертөнц, тэр бүү хэл чуулганд болон үйлчлэлд дүүрэн бий.

“ХЭВШМЭЛ ИТГЭЛ”

“Гэмшлийн залбирлаар залбираад, Есүсийг Эзэнээ болгоод авбал, шууд аврагдах нь тэр.” Ийм хазгай ойголтоор бид Сайн мэдээг бохирложээ. Гэтэл Есүс ийм юм огт яриагүй. Матай 7:21 дээр Есүс: “Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орно гэж байхгүй шүү” хэмээн анхааруулсан. Есүсийн энэ үгийг одоогийн тэнцвэрээ алдсан сургаал, номлол, бичээс, дуу хөгжмийн хольцгүйгээр - шууд харах юм бол, орчин цагийн Сайн мэдээнээс тэнгэр газар шиг ялгаатай байгааг мэднэ. Гэмшлийн залбирал хэлээд, Түүнийг Эзэн гэсэн болгон нь тэнгэрт орно гэж байхгүйг Есүс дэндүү ойлгомжтой хэлжээ. Харин тэнгэрт орохгүй хүмүүс хааш явахыг бид сүүлийн бүлгээрээ үзсэн.

Ер нь Сайн мэдээний хэвшмэл цуглаан ямар байдгийг ярилцъя. Номлогч нь: “Есүс дээр ирж, ерөөгд. Есүс бидэнд баяр хөөр, амар тайван, эд баялаг, аз жаргал, эрүүл мэндийг өгч, тэнгэрийн улсад оруулна” гэж хэлнэ. Үгийг минь бүү гуйвуулаарай. Бурхан биднийг ерөөх чин хүсэлтэй. Гэхдээ Есүс хүмүүсийг хэзээ ч ерөөлөөрөө даллаж байгаагүй.

Ийнхүү “арилжааны” чанартай гучаад минутын илтгэлийн дараа номлогч хүмүүсээс толгой гудайхыг хүснэ. Тэгээд өнөөдөр

үхбэл, тэнгэрийн улсад очмоор байгаа эсэхийг нь асууна. Заримдаа аль болох хүмүүсээ алдахгүй, авч үлдэхийн тулд зүүн баруун талд байгаа хүмүүсийг нь давхар залбирч өгөхийг ятгана. Тэгээд “Та өнөөдөр үхлээ гэхэд тэнгэрт орох уу?” гэж асуугаад, “Орно гэж хариулж чадахгүй байгаа хүн байвал, урагш нь дагуулаад ир!” гэж зааварлана.

Хүмүүсийг урагш гарч байх үеэр “Есүс танд хайртай” зэрэг сэтгэл уяраам дуу дуулж өгнө. Эсвэл хөгжимчид нь баярын марш тоглож, танхим дахь хүмүүс инээмсэглэн, алга нижигнүүлнэ.

Хүмүүсийг урд гарч ирмэгц, номлогч тэдний толгойг гудайлгуулаад, нэг иймэрхүү залбирал хэлүүлнэ: “Тэнгэрийн Аав аа, би нүгэлтэй хүн. Миний нүглийг уучлаарай. Энэ өдөр би Есүсийг Эзэн ба Аврагчаа болгож байна. Намайг хүүхдээ болгосонд баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.”

Хүмүүс хурайлж, хөгжим хангинаж, шинэ “итгэгчид” маань ирсэн шигээ л гарч явна. Гэхдээ нэг ялгаатай: тэд одоо мэхлэгджээ. Тэдэнд дуулгаваргүй амьдралаа гэмших, өөрийнхөө хүслийг няцааж, Бурханы хүслийг хайх, Христийн төлөө өөрийнхөө амийг алдах талаар юу ч хэлж өгөхгүй. Тэд Есүсийг Эзэнээ болгосон ч, зүрх нь огт өөрчлөгдөхгүй. Есүс зүгээр л амьдралынх нь нэг хэсэг болжээ.

Тэгвэл би танд хэлье. Хаадын Хааны, эздийн Эзэн маань хүний амьдралд баахан олон хайрынх нь хоёрдугаарт юмуу эвсэл бүр нэгдүгээрт байхаар ирдэггүй юм. Тэр бидний амьдралд Өөрийнхөө эзлэх байрсуурийн төлөө ямар ч хүн, юм, үйлажилтай өрсөлдөхгүйгээр, бидний бүрэн эрхт, төгс Хаан байхаар ирдэг юм. Тэрбээр бидний Эзэн буюу Дээдийн дээд эзэнтэн, эзэмшигч байх ёстой. Одоо бидний амьдрал биднийх биш, Түүний мэдлийнх нь болжээ.

Бодоод үз. Танд бусад амрагуудаасаа илүү үнэнч байна гэж хэлж байгаа хүнтэй та гэрлэх үү? Тэгвэл ертөнцийн Хаанд ингэж хандах нь доромжлол биш үү? Тэр “Та миний амрагууд дундаас хамгийн хайртай нь” гэж хэлж байгаа сүйт бүсгүйг хүлээж авна гэж бодож байна уу? Энэ нь “хоёр нь нэг болдог” гэрээний харилцаа биш, зүгээр л тохиролцоо болно. Энэ бол заль!

Тэдгээр шинэ “итгэгчид” нь амиа хоохойлсон дэлхийн амьдралаа няцааж, дотроосоо Есүсийн шинэ мөн чанарыг бойжуулж мэдэхгүй. Тэд дөнгөж сая тэнгэрийн амлалт, сайхан амьдралын төлөө өөрийгөө худалдчихжээ. Сонин байгаа биз? Өнөөдөр хүмүүс зөвхөн Есүст итгэснийхээ төлөө хавчигдаж, алуулдаг газар олон

бий. Гэтэл Барууны итгэгчид бид амьдралаа дээшүүлж, тэнгэрт орохын төлөө Есүс дээр ирдэг. Гэхдээ байна шүү - бид бас Түүний төлөө амиа алдах хэрэгтэй болдгийг би танд хэлмээр байна.

Яг ийм Сайн мэдээнээс болж өнөөдөр маш олон евангелийн итгэгчид мэхлэгдчихсэн явж байна. Шинэ дээрээ юм бүхэн сайхан байдаг шиг, шинэ итгэгчид маань шинэхэн “итгэлдээ” сэтгэл хөөрөн, Христийн үйл ажиллагаа бүрт хамрагдан, чуулганд явж, Сайн мэдээний аянд ч оролцоно. Яг л шинэ клуб, спорт, сургууль, ажил шиг. Шинэ юм бүхэн ондоо байдаг. Гэхдээ тэд жинхэнэ дагалдагч нартаа Есүсийн тушаасан тушаалыг хараахан мэдэхгүй яваа юм: Есүсийг дагах үнэ төлөөсийг нь мэдээд, дараа нь Түүнд амьдралаа бүр мөсөн зориулах шийдвэр гаргах. (Лук 14:27-33)

Олохын төлөө алдах

Энэ бол солилцоо. Бид амиа бүрэн өгч, оронд нь Түүний амийг (мөн чанарыг) хүлээн авна. Есүс үүнийг ахин дахин хэлсэн:

“Тэрээр хурсан олныг шавь нарынхаа хамт дуудаж тэдэнд хандан —Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа үүрч Намайг дага.” (Марк 8:34)

Бид Эзэн рүү цаг үргэлж ойртох ёстой. Аврал нь ганц удаа залбираад л, дараа нь дур дурынхаа амьдралыг хөөдөг зүйл биш юм. Гэтэл олон хүн яг ингэж байна. Ганц ялгаа нь одоо тэрбээр тэнгэртэй холбоотой “Христийн” клубын гишүүн болжээ. Есүс цааш нь “Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө, сайнмэдээний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна” гэж ярьсан. (Марк 8:35)

Энэ бол тодорхой солилцоо юм. Бид амьдралынхаа эзэн байх эрхээсээ татгалзана гэсэн үг. Ингэж чадсан хүн л Түүний хүслийг дагана. Үүнийхээ хариуд бид Түүний мөнхийн амийг хүлээж авдаг. Гэтэл өнөөгийн заадаг Сайн мэдээнд Есүсийг дагахын энэ амин чухал талыг ер хэлдэггүй, зөвхөн ашгийг нь л тоочдог. Үндсэндээ бид загалмайн нөлөө, дуудлагыг номлохгүйгээр амилалтын амлалтыг л номлодог болжээ.

Яг л зурагтаар цэрэг татлагын ухуулга үзэж байгаа арван наймт шиг. Хүү цэргийн дүрэмт хувцсаар гангарч, уудам тэнгэр дор

аварга том усан онгоцны тавцан дээрээс зах хязгааргүй задгай далайг довтлон, өөр хоорондоо инээлдэн хөөрөлдөж, жинхэнэ эр хүний ажлыг хийж, жаргалдаа умбаж яваа үе тэнгийнхээ залуусыг харжээ. Тэд ийнхүү ямар ч мөнгө төлөлгүйгээр дэлхийг тойрно.

Залуу хүү тэр даруй цэрэгт элсэв. Хүү ашигт нь татагдсандаа, гэрээнийхээ нөхцлийг ч уншсангүй. Тэрбээр дэлхийтэй танилцаж, эх орныхоо зэвсэгт хүчинд зүтгэж, олон найз нөхөдтэй болно гэж бодохоос хөл нь хөнгөрнө.

Гэтэл удалгүй бэлтгэл сургууль нь ч эхлэж, өглөөний есд орондоо орох нь хэвийн л зүйл гэдгийг мэдэв. Сэгсгэр үснээсээ хагацаж, сард ганц хоёр удаа л базаасаа гарахыг зөвшөөрдөг учраас, дуртай цагтаа дуртай газраа ч очиж чадахгүй. Хамгийн муухай нь цэргийн нягт нарийн цагийн хуваарь нь бусадтай үг солих ч зав олгохгүй. Өдөржин ариун цэврийн өрөө угааж, бохир өрөөнүүд цэвэрлэж, гар дээрээ суниаж, хүнд дасгал хийнэ. Урьдын эрх чөлөө баяртай! Өдөржин ажиллаж, орой нь дэр толгой хоёр нийлүүлээд л нам болно.

Гэхдээ залуу удахгүй усан онгоцон дээр гарах учраас, бүх зүйл өөрчлөгдөнө хэмээн горьдоно. Үндсэн бэлтгэл сургууль дуусмагц, залуу усан онгоцон дээр ажиллах хүсэлтээ гаргажээ. Гэхдээ энэ нь ч усан дээр л болохоос биш, ялгаагүй л хүнд хүчир хөдөлмөр байв. Тэгж байтал дайн гарч, залуу хүсээгүй дайндаа оржээ.

Зэвсэгт хүчин түүнд үнэгүй амьдрал амласан учраас л, залуу сайн дураараа цэрэгт явсан. Гэхдээ энэ үнэгүй амьдрал нь түүний бүх эрх чөлөөг авна гэдгийг зэвсэгт хүчин түүнд анхааруулаагүйд сайхь залуу гомджээ. Өөрөөр хэлбэл тэрбээр дотор нь юу байгааг мэдэхгүйгээр зүгээр л боодолд нь хууртагдан, мэхлэгдсэн байна.

Бид үнэгүй олддог авралын талаар номлодог. Аврал үнэгүй гэдэг нь үнэн. Гэхдээ аврал нь тэдний эрх чөлөөг авна гэдгийг бид хүмүүст хэлдэггүй. Эрх чөлөө гэдэг нь амьдралын эрх чөлөө биш, харин ухамсрын эрх чөлөөг хэлж байгаа юм шүү. Учир нь Христээс гадна байгсад нь нүгэлд хүлээтэй юм. Тэд өөрсдийгөө бүрэн эрх чөлөөт хүмүүс гэж боддог ч, үнэндээ боол билээ.

Үүнийг Матрикс гэдэг кино мундаг дүрслэн харуулдаг. Хэдэн жилийн өмнө том хүү маань энэ киноны хянан тохиолдуулсан хувилбарыг авчраад, манайхан гэр бүлээрээ үзэх үед би нэгэн гайхмаар параллелийг харсан юм.

Матриксаас “Зүүднээсээ сэрээгүй хүн яаж зүүдний ертөнцийг бодит ертөнцөөс ялгах уу?” гэсэн нэгэн сонин асуулт ургадаг.¹

Кино маань хорин нэгдүгээр зууны сүүлээр өрнөж буй үйл явдлаар эхлэнэ. Хүмүүс хиймэл оюун ухаан хөгжүүлээд, үүнийгээ машин гэж нэрлэжээ. Тэгтэл нөгөө машинууд нь дэлхийг эзлэж, хүмүүс эргээд тэдэнтэй тулалдаж эхлэнэ. Яваандаа эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн ширүүсч, дэлхий доройтож, машинууд ялдаг.

Машинууд хүний биеэс гаргаж авсан эрчим хүчийг ашиглан амьд үлдэж болохыг олж мэдээд, хүмүүсийг өөртөө үйлчлүүлэхийн тулд маш том заль зохион мэхлэдэг. Тийнхүү хорин нэгдүгээр зууны амьдрал хэвийн л үргэлжлэх мэт харагдавч, үнэндээ хүмүүсийн биесүүд нь том ферм дээрх чингэлэг дотор хураалгаатай, харин тэдний оюун санаа нь жирийн амьдралыг санагдуулам, дэлхийг хэрсэн Матрикс гэдэг реалити хөтөлбөрт залгагдсан байна. Хүн төрөлхтөн бодит биш, хийсвэр эрх чөлөөг эдлэх бөгөөд үнэндээ машинуудын боол болжээ.

Тэр үед Матриксыг хакердан чөлөөлөгдөж гараад, өөрсдийгөө жинхэнээсээ хэн болохыг олж мэдсэн хэсэг бүлэг эрэгтэй, эмэгтэй хүмүүс гарч ирнэ. Тэд амьдрахын тулд жинхэнэ дэлхий дээр Сион нэртэй колонн байгуулна. Тэдний хэд хэд нь машинуудтай тулалдаж, хүн төрөлхтнийг чөлөөлөхийн тулд Матрикс руу эргэж нэвтэрнэ. Тулаан ширүүн, амьдрал хэцүү байсан ч, чөлөөлөгчид хуурамч эрх чөлөөнд биш, жинхэнэ эрх чөлөөнд амьдрахыг хүсдэг. Тэд хуурамч боолчлолд тухлахаасаа илүү эрх чөлөөнд зовохыг сонгожээ.

Тэгэхээр энд ийм параллель байна. Олон үл итгэгчид Христэд итгэгчдийг эрх чөлөөгүй, хүлээтэй боолууд, харин өөрсдийгөө эрх чөлөөтэй хүмүүс гэж боддог. Гэхдээ үнэндээ Христийн гадна байгаа хүмүүс нь машинуудын хяналт дор фермд хэвтэж байгаа хүмүүс шиг хүлээтэй юм. Үнэндээ тэд л нүглийн боол билээ.

Христэд итгэгч байх амаргүй

Гэхдээ Сайн мэдээг хэзээ ч сонсоогүй юмуу итгэхээс татгалзсан хүмүүс л хүлээтэй байдаг юм биш. Өнөөдөр жирийн “итгэгч” нар ч нүгэлд боолчлогдсоор байна. Бид Есүсийг дагана гэж яадгийг бүрэн гүйцэд хэлж өгөөгүйгээс болж, энэ асуудал үүсчээ. Олон хүн өөрийгөө эрх чөлөөтэй гэж боддог ч, үнэндээ нүглийн боол хэвээр байгаа нь амьдралаас нь бэлхэн харагддаг. Есүс:

“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр нүглийн боол мөн. Боол гэрт мөнхөд байдаггүй, харин хүү л мөнхөд байдаг. Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно” (Иохан 8:34-36) хэмээн айлджээ.

Энэ нь жимсний модны жишээтэй адил үнэн байна. Нүглээ хийсээр байгаа хүн нь нүглийн боол хэвээр ажээ. Түүний мөн чанар өөрчлөгдөөгүй учраас, тэрбээр хүү нь биш юм. Тэрбээр өөрийгөө гэмшлийн залбирал хэлсэн учраас, эрх чөлөөтэй хүн хэмээн үзэж байж болох ч, Есүсийг дагахын тулд хувийн “эрхээсээ” сайн дураараа татгалзалгүй, өөрийнхөө хуурамч эрх чөлөөг авралын ашиг тустай нь зэрэг эдлэхийг хүсдэг нэгэн юм. Гэхдээ энэ хоёрыг зэрэг эдлэх боломжгүй!

Тэр хүмүүс “итгэлийн” шинэ амьдралаа гал халуунаар эхлэж болно. Учир нь шинэ юм хэзээд сайхан байдаг. Гэхдээ яваандаа тэдний өөрчлөгдөөгүй, хуучин мөн чанар нь ил гарах боловч, хуучин шигээ болхи аргаар биш, харин Христитгэлийн боловсронгуй хэл яриа, хэв маягаар илэрнэ. Тиймээс л энэ нь онц аюултай бөгөөд Шинэ гэрээ ч энэ талаар хатуу анхааруулсан байдаг.

2Тимот 3:1 дээр Паул “Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав” гэжээ. Гэтэл бид яг тэр эцсийн өдрүүдэд амьдарч байна. Үүнд эргэлзэх хэрэггүй. Есүсийг тун удахгүй ирэхийг бүх эш үзүүлэл хэлдэг. Паул ч манай энэ үеийг Христэд итгэхэд хамгийн бэрх цаг үе байхыг зөгнөн харжээ.

Бусад орчуулга дээр “аюултай, аймшигтай” ч гэж дүрслэдэг. Тэгвэл яагаад тэр вэ? Паул өөрөө маш хүнд бэрх амьдрал туулсан хүн. Тэр таван тохиолдлоор гучин есөн удаа ташуурдуулсан. Гурван удаа саваагаар ороолгуулсан. Нэг удаа чулуугаар шидүүлж, олон жил шоронд хоригдсон. Тэр хаа ч очсон нүд үзүүрлэгдсэн. Гэтэл ингэтэл зүдэрсэн хүн бидний төлөө тэгтэл зовнисон байх юм. Яагаад тэр вэ? Одоо хэлж өгье:

“Учир нь хүмүүс аминч, мөнгөнд дурлагч, сагсуу, их зантай, доромжлогч, эцэг эхдээ дуулгаваргүй, үл талархагч, ариун бус, үл хайрлагч, үл эвлэрэгч, гүтгэгч, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагч, тэрслэгч, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагч байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагч болох болно.” (2Тимот 3:2-4)

Үүнийг уншаад та, Паул яг юу хэлэх гэсэн юм бол оо гэж гайхаж байна уу? Энэ жагсаалт Паулын үеэс юугаараа ялгаатай гэж? Тэр үеийн хүмүүс ч ялгаагүй л өөртөө хайртай, мөнгөнд дуртай, бузар үйлтэй, хатуу сэтгэлтэй байсан. Тиймээс ч Пентекост өдөр Петр “Энэхүү гажууд үеийнхнээс аврагдагун” (Үйлс 2:40) гэж хэлсэн байдаг. Тэгвэл Паул яагаад манай энэ үеийг олноос онцлоод байна?

Цааш нь уншбал, тэрбээр учрыг нь хэлжээ: “Тэд итгэл сүсэгт дүртэй ч хүчийг нь үгүйсгэдэг. Чи тэднээс хол бай.” (2Тимот 3:5) ЭнКэйЖэйВи Библи дээр “бурханлаг дүртэй боловч, хүчийг нь үгүйсгэдэг” гэдэг.

Тэгэхээр, яагаад чухам өнөөдөр Христэд итгэх хамгийн хэцүү үе болохыг та харлаа. Өөрийгөө Христэд итгэдэг, дахин төрсөн, аврагдсан гэх боловч, амиа хичээсэн амьдралаа загалмайгаар устгуулдаггүй хүн олон болно. Тэд Есүсийг дагахын төлөө хувийнхаа эрх ашиг, тачаалыг хаяж чадахгүй. Тэд Есүсийг жинхэнээсээ Аврагчаараа хүлээж авсан. Гэхдээ тэдний хувьд Есүс юу хийж чаддаг нь л чухал болохоос биш, Хэн болох нь тийм чухал биш. Яг л мөнгөнөөс нь болж эр хүнтэй гэрлэдэг хүүхэн шиг гэх үү? Тэр хүүхэн хар хүндээ хайртай байж болно оо. Гэхдээ тэр хайр нь буруу сэдэлтэй юм. Үүнтэй адил олон хүн аврал, хамт олон, амжилт эвсэл хойд насаа бодсондоо Есүсийг хайдаг. Тэд Есүсийг өөрийнхөө Аврагч гэдэгт чин сэтгэлээсээ итгэдэг ч, амьдралынхаа жолоог хэзээ ч Түүний гарт өгдөггүй.

Паул ийм “итгэгчдийг” “үргэлж суралцавч, үнэний мэдлэгт хэзээ ч хүрдэггүй” хүмүүс гэжээ. (7-р ишлэл) Тэд бүх цуглаанд явж, Бурханы бүх Үгийг сонссон ч, нэг ч өөрчлөгдөхгүй.

Ялгахын аргагүй

Хамгийн хэцүү нь ийм хүмүүсийг ялгаж танихын аргагүй байдаг. Өөрийгөө дахин төрсөн гэдэг, яг жинхэнэ итгэгч шиг ярьж чаддаг, бурханлаг хүмүүстэй нөхөрлөдөг, тэр бүү хэл итгэгчдийн цуглалалтад дуртай боловч, мөн чанар нь өөрчлөгдөөгүй, амиа эрсэн хүн байна. Үнэндээ тэрбээр танигдахын аргагүй зальт этгээд бөгөөд түүний энэ заль мэх нь өвчин шиг л тархдаг. Зарим хүн Христчин соёлын хэв хэмжээ дээр амьдралаа суурьлуулдаг боловч, тэр соёл нь тэнгэрийн арга замтай нийцдэггүй учраас, жинхэнэ

итгэгч хүн шиг амьдрах боломжгүй болгодог. Хэрэв та Паулын үед итгэгч байсан бол, амь нас чинь цаг үргэлж аюулд байна. Амьдралаа Есүст өгөө л бол, амь нас чинь шууд эрсдэлд орно.

2Тимот 3 дээр Паул цааш нь:

Харин чи миний сургаал, төлөв байдал, зорилго, итгэл, уужим сэтгэл, хайр, гэвчээр, хавчлага, зовлонг дагасан. Антиох, Икониум, Лустрт надад тохиолдсон ямар хавчлагуудыг би тэссэн билээ. Эзэн намайг тэр бүгдээс аварсан юм. Үнэндээ, Христ Есүс дотор сүсэг бишрэлтэй амьдрахыг хүсэгч бүх хүн хавчигдах болно. Харин ёрын муу хүмүүс, мэхлэгчид хуурч, хуурагдан улам муудна” (2Тимот 3:10-13) гэжээ.

Паул маш тодорхой хэлжээ. Тимот Паулын дан ганц сургаалд нь татагдаагүй, харин ёстой л өнө мөнхөөр хөтлөгдсөн амьдралын зорилго, хэв маяг нь татагдсан юм. Паулыг хариултаа авдаг залбирал нь, үйлддэг гайхамшиг тэмдгүүд нь, үйлчлэлийнх нь алдар нь, Бурханы үгийг мундаг номлодог чадвар нь бус, чухам амьдралынх нь хэв маяг л гэрчилжээ. Итгэгч хүний амьдралын хэв маяг нь л түүнийг үнэхээр жинхэнэ итгэгч мөн эсэхийг тодорхойлогч гол хүчин зүйл байсан, байгаа, байх ч болно.

Паул муу ёрын хүмүүс, хуурамч хүмүүс улам гаарна гэсэн. Муу хүнээс хол байх ёстойг бид бүгдээрээ л мэднэ. Гэхдээ гаднаа цагаан атлаа эрээн дотортой хүмүүс л хамгийн аюултай. Тэд Христийн нэрийг барьж, итгэлийг хэлбэрдэж чаддаг ч, зан үйлдэл нь яг л бахь байдгаараа учраас, Бурханы амьдрал өөрчлөгч нигүүлслийн хүчийг гэрчилж чаддаггүй. Паул тэднийг бусдыг мэхлээд зогсохгүй, өөрсдөө ч мэхлэгдэнэ гэж хэлснийг тэмдэглэнэ үү.

Манай түүхийн гол дүр Мэхлэгдэгч яг л тэгсэн. Тэрбээр өөрийгөө Энделийн сургуульдаа идэвхитэй сурдаг, итгэл бишрэлээ ил тод харуулдаг, хаантайгаа ч дажгүй харилцаатай гэдэгтээ үнэн голоосоо итгэсэн. Гэхдээ Мэхлэгдэгч аман дээрээ л “итгэлтэй” гэх боловч, амьдрал дээрээ нэг ч өөрчлөлт гаргаагүй. Тиймээс тэр өөрөө мэхлэгдээд зогсохгүй, бусдыг ч мэхлэжээ. Мэхлэгдэгчийн үлгэрлэн харуулсан энэ “үгээр” түүнтэй унтсан охидоос авахуулаад түүнийг даган дууриасан олон сурагч явжээ.

“Юун үг? Мэхлэгдэгч чинь багш байгаагүй шүү дээ!” гэж

үү? Тийм ээ, үгээр. Учир нь бидний үгээс илүү үйлдэл маань чанга ярьдаг. Учир нь Жэйлиний үгийг дагадаг сурагчид нь Мэхлэгдэгчийн энэ хүчтэй атлаа буруу жишгээр явахгүй хэмээн тэмцэж байсан бол, арай сул сурагчид нь шууд л нөлөөнд нь автдаг байжээ.

Энэ тэмцлийн талаар Паулаар тогтохгүй, Шинэ гэрээний бусад бичээч нар ч анхааруулсан байдаг. Жишээлбэл Иуда:

“Хайртууд аа, би та нарт бидний хуваалцдаг авралын тухай бичихээр бүх зүтгэлээ гаргаж байхдаа, ариун хүмүүст тушаагдсан итгэлийн төлөө тэмцэхийг ятган бичих шаардлагатай хэмээн бодлоо” (Иуда 1:3) гэжээ.

Түүний зовнилыг мэдэрч байна уу? Иуда авралын талаар бахдан бичихийг хүссэн ч, өөр зүйлийн талаар бичихээс өөр аргагүй болжээ. Тэрбээр Бурханы хүмүүсийг итгэлийнхээ төлөө тулалдахыг ятгаж байна. Энэ нь ямар учиртай тулаан бэ? Иуда үүнийг ингэж тайлбарлажээ:

“Учир нь шийтгэлд хэдийнээ заагдсан, сүсэг бишрэлгүй хэсэг хүн сэм шургалан орж ирсэн бөгөөд тэд Бурханы маань нигүүлслийг садарлал болгон гажуудуулж, бидний цорын ганц Эзэгнэгч бөгөөд Эзэн Есүс Христийг үгүйсгэдэг.” (Иуда 1:4)

Энэ нь бурханлаг бус амьдралаа өмөөрөхийн тулд Бурханы нигүүлслийг завхруулсан хүмүүсийн үүсгэсэн нөлөөтэй хийх тулаан ажээ. Энэ нөлөө нь шууд чуулганыг чиглэсэн халдлагаас ч аюултай; үр хөндөлт хар тамхи, ижил хүйстнүүдийн гэрлэлт зэрэг Библийн зарчимтай тэрсэлддэг хуулийг дэмжиж, дунд сургуульд хувьслын онол заахыг шаардахаас ч аюултай; бүхий л төрлийн гаж урсгал, хуурамч шашнаас ч аюултай. Энэ нь мөнхийн аюултай юм.

“Энэ чинь тэгээд чуулганы хүмүүст ямар хамаатай гэж? Иуда Есүс Христийг эсэргүүцдэг юмуу няцаадаг хүмүүсийн талаар ярьж байна. Өнөөдөр чуулган ийм хүмүүсийг хүлээж авах ч үгүй” гэж хэлмээр байна уу?

Гэхдээ та яагаад Иудагийн үеийн итгэгчдийг илүү эмзэг байсан гэж бодоов? Дахиад анхааралтай харна уу. Тийм хүмүүс

чуулганд сэм нэвтэрдэг гэж байна. Иудагийн үед ч, манай үед ч Есүс Христийг ам хэлээрээ няцаадаг хүнийг чуулган тэвчихгүй. Тэгвэл тэр хүмүүс Есүсийг яг яаж няцаадаг болж байна? Хариулт нь Шинэ гэрээний өөр нэг номд бий: “Тэд Бурханыг мэднэ гэдэг ч үйлсээрээ Түүнийг үгүйсгэдэг. Тэд булай, дуулгаваргүй бөгөөд алив сайн үйлсэд үл тэнцэнэ.” (Тит 1:16) Тэд Есүсийг амаараа биш, харин амьдрах хэв маягаараа няцаадаг ажээ. Тэд Бурханыг мэддэг царайлж, Есүсийг Эзэнээ гэдэг ч, үйлдэл нь өөрийг хэлдэг. Тэд бусдыг мэхлээд зогсохгүй, өөрийгөө ч мэхлэдгийг санаарай. Тэд өөрийгөө жинхэнэ итгэгч гэж боддог.

Бурханы жинхэнэ нигүүлсэл

Тийм хүмүүс Бурханы нигүүлсийг гажуудуулдаг гэж Иуда хэлжээ. Бидний хагас дутуу заасан сургаалаас болж эцсийн өдрүүдэд буюу манай энэ үед ийм явдал газар аваад байна. Бид нигүүлслийг бурханлаг бус амьдралынхаа хэв маягийг далдлах Бурханы хаацайлагч хөнжил болгожээ. “Хүн юм чинь алдалгүй яахав. Бурхан биднийг нигүүлслээрээ уучилна” гэдэг үг сонссон уу? Энэ бол аймшигтай мэхлэл шүү. Бичээс нигүүлслийг “шархны наалт” гэж хэлээгүй. Бичээс нигүүлслийг үнэн биднээс юу шаардана - түүнийг нь хийх хүчтэй болгодог бидний доторх Бурханы оршихуй гэж заадаг.

Бид Бурханы нигүүлслийг зүгээр л Бурханы оройгүй таалал гэж заадаг. Нигүүлсэл нь үнэхээр Бурханы таалал мөнөөс мөн. Гэхдээ нигүүлсэл биднийг Бурханы үгээр амьдрах хүчтэй болгодог гэдгийг бид заадаггүй. Нигүүлслийг хүлээж авсан хүний амьдрал заавал өөрчлөгддөг. Жинхэнэ нигүүлсэлтэй хүн заавал Бурханы үгийг дагана. Тиймээс л Иаков:

“Иймээс ч итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм. Гэвч хэн нэг чинь “Чамд итгэл байна, надад үйлс байна. Чи надад итгэлээ үйлсгүйгээр харуул. Би чамд итгэлээ үйлсээрээ харуулъя” гэж хэлж болох юм. Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн. Четгөрүүд ч үүнд итгэдэг бөгөөд бэмбэгнэдэг”
(Иаков 2:17-19) гэдэг.

Иаков бидний өнөөгийн сургаал дахь цууралтыг харуулжээ. Бид “Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана” (Үйлс 16:31) гэх мэт бичээсийг хэлдэг. Гэхдээ “Есүс байдаг, Есүс Бурханы Хүү” гэдэгт итгэхэд л аврагдчихдаг байсан бол, үүнд итгэдэг чөтгөрүүд ч бас аврагдах учиртайг Иаков хэлжээ. Инээдтэй юм. Гэтэл чөтгөрүүд үүнийг мэдээд бүр чичирдэг гэж байгаа. Өөрөөр хэлбэл чөтгөрүүд, аман дээрээ итгэдэг гэдэг ч, амьдрал дээрээ итгэдэггүй хүмүүсээс ч илүү Бурханаас эмээхийг мэддэг ажээ.

Есүс Христийн нигүүлслээр жинхэнээсээ аврагдсаны нотолгоо маань бидний амьдралын хэв маяг юм.

“Бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ. “Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга. Харин Түүний үгийг сахидаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ. Үүгээрээ бид Түүний дотор байгаагаа мэднэ. Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай.” (1Иохан 2:3-6)

Бид Есүсийн тушаалыг дагадаг бол, Түүнийг үнэхээр мэддэг ажээ. Есүсийг мэддэг гэх атлаа Үгийг нь дагадаггүй бол, тэрбээр үнэнээс хөндий, мэхлэгдсэн нэгэн юм. Иймээс л Иохан: “Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэн нэг нь нүгэл үйлдвээс Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн. Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй, хамаг ертөнцийн нүглийн учир билээ (1Иохан 2:1-2) гэжээ.

Иохан “Та нар нүгэл үйлдэхдээ... Өмгөөлөгчтэй” гэж хэлээгүйг анхаарна уу. Тиймээс бид нүгэл хийхгүй байхыг л зорих ёстой. Нигүүлслийн хүч бидэнд Христ шиг амьдрах хараа өгдөг. (1Иохан 2:6 дээр хэлсэнчлэн “Тэр яаж явсан яг Түүн шиг явах” ёстой юм) Учир нь бид дуулгаваргүй мөн чанараас чөлөөлөгдсөн. Гэхдээ хэрэв нүгэлд дийлдчихбэл, бидэнд Өмгөөлөгч бий.

Бидний хувьд Бурханд таалагдах үйлчлэл хийх боломжтой болсон нь хамгийн том завшаан билээ.

“Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм.” (Еврей 12:28)

Нигүүлсэл биднийг Бурханд таалагдах үйлчлэл хийх хүчтэй болгодог.

Тэгвэл бид яагаад Сайн мэдээг бүхлээр нь биш, таллаж тунхаглана вэ?

Аврал бол ямар ч сайн үйлс, гавъяа шагналаар олж авашгүй, бэлэг гэдэг нь үнэн. Гэхдээ авралыг хүлээж авах цорын ганц зам нь Есүсийн эзэний эрх мэдэлд амьдралаа бүрэн өгөх гэдгийг бид хүмүүст хэлэх ёстой. Ингэж байж л бид Эзэний мөн чанартай нийцсэн нигүүлслээр хүчирхэгжинэ. Петр:

“Бурханыг болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон. Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанарыг хуваалцагч болох юм” (2Петр 1:2-4) гэсэн.

Үүнээс анхаарах ёстой хэд хэдэн зүйл байна: Есүс Христийг мэдэх мэдлэгээр дамжин бидэнд нигүүлсэл өгөгдсөн; нигүүлсэл бол биднийг бурханлаг зан байдлаар амьдрахад шаардлагатай бүхнээр хангадаг Бурханы тэнгэрлэг хүч мөн; бурханлаг амьдралын хэв маяг нь Бурханы тэнгэрлэг мөн чанартай нийцнэ. Ийм замаар бид Адамаар дамжин дэлхийд нэвтэрч, Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийн хүслээр үржин тархсан завхралаас авран сэргээгдсэн юм. Тиймээс энэ тэнгэрлэг мөн чанараараа хэнээс ч айлгүй амьдар. Паул:

“Учир нь бүх хүнд аврал авчрагч Бурханы нигүүлсэл үзэгдэж, сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг үгүйсгэхийг, мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд сургадаг. Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхлантай

илэрхийллийг хүлээдэг. Тэр Өөрийгөө бидний төлөө өгсөн нь биднийг алив ёс бус явдлаас золин, сайн үйлсэд зүтгэгч тусгай ард түмнийг Өөртөө цэвэршүүлэхийн тулд юм. Чи эдгээрийг бүхий л эрх мэдлээр ярь, ятга, зэмлэ. Хэн ч чамайг бүү басамжлаг” (Тит 2:11-15) хэмээн маш тодорхой хэлжээ.

Бурханы нигүүлсэл бидэнд бүхий л бурханлаг бус явдал, дэлхийн дур хүслийг эсэргүүцсэн, биеэ хянан захирсан, бурханлаг амьдралаар цэх амьдрахыг зааж өгдөг. Бурханы нигүүлсэл яг л багш нар шиг бидэнд зааварлаж, биднийг хүчжүүлдэг.

Бид эдгээрийг заах ёстой гэсэн байгааг анхаарна уу. Үнэндээ Паул цааш нь “Энэ бол итгэмжит үг. Эдгээр зүйлийг итгэлтэй яриасай гэж би чамаас хүсэж байна. Тэгвэл Бурханд итгэсэн нь сайн үйлс сахихдаа хянуур болох юм. Энэ нь сайн бөгөөд хүмүүст тустай” (Тит 3:8) гэжээ.

Бид Бурханы нигүүлслийн хүчээр сайн үйлсийг сахих ёстой. Бид аврагдахаасаа өмнө нигүүлсэлгүй байсан. Хуучин гэрээний ариун хүмүүс ч ялгаагүй. Нигүүлсэл нь Есүс Христээр дамжиж бидэнд ирсэн Бурханы бэлэг юм.

Тиймээс л Есүс бидэнд: “Хэрэв чи Хуучин гэрээний цагт хүний амь бүрэлгэсэн бол, тамд хаягдах ёстой алуурчинд тооцогдох байсан бол, харин нигүүлслийн дор ах дүүсээ тэнэгээр нь дуудах, хар буруугаар шүүх, уучлахаас татгалзах юмуу ямарваа хэлбэрээр үзэн ядахад л тамын галд хаягдах аюулд орно (Матай 5:21-22) гэсэн. Яагаад? Учир нь өдгөө бид нигүүлслийн хүчээр дотроо ч, гаднаа ч Бурханы мөн чанарын дагуух чадвартай болсон юм.

Байнга баталгаажуул

Эдгээрийг байнга баталгаажуулахыг Тит 3:8 дээр сануулжээ. Байнга! Гэтэл миний л мэдэхийн энэ талаар индрийн араас юмуу итгэгчдийн дунд байнга байтугай барагтай ярьдаггүй. Иймээс л бид Бурханы нигүүлслээр сайн үйлсээ сахихыг мартжээ. Өөрөөр хэлбэл бид итгэлгүй, мэдлэггүй байдлаасаа болоод дотоод хүчээ царцааж байна. Гэтэл нигүүлслийг ажиллуулдаг итгэл маань чанга байсан нөхцөлд л ажиллана. Паул: “Христийн төлөөх гэдгээс маань үүдэх аливаа сайныг чи таньснаар итгэлийн нөхөрлөл чинь үр дүнтэй болоосой гэж би залбирч байна” (Филемон 6) гэсэн.

Бид үнэнийг байнга баталгаажуулахгүй бол, үнэнээс дайжина. Үүнийг Еврей ном ч хэлдэг:

“Тиймээс бид гулсаад өнгөрчихгүйн тулд сонссоноо тун анхаарах ёстой. Учир нь тэнгэрэлч нараар хэлүүлсэн үг баттай байсан бөгөөд аливаа тэрслэл ба дуулгаваргүйдэл нь шударга хариугаа хүртсэн бол, бид ийм агуу авралыг үл хайхраад хэрхэн зугтаах билээ? Энэхүү авралыг эхлээд Эзэн айлдсан бөгөөд сонссон нь бидэнд баталсан юм.” (Еврей 2:1-3)

Үнэнийг байнга бататгаснаараа, бид өнө мөнхөөр амьдрах зорилгоосоо төөрөхгүй, хараагаа алдахгүй.

Би хүүхэд байхдаа их загасчилдаг байлаа. Загасандаа хамаг ухаанаа өгчихөөрөө зангуугаа хаяагүй л бол, завьтайгаа тэнэж одно. Дөчин таван минутын дараа сэхээ ороод харахнаа, хаа ч яваагаа мэдэхгүй. Завиа биш, загасаа анхаарсан учраас төөрчээ.

Бид ч золоор гайгүй өнгөрч. Гэтэл энэ хайхрамжгүй явдлаасаа болоод олон хүн анхныхаа байршлаас туугдаж, адагтаа хүчтэй хүрхрээнд орж, амь насаа ч алддаг.

Өнө мөнхийн хувьд ч ялгаагүй юм. Бурхан бидэнд “эдгээрийг баталгаажуул” гэж хэлсэн л бол, баталгаажуулах л ёстой. Тэгвэл бид яагаад нигүүлслийн хүч биднийг бурханлаг амьдрах чадвартай болгодог гэдгийг ярихгүй байна?

Анхны чуулган ярьдаг байсан. Эртний чуулганы эцгүүдийн бичвэрийг сурвалжилж үзэхэд, тэдгээр нь Бичээсийн хувьд хэвийн, бидний хувьд харийн үг шиг санагддаг. Эхний хэдэн зууны итгэлийн эцгүүд маань “авралыг үйлсээр батлан харуулна” гэдэгт бат итгэдэг байжээ. Хэдэн жишээ үзье л дээ.

Хамгийн түрүүнд элч Иоханы анд нөхөр байгаад өндөр насандаа баривчлагдан, шарагдаж үхсэн, Смирна чуулганы бишоп Поликарп (МЭ 69-156) гэдэг хүний үгээс эш татъя: “Олон хүн үйлсээр биш нигүүлслээр аврагдсанаа мэдэн, (авралын) энэ баяр баясалд орохыг хүснэ.”² Өнөөгийн евангелийн хүрээнийхэн ч яг энэ мэдэгдлээр явах ёстой. Тэд ч үүнийгээ маш сайн номлодог. Гэхдээ Поликарп итгэгчдэд бас ингэж хэлжээ: “Түүнийг үхлээс амилуулсан Нэгэн биднийг бас амилуулна - гагцхүү хэрэв бид Түүний хүслийг биелүүлж, тушаал дотор нь алхаж, Түүний хайрладгийг хайрлаж, өөрийгөө бүхий л зөвт бус юмсаас сахин

явах аваас.”³ Гэтэл өнөөдөр яг энэ үгийн талаар нэг ч дуугардаггүй.

Хэрэв гэсэн үгийг анзаарав уу? Бид итгэгчдийн амилалтаар амилуулагдахын тулд Бурханы хүсэл тушаалыг сахин биелүүлэх ёстой ажээ. Яг энэ үгийг Есүс ч хэлсэн байдгийг удахгүй үзнэ.

Дараагийн хүн нь элч Паул, Петр хоёрын анд нөхөр, Ромын чуулганы харгалзагч Ромын Клемент (МЭ 30-100). Тэрбээр “Бид өөрийнхөө юмуу үйлсийнхээ хүчээр эсвэл мундагтаа юмуу бурханлагтаа зөвтгөгдөөгүй. Харин аугаа хүчирхэг Бурхан л бүгдийг итгэлээр нь дамжуулж зөвт болгосон”⁴ гэжээ. Энэ мэдэгдлийг ч өнөөгийн Христийнхэн дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ Клемент ч ялгаагүй итгэгчдэд хандан өөр нэг үгийг бичжээ: “Бид сайн үйлст түргэн байх ёстой. Учир нь Тэрбээр: “Бурхан, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө” (Ром 2:6-10) хэмээн айлдсан буюу”⁵.

Магадгүй иймээс л Паул “... би тэнгэрлэг үзэгдэлд дуулгаваргүй байж болсонгүй. Харин эхлээд Дамаск болон Иерусалимд, дараа нь Иудейн бүх нутгаар тэрчлэн харийнханд хүртэл “Та нар гэмшиж, Бурхан өөд эргэн, гэмшилд дүйцэх үйлс бүтээгтүн” гэж тунхагласан бус уу?” гэж хэлсэн байх. (Үйлс 26:19-21) Паул үүнийг онцлосон учраас, түүний нөхөр Ромын Клемент ч даган дууриажээ.

Дараагийн хүн нь Александрын Клемент (МЭ150-200). Тэрбээр Египетийн Александрын чуулганы бас шинэ итгэгчдийн сургуулийн тэргүүн байв. Тэрбээр үл итгэгчдэд хандан: “Итгэлгүй болбоос эдүгээ мянга сайн үйлс хийгээд, үхсэний дараа ширхэг ч ашиггүй буюу”⁶ хэмээн бичжээ.

Үүнийг ч өнөөгийн евангелийнхан гүнээ дэмждэг. Итгэдэггүй хүн мянга буян хийлээ ч, Бурханы хаанчлалд орохгүйг бид номынхоо сүүлийн хэдэн бүлгээр үзсэн. Бид Бурханы нигүүлслээр л аврагдсан билээ. Гэхдээ Клемент итгэгчдэд юу гэж бичсэнийг үзнэ үү:

“Үнэнийг эрж, өөрийгөө сайн үйлсээрээ онцгойруулдаг хүн мөнх амийн шагналыг олно... Бурхан (аврагдахад) шаардлагатай хүчээр хэрхэн хангадгийг ухаарч мэдсэн атлаа авралд хөтлөдөг үйлсийг чухалчилдаггүй зарим хүн найдвартаа хүрэхэд шаардлагатай бэлтгэлээ базааж чаддаггүй.”⁷

“Энэ хүмүүс Шинэ гэрээгээ уншаагүй болтой” гэж үү? Харин ч уншсан болоод л ингэж хэлжээ. Жош Мкдовелийн “Тогтоол

шаардсан нотолгоо” гэдэг номд Александрын Клементийг эш татсан бичээсийнхээ 2400 - ийг нь Шинэ гэрээний гурваас бусад номоос авсан гэдэг⁸. Бусад нь ч ялгаагүй. Гэтэл өнөөгийн Христчин номууд Бичээсээс маш бага эшлэдэг. Бид үнэнийг баталгаажуулахгүй явсаар, алдуурч одоогүй байгаа?

Эрээвэр хураавар Сайн мэдээ

Бид Ром 10:9 - өөс өөр ишлэл мэдэхээ байжээ: “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно.” Тэгээд үүнийхээ араас гэмшлийн “шидэт” залбирлаа хэлээд л боллоо.

Бид яагаад Есүсийн үгийг бүрэн бүтнээр нь заахгүй байна? Есүс: “Та нар Намайг “Эзэн, Эзэн” гэж дууддаг хэрнээ юунд хэлснийг минь эс хийнэ вэ?” (Лук 6:46) гэсэн. Эзэн гэдэг нь бүрэн эрхт эзэнтэн, эзэгнэгч, эзэмшигч гэсэн утгатай үг болохыг бид мэднэ. Тиймээс Есүс: “Намайг Эзэн гэж худлаа дуудаж өөрийгөө мэхлэсэнд орбол, “Аугаа Эш үзүүлэгч юмуу Багш” гэж дуудсан нь дээр” гэж хэлсэн юм.

Тэгвэл Есүс юунаас болж энэ тухай ярих болсныг харья: “Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй.” (Матай 7:21a)

Есүсийг Эзэн гэсэн болгон нь тэнгэрт ороод байдаггүйг бид хангалттай үзлээ. “Гэмшлийн залбирал” ч биднийг тэнгэрт оруулах баталгаа болохгүй нь байна. Тэгвэл тэнгэрт хэн орох вэ?

Есүс үүнд: “Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч л орно” (Матай 7:21б) хэмээн хариулжээ.

Сонин юм аа. Поликарп ч яг ингэж хэлсэн. Тэгэхээр бид Есүсийг ярьснаар биш, харин Есүсийг яриад, Бурханы хүслийг биелүүлснээр л тэнгэрт орох ажээ. Харин өөрийгөө даруусган, амьдралаа няцааж, Есүсийг Эзэнээ болгох үед Бурханы өгдөг нигүүлслээр л бид Бурханы хүслийг биелүүлж чадна. Ярих амархан. Харин Есүсийн Эзэний эрх мэдэлд бүрэн захирагдах л хэцүү.

Яагаад үүнийг ахин дахин хэлээд байгаа шалтгааныг үзнэ үү:

“Тэр өдөр Надад олноороо “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны

нэрээр олон гайхамшигийг үйлдэж байсан бус уу?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.”
(Матай 7:22-23)

1980 оны сүүлээр Бурхан надад нэг үзэгдэл харуулсан юм. Би зах хязгаар нь үзэгдэхгүй, оволзсон их хүмүүсийг үзэв. Тэр дунд атеист, нүгэлтнүүд, өөр шашны сүсэгтнүүд байсангүй, харин бүгд л Христэд итгэдэг нэртэй хүмүүс байлаа. Тэд Есүсээс “Бурханы хаанчлалд, Эзэнийхээ баяр хөөрт ор” гэдэг үг сонсоно гэдэгтэй итгэл дүүрэн Шүүх сэнтийн өмнө ирээд, Есүсээс: “Ёс бусыг үйлчдэгч та нар Надаас зайл” (Матай 7:23) гэдэг үгийг сонсоно.

Тэдний царайн дээрх айдас, цочролыг үгээр хэлэшгүй. Байхгүй авралдаа хоосон найдах шиг аймшиг байхгүй. Тэнгэрт орохоор очоод, тамын галд хаягдана гэж юу болохыг төсөөлж байна уу? Тэгээд заасан, сурсан хоёр хоёулаа мөнхийн тавиландаа тийм хөнгөн хуумгай хандсанаа мөнхөд харуусна гэж юу болохыг төсөөлж байна уу?

Есүсийн анхааруулгыг үл тоосон, “хэрэглэгч бол хаан” гэсэн сурталтай номлол маань биднийг үүнд л хүргэнэ.

Яагаад бид Бурханы зөвхөн ашигтай, эерэг зөвлөгөөг биш, харин бүх зөвлөгөөг заах ёстойг одоо ойлгов уу? Мэдээж бид Бурханы ашигтай, эерэг зөвлөгөөг зааж, үүнээс ач тус хүртэх ёстой. Гэхдээ үүнийхээ хажуугаар Бичээсийн анхааруулга тушаалыг үл хэрэгсэж хэрхэвч болохгүй!

Би нэг конференц дээр: “Би Шүүх өдөр над руу “Чи надад үнэнийг заахгүй яасын?” гэж хашхирч байгаа хүмүүсийн цусны буруутан болмооргүй байна! Тиймээс үнэнийг л номлоно!” гээд хэлчихсэн юм.

Гэтэл номлолын дараа надтай нэг пастор уулзаад: “Чи, үйлчлэгч бидэн дээр Хуучин гэрээний теологийг нялзаана гэнэ ээ? Сайн мэдээг бүтнээр нь заасангүй гээд, бид хэн нэгний цусны буруутан болохгүй” гэж хилэгнэв. Тэрбээр Бурханы эерэг үгд дуртай ч, жаахан аягүй үгээс нь зугтаж явдаг нь илт байлаа.

Тэгэхээр нь би: “За, эрхэм ээ, Ефесийн удирдагч нарт хэлсэн Паулын үгийг хар” гээд, гарт байсан Библиэсээ Үйлс номыг гаргаад, уншууллаа: “Тиймээс би бүх хүний цусны буруугүй гэдгээ та нарт энэ өдөр гэрчлэх байна. Учир нь би Бурханы бүхий

л төлөвлөгөөг та нарт мэдүүлэхээс зайлсхийсэн нь үгүй билээ.” (Үйлс 20:26-27)

Цочирдсон номлогч нүд амаа ангайсаар над руу хараад: “Би үүнийг хэзээ ч мэдээгүй ш дээ” гэж хэлсэн юм. Тэгээд бид хоёр сайхан ярилцав. Би түүнд: “хүн бүрийг Христийн дотор төлөвшүүлэхийн тулд бид захаас гадна бас анхааруулах ёстой” (Колоссай 1:28) гэдгийг хэлж билээ. Тэгэхдээ, яг юуг анхааруулах гэж? Үнэнээс дайжихгүй байхыг анхааруулах! Бурханлаг байдлаас өөрийгөө төдийгүй, бусдыг урвуулагч хуурамч хүмүүсийн ухуулдаг үгд туугдахгүй байхыг анхааруулах!

Үйлс 20-аар бүлэгт Паул тун удахгүй удаан хамт байж, хайрлан дассан Ефесчүүдээсээ салаад, хожим тэнгэрт л уулзалдахаа мэджээ. Тэгээд хамгийн хайртай хүмүүстээ сүүлийн захиасаа үлдээж байгаа Паул ингэж хэлсэн байдаг:

“Бурхан Өөрийн цусаар Өөртөө өмчилж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь. Намайг явсны дараагаар, сүргийг үл өршөөх хэрцгий чононууд та нарын дунд орно гэдгийг ч би мэдэж байна. Та нарын дундаас ч дагалдагчдыг өөрсдөдөө татах гажууд зүйлсийг заах хүмүүс гарч ирнэ. Иймээс гурван жилийн турш өдөр шөнөгүй хүн бүрийг нулимс унаган тасралтгүй сэнхрүүлж байсныг минь санан дурсаж сэрэмжтэй байгтун.” (Үйлс 20:28-31)

Тэр хүмүүс үнэнийг хэрхэн завхруулах вэ? Магадгүй үгээрээ - гэхдээ үүнээс илүүтэй үйлдлээрээ. Паул үүнийг л мэдсэн учраас, Ефесчүүддээ гурван жилийн турш өдөр шөнөгүй сэрэмжлүүлжээ. Тиймээс бид ч үүнийг байнга баталгаажуулах ёстой.


Хайрладаг... гэхдээ шударга Бурхан

Манай түүхийн гол дүр Мэхлэгдэгч ямар зовлон, цочролд орсныг санаж байна уу? Зуун гучин жил Ганцын тас харанхуй, тэвчимгүй, шатам халуун, агааргүй бүгчим хайрцаг дотор тамлагдана гэдэг төсөөлөгдөшгүй. Гэхдээ манай энэ түүх ч Бурханы зөвлөгөөг бүрэн эхээр нь заагаагүйгээсээ болж тамлагдах эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эдлэх жинхэнэ тарчлааны дэргэд юу ч биш юм.

Жэйлин хайрлахаа ч мэддэг, хатуурхахаа ч мэддэг шударга хаан байсан. Тиймээс л тэрбээр Дагоны мөн чанарт хувирсан хүнийг Аффабелд оруулаагүй. Хэрэв оруулчихбал тэр хүн Аффабелийг - иргэдтэй юутай хийтэй нь - тэр аяар нь завхруулах байв. Ийм маягаар Жэйлин гэмгүй хүмүүсийг хайрлан хамгаалжээ.

Нөгөөтэйгүүр, Жэйлин Дагонтой адилхан хүнд Дагоноос бага шийтгэл ноогдуулаагүй. Тиймээс Жэйлинийг дагаагүй бүхэн Дагонтой адилхан Ганцын гянданд орсон юм.

Бурхан гэмгүй хүмүүсийг хайрладаг учраас л, Сатаны мөн чанартай хүнийг мөнхийн хотдоо оруулахгүй. Бурхан Сатаныг хамсаатнуудтай нь Галт нууранд хаясан хэрнээ дагалдагч нарыг нь үлдээчихбэл, тун шударга бус явдал болно. Сатаны мөн чанартай бүхэн Галт нууранд мөнхөд хаягдах ялтай. Бурхан бол мөнхийн өршөөнгүй, шударга Бурхан. Түүний суу алдар дэлхий даяар түгнэ.



ХОЁРДУГААР ХЭСЭГ: БҮЛЭГ 4-5

1. Та энэ хэсгээс өмнө мөнхийн шүүх нь Христитгэлийн суурь доктрины нэг гэдгийг мэддэг байсан уу? Христийн дагалдагч нар үүнийг бүрэн гүйцэт ойлгоогүй нөхцөлд юу болдог вэ?
2. Христэд итгэдэг олон хүн тамын тухай ярихаас зайлсхийдэг. Гэхдээ энэ тухай ярих нь үнэндээ бусдыг хайрласан явдал юм. Итгэгч хүн (хувь хүнийхээ хувьд ч, чуулганыхаа хувьд ч) тамын тухай хайраар ярьбал, яг яаж ярих вэ?
3. Та итгэл, үр жимс (үйлс) хоёрын харилцааг яаж тайлбарлах вэ? Аврал нь бэлэг юм бол, яахаараа итгэлд үйлс амин чухал байдаг вэ?
4. Есүсийг дагах шийдвэр нь хүний амьдралд ямар нөлөө авчирдгийг ярилгүйгээр, зөвхөн Сайн мэдээний үр өгөөжийн талаар ярих тухай 5- аар бүлэгт үзсэн. Христийн эзэний эрх мэдэлд захирагддаг амьдрал нь яагаад ямар ч өөрчлөлтгүй, зүгээр л сүнслэг гайхамшигтай хөөцөлддөг амьдралаас илүү баялаг вэ?
5. Авралын талаар, шүүлтийн талаар, бидний энэ амьдрал өнө мөнхийн амьдралд маань хэрхэн нөлөөлдөг талаар сурсан зүйлсээ эргэцүүлэн бодно уу. Нигүүлслийн мөн чанарын талаар 5-аар бүлгээс сурсан зүйл чинь таны үзэл бодлыг өөрчлөв үү?

ጌ-ጦ ለጎርጎጦ

ТОМ УХРАЛТ

Харин эцсийг хүртэл тэвчсэн нь аврагдах болно.

— Матай 24:13

Одоо Дүр эсгэгч, Бүрэг хоёрыг авч үзье. Тэд нэгэнтээ Жэйлинийг жинхэнээсээ дагадаг байжээ. Гэхдээ нэг нь зөв сэдлээр дагаагүй бол, нөгөө нь эцэстээ Жэйлиний замаас ухарчээ.

“Итгэснээ унших” эсвэл “Уншсандаа итгэх”

Энэ бүлгээр ярих зарим зүйл маань евангелийн итгэгчдийн хүрээнд маргаан дагуулдгийг би мэднэ. Гэхдээ бид өөртөө үнэнч бөгөөд шударга хандахыг хүсч байгаа л бол, одоо үзэх Бичээсийн нарийн судлалын дараа ямар ч маргаан үлдэх учиргүй. Тиймээс Дүр эсгэгч, Бүрэг шиг хүмүүсийн талаар Библи юу заадгийг маш нээлттэй зүрх, бодлоор уншаарай.

Бичээсийг уншихдаа уншсан зүйлдээ итгэхээсээ илүү итгэдэг зүйлээ унших нь Бичээсийг таньж мэдэхэд том саад болдог. Бид үнэнийг муудсан линзээр харж эхлэхдээ, итгэдэг зүйлээ уншиж эхлэдэг. Бурханы талаар, Түүний арга замын талаар урсгал чиглэлээс, энд тэндээс, бусдаас олж авсан буруу зөв ойлголтоос болж линз маань мууддаг. Гэхдээ энэ нь яваандаа мэхлэлд хүргэдэг учраас л туйлын аюултай юм. Үүний жишээг Иов номоос харж болно.

Би саяхан Библиэ унших гэтэл, Ариун Сүнс надад: “Иов номыг гаргаад, 32-аар бүлгээс унш” гэж хэллээ. Би ч тэр хэсгийг гаргаснаа, Элихүгийн яриа эхлэдэг хэсэг болохыг танив.

Эхлээд үүнээс өмнө юу болсныг товч дурьдъя. Үлэмж гай

зовлонд өртсөн, зовлонт золгүй Иовын Бурханы талаарх бодол шууд доройтжээ. Тэрбээр Бурханы цэц ухааныг хайхын оронд (Иаков 1:2-8) амьдралын туршлагаараа Бурханыг дүгнэж эхэлнэ. Энэ бодол нь яваандаа өөрийгөө зөвтгөх явдал болж хувирдаг. Элихүгийн яриа гардаг тэр бүлгээс өмнөх хэдэн бүлэгт нь нөгөө гурван найз нь Иовын зовлонг өөр өөрийнхөөрөө тайлан, элдвээр цэцэрхжээ. Гэхдээ дэмий үгс нь байдлыг улам л дордуулна. Тэд Иовын биеэ зөвтгөсөн бодлыг няцааж дийлээгүй учраас, түүнийг зүгээр л яллажээ.

Найзууд дотроосоо хамгийн залуу нь болох Элихү Иовоос ч, нөгөө гурваасаа ч Бурханы цэц ухааныг олж сонсох гэж чилтэл хүлээв. Тэгээд нөгөөдүүлээ хэлэх үгээ бармагц, амаа нээжээ: “Харагтун, би үгийг тань хүлээж, Хэлэх үгээ эргэцүүлэх зуурт тань Цэцэн мэргэн тайлбаруудыг тань сонслоо. Тийм ээ, та нарыг би маш хянуур ажиглалаа. Үзэгтүн, Иовыг няцаасан хэн ч байгаагүй бөгөөд Үгэнд нь хариулсан хэн ч байгаагүй юм. Гэсэн ч “Мэргэн ухааныг бид оллоо. Хүн биш, Бурхан л түүнийг цохиг” гэж бүү хэл.” (Иов 32:11-13)

Элихү нөгөө дөрвөө: “Чи татгалзсан учраас Тэр тохируулан буцааж төлөх ёстой юу?” хэмээн зэмлэжээ. Элихү яг өнөөдрийн алдааг онож хэлсэн байна. Өнөөгийн чуулганы буруу чигтэй теологийн нэг үндэс нь: Бурханы Үгээр үнэнийг байгуулахын оронд туулсан туршлагаараа Бурханы Үгийг хөрвүүлдэг болсонд оршино.

Элихү амьдралын туршлагаар бий болсон Бурханы талаарх үзэл бодол, теологийг ярилгүй, харин үнэнийг гуйвуулалгүйгээр, гагцхүү Бурхан Үгийг шууд ярьжээ. Гэтэл түүнийг ярьж дуусмагц ийм явдал болов:

“Тэгтэл ЭЗЭН хуй салхин дундаас Иовд хариулан —Ухаангүй үгсээрээ зорилго төлөвлөгөөг минь сөрдөг хэн юм бэ, чи? За, бэлхүүсээ чанга бүсэл. Эр хүн шиг зогс. Чамаас Би асуух бөгөөд Чи Надад мэдүүлж өг” (Иов 38:1-3) хэмээв.

Амплифайд Библи дээр “Мэдлэггүй үгээр зөвлөгөөг харуулагч энэ хэн бэ?” гэдэг. Бурханы үгийг болсон явдал, бусдын үзэл, алдаатай теологиор шүүх үед яг ийм зүйл болдог. Бид Бурханы зөвлөгөөг харлуулж, бусад бүх нөлөөнд нээгддэг. Иймээс л Бурханы арга замыг худлаа тайлбарлах үед маань Бурхан Иовд болон түүний гурван найзад уурласан шигээ бидэнд уурладаг.

Яагаад гэвэл бид хүмүүст үнэнийг яриагүй учраас!

Дараа нь Бурхан Иовд бүтэн дөрвөн бүлгийн турш үгээ айлддаг.

“Тэгээд Бурханыг ярьж дуусмагц Иов: —Та бүхнийг үйлдэж чаддаг, Зорьсонд тань боломжгүй нь үгүй гэдгийг би мэднэ.

“Мэдлэггүйгээр зорилго зөвлөгөөг хаадаг Би хэн юм бэ?” Миний хувьд үл мэдэх Дэндүү гайхалтай, ойлгоогүй зүйлээ би ярьж дээ. Та сонсооч, би ярья. Танаас асууя би, надад мэдүүлээч.

Таны тухай чихээрээ сонсож л байлаа, би. Тэгтэл одоо нүд минь Таныг харж байна. Харин би хэлснээсээ буцаж байна. Үнс шороон дунд гэмшье” гэжээ (Иов 42:2-6).

Иов “(Өмнө нь) Таны тухай чихээрээ сонсож байлаа, би. Харин одоо нүд минь Таныг харж байна” гэж хэлснийг үзэв үү? Үүнд маш хүчирхэг үнэн оршино. Бичээс биднийг “Эзэний алдрын тусгалыг тольдох харах мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг” гэдэг (2Коринт 3:18). “Сонсоод... өөрчлөгддөг” гэж хэлээгүй байгаа биз? Есүс бол Бурханы амьд үг. Түүнийг харах гэдэг нь Түүнийг мэдэх, Түүнийг арга замыг мэдэх явдал юм.

Үнэн хүнийг ингэж л өөрчилдөг. Бид Бурханы үгийг сонслоо ч, ухаарахгүй бол өөрчлөгдөхгүй. Харин Бурханы Үг бидний зүрхэнд нэвтрэхийг ойлгох үедээ: “Би харлаа, харлаа (ойлголоо, ойлголоо)! хэмээн дуу алддаг. Энэ үед бид ухаарч, Есүстэй улам адилхан болно.

Энэ сүнслэг үнэн л Паулыг “...та нарын төлөө талархдагаа зогсоохгүй. Бидний Эзэн Есүс Христийн Бурхан, алдрын Эцэг нь та нарт мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг өгч, Өөрийгөө бүрэн мэдүүлж зүрхний чинь мэлмийг гийгүүлээсэй!” (Ефес 1:15-18) хэмээн залбирахад хүргэжээ. Иов зовлонд унахаасаа өмнө ч туйлын бурханлагаар амьдарч байсан. Гэхдээ тэр дөнгөж сая л ухааралд хүрч, Бурханыг илүү сайн мэджээ.

Бурхан Иовтой ярьж дуусаад, Иовын найз Элифазд: “Та нар Миний тухай зарц Иов шиг минь зөвийг яриагүй тул Миний уур хилэн чиний эсрэг ба хоёр найзын чинь эсрэг дүрэлзэж байна” (Иов 42:7) хэмээн айлддаг.

Бид Бурханыг, Бурханы арга замыг худлаа таниулбал Бурхан зүгээр өнгөрөөхгүй. Яагаад гэвэл бид үүгээрээ Бурханы зөвлөгөөг харлуулж, Түүний шударга чанарыг завхруулдаг. Иймээс миний

хувьд Бичээсийн бүрэн үнэнтэй нийцэхгүй теологийг цухалзуулдаг хүмүүс сэжигтэйгээр барахгүй аймаар санагддаг. Бид үнэнээр зааварлуулж, засуулахгүй бол яаж үнэнийг мэдэх билээ?

Иов номын дараа Эзэн надад олон асуултад хариу өгсөн үнэнийг ойлгуулсан юм: “Энэ бол хүмүүс, чуулганууд, урсгал чиглэлүүд Миний оршихуй, амьдрал өөрчлөгч хүчийг үздэггүйн гол шалтгаан. Тэд Миний цэвэр үгийг тунхаглалгүй, харин яг л Иовын нөхөд шиг өөрсдийнхөө шүүвэрлэсэн хөрвүүлэг, үзэл бодлыг хэлдэг. Тэд мэдлэггүй үгээрээ Миний зөвлөгөөг харлуулдаг.”

Хэрэв бид Бурханы оршихуй, хүчийг жинхэнээсээ мэдмээр байвал, ямар ч засалгүй, цэвэр үнэнийг хайх ёстой. Тиймээс Бурханы шүүлтийн талаарх Бичээсийн илчлэлийг судлахдаа, Бурханы хувирашгүй үнэнийг Түүний талаарх олдмол бодол, алдаатай теологи, нөхцөл байдлаар хэзээ ч бүү өөрчил. Зүгээр л илчлэгдсэн Үг дотроос Бурханыг хай. Тэгвэл Түүний арга замыг олно.

Олохын тулд алдах

Тэгэхээр одоо Дүр эсгэгчийн хувь зохиолыг авч үзье. Үүний тулд өмнөх бүлэгт гарсан Есүсийн үгийг дахин нэг харцгаая:

“Тэр өдөр Надад олноороо “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгийг үйлдэж байсан бус уу?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.” (Матай 7:22-23)

Энэ үгийг ЭнКэйЖэйВи Библи “Би та нарыг хэзээ ч мэдэхгүй. Надаас зайл, хууль ёсгүйг хэрэгжүүлэгсэд ээ!” гэж хөрвүүлсэн байдаг. Энэ орчуулга нь ч эх хувьтайгаа илүү таардаг. Хууль ёсгүй байдлыг Грекээр аномиа гэх агаад Бурханы хуулийн юмуу хүслийн эсрэг үйлдэх гэсэн утгатай юм. Энгийнээр хэлбэл Бурханы эрх мэдэлд захирагддаггүй л гэсэн үг.

Есүс “хууль ёсгүй байдлыг хэрэгжүүлэгсэд” гэдэг үгээрээ хааяа нэг бүдэрчихдэг юмуу эсвэл чөлөөлөгдөх гэж тэмцэлдэж байгаа Христийн доторх нялх балчир итгэгчдийг хэлээгүй, харин Бурханд тааламжтай зүйлсийн эсрэг амьдраад сурчихсан, тэдгээрийг үл тоодог, энэ байдлаа зөвтгөдөг эвсэл зүгээр л даажигнаад өнгөрдөг

хүнийг хэлжээ. Тиймээс Есүсийн үг нь Мэхлэгдэгч шиг төөрсөн, Дүр эсгэгч шиг итгэмжгүй хүний аль альд хамаатай.

Есүсийн ярьсан тэдгээр хүмүүс нь шийтгэгдэж, өнө мөнхөд хараагдагсдын газар хаягдана. Тиймээс бид Эзэний үгийг үл тоох юмуу хөнгөн хуумгай үзэж огт болохгүй.

Есүсийн дээрх үгд дурьдагдсан, хоёрдугаар төрлийн хүмүүсийг авч үзье. Бурханы хаанчлалаас нүүр буруулсан тэдгээр хүмүүс нь Есүсийн нэрээр чөтгөрийг хөөдөг хүмүүс ажээ.

Тэд чухам хэн бэ? Эзэн Есүстэй ямар ч холбоогүй атлаа Есүсийн нэрээр чөтгөрийг хөөдөг эрэгтэй, эмэгтэй хүмүүс байж болох уу? Үүний хариултыг Үйлс номоос харцгаая:

“Гэвч мөн шившлэг хийдэг тэнүүлчин иудейчүүдийн зарим нь муу ёрын сүнстэй хүмүүст —Паулын тунхагладаг Есүсээр та нарыг би хөөж байна гэж Эзэн Есүсийн нэрийг ашиглахыг завджээ. Иудей ахлах тахилч Скюгийн долоон хөвгүүн үүнийг үйлдэж байв. Муу ёрын сүнс тэдэнд —Би Есүсийг танина. Паулыг ч мэднэ. Харин та нар хэн юм бэ? гэв. Тэгээд муу ёрын сүнстэй мөнөөх хүн тэдэн уруу ухасхийн дайрч мөнөөх хэдийг хүч түрэмгийлж, дийлэв. Нөгөө хэд ч гэмтэж шархдан тэр байрнаас нүцгэн шалдан гараад зугтжээ.” (Үйлс 19:13-16)

Дээрх хүмүүс Есүсийн нэрээр чөтгөрүүдийг хөөж чадаагүй! Чөтгөрийг хөөхийн тулд Есүсийн нэртэй байхад л болчихдог биш, харин ямарваа байдлаар тэр нэрийн Эзэнтэй Өөртэй нь харилцаатай байх ёстой ажээ. Та өмнөх бүлэгт гарсан хүмүүс шиг биш, харин жинхэнээсээ Христийн дагалдагч байх ёстой.

Та яг одоо: “Гэхдээ Есүс тэднийг хэзээ ч мэдэхгүй гэсэн шүү дээ. Тэгвэл тэд яаж Есүсийн нэрээр гайхамшиг үйлдэж, чөтгөрийг зайлуулсан болж таарах уу?” гэж бодож байж магадгүй.

Цэвэр авралын төлөө Есүстэй нэгдсэн хүмүүс байдаг ч, хувийнхаа эрх ашгийн төлөө нэгдсэн хүмүүс ч байна. Тэд Бурханы зүрхийг хэзээ ч танин мэдээгүй, зөвхөн хүч, ерөөлийг нь л хүсдэг. Тийм “ялзарсан санаа, үнэнээс хагацсан, итгэл сүсгийг ашиг олох хэрэгсэл гэж боддог” хүмүүсийн талаар Паул сэрэмжлүүлсэн. (1Тимот 6:5)

Тэд Есүс дээр хувийнхаа эрх ашгийн төлөө л ирсэн учраас хайрын биш, ашгийн сэдлээр үйлчилдэг. Гэхдээ 1Коринт 8:3

дээр “Хэн Бурханд хайртай байна, тэр Түүгээр танигдсан” гэдэг учраас, Есүс тэднийг танихгүй.

Бурхан түүнийг мэднэ. Мэднэ гэдэг нь Бурхан бүгдийг мэддэг гэдэг утгаараа мэддэг гэж хэлээгүй юм. Бурхан үнэхээр бүгдийг мэддэг! Гэхдээ энд ойр дотно харилцааны тухай хэлжээ.

Есүс Шүүх өдөр тэр олон хүнд: “Би та нарыг хэзээ ч мэдэхгүй!” гэсэн. Тиймээс Бурханд хайргүй тэдгээр хүмүүс нь хэдий Бурханаас аврал хайж ирсэн ч, Бурхан Аав, Есүс хоёр тэднийг дотно мэдэхгүй ажээ. (Тэд Бурханыг үг дуугүй дагаагүй, айж эмээгээгүй, талаархаагүй учраас мэдээж Бурханыг хайрлаагүй) Есүсийг хайрлана гэдэг нь Түүнд амьдралаа өгөхийг хэлж байгаа юм. Та цаашид өөрийнхөө төлөө биш, Түүний төлөө амьдарна.

Иудас бол тэдний нэг жишээ. Иудас Есүстэй нийлж, золиос гарган Есүсийг дагахдаа, Бурханд хайртай юм шиг л харагдаж байсан. Иудас Есүсийн үйлчлэлийн багт орж, Эзэнтэй хамт явахын төлөө байгаа бүхнээ орхисон. Ширүүн хавчлага ирэх үед бусад нь зугтаж байхад тэр үлдсэн. (Иохан 6:66) Тэр бууж өгөөгүй. Тэр чөтгөрүүдийг хөөж, өвчтэйг эдгээж, сайн мэдээг номлосон. (Лук 9:1)

Гэхдээ Иудасын санаа анхнаасаа зөв байгаагүй. Тэр амиа бодсон зангаа хэзээ ч гэмшээгүй. “Тэгэхийн бол та нар надад юу өгмөөр байна?” (Матай 26:15) гэх мэт үгээр нь түүний жинхэнэ чанар нь илэрдэг байсан. Тэр нэр олох гэж оролддог байсан (Матай 26:25), Есүсийн үйлчлэлийн сангаас хувьдаа завшдаг байсан (Иохан 12:4-6) гэх мэтээр тоочоод л байвал, тоочоод л байна. Иудас хэдийгээр Эзэнийг гурван жил хагас дагасан ч, үнэндээ Эзэнээ мэдээгүй юм. Тиймээс Есүс: “Би та нарыг, арван хоёуланг чинь сонгосон биш үү? Гэтэл та нарын нэг нь диавол байна” гэжээ. Есүс Искаротын Симоны хүү Иудасыг хэлжээ. Тэр арван хоёрын нэг бөгөөд Есүсийг барьж өгөх гэж байв” гэсэн юм. (Иохан 6:70-71)

Иудас шиг үйлчлэлийн золиос гаргаж, хүмүүсийг чөтгөрийн дарлалаас чөлөөлж, өвчтэйг эдгээж, Сайн мэдээг номлож, Есүст авралын төлөө найддаг боловч, Есүсийг үнэндээ танихгүй хүмүүс бий. Тэд Бурханд биш, олз ашигт хайртайдаа л ингэдэг. Дүр эсгэгч яг тийм хүн байсан. Тэр Жэйлиний нэр нөлөө, эрх хүчинд нь дурласандаа, Түүнийг дагасан бөгөөд анхнаасаа л Түүнийг хайрлах ямар ч санаагүй байжээ.

Ийм хүмүүст хамгийн аймшигтай шийтгэл товлогдсон болно. Есүс Иудагт: “Харин Хүний Хүүг бариулах тэр хүн золгүй еэ! Тэр хүн төрөөгүй байсан бол дээр байхсан (Матай 26:24) гэж хэлсэн байдаг. Олз ашгийн төлөө Бурханд үйлчилж, Эзэний нэрээр хүмүүсийг завшдаг шашны удирдагч нарт Есүс: “Та нар ...илүү хүнд шийтгэл хүлээнэ” (Матай 23:14) гэсэн. Ийм хүмүүс Дүр эсгэгч шиг тамын хамгийн харанхуй, хамгийн тарчлаантай хэсэгт хаягдана.

Авралаа хаях

Сая бид Дүр эсгэгч шиг хүмүүсийн талаар үзлээ. Тэгвэл Бүрэгийн хувьд? Тэр Жэйлинтэй жинхэнээсээ харилцаж, хайрладаг байсан ч, эцсээ хүртэл тэвчээгүй юм. Бичээс ч энэ талаар ярьдаггүй гэж үү? Эш үзүүлэгч Езекиелийн үгээр судлалаа эхлээ:

“Гэвч зөвт нэгэн зөвт байдлаасаа эргэж, гажуудлыг үйлдээд, буруутын хийдэг хамаг жигшүүрийг үйлдэх аваас тэр амьд үлдэх үү? Үйлдсэн бүх зөвт үйлс нь үл дурсагдана. Учир нь урвалт ба үйлдсэн нүглийнхээ улмаас тэр үхэх болно.”
(Езекиел 18:24)

Нэн түрүүнд Бурхан өөрийгөө зөвт гэж боддог ч, хэзээ ч зөвт байгаагүй хүний тухай биш, харин жинхэнэ зөвт хүний тухай ярьжээ. Тэрбээр өмнө ярьсан мэхлэгдсэн эвсэл хуурамч хүмүүсээс ялгаатай.

Гэтэл Бурхан тэр хүний ямар ч зөвт байдлыг санахгүй гэжээ. Бурхан нэг мартахаараа хэзээ ч байгаагүй юм шиг мартдаг. Бурхан бидний нүглийг зүүн нь баруунаасаа хол байдаг шиг холдуулж, умартлын далайд хаядаг гэсэн. Тэгээд “Би тэдний гэм бурууд өршөөнгүй хандана. Би цаашид нүглийг нь дахин эс санана” гэдэг (Еврей 8:12). Бид Есүсийг Эзэнээ болгон хүлээж авах үед Бурхан бидний нүглийг мартдаг. Дявол биднийг яллах гэж оролддог ч, Бурхан бидний нүглийг дахиж санахгүй гэсэн. Тиймээс Түүний хувьд бид хэзээ ч нүгэл үйлдээгүй буюу.

Гэхдээ нөгөө тал нь ч бас үнэн болохыг санаарай. Бурхан хүний зөвт байдлыг санахгүй гэдэг нь Түүнийг таньдаг байснаа ч мартаж, тэр харилцаа бүр мөсөн устана гэсэн үг юм.

Тэгэхээр, итгэгч хүн авралаа нэг мөр хаяад явна гэдэг нь ямар утгатай болохыг Бичээсээс харцгаая. Элч Иаков:

“Ах дүү нар минь, хэрэв та нарын нэг чинь үнэнээс гажаад, хэн нэг чинь түүнийг эргүүлэн авчирвал,хуурамч замаас нь нүгэлтнийг эргүүлж авчирсан тэр хүн түүний сэтгэлийг үхлээс аварч, тоо томшгүй олон нүглийг халхлах болно гэдгийг та нар мэдэгтүн” (Иаков 5:19-20) гэжээ.

Хамгийн түрүүнд “Ах дүү нар аа... та нарын дундаас” гэдэг үгийг анхаарна уу. Иаков өөрийгөө Христэд итгэгчид тооцохоос цаашгүй хүний талаар яриагүй, харин үнэнээс дайждаг жинхэнэ итгэгч хүний талаар ярьж байна. Үнэнээс дайждаг ахан дүүсийг энд нүгэлтэн гэжээ. Энэ нь тэрбээр буцаад дахин төрөөгүй хүн болчихсон гэсэн үг биш, харин байнга нүгэл үйлдэж байгаа учраас, бүрэн дуулгавартай болох ёстой гэсэн үг юм. Хэрэв тэрбээр Бурхан руу эргэж ирэхгүй (гэмшихгүй) аваас, сүнсний үхлээр үхнэ. Сургаалт үгс үүнийг “Ухааны замаас гажигч хүн Үхэгсдийн чуулганд дуусна” (Сургаалт үгс 21:16) хэмээн батлан хэлсэн.

Эргэлт буцалтгүйгээр Бурханы замаас дайжигч нь үхлийн чуулганд буюу эхлээд Хайдаст, хожим нь Галт нуурт орно гэсэн Иаковын үгийг Сургаалт үгс батлан хэлжээ.

АМИЙН НОМ

Амийн номын талаар Шинэ гэрээнд найман удаа ярьдаг. Өнө мөнхөд амьдрах, Эзэний хүмүүс энэ номд бичигдсэн болохыг Паул, Иохан хоёр хэлсэн. Биднийг дахин төрөх үед нэрс маань тэнд бичигддэг.

Дөрөвдүгээр бүлэг дэхь Эфросинигийн гэрчлэлийг санаж байна уу? Тэр жаалхан Грек охин амьдралаа Есүст өргөх үед Бурхан Аав нэрийг нь Амийн номд бичээд: “Тэр бүлдээ тавтай морил!” гэж хэлсэн. Яг үүнтэй адил Паул итгэл нэгт нөхөддөө: “Тийм ээ, үнэнч нөхөр минь, чамаас гуйя. Сайнмэдээний төлөө надтай болон Клем, бусад хамтран зүтгэгчдийн минь хамт тэмцсэн тэдгээр эмэгтэйчүүдэд туслаарай. Тэдний нэрс амийн номд бий” гэж бичсэн байдаг (Филиппой 4:3).

Гэхдээ нөгөө тал нь ч бас үнэн болно. Амийн номд бичигдээгүй

бүхэн нь алдагдана. Илчлэл номын 21:27 дээр: “Мөн амийн номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав” гэсэн. Тэгэхээр бичигдээгүй нь үхлийн чуулганд орох ажээ.

Илчлэл 3:5-аар ишлэлийг Есүс хотынхонд, итгэдэггүй хүмүүст, худал бурхдын сүсэгтнүүдэд юмуу “чуулганы” дүртэй чуулганд биш, харин жинхэнэ чуулганд айлджээ:

“Энэ мэт ялагч нь цагаан хувцас өмсөнө. Би түүний нэрийг амийн номоос баллахгүй.”

Баллах гэдэг үгийг харж байна уу? Тэгэхээр, тэр нэр анх тэнд байсан байна. Зөвхөн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин дахин төрсөн хүмүүс л Амийн номд бичигддэг. Итгэгч бус хүмүүс юмуу Есүстэй хэзээ ч хамт алхаж байгаагүй мэхлэгдсэн хүмүүс хэзээ ч тэр номд бичигдэхгүй учраас, нэрс нь баллагдах боломжгүй юм. Тиймээс л Есүс “гэр бүлийнхээ” тухай өгүүлжээ.

Сэрээсэн үзэгдэл

Арван есдүгээр зуунд дал орчим жил Эзэнд итгэмжтэй үйлчилсэн нэгэн хүн байжээ. Тэрбээр Христийн бие дотор маш хүчтэй нөлөө авчирч, 65 орчим сая ном хэвлүүлж, Библийн сургуулиараа 20,000 хүнийг сургажээ.

Тэрбээр миний яриад буй яг энэ сэдвээр нэгэн номдоо бичсэн байдаг юм. 1952 онд Есүс түүнд үзэгдлээр үзэгдээд, түүний маш сайн мэдэх нэгэн пасторын гэргийг харуулжээ. Тэр эмэгтэй үйлчлэлээс болж хамаг чадвар, гоо үзэсгэлэн нь үрэгдэж байна гэдэг худалд итгэх болсон аж. Тэгээд сүүлдээ дэлхийн цуу, алдар, баялагт дурлан, олзлуулж, нөхрөөсөө салаад хүссэн амжилтынхаа араас явжээ.

Гэтэл Эзэн тэр үйлчлэгчид: “*Тэр эмэгтэй нэгэн цагт Миний охин байлаа*” гээд, түүний төлөө бүү залбир гэжээ. Одоо би тэр хүний номоос шууд эш татъя:

-“Эзэн минь, тэр яагаа вэ?” гэж би асуулаа.

-“Тэр уйлж, шүдээ хавирдаг хараагдагсдын газар өнө мөнхийг өнгөрөөнө” гэж Эзэн хариуллаа. Тэгээд үзэгдэлдээ би тэр эмэгтэйг тамын гав руу унаж байхыг бас аймшигтай чарлахыг нь сонсов.

-“Тэр Таны хүүхэд байсан шүү дээ. Таны Сүнсээр дүүрч, үйлчлэлд ч оролцдог байсан. Гэтэл та түүний төлөө бүү залбир гэх юм. Би ойлгохгүй байна!”

Эзэн надад “Хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй” (1Иохан 5:16) гэсэн Бичээсийг сануулав.

Би: “Гэхдээ Эзэн минь, энэ Бичээст хэлсэн нь махан биеийн үхэл бөгөөд хүн нүгэл үйлдсэн ч, аврагдана гэдэгт би итгэсээр ирсэн шүү дээ” гэлээ.

-“Гэхдээ Бичээс махан биеийн үхэл гэж хэлээгүй” хэмээн Эзэн онцлоод: “Чи өөрөө нэмээд байна. Чи Нэгдүгээр Иоханы тавдугаар бүлгийг бүхлээр нь унших юм бол, тэнд амь, үхлийн тухай - сүнслэг амь, сүнслэг үхлийн тухай ярьж байгаа. Энэ бол сүнслэг үхэл. Энэ нь үхэлд хүртлээ нүгэл үйлдэгч хүний тухай юм. Тиймээс л би чамайг түүний төлөө бүү залбир хэмээв. Тэр эмэгтэй үхэлд хүртэл нүгэл үйлдсэн учраас, Би чамд түүний төлөө бүү залбир гэлээ” хэмээн айлдав.

-“Эзэн минь, энэ чинь миний теологийг эвдэж байна. Та над нарийн тайлбарлаж өгөөч?”(Заримдаа бид Бурханы Үгтэй эгнэхгүй байгаа теологио эвдэх ёстой).

Есүс надад Еврей 6:4-6-аар ишлэлийг сануулав:

“Учир нь нэгэнтээ гэгээрүүлэгдсэн бөгөөд тэнгэрлэг бэлгийг амссан, Ариун Сүнсний хуваалцагч болсон, Бурханы сайн үгийг болон ирэх үеийн хүчийг амссан атлаа дараа нь завхайрагсад дахин шинээр гэмших боломжгүй. Яагаад гэвэл тэд өөрсдөдөө Бурханы Хүүг дахиад цовдолж, илэрхий гутамшиг болгодог аж.”

Дээрх бичээст анхаарах ёстой хэд хэдэн шинж бий. Нэгдүгээрт - гэгээрүүлэгдсэн бас тэнгэрлэг бэлгийг амссан хүний талаар л итгэлээ хаясан гэж ярина. Есүсийг хүлээж аваагүй хүний талаар итгэлээ хаясан гэж ярих боломжгүй. Учир нь Есүс бол тэнгэрлэг бэлэг юм. Хоёрдугаарт- тэр хүн Ариун Сүнсээр дүүрсэн байх ёстой. Гуравдугаарт - тэрбээр Бурханы сайн үгийг болоод ирэх үеийн хүчийг амссан хүн байна. Тэгэхээр энэ нь нялх итгэгч биш, төлөвшсөн итгэгч болох нь харагдаж байна.

Надад хүмүүс Эзэнд “Би танд үйлчилмээргүй байна” гэж хэлсэн

тухайгаа уйлан хайлан ярьдаг. Гэхдээ дараа нь тэд дээрх болон дээрхтэй төстэй Бичээсийг үзээд, харуусан гэмшжээ. Нялх хүүхэд мунхаг байдлаасаа болж заримдаа мунхаг авирладгийг Эзэн мэднэ. Гэхдээ Еврей ном нялх итгэгчийн тухай яриагүй, харин төлөвшсөн итгэгчийн тухай ярьсан юм.

Тэдгээр зовнисон хүмүүсийг би: “Хэрэв та (дээрх шиг) үхэлд хүргэх нүгэл үйлдсэн байсан бол, Есүстэй нөхөрлөх гэж буцажирэх ч үгүй. Гэтэл Есүсийг санаж, жинхэнээсээ гэмшиж, бурханлаг үр жимс ургуулсан чинь өөрөө Ариун Сүнс таныг эргүүлж авчирсны баталгаа мөн” хэмээн Үгээр босгодог. Хэрэв тэр хүмүүс Есүсээс нэг мөр салсан бол, нөгөө үйлчлэгчийн үзэгдэлд гарсан эмэгтэй шиг Есүстэй дахин дотносохыг ч хүсэхгүй, ариун амьдрахыг ч хүсэхгүй байх байсан.

Есүс тэр эмэгтэйг “Бурханы хүүхэд байсан” гэжээ. Үзэгдэл үзсэн үйлчлэгч нь өөрөө хүн авралаа алдахгүй гэдэг итгэл үнэмшилтэй урсгал чиглэлд өсч бойжсон байв. Тэд ямар ч болзолгүй, мөнхийн баталгаатай авралд итгэдэг. Тиймээс л тэрбээр Эзэнд: “Энэ чинь миний теологийг эвдэж байна” гэж хэлсэн юмсанж. Бурханы хүүхэд байсан тэр эмэгтэй нэрээ Амийн номд бичүүлээд байсан ч, тэвчилгүй, дэлхий рүү нэг мөр явсан учраас - Илчлэл 3 дээр хэлсэн Есүсийн анхааруулгаар - нэр нь баллагджээ. Тэр итгэлээ хаяхыг сонгосон. Тэр бол “ялагч” биш. Тиймээс л ийм хүн сэргээгдэх боломжгүйг Еврей номын бичээч хэлжээ. Тэр эмэгтэй одоо хоёр удаа үхжээ. Нэгэнтээ нүгэлдээ үхсэн байгаад мөнхийн амийг хүлээн авч амьдарсан ч, ахин Есүсийг нэг мөр хаяж явснаараа дахин нүгэлдээ бүр мөсөн үхжээ (Иуда 12).

Ийм байдалд орсон хүн хэзээ ч дахин сэргээгдэхгүй. Тиймээс л Еврей номын бичээч “тэднийг дахин гэмшил рүү шинэчлэх... боломжгүй” гэжээ. Тэгэхээр хүн ахиад “дахин төрж” болно гэдэг нь буруу юм.

Би дахиад хэлье: Энэ нүглийг үйлдсэн хүн гэмших ямар ч хүсэлгүй, Есүсийн төлөө дахиад амьдралаа зориулах ямар ч хүсэлгүй болдог. Ариун Сүнснээс өөр хэн ч биднийг Есүс рүү ойртуулж чадахгүй. Итгэлээ нэг мөр хаясан хүнийг Ариун Сүнс нэг мөр орхисон л бол, дахиад хэзээ ч эргэж очихгүй. Яг л дээрх үзэгдэлд гарсан эмэгтэйг нэг мөр орхисон шиг. Тиймээс л Ариун Сүнс баргийн юманд бууж өгдөггүй, тэвчээртэй Нэгэн билээ.

Түнэр харанхуй

Үүнийг элч Петр бидэнд бүр ч тодорхой хэлж байна:

“Хэрэв тэд хорвоогийн бусармагаас Эзэн ба Аврагч Есүс Христийн мэдлэгээр зугтаад...” (2Петр 2:20)

Тэгэхээр, эхлээд Петр хэнд хандан ярьсныг үзье. Хүн дэлхийн бузраас (муу муухайгаас) Аврагч, Эзэн Есүс Христийг мэдэх мэдлэгээр зугтсан бол, ямар ч эргэлзээгүй Христэд итгэгч болсон. Тийм хүнийг үүний өмнөх бүлэгт өгүүлсэн, Бурханыг мэддэг гэдэг ч, үнэндээ мэддэггүй мэхлэгдсэн хүмүүсийн ангилалд багтааж болохгүй. Тэд бол Эзэн Есүсийн аврагч нигүүлслээр энэ дэлхийн завхралаас жинхэнээсээ зугтсан хүмүүс юм. Тиймээс Петр жинхэнээсээ дахин төрсөн хүмүүст хандаж өгүүлсэн нь эргэлзээгүй байна. Цааш нь уншъя:

“...зугтсаны дараа тэдгээрээр дахин урхидуулан дийлдвэл тэдний хувьд сүүлчийн байдал нь эхнийхээсээ бүр дордох болно. Учир нь зөвт байдлын замыг мэдээд, өөрсдөд нь өгөгдсөн ариун тушаалуудаас нүүр буруулан эргэснээс энэ замыг мэдээгүй байсан нь тэдэнд дээр байх байсан.” (2Петр 2:20-21)

Петр энд эргээд нүгэлд боолчлуулсан хүмүүсийн талаар яриад уналаа. Уг нь тэд Есүс Христээр дамжих жинхэнэ авралыг үзээгүй байсан бол дээр байх байж. Тэд дуулгавартайгаар ариун амьдрахын оронд, амьдралын таашаал, тачаал, бардамналыг эргэлт буцалтгүй сонгожээ.

Яагаад зөвтийн замыг мэдээгүй байсан бол дээр гэж? Үүнд Иуда хариулдаг. Петрийн адил Иуда ч бас авралаа хаясан хүмүүсийн талаар ярьдаг. “Тэд золгүй еэ! Учир нь тэд Каины замаар явж, шан харамжийн төлөө Балаамын төөрөгдөлд өөрсдийгөө тушаасан бөгөөд Корегийн тэрслэлд мөхжээ.” (Иуда 11).

Каин, Балаам, Коре нар бүгд л Эзэнтэй харилцаатай байсан хүмүүс. Тэдний хоёр нь үйлчлэгч байсан. Каин Бурханд дуулгаваргүй загнасан бол, Балаам мөнгөнд дурласан, харин Коре эрх мэдлийн эсрэг тэрслэсэн. Иуда 12-13:

“Эд бол та нарын хайрын зоогон дахь сэв бөгөөд эмээлгүйгээр та нартай найрлахдаа өөрсдийгөө л тэжээдэг. Тэд салхинд туугдах хургүй үүл, үндсээрээ сугалагдсан, хоёр дахиа үхсэн, үр жимсгүй, намрын мод бөгөөд өөрсдийнхөө шившгийг хөөсрүүлэх тэнгисийн догшин давалгаа, тэнүүчлэгч одод мөн. Түнэр харанхуй нь тэдний төлөө үүрд хадгалагдсан юм.”

Анхны чуулганы гишүүд нь Бурхантай болоод өөр хоорондоо тогтоосон дотно харилцааныхаа илрэл болгон орой бүр хамтдаа хайрын зоог барьдаг байжээ. Хайрын зоог нь ихэвчлэн Эзэний зоогийн билэгдлээр өндөрлөнө.² Эндээс бид зог тусмаар нэгэн үнэнийг мэдэж болно: авралаа хаяж явдаг хүмүүс нь заавал мөнөөх үзэгдэлд гарсан эмэгтэй шиг чуулганаасаа явалгүй, чуулган дотроо үлдэж болох ажээ. Тийнхүү тэд нялхас, сул дорой, шархтай эмзэг хүмүүсийг хөндөж чадах учраас, туйлын аюултай юм.

Коре яг тийм хүн байсан. Тэрбээр Аароны хамтран үйлчлэгч байсан ч, Мосе Аарон хоёрт “Та нар арай дэндэж байна. Даяар хотол түмэн, хүн бүр нь ариун бөгөөд ЭЗЭН тэдний дунд байна. Юунд та нар өөрсдийгөө ЭЗЭНий чуулганаас дээгүүр өргөмжилнө вэ?” (Тооллого 16:3) гэдэг. Коре энэ үгээрээ 250 удирдагч, чуулганы 14,700 гишүүн дээр үхлийн шийтгэл авчирсан!

Сэв мэт эдгээр урван тэрслэгчид нь чуулган дотор байж л байдгийг Иуда хэлсэн. Тэд нэгэнтээ дотор нь алхаж явсан нигүүлслийнхээ хуурамч баталгаанд найдан, өөртөө үйлчилж, Бурханаас айж ичэхээ больдог. Коре: “Бурхан бид бүхэнтэй хамт байгаа” гэж хэлсэн байгаа биз? Тэр ч бас тэр хуурамч баталгааг тээж явжээ. Учир нь маргааш нь газар ангайж, там түүнийг амьдаар нь залгисан юм.

Тэдгээр урван тэрслэгчид Христэд итгэгчдийн хэлээр ярьсаар байдаг. Тэд бусад итгэгч нартай нөхөрлөдөг ч, Есүсийг эргэж ирэх үед ялагчдын дундаас тэднийг олохгүй. Есүс сэвгүй чуулганы төлөө эргэж ирнэ. (Ефес 5:27)

Иуда тэр хүмүүсийг хоёронтаа үхсэн гэжээ. Хүн яаж хоёр үхэх вэ? Та нэгэнтээ нүгэлд үхсэн байгаад, шинэ төрөлтөөр мөнхийн амийг хүлээн авсан ч, байнга үйлддэг нүгэл, гэмшилгүй байдлаараа дахин үхдэг. Христэд итгэдэг хүн үнэнээс дайжаад, тэр байдалдаа байсаар байвал, түүний сүнс нь үхнэ гэж Иаков хэлснийг санаж байна уу? Түүнчлэн Иохан ч итгэгчдийг үхэлд хүргэдэг нүглийн талаар ярьсан. Иаков ч, Иохан ч “хоёронтаа

үхдэг” хүний тухай өгүүлжээ.

Иуда “түнэр харанхуй нь тэдний төлөө үүрд хадгалагдсан” гэж хэлснийг анхаарна уу. Түнэр харанхуй нь хамгийн аймшигтай мөнхийн шийтгэл юм.

Үүнийг дахин ирэлт ба шүүлтийн талаар хэлсэн Есүсийн үгээс тодорхой харж болно:

“Эзэн нь ирэх үед сэргэг байх боолууд ерөөлтэй еэ. Үнэнээр Би та нарт хэлье. Эзэн нь бүсээ бүсэлж, боолуудаа тухлахыг урьж, тэдэнд үйлчилнэ. ... Харин тэр зарц зүрхэндээ “Эзэн маань ирэхгүй удна” гээд зарц нарыг эр эм гэлгүй жанчиж, идэж уун согтуурч эхэлтэл, бодоогүй өдөр, мэдээгүй цагт нь мөнөөх зарцын эзэн ирж, түүнийг тас хэрчиж, итгэлгүйчүүдтэй хувийг нь онооно. Эзнийхээ хүслийг мэдсэн хэрнээ бэлдээгүй, хүслийнх нь дагуу биелүүлээгүй зарц ташуурын амт хатуухан хүртэнэ. Харин үүнийг мэдээгүй бөгөөд ташуурын амт хүртэх хэрэг үйлдсэн нэг нь багахан хүртэнэ. Хэнд их өгөгдсөн байна, түүнээс ихийг шаардана. Хэнд их даалгагдсан байна, түүнээс ихийг нэхнэ.” (Лук 12:37, 45-48)

Маш олон зүйлийг өгүүлсэн энэ ишлэлээс голыг нь л базаж ярья. Нэгдүгээрт - энд гарч байгаа хүн нь гадны хүн, харь үндэстэн юмуу нүгэлтэн биш, харин эзэнийхээ хүслийг мэддэг ч, дураараа дургисан зарц ажээ. Тэрбээр сайн мэдэхгүй байж байгаад, цөөхөн ташуурдуулсан Бие даагчтай адилгүй юм. Тэрбээр бас Мэхлэгчдэгчийн ангилалд ч багтахгүй. Мэхлэгдэгч өөрийгөө зарц гэж бодсон ч, Жэйлиний хэлснээр тэрбээр хэзээ ч зарц байгаагүй байдаг. Есүсийн энд ярьсан хүн нь эзэнийхээ хүслийг нэгт нэгэнгүй мэддэг зарц хүн байжээ. Гэвч тэр авралаа хаяж явсан.

Тэрбээр бусад зарц нараа зодож танхайрсан байгаа. Өөрөөр хэлбэл тэрбээр өөрийнхөө эрх ашиг, таашаалын төлөө бусдыг завшаад сурчихсан гэсэн үг. Тэрбээр идэж, ууж, согтуурч, өнөөдрөөрөө л амьдарч, өөртөө л үйлчилдэг. Урван тэрслэгч нь Бурханаас огт айж ичэлгүйгээр бусадтайгаа наргидаг тухай Иуда ярьсныг санаж байна уу? Тэд өөртөө л үйлчилдэг. Тэдний бүх шийдвэр зөв харагддаг ч, өөрийнх нь л эрх ашгийн төлөө байдаг.

Тэгээд эцэстээ тэр зарц үл итгэгчдийн (буюу хэзээ ч аврагдаагүй хүмүүсийн) байдаг газарт хаягдах шийтгэл авчээ. Үл итгэгчид нь цөөхөн ташуурдуулсан бол, эзэнийхээ хүслийг мэдсэн ч, мэдээгүй

мэт амьдарсан зарц хатуу шийтгүүлж хамгийн хүнд мөнхийн шийтгэлд буюу Галт нуур - түнэр харанхуйд орно!

Хорсол, үл уучлал

Энэ бол Бүрэгийн (бас Дүр эсгэгчийн) алдаа юм. Жэйлин түүнийг бусдыг уучлахыг хүсч байгааг Бүрэг мэдсэн ч, уучлаагүй. Тэр Хутгуурт хорсохоор шийдэж, энэ хорсол нь яваандаа түүнийг ялзруулжээ. Тиймээс л Бичээс: “Хэн чинь ч Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд болон аливаа гашуун үндэс урган хор учруулж, түүгээр олноороо бузарлагдахгүйн тулд сэрэмжил” (Еврей 12:15) гэдэг.

Хүмүүсийг Бурхантай алхах амьдралаас нь тасладаг хамгийн том урхи бол үл уучлал гэдгийг миний бие Бичээсээс болон үйлчлэлийнхээ туршлагаас мэднэ. Бүрэгийн хувьд ч ялгаагүй - үл уучлал нь л түүнийг гажуу итгэл, үнэмшил, үйлдэлд хүргэжээ.

Матай 18-аар бүлэгт Есүс “нэгэн аугаа хаан хэрхэн тооцоо хийсэн” тухай сургаалт үлгэр ярьдаг. Хаан дээр арван мянган талантын өртэй зарцыг авчиржээ. Талант нь мөнгөний хэмүүр биш, харин жингийн хэмжүүр юм. Үүгээр алт (2Самуел 12:30-ийг үзнэ үү), мөнгө (1Хаад 20:39-ийг үзнэ үү) тэргүүтэй метал бараа таваарыг хэмждэг байж. Энэ сургаалт үлгэрт талант нь өрийн хэмжүүрийг төлөөлж байгаа учраас, Есүс алт, мөнгийг хэмждэг нэгжийн тухай ярьж буй гэдэгт итгэж болно. Яахав, алт байжээ гэж бодъё.

Нэг талант нь ойролцоогоор гучин дөрвөн кг-тай дүйцнэ. Энэ нь насанд хүрсэн эр хүний өргөж даах хэмжээ юм (2Хаад 5:23). Тэгвэл арван мянган талант нь ойролцоогоор 375 тонн болно. Тэгэхээр тэр зарц хаандаа 375 тонн алтны өртэй байжээ. Намайг энэ номыг бичиж байхад нэг унци алт ойролцоогоор 1200 доллар байсан. Тэгвэл жаахан тоо бодъё. Арван мянган талант алт нь ойролцоогоор арван дөрвөн тэрбум доллар болох нь. Тэгэхээр, зарц хаандаа тийм их өртэй байж! Гол нь тэр зарц хаандаа хэзээ ч төлж барахааргүй өртэй байсныг л Есүс хэлжээ.

Тэгээд хаан тэр зарцад болон гэр бүлд нь өрөө барагдуулахын тулд зарагдах ёстойг нь дуулгатал, нөгөө зарц хааныхаа хөлд хөсөр унаад, өршөөл гуйсанд хаан нь өршөөжээ. Бүхий л өрийг нь бүрэн хүчингүй болгосон.

Энэ түүхийн хаан нь Бурхан Аавыг төлөөлж байгааг бид

ойлголоо. Өрнөөсөө чөлөөлөгдсөн хүн нь Есүс Христээр дамжин уучлалыг хүлээж авсан хүн юм. Хор хүргэсэн л бол өртэй болно. Хүмүүс “Чи үүнийхээ хариуг төлнө өө, гайгүй” гэж хэлж байхыг сонссон уу? Тэгвэл уучлал нь тэр өрийг цуцлаж буй явдал юм. Тэр зарц яг л бидэн шиг төлж барахын аргагүй их өрөө уучлуулжээ.

Гэтэл дараа нь ийм явдал болов. “Харин өнөөх зарц гадагш гараад, өөрт нь зуун денарын өртэй байсан анд болох нэгэн зарцыг олж хараад барьж авч хоолойг нь боон, “Өрөө төл” гэв.” (Матай 18:28)

Денар нь нэг өдрийн цалин юм. Өнөөгийнхөөр 100 доллар гэж төсөөлье. Тэгвэл нөгөө зарц нь 10,000 долларын өртэй болж таарна. Энэ ч багагүй л өр.

Тэгтэл “Харин анд нь болох тэр зарц сөхрөн унаж, түүнээс гуйн “Намайг тэвчиж хүлцээч. Чамд бүгдийг төлнө” гэжээ. Харин тэр үл хүсэн, явж түүнийг өр ширээ төлтөл нь шоронд хаяв.” (Матай 18:29-30) Эхний зарц өөрөө арван дөрвөн тэрбум долларын өрөө уучлуулсан. Гэтэл өөртөө 10,000 долларын өртэй найзаа уучлалгүй, өрөө төлтөл нь шийтгэхээр шийджээ.

Хүн бид Бурханаар арван дөрвөн тэрбум долларын өрөө уучлуулчихаад, бие биеэсээ арван мянган долларын өрөө нэхдэг! Хүмүүс таныг яаж ч гомдоосон бай, тэр алдаа нь Бурханы өмнө гаргасан таны алдааны дэргэд юу ч биш юм. Та өөрийгөө хамгийн аймшигтай доромжлол үзлээ гэж бодож байгаа бол, Есүс ямар аймшигтай доромжлуулсныг ухаараагүй л байна. Есүс бидний арван дөрвөн тэрбум долларын өрөнд алуулсан, ямар ч гэм буруугүй хурга байсан.

Уучилдаггүй хүн ямар аймшигтай өрөө уучлуулснаа мартжээ! Есүс өөрийг нь ямар гээчийн үхэл, мөнхийн тамаас чөлөөлсөнийг ухаарсан хүн бусдыг зүгээр л уучилна. Мөнхийн галт нуур шиг аймшиг байхгүй. Үүнээс чөлөөлөгдөх арга байхгүй. Өт нь үхэхгүй, гал нь унтрахгүй. Бурхан биднийг Хүү Есүс Христийнхээ үхлээр дамжуулан уучлахаас өмнө биднийг ийм л хувь зохиол хүлээж байсан! Уучилж чаддаггүй хүн тамыг мэдэхгүй л байна. Тэрбээр Бурханы хайр, уучлалыг ухаараагүй л байна.

Цааш нь юу болсныг үзье:

“Анд зарц нар нь болсон явдлыг хараад ихэд гутарч, эзэндээ очиж, болсон бүгдийг мэдэгджээ. Тэгтэл эзэн нь түүнийг дуудаад түүнд “Ёрын муу зарц, чи надаас гуйсан тул би бүх

өрийг чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи бас анд чинь болох тэр зарцыг өршөөх ёстой байсан бус уу?” хэмээв.
(Матай 18:31-33)

Есүс энд үл итгэгч хүний тухай бус, хааны зарц - дахин төрсөн итгэгч хүний тухай ярьсан. Тэрбээр хаанаараа үлэмж их өрөө уучлуулж (аврагдаж), хааныхаа зарц болжээ. Түүний уучлаагүй хүн нь ч бас хааны зарц байжээ. Тэгэхээр, уучилдаггүй итгэгч хүн ч бас ингэх нь байна.

Бид эндээс нэгэн гайхалтай үнэнийг мэдэж болно. Есүс Сайн мэдээний сургаалт үлгэр ярьсныхаа дараа заавал хүмүүсээр асуулгаж байж утгыг нь тайлбарладаг байсан бол, энэ сургаалт үлгэрийн утгыг шууд Өөрөө тайлбарлаж өгсөн байдаг. Миний бодлоор Есүс жирийн ойлголтоос давсан зүйл ярьсан учраас хүмүүст багтай ойлгуулахыг хүссэндээ тэгсэн байх. Тэгээд Есүс ингэж тайлбарлажээ:

“Эзэн нь ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажээ. Түүнчлэн та нарын нэгбүр чинь ах дүүгээ зүрхнээсээ эс уучлах аваас тэнгэрлэг Эцэг минь ч та нар тэр мөн тэгж хандах болно гэлээ.” (Матай 18:34-35)

Энэ хоёр ишлэлээс би гурван чухал санааг заамаар байна. Нэгдүгээрт - үл уучлагч зарцыг зандалчинд тушаасан. Хоёрдугаарт - одоо тэр анхныхаа 375 тонн алтаа төлөх ёстой болсон. Гуравдугаарт - ахан дүүсээ уучилдаггүй хэнийг ч Бурхан Аав ингэх болно.

Одоо товч тайлбарлая. Нэгдүгээрт - зандалчин (буюу тамлал) нь жирийн нөхцлөөс давсан, бие, оюуны үлэмж хүчтэй зовлон, зовиурыг илэрхийлнэ. Энэ тамлалыг зандалчин гүйцэтгэдэг.

Уучлахаас татгалзсан итгэгч хүн чөтгөрийн сүнсэнд тамлуулдаг. Эдгээр зандалчид буюу тамлагчид нь хүссэн үедээ бие, оюуныг маань хүссэнээрээ тамлан зовоох зөвшөөрөлтэй. Бусдыг зүрхнээсээ уучилж, суллаагүйгээсээ болж эдгэрэл, тайтгарал, тайвшрал, чөлөөлөлт хүлээж авч чадахгүй байгаа олон хүнд би үйлчилж явсан. Энэ хорсол нь эцэстээ заавал Бурханд хорсох хорсолд хүргэдэг юм. Тэр хүний итгэл нь ялзарч, ямар ч гэмшил уучлал байхгүй бол эцэстээ үхэж дуусна.

Хоёр дахь зарчим нь үл уучлагч зарц өөрийнхөө төлөхийн аргагүй их өрийг төлөх ёстой болсон. Тэр одоо боломжгүй юмыг хийх ёстой болжээ! Энэ бол Есүсийн загалмай дээр төлсөн өр юм. Та үүнд дургүйлхэж магадгүй. Гэхдээ Есүсийн хэлсэн өөр нэгэн үгийг үзнэ үү: “Та нар залбиран зогсохдоо хэрэв хэн нэгний эсрэг ямар нэгэн юм чамд байгаа бол уучил. Тэгвэл тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын алдааг уучилна.” (Марк 11:25)

Есүс энд “Тэнгэрийн Аав чинь” гэжээ. Бурхан бол үл итгэгчдийн хувьд Бурхан, харин итгэгчдийн хувьд Аав нь юм. Түүнчлэн нүгэлтнүүд жинхэнэ Бурханд хандан залбирдаггүй. Тиймээс Есүс энд Бурханы хүүхдүүдийн тухай ярьж байгаа нь тодорхой байна.

Цааш нь үзье. “[Харин та нар эс уучилбал тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын алдааг үл уучилна] гэв.” (Марк 11:26) Үүнээс тодорхой байна гэж юу байхав. Эндээс бас гуравдугаар зарчим ургана: уучлахаас татгалзсан хүн төлж баршгүй өрөө төлж дуусгатлаа тамлуулна. Гэхдээ тэр өрийг төлж дуусгах ямар ч боломжгүй юм. Учир нь хэн ч өөрийнхөө сүнсний өрийг төлөөд аварч чадахгүй. (Дуулал 49:7) Есүс “Та нар уучлахгүй бол, Аав чинь та нарын зөрчлийг уучлахгүй” гэсэн. Тиймээс уучлах нь ашигтай байгаа биз дээ?

Гэхдээ би гомдлоо мартаж, уучлахын төлөө зүтгэж байгаа хүний талаар яриагүй шүү. Би Бүрэг шиг уучлахаас зориуд татгалзаж байгаа хүний талаар ярьж байна. Бүрэгийн үл уучлах шийдвэр нь бусад муу ёрын юмст үүд нээж, сүүлдээ тэр Жэйлинийг хаясан. Түүнийг гомдол л сүйрүүлсэн биш үү? Тиймээс л Еврей номын бичээч бидэнд өөрийгөө сайтар нягтлаж, алив хорслыг хая гэжээ. Учир нь үүгээр олон хүн ялзардаг.

Одоо л бид Матай 24:10, 12-13 дээр Есүс эцсийн өдрүүдийн чуулганы талаар ярихдаа, яагаад: “Тэр үед олноороо бүдрэх (гомдох) бөгөөд нэг нэгнээ тушааж, нэг нэгнээ үзэн ядна. ... Ёс бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө. Харин эцсийг хүртэл тэвчсэн нь аврагдах болно” гэж айлдсныг ойлголоо.

Бидний аж төрж байгаа энэ үед хүмүүс ганц хоёроороо юмуу хэсэг бүлгээрээ биш, харин бүр бөөн бөөнөөрөө гомдоно. Бөөн бөөн гэдэг нь өргөн, маш том, хязгааргүй их гэсэн утгатай. Гомдол буюу үл уучлал нь хууль ёсгүй байдал руу хөтлөж, хүмүүсийн хайр бөөн бөөнөөрөө хөрнө.

Энд хайр хэмээн орчуулсан үг нь агапэ гэдэг Грек үг бөгөөд энэ нь хүнийг Христэд итгэж, аврагдах үед зүрхэнд нь дүүрдэг Бурханы хайр юм. Тэр хүмүүс Бурханы хайрыг жинхэнээсээ хүлээж авсан учраас, Есүс зүгээр нэг дүр эсгэсэн, хуурамч хүмүүсийн талаар яриагүй ажээ. Түүнчлэн Есүс "...эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдана" гэсэн нь итгэгч хүмүүст л хандаж өгүүлсэнийг нь илтгэнэ. Хүн хуурамч юмуу нүгэлтэй хүнд "Эцсээ хүртэл тэвчихбэл аврагдана шүү" гэж хэлдэггүй. Учир нь тэд уралдаанд оролцоогүй хүмүүс юм.

Итгэлээ хаях

Өнөөдөр итгэлээ хаях явдал итгэгчдийн дунд ихээхэн газар авна. Паул "Учир нь эхлээд урвалт гарч, сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн илчлэгдэхээс нааш хэн ч та нарыг ямар ч аргаар бүү мэхлэг" (2Тесалоник 2:3) гэжээ. Мөн 1 Тимот 4:1 дээр "Харин хожмын цагт зарим нь итгэлээ орхин, мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн сургаалд анхаарал хандуулна гэж Сүнс тодорхой хэлдэг" гэсэн.

Яагаад? "Цаг нь ирэхэд хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсөдөө цуглуулах бөгөөд чих нь үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно." (2Тимот 4:3-4)

Дээрх ишлэлд Паул хүмүүсийг "итгэлээ хаяна" гэжээ. Тэрбээр хийсвэр итгэлийн тухай бус, харин Есүс Христэд итгэх жинхэнэ итгэлийн тухай ярьж байна. Учир нь жинхэнэ итгэлтэй байсан хүмүүс л итгэлээ хаяж явж чадна биз дээ?

Шинэ гэрээний бараг бүх бичээч "итгэлээ хаяж явах итгэгчдийн" талаар бичсэн байдгийг би хэлсэн. Тэгвэл одоо анхан үеийн чуулганы түүхэн эцгүүд энэ талаар юу бичсэн байдгийг үзэцгээе. Тэдний дунд Шинэ гэрээний элч нартай нөхөрлөж явсан хүмүүс ч бий. Тэдний бичвэрүүд ч Бичээсийн үгтэй яв цав таардаг:

Тиймээс эцэстээ аврагдаж чадахын тулд зөвт байдлаар амьдаръя.
— Ромын Клемент³

Амьдралдаа хамгийн сайн үйл хэргийг хийсэн боловч, эцэстээ

ёрын муу руу хөл алдан гүйсэн хүний урьд туулсан бүх зовлон ямар ч ашиггүй болно. Учир нь жүжгийн оргил хэсэг дээр тэрбээр өөрийнхөө дүрийг бүтээж чадаагүй юм.

— Александрын Клемент⁴

Зарим хүмүүс Бурханыг хамгийн дорд хүнд ч хамаагүй (өгнө гэж амласан) амлалтаа өгөхгүй л бол, байж сууж чаддаггүй юм шиг боддог. Тийнхүү тэд Бурханы эрх чөлөөг боолчлол болгон хувиргадаг... Тиймээс л олон хүмүүс (нигүүлслийг) хаядаггүй гэж үү? Олон хүнээс энэ бэлэг нь авагддаггүй гэж үү?

— Тертуллиан⁵

Хүн шаардлагатай зөвт байдал нь эзэмшиж чадах бөгөөд үүнээсээ ч дайжих боломжтой.

— Ориген⁶

Бурханыг дагадаггүй хүмүүс нь Түүний өв залгамжлалаас таслагдаж, хөвгүүд нь байхаа больдог.

— Иренаус⁷

Үүнийг хараад зарим хүмүүс намайг: “Жон, чи Арминиан юм байна” хэмээн ташаа цоллож байсан ч удаатай. “Арминиан” гэдэг нэр томъёог толь бичигт “урьдаас зурсан хувь төөрөг, урьдаас тогтоогдсон сонголтын талаарх Калвинист доктриныг эсэргүүцэж, хүний эрх чөлөөт хүсэл нь Бурханы бүрэн эрхт байдалтай хослон нийлдэг хэмээн итгэдэг Иакобус Арминиус тэргүүтэй түүний дагалдагч нарын теологиос үүссэн нэр” хэмээн тодорхойлжээ.⁸

Тэгэхээр нь би тэдэнд зүгээр л: “Би Калвинист ч биш, Арминиан ч биш. Би Бурханы хөсөрдөшгүй Үгд итгэдэг Христэд итгэгч” гэж хэлдэг.

Иакобус Арминиус нь Бичээсийн бичээч нараас бүү хэл, дээрх анхан үеийн түүхэн эцгүүдээс ч хожуу үеийн хүн юм. Тиймээс та дээрх бичээчдийг Арминиан гэж дуудаж чадах уу? Мэдээж үгүй. Учир нь эд чинь Арминиусаас бүр эрт амьдарч байсан хүмүүс. Би өөрийнхөө хувийн бодол, ойлголт, итгэл үнэмшлийг бичээгүй, харин Шинэ гэрээнд маш тодорхой хэлсэн үнэнийг бичиж байна. Бурхан ч итгэгч бидэнд Өөрийнхөө анхааруулга үгийг маш тодорхой хэлсэн. Бид хүнийхээ үзэл бодолд баригдалгүй, харин Ариун Сүнсээр хөглөгдсөн Бичээсийн агуулгад нээлттэй байх ёстой. Учир нь:

“Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай. Энэ нь Бурханы хүн чадамгай, аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд” (2Тимот 3:16-17) ажээ.

Есүсийн анхааруулж, хатуу донгодсон хуурамч удирдагч нар нь ихэд боловсон, уран үгээр ярьдаг байсан нь онц сонирхолтой. Гэтэл Иохан баптист, Есүс тэргүүтэй үнэнийг ярьдаг хүмүүс нь “хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй Нэгэний хувьд тэдэнд зааж байжээ.” (Матай 7:29) Ийм учраас Паул Титэд “Чи эдгээрийг бүхий л эрх мэдлээр ярь, ятга, зэмлэ. Хэн ч чамайг бүү басамжлаг” (Тит 2:15) гэсэн юм. Паул Тимотод ч ингэж хэлсэн:

“Ефест үлдээч гэж чамаас гуйсан нь өөр сургаал заахгүй байхыг чи зарим хүмүүст зааварлах.” Паул мөн Тимотод: “Угийг тунхагла. Цагаа олсон ч, олоогүй ч бэлэн бай. Уужим сэтгэлээр, сургаалаар сэнхрүүл зэмлэ, урамшуул” (2Тимот 4:2) гэсэн.

Ефес 6 дээр Паул: “Ярих ёстой шигээ намайг зоригтой тунхаглахын минь төлөө” (Ефес 6:20) гэжээ. Тэгэхээр, энэ нь үнэнийг тунхагладаг Бурханы бүх хүмүүсийн амин чанар гэдгийг та хараа байх. Тэдний эрх мэдэл нь Бурханы Үг болой. Тэд хувийнхаа мэдрэмж, заалгасан эрдэм, олонхийн үзэл бодлын талд орсонгүй. Учир нь олонхи буруу байж болно. Харин Бурхан хэлсэн л бол хэлсэн.

Бүдрэхээс чинь хамгаална

Зарим хүмүүс Бичээст маш тодорхой гардаг, нигүүлслээс салах тухай энэ яриаг сонсоод айдаг. Тэгээд балмагдсаар над дээр ирээд: “Би мөнхийн баталгаатай гэж бодсон шүү дээ” гэдэг.

Тэгэхээр нь би ингэж хариулдаг юм: “Тийм ээ, бид мөнхийн баталгаатай! Есүс: “Надад Аавын өгснийг Би нэгийг нь ч алдахгүй” гэж хэлсэн (Иохан 18:9-ийг үзнэ үү). Учир нь Есүс биднийг хэзээ ч хаяхгүй бас орхихгүй. Гэхдээ бид Есүсийг орхихгүй гэж Тэр хэзээ ч хэлээгүй.” Ингэж хэлэхээр тэр хүмүүс бүр ч том хардаг. Тэгэхээр нь би өөдөөс нь: “Хэрэв та Есүс Христэд үнэхээр л хайртай бол, Түүнээс сална гэж үү? Түүнд үнэхээр л хайртай бол,

хэзээ ч Түүнээс урвахгүй! Энэ чинь л таны мөнхийн баталгаа шүү дээ” гэж хэлдэг.

Та Бурханд хайртай бол, тушаал Үгийг нь дуртайяа биелүүлнэ! Харин Бурханд албатай юм шиг үйлчилж байгаа бол, Бурхантай хуулийн хүрээнд л харилцаж байгаа учраас, Үгийг нь биелүүлэх гэж зүдэрнэ. Бид Бурханыг царайчилсандаа биш, харин Түүнд хайртай учраас үйлчлэх ёстой!

Чуулганд муу нөлөө их байсан ч, Бурханыг хайрлах хайраа яаж шинэ байлгахыг Иуда бидэнд зааж өгчээ: “Мөнх аминд аваачих Эзэн Есүс Христийн маань өршөөлийг хүлээн, Бурханы хайранд өөрсдийгөө сахь.” (Иуда 21) Бид амьдралынхаа өдөр хоног, эгшин бүрт Эзэнийгээ л харах ёстой. “Түүнд ийнхүү найдаж байгаа бүхэн Түүний цэврийн адилаар өөрийгөө цэвэршүүлдэг” (1Иохан 3:3) шиг, Тэр бидэнд Өөрийгөө улам бүр илчлэх болтугай гэсэндээ цаг үргэлж Түүнийг үгүйлэн хайх ёстой юм. Иохан онцгойлон Есүс Христийн илчлэлийн тухай ярьжээ.

Бурхантай, Бурханы Сүнстэй тогтоох нөхөрлөлийг хайсаар байгаа хүн хэзээ ч Есүсээс салахгүй. Айх ч шаарлагагүй. Иуда номын төгсгөлийн хэсэг бол миний хайртай Библийн амлалтын нэг юм. Есүсийг хайж, өөрийгөө Бурханыг хайрлах хайр дотор сахьдаг хүмүүст Иуда:

“Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен” (Иуда 24-25) гэжээ.

Та ч бас ингэх болтугай!

БҮЛЭГ 7

СУУРЬ

Хуй салхи шуурчээ, буруутууд алга болох.

Зөвт нь мөнхийн суурьтай байх.

— Сургаалт үгс 10:25

Аффабелийн түүх рүүгээ эргэж ороод, Өгөөмөр, Аминч хоёрын шүүх, шагналын талаар ярихаасаа өмнө сүүлийн гурван бүлэгт ярьсан зүйлсээ дүгнэж үзье. Дөрөвдүгээр бүлгийн удаах хэсгийг санана уу:

“Тиймээс Христийн тухай балчир ойлголтыг орхиж, төлөвшилд тэмүүлцгээе. Түүнчлэн үхлийн үйлсээсээ гэмших, Бурханд итгэх, баптисмын тухай заавар, гар тавих тухай, үхэгсдээс амилуулагдах болон мөнх шийтгэлийн тухай сургаалуудын суурийг дахин дахин тавихгүй байя. (Еврей 6:1-2)

Мөнхийн шүүлт, шийтгэлийн талаарх үнэний тал дээр бат суурьгүй бол, бид Христ дотор эрүүл саруул амьдрал байгуулж чадахгүй. Яг л уншиж бичих гэх мэт үндсэн чадваргүй байж, боловсролоо дээшлүүлэх гэж оролдохтой л адил юм.

Яагаад тэр вэ? Сайн мэдээг нарийн үзбэл, Есүс тэнгэрийн талаар гэхээсээ илүү тамын талаар ярьсан байдаг. Тэрбээр бидний дотор Бурханаас эмээх суурь байгуулахын тулд ингэжээ. Жишээлбэл:

“Иймд харанхуйд хэлсэн чинь гэрэлд сонсогдоно. Дотор өрөөнд чихэнд шивнэсэн чинь дээвэр дээр зарлагдана. Би та нарт хэлье. Андууд минь, махбодыг хөнөөгчдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. Харин хэнээс айж эмээвэл зохихыг та нарт

сануулъя. Хөнөөсний дараа тамд хаях эрх мэдэлтэй Нэгэнээс эмээгтүн. Тийм ээ, Би та нарт хэлье, Түүнээс эмээгтүн.”
(Лук 12:3-5)

“Мөнхийн шүүлт, шийтгэлийн талаарх зөв ойлголтыг олж, хадгалах нь бидний зүрхэнд Эзэнээс эмээх сэтгэлийг баттай суулгадгийг” маш хүчтэй, тодорхой хэлж байна.

Одоо тайлбарлаж өгье. Там руу илгээх мөнхийн ялыг гагцхүү Бурхан л гаргаж чадна. Бидний далдуур ярьсан зүйлс ч шүүхийн өмнө Түүний алдрын гэрэлд ил гарна. Бидний үгс төдийгүй, сэдэл, хандлага, үйлдэл, үйлс ч ил болно. Тиймээс Эзэнээс эмээхүй нь бидэнд Түүнээс нуугдах юм ширхэг ч үгүй гэдгийг байнга сануулдаг. Түүний шударга шүүхээс юу ч зугтахгүй. Үүнийг ойлгоогүй хүн “Бурхан хууль ёсгүй явдлыг хардаггүй, харсан ч тоодоггүй” гэдэг хуурамч итгэл үнэмшилд хууртагдаж, огт байдаггүй Бичээсийн бус өршөөлд найдан тайвширдаг (яг л Мэхлэгдэгч, Бүрэг, Дүр эсгэгч нар шиг). Бид тэр даруй сүүлчийн өдрүүдэд Бурханд тууштай зориулсан амьдралаасаа ухарч, хууль ёсгүй байдал руу гулсаж орох үй олон хүний нэг болно.

Ийм суурьгүй хүн хүнээс амархан айж, айсан нэгэндээ үйлчилдэг. Бурханаас айдаг хүн ямар ч дарамт зовлон дунд Бурханаа л дагадаг бол, хүнээс айдаг хүн ялангуяа дарамт дор хүнд бууж өгөөд таашаал, махан биеийн хүсэл, бардамналыг маань цатгадаг юмс руу эргэдэг. Тиймээс мөнхийн шүүх, шийтгэлийн талаар ойлгохгүй бол, Эзэнээс эмээх сэтгэлээр дутах нь гарцаагүй. Учир нь Христийн шүүхээс айх ариун эмээхүй нь Эзэнээс эмээж явахын нэг шалтгаан мөнөөс мөн юм. Паул:

“Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. Иймээс бид Эзэнээс эмээхүйг мэдэж, хүмүүсийг ятгадаг. Бид Бурханд ил болсон. Мөн та нарын мөс чанарын дотор ч бид ил болсон гэж би найддаг”
(2Коринт 5:10-11) гэжээ.

Паул итгэдэггүй хүмүүст тамын ял унших (Есүсийн Лук 12-р бүлэгт ярьсан) Аугаа их цагаан сэнтийн шүүхийн талаар биш, харин итгэгчдийн шүүхийн талаар ярьсан. Бид энэ шүүхийн

талаар дараагийн бүлэгт ярих боловч, Паул Христийн шүүх сэнтийг Эзэнээс эмээхүйтэй тэгшитгэсэн байгааг анхаарна уу. Үнэндээ дээрх ишлэлд Паул шүүх сэнтийг “Эзэнээс эмээхүй” гэж нэрлэсэн байна. Тэгэхээр, Эзэнээс эмээхүй, Эзэний шүүх хоёр нь салшгүй ойлголт бөгөөд эрүүл амьдралын түлхүүр юм.

Зөнч Исаиа ингэж хэлжээ: “Тэр чиний цаг хугацааны бат суурь бөгөөд Мэргэн ухаан, мэдлэг ба авралын баялаг мөн. ЭЗЭНЭЭС эмээхүй нь түүний эрдэнийн сан билээ.” (Исаиа 33:6)

Ариун эмээхүй нь Бурханы баттай суурийг байгуулах гол түлхүүр юм. Есүс Өөрийнх нь нэрээр гайхамшиг үйлдсэн үй олон хүмүүсийг няцааж, мөнхийн шийтгэл рүү илгээх тухайгаа ярьсан. Тиймээс Матай 7 дээр Есүс тэдний уналтын талаар үргэлжлүүлэн ярьсанд гайхах явдалгүй. Тэр хүмүүс шуургыг тэсч гарахгүй сэтгэлгээ, итгэл үнэмшил дээр амьдралаа байгуулжээ. Есүс:

“Тиймд эдгээр үгсийг минь сонсоод үүний дагуу үйлдэгч бүр хадан дээр байшингаа барьсан ухаалаг эртэй зүйрлэгдэнэ. Бороо асгаж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу эс үйлддэг нь элсэн дээр байшингаа барьсан мунхаг эртэй зүйрлэгдэнэ. Бороо асгаж, үер буун салхи салхилж, байшинг нүдсэнд тэр нь нурав. Эвдрэл нь асар их байлаа” (Матай 7:24-27) гэдэг.

Эцсээ хүртэл тэвчсэн нь бат суурийнхаа ачаар л шуургыг давжээ. Эзэнээс эмээхүй нь биднийг тогтоож барьдаг суурь, Бурханы баялгийн сан хөмрөг юм. Түүний аврал, цэц ухаан, мэдлэг нь бүгд Эзэнээс эмээхүйд л бий.

Эзэнээс эмээхүй

Эзэнээс эмээхүй гэж юу вэ? Бурханаас ухаан алдтал айх явдал уу? Тэгвэл Бурханаас ингэтэл айж байгаа хүн Түүнтэй яаж дотносож чадах билээ? Бурхан Өөрийгөө Израильд илчлэхээр ирэхдээ, тэдэнтэй яг л Мосетэй нөхөрлөдөг шигээ нөхөрлөхийг хүссэн боловч, Израиль Түүнээс зугтаж, ойртохыг ч хүсээгүй. Тэгэхэд нь Мосе хүмүүст: “Бүү ай. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл

бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм” (Гэтлэл 20:20) гэсэн буй.

Мосегийн үг нь хоорондоо авцалдахгүй мэт харагддаг ч, үгүй юм. Мосе Бурханаас айх ба Бурханаас эмээхийн ялгааг тодорхой харуулжээ. Нуух юмтай хүмүүс л Бурханаас айдаг. Эдэн цэцэрлэгт Бурханы үгийг зөрчсөн Адам яалаа? Адам Эзэний оршихуйгаас нуугдсан. Нөгөөтэйгүүр Эзэнээс эмээдэг хүн нь Эзэнээс холдож, Эзэнд дуулгаваргүй авирлахаас айж явдаг хүн юм. Тэгэхээр ариун эмээхүйг хамгийн энгийнээр Бурханаас холдохоос айх явдал гэж хэлж болно.

Цаашаа явцгаая. Эзэнээс эмээх гэдэг нь Түүнийг хэнээс ч, юунаас ч дээгүүр өргөмжилж, үнэлэж, цэнэж, хүндэтгэж, дээдлэхийг хэлнэ. Түүний хайрладгийг хайрлаж, Түүний үзэн яддагийг үзэн ядна. Эзэнээс эмээдэг хүн Түүнд Үгд чичирч, ойлгохгүй, зовиуртай, ашиггүй харагдаж байсан ч, тэр даруй бүрэн гүйцэд даган биелүүлдэг. Тиймээс Эзэнээс эмээхүйн нотолгоо нь Түүний Үг, арга зам, тушаалыг дуулгавартай дагах явдал юм.

Бичээс Эзэнээс эмээхүй нь цэц ухааны эхлэл гэдэг. Өөрөөр хэлбэл цэц ухааны суурь юм. Цэц ухаан нь зөв цагт зөв сонголт хийх чадвар бөгөөд бид энэ талаар илүү дэлгэрүүлж ярина. Дарамт дор буруу сонголт хийж байгаа хүмүүс нь цэц ухааны хомсдолтой хүмүүс агаад цэц ухааны эх үүсвэр нь Эзэнээс эмээхүй юм.

Бичээс бидний амьдралыг байшин барихтай зүйрлэдэг.

Эхлээд суурийг нь тавина, дараа нь бүтцийг нь босгоно. Сургаалт үгс 24:3 дээр “Орон гэрийг цэц ухаанаар босгоно” гэдэг. Хэрэв бид амьдралаа зөв сонголт хийх чадвараар барьж байвал, Шүүх сэнтийн өмнө итгэлтэй зогсож чадахуйц эрүүл амьдралыг байгуулна. Энэ цэц ухааны эхлэл буюу суурь нь Эзэнээс эмээхүй юм.

Салахаас сэргийлнэ

Христэд итгэгч хүмүүс Эзэнээс үнэхээр эмээдэг бол, итгэлээсээ хэзээ ч няцахгүй. Тийм хүмүүс Есүст зориулагдах бүрэн зориулалтаасаа хэзээ ч салахгүй, холдохгүй, Бурханы Үгд ч тоомжиргүй хандахгүй бас итгэгчдийн зүрхийг хатууруулж, адагтаа хөл алдуулдаг нүгэлд ч дурлахгүй. (Еврей 3:12-13) Учир нь тэрбээр нууцаар үйлдэж, ярьсан бүхэн Шүүх сэнтийн өмнө нийтэд ил болно гэдгийг мэднэ.

Шинэ гэрээний хүмүүсийн талаар Иеремиа 32:38-40 дээр Бурхан юу айлдсныг үзнэ үү:

“Тэд Миний ард түмэн, Би тэдний Бурхан болно. Тэд сайныхаа төлөө болон өөрсдийн дараах үр хүүхдүүдийнхээ төлөө Надаас үргэлж эмээхийн тулд Би тэдэнд нэг зүрх, нэг замыг өгнө. Тэдэнд сайныг үйлдэн тэднээс эргэхгүй гэж Би тэдэнтэй үүрдийн гэрээ байгуулна. Тэд Надаас эргэхгүйн тулд Би тэдний зүрхэнд Надаас эмээхүйг хийнэ.” (Иеремиа 32:38-40)

Бурхан Өөрийнхөө хүмүүсийн талаар: “Тэд Надаас эргэхгүйн тулд Би тэдний зүрхэнд Надаас эмээхүйг хийнэ” гэж хэлжээ. Малайзд болсон нэгэн цуглаан дээр Эзэнээс эмээхүйн Сүнс маш хүчтэй буусныг санаж байна. Танхим Библийн сургуулийн оюутнууд, пасторууд зэрэг Зүүн аймгуудаас ирсэн хүмүүсээр пиг дүүрсэн байлаа. Цуглааны төгсгөлд хүмүүс тайзны эргэн тойронд бөөн бөөнөөрөө зогсолтгүйгээр уйлж, газар тэрийн хэвтэж байв.

Эзэний аймшиг агаар мандалд ноёлж, надад яг л Жон Бивэр чи ганц буруу хөдлөж, ганц буруу үг хэлэх л юм бол, дуусаа шүү гэх шиг л санагдаж байлаа. Би дуусах байсан эсэхээ мэдэхгүй л дээ. Гэхдээ Шинэ гэрээнд яг тэгж үхсэн эрэгтэй, эмэгтэй хоёрыг би мэднэ. Тэдний шийтгэлийн үр дүнд “Чуулган даяар, энэ бүхнийг сонссон бүгд дээр үлэмжийн айдас ноёлов” (Үйлс 5:11) гэдэг.

Малайзын тэр уулзалтын дараа Энэтхэгийн нэгэн хос надтай уулзаад: “Жон, бид хоёр одоо дотроо цэв цэвэрхэн болчихсон юм шиг л санагдаж байна” гэсэн юм.

Тэгэхээр нь би тэдэнд: “Би ч бас” гэж хариулж билээ.

Маргааш өглөө нь би зочид буудлынхаа өрөөнд байж байхдаа: “ЭЗЭНээс эмээхүй нь цэвэр, Мөнхөд оршдог” (Үйлс 19:9) гэсэн ишлэлийг уншив.

Гэтэл Ариун Сүнс надтай яриад: “Люсифер тэнгэрт тэргүүн магтаалч байсан. Тэр тослогдсон, гоо үзэсгэлэнтэй, ерөөгдсөн нэгэн байсан. Гэхдээ тэр Надаас эмээгээгүй тул мөнхөд оршоогүй” хэмээн айлдсан юм.

Би энэ талаар бодож байтал “Миний сэнтийг хүрээлэн, Миний алдрыг харсан тэнгэрэлч нарын гуравны нэг нь Надаас эмээгээгүй тул мөнхөд оршоогүй” гэхийг сонсов.

Би Бурханы энэ илчлэлийг сонсоод зог тусав. Тэгтэл дахиад

л: “Адам, Ева хоёр Миний алдрын оршихуй дотор алхаж байсан. Тэд Надтай нөхөрлөж байсан ч, Надаас эмээгээгүй тул Миний оршихуйд мөнхөд оршоогүй” гэж хэлэх нь сонсогдсон юм.

Эзэнээс эмээхүй нь бидэнд бат зогсох хүчийг өгч, Бурханы Үгийг цаг үргэлж сахихад тусладаг. Бурханы Үг бидэнд “Ингэхээр Түүний амралтад орох амлалт байгаа учраас та нараас хэн нэгэн нь өөрийгөө түүнд хүрсэнгүй гэж санах вий гэдгээс эмээцгээе” (Еврей 4:1) хэмээн анхааруулжээ. Хайрлацгаая биш, харин эмээцгээе гэсэн нь сонин байгаа биз? Бурханаас эмээхүй л биднийг нүгэл рүү эргэж гулсахаас сэргийлдэг.

Алдартай Сайн мэдээ тараагч

Би шоронд таван жилийнхээ ялын сүүлийн жилийг эдлэж байгаа нэгэн алдартай сайн мэдээ тараагч дээр очиж уулзснаа хэзээ ч мартаггүй. Түүний хэрэг дэлхий даяар мандаж, үүнээс болж хаанчлалын нэр хүнд ч ихээр унасан юм. Гэхдээ шоронд орсон эхний жилдээ тэр хүн Эзэнтэй жинхэнээсээ уулзжээ. Намайг тэр шоронд дөрвөн жилийн дараа дахин ирэхэд, тэр хүн шууд л надад: “Жон, энэ шорон Бурханы надад оноосон шийтгэл биш, өршөөл байж. Би тэр чигээрээ амьдраад л байсан бол, мөнхийн тамд л орж дуусах байсан” гэж хэлсэн юм.

Би мэл гайхав. Тэгээд миний өмнө Бурханы дарууссан хүн, Христийн жинхэнэ зарц байгааг мэдлээ. Тэрбээр олон жилийн өмнө Есүсийг хайрлах халуун хайраар үйлчлэлээ эхлүүлж байсныг би мэднэ. Түүний гал халуун сэтгэл хэнд ч илт байсан. Гэхдээ үйлчлэлийнхээ ид оргил үе дээр яаж яваад Эзэнээс холдчихсныг нь би гайхширч байсан учраас: “Та яаж яваад Есүст хайргүй болчихсон юм бэ?” гэж асуусан юм.

Гэтэл тэрбээр над руу харснаа, шууд л: “Би Есүст хайргүй болоогүй!” гэж хэлэх нь тэр.

Би бүр ч их гайхширч: “Тэгвэл өнгөрсөн долоон жилийн турш таны үйлдсэн хуурамч захидал, завхайрал - шоронд ороход хүргэсэн энэ бүх хэргийн хувьд?” гэтэл, тэр хүн:

“Жон минь, би Есүст дандаа хайртай байсан. Гэхдээ би Бурханаас эмээдэггүй байсан юм. Би Түүнийг амьдралынхаа дээдийн дээд эрх мэдэл болгоогүй байсан” гэж хэлээд, дараа

нь намайг зог тусгасан нэгэн үг хэлсэн юм: “Жон, өнөөдөр Америкийн сая сая итгэгчид яг л над шиг амьдарч байна. Тэд Есүсийг Аврагчаараа дуудаж, Түүнийг хайрладаг ч, Түүнээс дээдийн дээд Эзэнийх нь хувьд огт эмээдэггүй!”

Намайг нэг хурц гэрэл сүлбээд авах шиг л болов. Яг тэр эгшинд би Есүсийг хайрласан ч, Түүнээс салж болдог юм байна гэдгийг ухаарсан юм. Хайрлахаас гадна Бурханаас эмээх ёстой ажээ. Мосегийн үгийг л сана: “Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм.” (Гэтлэл 20:20) Эзэнээс эмээхүй л биднийг Люсифер, тэнгэрэлч нарын гуравны нэг, Адам шиг Бурханаас салалгүй, дуулгавартай үлдэх хүч болдог ажээ.

Авралаа гүйцэлдүүл

Энэ шалтгаанаар Паул “та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр (өөртөө эрдэлгүй, тун болгоомжтойгоор, ухаан мэдрэмжээ чагнаж, өдөөлтөөс гярхайгаар сэргийлэн булгаж, Бурханыг гомдоож, Христийн нэрийг доромжлох алив бүхнээс мэдрэгээр шарван), гүйцээ (зорилгоо сахин, хөгжүүлж, бүрэн гүйцээ)” (Филиппой 2:12) гэжээ. Бид авралаа айдас бас чичрэлээр сахин гүйцээх ёстой. Ингэж байж л бид шүүхийн өмнө бодол, үг, үйлс бүр маань ил болно гэдгийг цаг үргэлж санаж сэргэж явна. Ийм ухамсартай хүн даруу, сэрэмжтэй, эрүүл ухаантай, мэдрэг байж, Бурханыг үл дагах өдөөлтөд сэргэг байн, Бурханд таагүй бүхнээс цаг үргэлж зайлсхийж явна.

Паул биднийг хайр, эелдэг зангаар авралаа гүйцэлдүүл гэж хэлээгүй байгаа биз? Эзэнээс эмээхүй нь биднийг Эзэний нигүүлслээс салж, хууль ёсгүй амьдрал руу уруудахаас сэргийлдэг бол, Бурханы хайр нь биднийг Бурхантай тогтоох дотно харилцаанаас маань салгадаг хуульчлалаас сэргийлдэг юм. Түүнчлэн Бурханыг хайрлах хайр маань бидний санаа, сэдлийг дүүрэн, халуун, тунгалаг хэвээр байлгадаг. Бид Бурхантай эрүүл харилцаа тогтоохын тулд Бурханыг хайрлах ч ёстой, Бурханаас эмээх ч ёстой. Тиймээс л Паул Бурханыг бидний тэнгэрлэг Аав бас залгигч гал гэжээ (Еврей 12:29).

Бурхан бол хайр. Гэхдээ бас шударга бөгөөд ариун Шүүгч. Түүнээс эмээдэггүй хүн тэсч үлдэхгүй. “Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдана” (Матай 10:22) гэдгийг Есүс хэлсэн.

Бидний нөлөө

Түүнчлэн мөнхийн шүүлт, шийтгэлийн талаар бат ойлголттой явах ёстойн өөр нэг шалтгаан нь бусдад үзүүлэх нөлөө юм. Бид Эзэнээс эмээхгүй бол, үг юмуу үйлдлээрээ тэнцвэргүй Сайн мэдээг хүмүүст түгээж эхлэнэ. Харин энэ нь бидний нэр нөлөөн дор байгаа хүмүүсийг няцахад - магадгүй бүр мөнхөд алдагдахад хүргэдэг.

Ийм суурь доктрингүй Сайн мэдээний багш нар, пасторууд нь Бичээсийн ерөөгдөж, баяжиж, аз жаргалтай амьдрах зарчмуудыг л баруун солгойгүй цацаад байдаг. Мэдээж эдгээр зарчим нь үнэн учраас үнэхээр хэрэгжиж, эрүүл мэнд, санхүү, харилцааны амжилт, амар тайвныг бүтээдэг. Гэхдээ мөнх шүүлтийн талаарх суурь ойлголт байхгүй бол, бид загалмайг бас Есүсийг дагахын төлөөсийг номлохоос зайлсхийж, амь биеэ алдсан ч хамаагүй - загалмайн өмнө амьдралаа өргөх дуудлагын оронд зүгээр л амь биеэ бөөцийлсэн Сайн мэдээг л номлох болно.

Хэрэв бид өнө мөнхөөр хөтлөгдөхгүй бол, амьдралыг өнө мөнхийн хараагаар харалгүй, энэ амьдралдаа л ашиг хонжоо олохын төлөө амь биеэ зориулах болно. Бид хүмүүст итгэлийн өвөг шигээ “суурь бүхий хотыг хүлээж байсан юм. Түүнийг бүтээгч ба барилгачин нь Бурхан мөн” (Еврей 11:10) гэж заахын оронд, өнөөдрөөрөө л амьдрахыг заана.


Гэхдээ бүү зовоорой. Бурханы зарчмыг дагасныхаа төлөө та энэ амьдралдаа ч шагнуулна. Энэ амьдралдаа шагнуулна гэдэг нь худал сургаал биш. Гэхдээ бид энэ дэлхийд түр оршин сууж байгааг бүү мартаарай. Бид энэ дэлхийд амжилтанд хүрэх ёстой ч, нийгэм соёлынхоо биш, тэнгэрийн жишгээр хэмжигдэх амжилтанд л хүрэх ёстой юм. Дэлхий бидний жинхэнэ гэр биш.

Бурханыг дагахын төлөө энэ дэлхийгээс татгалзсан ариун хүмүүсийн сэдлийг харна уу:

“Тэд бүгд амлалтуудыг авалгүйгээр, харин холоос тэдгээрийг харж, батлан хэлж, өөрсдийгөө дэлхийд гаднынхан ба түр

суурьшигчид гэдгийг хүлээн зөвшөөрч итгэл дотроо нас барсан билээ. Учир нь тийн ярьдаг нь эх нутаг хайж буйгаа тодорхой харуулдаг. Үнэндээ, тэд гарч явсан нутгаа санаж байсан бол тэдэнд буцах боломж байх байсан. Харин тэд үлэмж дээр нутгийг хүсэж байв. Тэр бол тэнгэрлэг орон мөн. Тиймээс Бурхан тэдний Бурхан гэж нэрлэгдэхдээ ичээгүй юм. Учир нь Тэр тэдэнд хот бэлджээ.” (Еврей 11:13-16)

Эдгээр ариун хүмүүсийн эрэн хайж байсан гэр нь Бурханы хот - шинэ Иерусалим байсан бөгөөд бид ч энэ талаар номоо дуусан дуустал ярина. Энэ хотод амьдрах ёстой хүмүүсийг ялагчид гэнэ. Тэд энэ дэлхийн шилдгээс ч илүү шилдэг зүйлээр шагнуулах нь гарцаагүй.



ГУРАВДУГААР ХЭСЭГ: БҮЛЭГ 6-7

1. Та Христийг дагахын аль нэг ашгийг Есүстэй Өөртэй нь тогтоох дотно харилцаанаас дээр тавьдаг уу? Тэгвэл, яавал үүнээсээ больж, яг зөв зүйл дээр хараагаа хандуулах вэ?

2. “Итгэгч хүн итгэлээ хаяж явж болдог” гэхээр танд аймаар санагдаж байна уу? Энэ нь таны итгэж явсан зүйлтэй зөрчилдөж байна уу? “Итгэгчид бид Эзэнээс айх биш, харин эмээж явах ёстой” гэдэг үнэнийг баримтлан хариулна уу.

3. Матай 18:23-35 дээрх өршөөлгүй зарцын түүхийг эргэцүүлэн бодно уу. Таны бодлоор Бурхан яагаад үл уучлалд ийм ноцтой ханддаг вэ?

4. Ариун эмээхүй үгүй бол, Бурханы өршөөлийн талаарх ойлголт гажуудаж, итгэгч хүн мэхлэлд хүрч болдгийг өөрийнхөө үгээр тайлбарлана уу.

5. Өнө мөнхийн амьдралын талаарх бидний ойлголт өөрт маань төдийгүй, өрөөлд ч нөлөөлдөг. Хамгийн чухлыг нь гээчихээд, Бурханыг дагах нь эрүүл мэнд, амжилт, бүтээмж зэрэг өч төчнөөн ашигтай хэмээн энэ дэлхий дээрх ашиг тусыг тоочоод байх нь аль хэр зөв бэ?



ᠠ-ᠮ ᠬᠡᠴᠡᠭ

АФФАБЕЛ ХЭМЭЭХ ХААНТ УЛС: ШҮҮХ ӨДӨР II

*Оюун санаа хийгээд зүрхийг Нягтлагч нь Би байгаа юм гэдгийг
бүх чуулган мэдэх болно. Би та нарын хүн бүрд
үйлсийнх нь дагуу хариу өгнө.*

— Илчлэл 2:23

Тэгэхээр, Аффабелийн түүхээ үргэлжлүүлж, Аминч, Өгөөмөр хоёрын хувь тавилан хэрхсэнийг үзэцгээе. Бид тэдний амьдралаас итгэгчдийн шүүхээр итгэгчид эн тэнцүү шагнуулахгүй зэрэг олон чухал үнэнийг сурна.

Итгэгчдийн шүүх

Энделчүүдийг өглөөгүүр Аугаа их танхимд орж ирмэгц л шүүх эхлэв. Амийн танхимд 500 гаруй Энделчүүд Жэйлин хаантайгаа учрахаар тэсэн ядан хүлээнэ. Өгөөмөр, Аминч хоёр ч шинэ, хуучин нөхөдтэйгээ уулзалдан ярилцаж байтал, Хааны харуулууд танхимд орж ирэв. Бүгд нам болон, чих тавьцгаав.

“Та нар удахгүй хаантайгаа уулзана. Тэр та нарыг үргэлж хайрлаж, та нартай учран золгох энэ өдрийг тэсэн ядан хүлээсэн буюу. Та нар Түүнийг хараагүй ч, Тэр та нарыг харсаар ирсэн. Тэр та нарын зүрхийг нягтлаж, үр жимсийг чинь ялган харсан. Тэр та нарын зүрхийг, сэдлийг, бодлыг, мэдрэмжийг бас үйлсийг мэднэ. Түүнээс нуугдах юм нэг ч үгүй. Түүний шүүх шударга. Үл тоогдож, ташаа ойлгогдох зүйл нэг ч гарахгүй.”

Хааны харуул тэдэнд Аугаа их танхим руу хэрхэн нэвтрэх талаар бас зайлшгүй бөглөх ёстой протоколын талаар зааварчилгаа өгөв. Үүний

дараа тэрбээр: “Хаан Жэйлиний өмнө хамгийн түрүүнд очих хүн бол Аминч. Нааш ирээд, Аугаа их танхим руу дагалдан явна уу” гэлээ.

Аминч шүүгдсэн нь

Аминч өөрийгөө Эндел хотын дарга байсандаа хамгийн түрүүнд орлоо гэж бодов. Тэрбээр захирагч байсныхаа төлөө хааны гадаад ертөнцөд гайгүй сайн шагнуулна гэдэгтээ ч итгэл дүүрэн явлаа. Тэрбээр Энделд итгэмжтэй байсан хүмүүсийг Аффабелд шагнаж, захирагч болгох талаар заасныг санажээ. Тэр хоёр жил хотын дарга хийхдээ нийгмээ хөгжүүлэн цэцэглүүлсэн байлаа. Тиймээс ч хаантайгаа уулзахаар маадгар алхаж явав.

Аугаа их танхимын хаалга нээгдэж, Аминчийг хааны оршихуйд нэвтрүүлэв. Аминч тэр нүсэр, жавхлантай танхимыг үзээд уушги зүрх нь савлаж байв. Энд тэндгүй танхим дүүрэн хүн. Аминч энд тэнд байгаа хоосон суудлыг гайхсан боловч, иргэд нь хамаагүй суусных байх хэмээн дүгнэжээ.

Тээр тэнд Жэйлиний сэнтий үзэгдэнэ. Аминчийн төсөөлөн бодож байснаас ч сүр жавхлантай ажээ. Түүнчлэн арай бага сэнтийнүүдийг нь ч Жэйлиний дэд захирагч нарынх байна хэмээн Аминч яг зөв таав. Гэтэл хэд хэдэн сэнтий хоосон байгааг үзээд, нэг нь өөрийнх нь байх хэмээн учир зүггүй догдлох нь тэр.


Эртний танил

Аминч Энделийн хуучин иргэд нь ямар сүр жавхлантай болж хувирсныг үзээд, хэлэх үггүй, дэмий л биширсээр урагш явлаа. Ийнхүү сэнтий рүү хэд алхсанаа гэнэт танхимын ард зогсох эртний нэгэн танилаа олж үзэв. Түүнийг Нийтэч гэнэ. Түүний ресторанд Аминч байнга зочилдог байжээ. Аминч Нийтэчтэй уулзах зөвшөөрөл авахаар харуул руу хартал тэр ч толгой дохив.

Аминч, Нийтэчийг тэвэрч аваад: “За сайн уу анд минь?” гэж мэнд усыг нь асуулаа.

Нийтэч ч: “Тун сайн. Гэхдээ миний нэр одоо Нийтэч биш, Хангалуун болсон. Эзэн Жэйлин сэнтийнхээ өмнө ирсэн бүх зарцдаа шинэ нэр хайрладаг” гэж хариулаад:

“Аффабел миний төсөөлж явснаас хол үзэсгэлэнтэй. Энэ Аугаа



их танхим бол энэ хотын үзэсгэлэн, сүр жавхлан, гайхамшиг руу нэвтрэх үүд юм. Хаан маань ч хэн хэнээс илүү дотно, хайрын, яруу алдарт нэгэн. Түүнийг мэдэж, Түүнд үйлчлэх нь миний хамгийн том талархал. Түүний хаанчлалд байх нь юутай ч эгнэшгүй, их хүндэтгэл шүү. Би энэ бүхнийг Энделд байхдаа мэдсэн сэн бол, өөрөөр амьдрах байсан. Хаандаа таалагдахыг хичээж амьдрах байсан. Эндел дэхь ахархан амьдралдаа илүү сайн иргэн байх байсан. Тэгсэн бол, өдийд Эзэнтэйгээ ойрхон амьдрахгүй юу” хэмээн өгүүлэв.

Аминч: “Ойлгосонгүй? Чи чинь Энделийн шилдэг иргэн байсан шүү дээ! Манайхны хамгийн нэртэй рестораныг чи л ажиллуулж, нийгмийн ажилд өгөөмрөөр өгдөг байсан. Янз бүрийн сайн санааны үйлсэд байнга л мөнгөөр бас үнэгүй хоолоор туслаж, тэр байтугай байр саваа ч зориулсан!” гэлээ.

Хангалуун толгой сэгсрээд: “Би тэр бүгдийг чинь бусдад таалагдах гэж л хийдэг байжээ. Түүнчлэн энэ нь илүү олон үйлчлүүлэгчийг татна гэж бодсон. Бусдыг ерөөх гэж биш, өөрөө л баяжих гэж тэр. Би Жэйлиний үгийг сонсох ёстой байсан. Тэр бидэнд “найр хийхдээ ядуусыг, зүдүүсийг, шоовдрыг, нүдгүйг урь. Тэд чиний ачийг хариулж чадахгүй учраас тэр цагт л чи жинхэнээсээ ерөөгдөнө. Учир нь зөвт хүмүүс амилуулагдах үед энэ бүхний чинь төлөө чамд буцааж төлнө”¹ гэж хэлсэн. Гэтэл би тэр хоолыг нийгмийнхээ сайны төлөө биш, өөрийнхөө ашгийн төлөө л хандивласан. Би Энделийн нэр нөлөөтэй хүмүүсийн нэг болохыг л хүссэн” гэж яриу.

Аминч бүр ч шохоорхон: “Тэгвэл Энделийн сургуулийн төлөө оруулсан тэр их хандив чинь? Жэйлин үүнийг чинь үнэлээгүй гэж үү?” гэсэнд,

Хангалуун: “Хандивласан хандивласан. Гэхдээ бизнесийнхээ ашгаас дүйцсэн хувийг биш, харин багахаан хувийг л! Би дампуурахаас айдаг байсан болохоороо хамаг мөнгөө хурааж дардаг байсан юм. Дээрээс нь сайхан амьдрах хүсэлдээ автаад... Үнэндээ би өөрийгөө л хамгаалахыг хичээсэн. Хүн чанартаа зулгаалгасандаа л жаахан өгдөг байлаа. Багш нар маань байнга л “хаанчлалын төлөө, дутагдаж гачигдсан хүмүүст өгөхийг” хэлдэг байсан учраас, араа бодсондоо л өгсөн гэх үү? Хайрлаж өрөвдсөндөө биш, харин сэтгэл дэхь зэм, дарамтаас мултрах гэж л өгдөг байжээ.

Би бас Жэйлиний өгүүлдэг, Аффабелд хайртай байсан бэлбэсэн авгайн түүхийг ч санаагүй. Санаж байна уу, Жэйлин

бидэнд бусдаас хавьгүй ихийг өргөсөн ядуу бэлбэсэн авгайн тухай ярьсныг? Учир нь бусад нь илүү гарснаа өгсөн бол, ядуу авгай өөрт байгаагаа л өгсөн”² гэв.

Аминч гэртээ зохион байгуулсан нөгөө олон үдэшлэг, зоогоо саналаа. Тэнд ширхэг ч ядарсан зүдэрсэн хүн байгаагаагүй. Тэгээд газрыг Энделийн сургуульд биш, их дэлгүүрт өгсөн шийдвэрт нь эгдүүцсэн олныг намжаах гэж 5000 итгэмжлэл өгсөн явдлаа ч бодлоо. Тухайн үедээ маш ихийг өгчихлөө гэж санасан ч, одоо бодоход тийм жаахныг өгсөндөө нүүр нь улайв. Жэйлин үүнийг юу гэж үнэлэх бол?


Ийнхүү элдвийг эргэцүүлж байтал “Би Жэйлинийг болон хүмүүсийг бодсон бол, цаг заваа зориулж, сургуульдаа үйлчлэх л байсан. Хүн бүр өөрийнхөө үүргийг хийсэн бол, хэдхэн хүний нуруун дээр байсан тэр их ачаа хавьгүй хөнгөрөх байсан даа. Жэйлиний загвар хэрэгжсэн бол, хэн ч илүү ачаа үүрэхгүй байсан. Хүнд ачаа үүрч байсан хүмүүс өндөр шагнал авсан л даа. Гэтэл би Жэйлиний хаанчлалын ажилд оролцохоос тээр шаасандаа л жаахан мөнгө өгч өөрийгөө тайвшруулдаг байсан юм.

Тэгээд миний амьдралыг шүүхэд, би өөрийнхөө тав тух, нэр төр, аюулгүй байдлын төлөө амьдарснаас биш, Жэйлиний төлөө амьдраагүй нь бүгдэд ил болсон. Ийнхүү одоо би Аффабелийн хамгийн дорд иргэдийн нэг болсон. Гэхдээ л Түүний сайн сайхан, намайг гэх хайранд нь талархаад баршгүй. Би энэ бүхнийг хүртэх зохисгүй хүн. Түүний хайр, энэрэлд хязгаар байхгүйг чи удахгүй өөрөө мэднэ ээ. Би Жэйлиний хайр энэрэлд насаараа өртэй хүн” гэсэн Хангалууны яриа бодлыг нь тасалдуулав.

Үүнийг дуулаад Аминч ч: “Хамгийн дорд иргээн? Энд анги давхаргын систем байдаг байх нь ээ?” хэмээн дуу алдлаа.

Гэтэл Хангалуун өөдөс нь инээмсэглээд: “Тийм ээ, нэг тиймэрхүү. Уг нь энэ талаар Энделд байхад минь заадаг л байсан. Бид л нухацтай хандаагүй болохоос. Гэхдээ сэтгэлийнхээ гүнд бол мэдэж л байсан. Үнэндээ чамайг танхимд орж ирмэгц би чиний бодлыг сонссон. Чи аль нэг сэнтийд санаархаа биз дээ? Хэдийгээр чи Энделд энэ тухайгаа ил гаргаж хэлдэггүй байсан ч, энэ талаарх эртний бичээсийг чи мэдэж л байгаа.

Эндел дэхь богинохон амьдралдаа Жэйлинд итгэмжтэй байсан хүмүүс нь одоо эндхийн нэртэй, мундаг удирдагч, иргэд болсон. Тэд хотын хамгийн сайхан хэсэгт аж төрж, хаантай ойр дотно



харилцдаг. Харин Энделд өөрийнхөө төлөө амьдарсан хүмүүс нь хотын захаар аж төрнө. Энэ ялгааг энэ танхимаас ч харж болно. Танхимын араар байгаа хүмүүс нь тал газар амьдардаг хүмүүс. Тэд хамгийн хүнд хүчир, хар бор ажил хийнэ. Тэд хаанчлалын хамгийн өчүүхэн нь юм. Дунд хавиар байгаа хүмүүс нь уулархаг газраар амьдарч, арай бүтээлч байр сууринд байдаг бол, урдуур байгаа хүмүүс хааны харштай зэрэгцэн аж төрж, хаантай хамтарч ажилладаг, хаанчлалын хамгийн аугаа хүмүүс.

Аминч анд минь, Жэйлин бол хайрлахыг мэддэг хэр нь шударга удирдагч шүү. Түүний өгсөн бүхэн шагнал гэж мэдээрэй. Түүний ачаар л бид энэ хотын хамгийн өчүүхэн хэсэгт ч гэсэн хамаагүй, энд орж чадсан” гэж ярив.

Ингэж хэлээд Нийтэч байрандаа орж зогслоо. Тэгтэл хааны харуул ч Аминчид үргэлжлүүлэн урагш явах дохио өгөв.

Алдартай багш


Аминч цаашаа дахин хэд алхаад Урамшуулагч гэдэг танилыгаа олж харжээ. Тэр Энделийн сургуулийн багш байсан бөгөөд Аминч ч түүнийг ихэд хүндэтгэдэг байв. Урамшуулагчийн уран чадварлаг, баялаг илтгэл нь Аминчийг ихэд хөглөдөг байв. Тэр мундаг багш оюутнуудаа сэргээж, өөртөө итгэх итгэлийг нь өрдөж өгдөг байжээ. Бусад багш нар нь хэдий урамшуулдаг ч, заримдаа хатуу үгээр зэмлэн эмзэглүүлдэг юмсанж. Харин Урамшуулагч багш хэзээ ч тэгэхгүй учраас оюутнууд ч түүний хичээлээс их сайхан мэдрэмжтэй гардаг байв. Үнэндээ Урамшуулагч Аминчийн хамгийн хайртай багш байжээ.

Аминч дахиад л хуучин багштайгаа ярьж болох эсэхийг лавлахаар хааны харуул руу хартал, харуул ч толгой дохион зөвшөөрлөө. Аминч Урамшуулагч дээр очоод, халуун дулаанаар мэндлэв.

Тэгээд тэсэлгүй: “Та чинь яахаараа энэ арын эгнээд байж байдаг билээ?” хэмээн асууж орхитол, Урамшуулагч:

“Энэ бол миний байр суурь, байх ёстой газар. Би Аффабелийн хамгийн дорд иргэдийн нэг. Би талд амьдарч, сантехникчээр ажилладаг” гэлээ.

Аминч “Юу?” хэмээн дуу алдаад: “Та чинь Жэйлиний хамгийн мундаг багш нарын нэг байсан! Тэгээд яахаараа хамгийн дорд иргэн болчихдог билээ? Та чинь тэр сэнтийд залрах ёстой хүн биз дээ?” гэв.



Урамшуулагч: “Энэ аугаа чуулганд эгнэж, Жэйлинтэй хамт захирч чадаагүй минь хэд хэдэн шалтгаантай. Тиймээс гол алдаагаа л хэлье. Амьдралаа Жэйлинд өгсөн хүмүүсийг барилгачидтай зүйрлэдэг байсныг санаж байна уу? Үүнийг сургуульд заадаг байсан. Эндэл дэхь нэг чухал үүрэг даалгавар нь бусдын амьдралыг барьж босгох даалгавар байсан. Харин багш нар үүнийг сургаал, зан авир, үйлсээрээ заах ёстой байсан юм.

Багш хүнийхээ хувьд би маш том үүрэг хариуцлага, завшаантай байсан. Би оюутнууддаа Жэйлинийн зарчим, арга замыг заасан ч гэлээ, олон талаараа эндсэн юм.

Би тэнцвэргүй зааж, Жэйлинд үйлчлэхийн сайн сайхан, эерэг талыг л ярьсан. Би олон оюутнуудаа амжилтанд хүргэхийн төлөө Жэйлиний арга замаар яв гэж ухуулснаас биш, амьдралын энхэл донхол, урхи хавхын талаар, уртын үр дагаварынх нь талаар яриагүй. Би тэдэнд Жэйлинд таалагдах нь амьдралын жинхэнэ зорилго болохыг заагаагүй. Зүгээр л амжилтанд хүрэхийн төлөө Түүний арга замыг ашиглахыг л заасан.

Эртний бичээс намайг Жэлиний зөвлөгөөг бүрэн бүтнээр нь заагаарай гэсэн. Үүнд хүн бүрт бүхий л цэц ухаанаараа Жэйлиний өмнө өөрийгөө төгс байлгахыг³ анхааруулж, заах ажил багтаж байсан. Би заасан, гэхдээ анхааруулаагүй. Төгс өөдрөг багш байхыг хичээхдээ, хэзээ ч эрүүл ухаантай анхааруулга өгөөгүй учраас, Жэйлинд олигтой алдар авчирсан амьдрал байгуулж чадаагүй юм. Үүнээс болж олон сурагч маань ялд унасан” хэмээн хэлээд, толгой гудайлаа.

Тэгээд Аминчийн нүүрэн дээрх цочроог хараад, багш нь ингэж хэлэв: “Тийм ээ, тэд ялд унасан. Миний тэнцвэргүй сургаалаас болж олон сурагч Ганц хэмээх хөсөр газар хаягдсан. Би өөрийнхөө алдар, нэр хүндийг алдахгүй гэсэндээ сурагчиддаа хэрэгтэй зүйлийг нь биш, дуртай зүйлийг нь өгчээ. Үүнээсээ болж буруу барьж байгуулсан. Би тэдний амьдрал дахь сул, асуудалтай талыг нь засч залруулаагүй. Би тэдний амин хувиа эрсэн хүслийг нь л бордож байжээ.

Эртний бичээс багш нарт: “Ямар ч амар тайван үгүй байхад тэд Миний хүмүүсийг “Амар тайван” гэдэг үгээрээ төөрүүлдэг бөгөөд босгож барьсан, нурах тавилантай хэврэг ханаа цагаанаар буддаг”⁴ хэмээн анхааруулга өгсөн байдаг. Миний олон сурагч зуурдын юмсаар амьдралаа босгосон. Тэр нь хэврэг хана гэдгийг

би дотроо мэдэж байсан ч, юу ч анхааруулаагүй. Сайн биш байхад нь би “Бүх юм сайн” гэдэг байсан. Би тэднийг буруу замаар замнуулж, худал хуурмагт нь живүүлсэн.

Одоо тэгээд Ганцад байгаа сурагчдынхаа араас гашуудсаар сууна. Яахав, Аффабелд орж чадсан хүмүүс бий нь бий. Гэхдээ миний эерэг сургаалаар бойжсон сурагчдын олонх нь...” гэж хэлээд, Урамшуулагч эргэж харснаа нам дуугаар: “...арын эгнээнд л сууж байна даа. Тэд амьдралаа үрж, хүчин зүтгэл нь Шүүх сэнтийн өмнө галд хуйхлагдсан” гэж шивэглэв.

Аминч түүнээс: “Галд хуйхлагдсан?” гэж лавлалал, багш нь:

“Тийм ээ, эртний бичээсийг санахгүй байна уу? “Тэр суурин дээр баригч нь алт, мөнгө, эрдэнэс юмуу эсвэл мод, сүрэл, дэрс ашиглаж болно. Гэхдээ шүүх өдөр барилгачны ажил үнэ цэнэтэй эсэхийг нь галаар шалгана. Ажил нь шатчих юм бол, барилгачин асар их гарз хохирол амсана. Барилгачин өөрөө галын дөлөөс хальт мулт л аврагдана.”⁵

Эртний элч нарын ярьсан тэр суурь нь Жэйлиний эзэний эрх мэдэл бөгөөд Жэйлин бидний хаанчлалд орох цорын ганц зам гэдгийг чи бид хоёр мэднэ. Гэхдээ үнэхээр Жэйлинийх болсон хүн энэ суурин дээр л барьж байгуулдаг.

Эртний бичээсээр хэмжихэд, амьдрал маань Жэйлиний зөвт жишигт хүрээгүй бөгөөд би заасан хүмүүстээ Аффабелийн төлөө сайнаар нөлөөлж чадаагүй учраас шагналаа алдсан. Аугаа багш Паул нөлөөлөхөөр дуудагдсан хүмүүсийнхээ талаар “Эцсийн эцэст юу бидний найдвар, баяр хөөр, юу бидний бардам шагнал титэм бэ? Энэ нь та нар юм! Тийм ээ, Эзэний өмнө бүгдээрээ зогсох үед та нар надад тийм их баяр авчирна”⁶ гэж хэлсэн байдаг.

Би Жэйлиний үнэнийг анх зааж эхлэхдээ мэдэж байсан ч, яваандаа бусдад таалагдахын тулд хамгаалалтаа буулгаж, тун удалгүй бардам занд туугдаж одоод, төдөлгүй энэ мэдлэгээсээ ташуурч, яг л ярьдаг шигээ амьдарч эхлэсэн. Ингэхдээ Жэйлиний анхааруулгыг гээж, мэхлэгдсэн. Эндхийн алдар ба тааллын тухай үзэл бодол нь Энделийнхээс тэс өөр шүү. Тэнд бидний аугаа мундаг гэж үздэг байсан зүйлс нь энд өчүүхэнд тооцогдоно” хэмээн яриу.

Аминч түүнээс: “Урамшуулагч аа, Жэйлин бидний нэрсийг өөрчилдөг гэж нэг найз маань хэлсэн. Таныг одоо хэн гэдэг болсон?” хэмээн ихэд шохоорхон асуутал, багш инээмсэглээд:

“Миний нэр Даруусагч болсон” гэж хэлээд, дээшээ харан

байрандаа буцаж зогслоо. Аминч хааны харуул руу хартал, харуул Даруусагчийн хэлсэн бүхэн үнэн гэх шиг толгой дохив.

Аминч сэнтий рүү үргэлжлүүлэн алхав. Одоо түүний нөгөө их итгэл замхарчээ. Тэрбээр амьдралаа эргэцүүлэн алхана. Ямар сэдэлтэй амьдарсан бол? Жэйлиний алдрын төлөө амьдарсан уу, амин хувийнхаа төлөө явсан уу? Жэйлиний үгээр амьдралаа авч явсан уу эсвэл мэхлэгдсэн үү? Бусдыг босгон байгуулсан уу эсвэл хувийнхаа амьдралыг байгуулахад ашигласан уу?

Захирагч

Аминч Аугаа их танхимын гол хавьцаа ирээд, иргэд нь улам л язгууртан төрхтэй болсоор байхыг анзаарав. Бүгдээрээ л түүн рүү таалсан, хайрын харцаар ширтэнэ. Аминч тэдний харц, царайнаас тайтгарал авч байлаа. Энэ нь яг одоо юутай тулахаа мэдэхгүй, баахан самгардсан түүнд маш их дэм болж байлаа.

Сэнтийд хүрэх тэр богино зам Аминчид хэдэн жил шиг л урт санагдана. Тэрбээр алхах зуураа Эндел дэхь амьдралаа энд тэндээс нь эргэцүүлсээр явсан ч, гайгүй сайн хотын дарга байсан учраас, Жэйлиний нэгэн дэд захирагч болчих байлгүй дээ хэмээн битүүхэн горьдсоор л явав.

Ингэж явсаар Аминч Жэйлиний дэд захирагч нарын дунд орж ирлээ. Толгой дээрх титэм, хаад язгууртны хувцас нь ч анзаарахгүй өнгөрөхийн аргагүй байв. Хүн бүр очирт таяг барьжээ. Тэд яахын аргагүй энэ хотын хамгийн эрхэм дээд хүмүүс байв. Аминч ч: “Хүн ийм сүр жавхлантай байж болдог оо?” хэмээн алмайрсаар явлаа.

Гэтэл дэд захирагчдын дунд Энделийн хотын захиргааны нэгэн гишүүний нарийн бичиг байсан нэг эмэгтэй зогсож байхыг Аминч үзээд: Тэр яахаараа сэнтийд сууж байдаг билээ? хэмээн нүд нь орой дээрээ гарав. Тэр эмэгтэй сургуульд Аминчийн хаана ч хүрдэггүй байсан бөгөөд Аминчаас жилийн өмнө төгссөн юмсанж. Тэр үг дуу цөөтэй эмэгтэй байсан учраас, Аминч түүнийг бараг л мэддэггүй байжээ.

Тэр эмэгтэй урагш алхтал хааны харуул зогсоод, түүнд мэхийн ёслол. Эмэгтэй Аминчтай халуун дулаанаар инээмсэглэн мэндлээд: “Аффабелд тавтай морилно уу. Би Тэвчээр - Ихт байна. Жэйлин чамтай уулзахаасаа өмнө намайг уулзаатах хэмээн илгээлээ. Би Аффабелийн дэд захирагчдын нэг байна” гэж хэлэв.

Аминч юу ч бодолгүй шууд л: “Захирагч ий? Чи чинь Энделд юу ч хийж гийгүүлээгүй байж, яахаараа захирагч болдог билээ?” хэмээн дуу алдснаа, гэнэт ухаараад, нүүр улайв.

Тэвчээр - Ихт “зүгээр ээ” гэх шиг толгой дохиод: “Битгий зов. Энэ хот дотор эсвэл энэ танхим дотор ямар ч худал хуурмаг нуугдахгүй. Чи үнэнээ л хэллээ. Энделд чи нэр төр, дүр төрхдөө л анхаардаг байсан. Энэ чинь олон хүнийг мунхаглаж байгаагаа ч мэдэлгүй, худлаа ярихад хүргэдэг. Үг хэдий чухал ч, санаа сэдэл үүнээс ч чухал. Харин санаа сэдэл нь энд хэзээд ил байдаг. Чи удахгүй Энделд хэлсэн үг бүрийнхээ төлөө шүүгдэхдээ, үүнийг ойлгоно оо” гэлээ.

Аминч “Үг бүрийнхээ төлөө! Хэлсэн үг бүрийнхээ төлөө?!” хэмээн дуу алдлаа.

Тэвчээр - Ихт “Тийм ээ, үг бүрийнхээ төлөө. Эзэн Жэйлиний анхааруулгыг санаж байна уу? “Шүүлтийн өдөр хүн бүр хэлсэн хэрэггүй үг бүрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэдгийг багтай мэдээрэй. Чамайг буруутай эсвэл зөв болохыг чинь хэлсэн үг бүрээр чинь шүүнэ.” Хэрэггүй үгс гэдэг нь дэмий хоосон эсвэл бодлогогүй үгс бөгөөд эдгээр нь бүгд Жэйлиний мөн чанартай сөргөлддөг юм” гэв.

Аминч түүнд: “Бид аймаар том худлын төлөө эсвэл аймаар том үнэний төлөө хариуцлага хүлээн гэдгээ мэдэж байсан л даа” гээд хэсэг бодолхийлээд “Тэвчээр - Ихт ээ, би одоо яах бол?” гэж асуулаа.

Гэтэл Тэвчээр - Ихт “Эртний бичээст “Чи хэлсэн эсвэл хийснээрээ шагнуулна”⁸ хэмээн тодорхой хэлсэн. Ажил юмуу үйлс чинь шалгагдаад зогсохгүй, эдгээрийн цаадах санаа сэдэл чинь ч шалгагдана. Түүнчлэн бодсон бодлоороо ч шүүгдэнэ. Жэйлиний шүүлт оюуныг хийгээд зүрхийг нягтлагч, шударга шүүх гэдгийг бүү мартаарай.”⁹ Учир нь Жэйлин Өөрөө “Би болбоос зүрхийг өвчиж, далд сэдлийг ч шинжилдэг Нэгэн. Би хүмүүст үйлсийнх нь дагуу хүртэх зохистой шагналыг нь л хүртээнэ”¹⁰ хэмээн айлдсан байдаг. Тэр үйлдэл, үг бүрийг төдийгүй, тэдгээрийн цаадах санаа сэдлийг ч шалгадаг.

Тиймээс л чи намайг сэнтийд суухыг хараад гайхсан. Чи намайг Эндел дэхь ололт амжилтаар минь л шүүсэн бол, Жэйлин намайг тэс өөр гэрлээр шүүсэн. Энэ гэрлийг чи одоо харж эхлэсэн бөгөөд тун удахгүй бүр ч тодорхой харна. Хүндэт найз минь, чи Эндел дэхь амьдралынхаа төлөө шударга шагнал хүртэнэ ээ” гэж хэлэв.

Аминч маш хатуу үнэнийг сонсжээ. Тийм боловч түүний хэзээ ч мэдэрч байгаагүй хайраар хүрсэн үг байлаа. Тэвчээр - Ихт дэд

захирагчийн үгнээс Аминч Жэйлинийг хайраар дүүрэн, халуун сэтгэлтэй захирагч болохыг нь ухаарчээ. Тэвчээрт - Ихтийн үг ч хайраар өлгийдсөн зэмлэл байв. Тиймээс Аминч хайр гэдэг нь бусдад таалагдах явдал биш, харин үнэн юм байна гэдгийг ойлгожээ.

Тэвчээр - Ихт бөхийсхийгээд: “Хаан чинь чамайг хүлээж байна” гэж хэлээд, буцаж сэнтийдээ суутал, хааны харуул Аминчид сэнтий рүү ганцаараа ойртож очихыг дохиод, өөрөө дэд захирагч нарын байрладаг доод тавцан дээр үлдэж хоцров.

Аминч Жэйлиний өмнө

Аминч хүлээж авсан зөвлөмжийнхөө дагуу Жэйлиний сүр жавхлант сэнтийгээс нэг шат доор байрших, тавцан дээр зогсоод, хаан руу харлаа. Тэр чуулган дотор Жэйлин шиг гоо үзэсгэлэнтэй, язгууртан төрхтэй, гайхамшигтай нэгэн байсангүй. Түүний яруу алдар нь дуу алдан, сөгдмөөр ажээ. Аминч амьдралдаа хэзээ ч ийм хүнийг үзээгүй. Түүний цэц ухаан, хүчийг хэн ч няцааж чадахгүйг Аминч тэр даруй мэдлээ.

Аминч анх удаа Жэйлиний нүд рүү ширтээд л хаан нь өөрийнх нь төсөөлж явснаас хавьгүй аймшигтай бас гайхамшигтай болохыг мэдэв. Хаан Аминчийг цоо ширтэхэд, тэрбээр хааны өмнө юугаа ч нууж хааж чадахгүй, нүв нүцгэн санагдлаа. Аминч эрдсэн их итгэл, арга чаргаа алдсан ч, үүндээ зовсонгүй. Одоо тэр үнэнээс өөр юуг ч хүсэхгүй байв.

Жэйлин түүнд: “Аминч аа, миний хаанчлалд тавтай морил. Энэ эгшинг тэсэн ядан хүлээлээ. Чи Энделд Миний хүмүүсийг захирч явсан. Тэгвэл одоо Аффабелд захирагч болж, сэнтийд суух эрхтэй юу?” хэмээн айлдахад нь нөгөө огт барьц алддаггүй, итгэл дүүрэн хүн чинь “А” ч гэж дуугарч чадсангүй. Саяхан л Аффабелд их үйл хэргийг гүйцэлдүүлнэ хэмээн сэтгэж явсан Аминч Аугаа их танхимд хэдэн хүнтэй ярилцсныхаа дараа юу бодохоо ч мэдэхээ байжээ.

Жэйлин Өөртөө ойрхон суугаа нэгэн дэд захирагчаас: “Аминч хэдэн хүнийг хаанчлалд оруулахад нөлөөлсөн?” гэж асуутал хэдхэн л нэр дурьдагдлаа.

Үүнийг сонсоод Аминч асар балмагдав.

Тэгтэл хаан нөгөө захирагчаас: “Тэгвэл Тэвчээр - Ихт хэдэн хүнийг Миний хаанчлалд авчирсан бэ?” гэтэл, нөгөө захирагч:

“Таван мянга гаруй хүнийг, эзэнтэн минь” гэж хариуллаа.

Аминч “Яаж тэр вэ? Тэр чинь нарийн бичиг байсан, харин би бол хотын дарга. Яахаараа түүний тоо тийм их, минийх ийм цөөн байдаг билээ?” хэмээн бувтналаа.

Гэтэл Жэйлин дуугаа өргөөд: “Би хэдэн хүнд нөлөөлсөн гэж асуугаагүй, харин хаанчлалын төлөө нөлөөлсөн гэж асуусан!” гэж хэлснээ, дараа нь арай нам боловч хатуу дуугаар: “Чиний хуучин багш Урамшуулагч буюу өдгөө Даруусагч чамаас ч олон хүнд нөлөөлсөн. Гэхдээ түүний тэр их нөлөөний тун бага хувь нь л миний хаанчлалтай холбоотой байсан юм. Тиймээс л тэр энэ хотын захирагч болж чадаагүй. Шүүх сэнтийг тэсч гардаг нөлөөлөл нь Миний зам, Миний хаанчлалд нийцэх эсэхээр шийдэгдэнэ.


Тэвчээр - Ихт сургуульдаа санхүүгээр ч, үйлчлэлээрээ ч хувь нэмрээ оруулсан. Тиймээс сургуулийн ач тусыг хүртсэн хүмүүс нь Тэвчээр - Ихтийн үр жимс мөнөөс мөн” хэмээн айлдав.

Тэгтэл Аминч ч мөчөөгөө өгөлгүй: “Би ч гэсэн сургуульд өгсөн шүү дээ” гэлээ.

Жэйлин түүнд: “Чиний хувь нэмэр чинь нэр төрөө л өсгөх сэдэлтэй байсан. Иймээс чи Энделд байхдаа шагналаа бүрэн бүтнээр нь авсан. Харин Тэвчээр - Ихт хаанчлалын төлөө, хүмүүсийг хайрласандаа өргөсөн юм.

Тэвчээр - Ихт Харгис гэдэг хүнийг Над руу авчирсан. Харгис яг одоо Амийн танхимд шүүгдэх цагаа хүлээж байна. Би түүнийг Сайн мэдээ дэлгэрүүлэгч гэж нэрлэнэ. Учир нь тэр тал бүрээрээ хүмүүстэй харилцаж чаддаг болж, хаанчлалын төлөө мянга гаруй хүнд хувьчлан нөлөөлсөн болно. Түүний барьж босгосон хүмүүс ч Тэвчээр - Ихтийн үр жимс мөнөөс мөн. Учир нь Тэвчээр - Ихт л Сайн мэдээ дэлгэрүүлэгчийг сайн мэдээнд хөтлөж, дэмжиж, сургасан” хэмээн айлдав.

Аминч Энделийн Харгисыг санаж байлаа. Аминч түүнийг итгэлдээ хэт улайрагч гэж үздэг байжээ. Иргэд Аффабелийн төлөө бүрэн зориулагдахгүй байгааг Харгис хотын сонинд байнга шүүмжилж бичнэ. Мөн олон Энделчүүдийг сургуулийн өргөжилтийн ажлыг дэмжих талаар хотын захиргааны гишүүдтэй холбоо барьж, шахаж шаард гэж байнга хөдөлгөнө. Аминч сургуулиас газрыг нь булаах үед Харгис л хамгийн чанга дургүйцсэн. Эдгээр шалтгаанаар Аминч Харгист дургүй байжээ. Гэтэл Харгис Аффабелийн хөгжилд ийм их хувь нэмэр оруулсан гэдгийг мэдээд Аминчийн нүүр улайв. Аминч яаж тийм сохор байв аа?



Тэвчээр - Ихт хаанчлалын төлөө Эндэлчүүдэд өөр бас яаж нөлөөлснийг Жэйлин үргэлжүүлэн тоочив. Олон жижиг зүйлс нь далайд дусал нэмэр болжээ. Тэр эмэгтэй хүмүүст цэвэр сэтгэл, хайраар хандсан. Гачигдсан хүмүүст туслаж, үнэний төлөө бат зогссон.

Хаан Тэвчээр - Ихтийн тухай ярьж дуусаад, Аминчийн амьдралыг зүйчлэн шалгав. Яг л Тэвчээр - Ихтийн хэлсэн шиг үг, үйлдлэл, сэдэл бүр нь жинлэгджээ.

Аминч хааныхаа төлөө олон зүйлийг хийж чадах байсан ч, ихэнхийг нь амин хувийнхаа баталгаа, нэр төрийн төлөө үйлджээ. Амьдрал нь шалгагдаж дуусмагц, Аминч өөрийгөө дуусжээ гэдгийг ухаарав.


Тиймээс: “Би насаараа шийтгүүлэх ялтай хүн. Би Ганцад байх ёстой. Би Таны надад өгсөн бэлэг авъяас, үүрэг хариуцлагаас маш ихийг үрлэгдэж, маш бага ашиг гаргасан” хэмээн уйлжээ. Аминч үнэхээр голоо тасартал харуусан, асгартал уйлж байлаа. Аугаа их танхимд орохоосоо өмнө ханхалзаж явсан энэ эрийн утсын чинээ улаан амь нь тасрахын даваан дээр иржээ. Одоо түүнд Жэйлиний өршөөлөөс өөр ямар ч арга зам үлдээгүй бөгөөд үнэндээ өршөөгдөнө гэдэгтээ ч итгэлгүй байлаа. Тэгээд Ганц руу цөлөгдөх ялын тогтоолоо л хүлээв.

Хэсэг аймшигтай нам гүм тогтсоны эцэст хаан: “Аминч аа, чи бол Миний зарц. Чи маш ихийг үрлэгдсэн ч гэлээ, надад итгэж, Миний эзэний эрх мэдэлд захирагдсан. Би чамд хайртай. Насан турш Миний хаанчлалд амьдрагтун” хэмээн айлдав.

Аминч айхын дээдээр айж, гайхахын дээдээр гайхлаа. Тэр толгойгоо өндийлгөөд, өдгөө зовсондоо биш, жаргасандаа баахан уйлав. Аминч хааныхаа өршөөл, сайн сайханд итгэж чадсангүй. Хормын төдийд л Аминч Жэйлиний сайн сайхны талаарх магтаал үнэн болохыг харав. Дөнгөж сая амьдралаа шалгуулаад, төсөөлшгүй хүнд зэмтэй, цөллөгөөс өөр шагналгүй ялтан байсан түүнийг ер бусын өр зөөлөн, энэрэнгүй хаан Жэйлин өөрийн биеэр хаанчлалдаа урьж байдаг. Юутай их өршөөл, хайр вэ!

Эндэлд хийсэн бүхэн нь шатсан ч, тэрбээр хаанаасаа: “Би чамд хайртай, Миний хаанчлалд тавтай морил” гэдэг үгийг сонсжээ. Хангалуун аргагүй үнэн хэлснийг Аминч ухаарав. Түүнд үүнээс илүү хүсэх юм байсангүй.

Гэтэл хаан Аминчид: “Аминч аа, одоо чиний хуучин нэр үгүй болж, Би чамд шинэ нэр хайрлана. Миний хаанчлалд чи



өдгөөгөөс Цэвэр санаа нэртэй болно. Би чамд тал газар орон байр бэлдсэн байгаа. Түүнчлэн чи ландшафтын дизайнераар ажиллана. Хэдийгээр чи энэ хотын захирагчаар ажиллахгүй ч, Надад гадаад нутаг дэвсгэрийг захирахад минь туслах болно” гэлээ.

Аминч: “Танд гадаад нутаг дэвсгэрийг захирахад туслах ий?” гэтэл Жэйлин:

“Энэ хотын иргэн бүр захирагч мөн. Энэ гаригийн хязгаар хүртэл сунасан Миний хаанчлал үй олон хоттой. Тэдгээр гадаад далай дахь хотын иргэд нь Аффабелийн иргэд шиг Энделд сурч боловсроогүй бөгөөд шүүгдэхгүй юм. Иймээс тэдэнд Аффабелийн иргэдийнх шиг өндөр чадвар байхгүй. Чи Аффабелийн удирдагч болохгүй ч, миний хаанчлалыг даяаршуулахад хувь нэмрээ оруулах болно. Харин чи Бенгилла тивийн хорин хотын бүх ландшафтын дизайнеруудыг сургаж, ажиллуулах ажлыг гардан удирдах болно” хэмээн тушаав.

Аминч толгой гудайн, уйлсаар байлаа. Энэ хааны энэрэлийг ухаарч ойлгох ч боломжгүй, үгээр тайлбарлах ч аргагүй ажээ.

Жэйлин ширээ рүү дөхөж очоод нэгэн юм авснаа, Цэвэр санаа дээр ирээд: “Энэ жимсийг ид” гэлээ.

Цэвэр санаа Жэйлиний гараас жимсийг нь аваад, идэв. Түүний идэж үзсэн хамгийн амттай жимс ажээ. Яг л тархи зүрхийг нь ариусгачих шиг л болов. Цэвэр санаагийн бодлууд нь аугаа их хайраар цалгиж, үйлчлэх хүслээр дүрэлзлээ. Тэр жимсийг идээд өнгөрсөн амьдралынхаа шарх, хар бодлуудаасаа цэвэрлэгдэж, эрч хүч, аз жаргал, итгэл найдвараар бялхав. Тэр жимс нь амийн модны жимс болохыг Цэвэр санаа тэр даруй мэджээ. Өөрийг нь Жэйлин тааламжтайгаар харахыг Цэвэр санаа үзээд, нүүр дүүрэн мишээв.

Тэгтэл Жэйлин түүнд: “Эргээд, гэр бүлээ хар” хэмээн айлдлаа.⁹

Цэвэр санаа болгоомжтой нь аргагүй эргэж харав. Учир нь тэр өөрийнх нь амьдралыг гэрчилсэн зон олноос зовсоор л байлаа. Тэгээд бүрэн эргэтэл, тэр олон хүмүүс бүгд баярлалдан, алга ташин, хашхиралдав. Хөгжим эгшиглэж, зарим иргэд нь бүжиглэв. Цэвэр санаа Аффабелийн иргэдийн тэр их хайр тааллыг ойлгож ядаж байв. Эндэл дэхь түүний бүх алдаа эндэл бүрэн эдгэрчээ.

Цэвэр санаа буцаж хараад, Жэйлиний царайнаас хамгийн сүр жавхлантай, баяртай инээмсэглэлийг олж үзэв. Жэйлин түүнийг хэзээ ч, хэний ч харж байгаагүй халуун дулаан, хайраар ширтэж байлаа. Цэвэр санаа одоо Тэвчээр - Ихт тэргүүтэй хүмүүсийн адил Жэйлиний бодлыг сонсож чадаж байв. Тэдгээр нь таалал,

хүлээн зөвшөөрөл, түүн дээр айсуу аз жаргалын найдвараар гийсэн бодлууд байлаа. Цэвэр санаа хаандаа сөгдөн мөргөтөл, хаан түүнийг босгон тас тэврээд: “Тавтай морил, найз минь” гэж хэлэв.

Тэгээд Цэвэр санаа танхимд өөрт нь зааж өгсөн байраа эзлээд, бусад Энделчүүдийнхээ шүүхэд оролцохоор хүлээлээ. Нулимс бүр арчигдаж, тэнд дахин ямар ч гуниг, өвчин, уйлаан байсангүй. Хуучин юмс өнгөрчээ.

Өгөөмөр ба түүний шүүх

Өдөр хөвөрсөөр, Амийн танхимд байсан бүх иргэд дуудагдаж, Өгөөмөр ганцаараа үлджээ. Гэхдээ тэр өрөө хотын зохиолч нарын бичсэн сайхан сайхан номоор дүүрэн байсан тул, Өгөөмөр ч цаг нөгцөөх гэж зовсонгүй. Хааны харуул Өгөөмөрийг дуудах үед тэрбээр Аффабелийн Хоёрдугаар номыг уншиж байлаа. Хааны харуул ч түүнийг: “Хаан тань хүлээж байна” хэмээн тун эелдгээр дуудав.

Өчнөөн жил хайрлаж, санасан Жэйлингтэйгээ уулзах нь гэхээс Өгөөмөрийн зүрх булгилж байв. Энэ эгшинг хичнээн ч жил хүлээв дээ. Гэтэл одоо цаг нь иржээ. Өгөөмөрийг дөхөж ирэхэд, хааны харуул мишээсээр угтан, тэд хамтдаа Аугаа их танхим руу явлаа.

Үүд нээгдмэгц, Өгөөмөр Аугаа их танхимын сүр жавхланг үзээд дуу алдав. Тэгсэнээ гэртээ хол сэнтийдээ залран суугаа Жэйлиний барааг олж харлаа. Дараа нь танхим дүүрэн Аффабелийн иргэдийг хараад: “Ямар сайхан хүмүүс вэ! Хаан хатад шиг ийм мундаг хүмүүсийг би яаж найзаа гэж дуудна аа?” хэмээн өөрийн эрхгүй бодогдов.

Гэтэл түүнтэй зөрсөн бүх иргэд түүнд мэхийн ёслож байхыг Өгөөмөр анзаарлаа. Сэнтий рүү ойртох тусам хүмүүс нь хачин гоё хувцастай, жигтэйхэн үзэсгэлэнтэй болсоор байв. Супер баатрууд л гэмээр. Гэтэл ийм эрхэмсэг хүмүүс Өгөөмөрт мэхийн ёслож байв.

Өгөөмөр Энделд таньдаг байсан хэд хэдэн хүнээ олж харжээ. Тэд Өгөөмөрийг бөөн баяр, хайраар ширтэж байв. Өгөөмөр гүйж очоод л бүгдийг нь тэвэрмээр байв ч, яг одоо болохгүй гэдгийг мэдэрчээ. Гэхдээ Ёсбусыг хараад тэссэнгүй. Өгөөмөр Ёсбус дээр харайж очоод тас тэврэн, хоёул учран золгосондоо баярлалдав.

Ёсбус Өгөөмөрт мэхийн ёслоод: “Шинэ гэртээ тавтай морил” гэлээ.

Өгөөмөр ч: “Ёсбус аа, чи юунд над мөргөнө вэ? Би чинь бурхан биш шүү дээ” гэтэл Ёсбус:

“Хүндэтгэл мөргөл ялгаатай. Бид зөвхөн эзэндээ мөргөв ч, Энделд бидэнд сайн үйлчилсэн хүмүүсийг хүндэтгэнэ. Мөнхүү захирагч нараа ч хүндэтгэнэ. Энделд байхдаа бид хүндэтгэлийн үнэ цэнийг мэддэггүй байж.

Өгөөмөр минь, чи Энделд намайг халамжилсан. Чи хаанд дуулгавартай байгаагүй бол, би энд байхгүй, Ганц хэмээх хөсөр газарт л дуусах байлаа. Тиймээс юу юунаас илүүтэй би хаандаа талархав ч, чамд ч бас талархлын өртэй. Насан турш чамд үйлчилж, чамайг хүндэтгэх нь миний хувьд өндөр хүндлэл билээ.

Өгөөмөр минь, Жэйлин хаан Шүүх сэнтийн өмнө миний нэрийг Эвлэрэл болгосон. Хааны хамгийн том өршөөлөө хайрласан хүн нь магад би л байх” гэж ярив.

Өгөөмөр түүнд “Эвлэрэл! Ямар жавхлантай нэр вэ. Эрхэм найз минь, би хожим чамаар үйлчлүүлэх гэж Энделд санаа тавьсан юм биш шүү дээ. Чамайг хайрласандаа, хувь заяанд чинь зовсондоо л санаа тавьсан шүү дээ” гэж учирлалал, Эвлэрэл:

“Тиймээс л би чамайг хүндэтгэж, чамд үйлчилнэ. Хаан ч чамайг том шагнана. Чи Жэйлинийг хайрласандаа үйлчилсэн. Бусад дагалдагч нарт таалагдах гэж эсвэл шан харамж горилсондоо үйлчилсэн удаа чамд байхгүй. Жэйлин бусдыг хайрладаг хүнд дуртай. Бид Энделд Жэйлиний алсын харааг төдийгүй, зүрх сэтгэлийг нь өвлөх ёстой байдаг. Харин хүндэт дүү минь, чи аль алийг нь өвлөсөн учраас, чиний санаа сэдлийг би ч өвлөж авсан юм. Тиймээс л Энделд байсан сүүлийнхээ долоо хоногт би маш олон хүнд Аффабелийг хайраар мэдүүлсэн. Хэдийгээр дэндүү богино ажилласан ч, хүчин зүтгэлийнхээ төлөө гайгүй сайн шагнуулсан шүү” гэхэд нь Өгөөмөр инээмсэглээд:

“Ямар сайн хэрэг вэ, Эвлэрэл минь! Би ч бас насан турш чиний төлөө үйлчилнэ” гэж хэлэв.

Эвлэрэл: “Өгөөмөр минь, чи ч Аффабелийн ууган иргэн шиг л ярьж байна шүү. Энэ аугаа хотод бид бие биедээ үйлчилдэг. Үнэндээ захирагч нь хамгийн аугаа зарц болдог. Бид хариуцлагын хүндийг үүрдэг ч, үүндээ жаргалтай байдаг. Энделд байснаас өөр шүү. Захирагч нар нь бусдыгаа зарцлахыг бодох биш, харин бусдад үйлчлэх завшаан олдох бүрий баяртайгаар гүйцэтгэнэ. Иргэн

бүрийн хамгийн том жаргал бол эхлээд хаандаа, дараа нь бусаддаа - нэн ялангуяа Энделд бидэнд нөлөөлсөн хүмүүст, эцэст нь - чиний тун удахгүй мэдэх гадаад далай дахь иргэдэд үйлчлэх явдал юм.

Бахархал болсон дүү минь, хаандаа бараалх даа. Тэр чамтай уулзаж, шагнахаар тэсэн ядан хүлээж байгаа” гэж хэлээд, Өгөөмөртэй тэврэлдээд салахад нь Өгөөмөр харуулыг дагаад цаашаа явлаа.

Өгөөмөр Жэйлиний өмнө

Өгөөмөр сэнтийд хориод метрийн зайтай ирээд, Жэйлиний дүр төрхийг илүү тод харав. Тэр Жэйлинээс хараа салгаагүй учраас, дэргэдүүрээ өнгөрөх дэд захирагч нарын ёсолгоо ч анзаарсангүй. Өгөөмөр Жэйлиний сүр жавхланд бүрэн автжээ.

Өгөөмөр шатаар ахисаар, сэнтийн доорх тавцан дээр гараад, хааныхаа өмнө хөсөр уналаа. Гэтэл хаан бууж очоод Өгөөмөрийг босгон: “Миний зарц Өгөөмөр минь, эзэнийхээ хаанчлалд тавтай морил. Чамтай уулзахыг тэсэн ядан хүлээлээ” хэмээн халуун сэтгэлээр өгүүлэв.


Өөдөөс нь Өгөөмөр: “Дээдэс минь, би л тэсэн ядан хүлээлээ. Насан турш Таны оршихуйд байж, үйлчилмээр байна” гэлээ.

Хаан: “Дэлхий бүтээгдсэн цагаас чамд хадгалсан хаанчлалыг минь хүлээн ав. Намайг өлсөхөд чи хооллосон, цангахад ундаалсан, харь хүн байхад минь чи л гэртээ оруулсан, нүцгэн байхад минь чи л хувцасласан, өвчтэй байхад минь чи л халамжилсан, шоронд чи л намайг эргэсэн” хэмээлээ.

Гайхаж цочирдсон Өгөөмөр: “Хэзээ би Таныг өлсөхөд хооллож, цангахад ундааллаа? Хэзээ би таныг харь хүн байхад гэртээ урьж, нүцгэн явахад чинь хувцаслалаа? Хэзээ би таныг өвчтэй байхад халамжилж, шоронд эргэж тойрлоо?” гэсэнд хаан:

“Миний ахан дүүсийн хамгийн дордод нь эдгээрийг хийх бүртгээ чи Миний төлөө л хийсэн!”¹¹ хэмээн айлдав.

Дараа нь Жэйлин Өгөөмөр өөрийнх нь хүмүүст үйлчилж, хуулийг нь биелүүлэхдээ, Жэйлинд өөрт нь үйлчилсэн болохыг харуулжээ. Өгөөмөрийн амьдралыг үзүүлж, үг, үйлдэл, бодол, зүрхний сэдэл бүрийг нь нягтлан шалгав. Өгөөмөрийн үйлчлэл, сургуульдаа өргөсөн хандив, бусдыг хайрлах сэтгэл, ямар ч



хэрэггүй, зохисгүй үйл явдал, ярианд оролцохоос татгалзсан, Жэйлиний төлөө хавчигдаж явсан, ресторанаараа дамжуулан бусдад үйлчилсэн хөдөлмөр, төөрсөн хүмүүст Сайн мэдээ ярьсан, тэдний төлөө олон цагаар уйлан залбирсан, Жэйлиний замаар алхахын төлөө биеэ татсан, Жэйлиний төлөөх халуун сэтгэлээсээ болж олон нийтийн арга хэмжээнээс гадуурхагдсан, бусдыг муулах яриа, хов живд оролцохоос татгалзсан зэрэг нь бүгд гарав.

Өгөөмөр хэд хэдэн зүйлээ галд шатаалгажээ. Хэдийгээр энэ нь тун багахан хувийн гарз байсан ч, Өгөөмөр алдсан боломж, гаргасан алдааныхаа төлөө үлэмж харуусан гашуудав.

Өгөөмөрийн шагнал

Өгөөмөрийн сүүлийн үг, бодлыг шалгасны дараа хаан Өөрийнхөө ойролцоо суугаа дэд захирагчаас: “Өгөөмөр Миний хаанчлалын төлөө хэдэн хүнд нөлөөлсөн?” гэж асуутал, захирагч:

“5183 хүнд, эзэнтээн. Нийгмийн зургааны нэгээс яльгүй ихэд” гэж хариулав.

Өгөөмөр ч: “Яахаараа ийм олон байдаг билээ?” хэмээн гайхлаа.

Гэтэл Жэйлин түүнд: ““Тарьсан үрийг чинь өсгөж, зөвт байдлын чинь үр жимсийг үржүүлнэ” гэсэн эртний бичээсийг санахгүй байна уу?”¹² Өгөөмөр өө, миний хаанчлал үржлийн зарчмаар ажилладаг” гэж хэлэв.

Дараа нь хаан Өгөөмөрийг хэдийгээр удирдагч байгаагүй ч, дуулгавартай үйлсээрээ олон нийтэд яг хэрхэн нөлөөлсөнийг нь дэлгэрэнгүй харуулжээ. Түүний үйлс яг л долгион шиг тархжээ. Тэгээд Жэйлин: “Нинжин хүн газар сайгүй тариалж, ядууст өгч, түүний шударга, сайн, эелдэг, өр зөөлөн, хайрын үйлс нь мөнхийн мөнхөд тогтоно”¹³ хэмээн бичигдсэн байдаг. Надад бүрэн зориулагдсан амьдралын цацраг мэт үр нөлөөг Шүүх сэнтийн өмнө ирэхээс нааш хүн ухаарахгүй. Иймээс олон хүн жижиг юмсыг ач холбогдолгүй хэмээн үл тоосондоо дуулгаваргүй загнадаг. Гэтэл үл тоогдом өчүүхэн юмс нь хаанчлалд хамгийн том ургац авчрах тохиолдол олонтаа” хэмээн өгүүлээд:

“Өгөөмөр, чи зүүн талдаа байгаа, Миний дэргэдэх эзгүй сэнтийг харж байна уу?” гэж асуув.

Өгөөмөр ч: “Харж байна аа, эзэнтээн” гэлээ.

“Чи энэ сэнтийд сууж, насан турш Надтай хамт захирах болно.”

Өгөөмөр мэл гайхаад: “Эзэн минь, би чинь захираад байх хүн биш - зүгээр л нэг ресторан ажиллуулдаг байсан. Надаас бэлэгтэй хүн зөндөө бий. Би яаж Таны энэ сүр жавхлант хаанчлалд Тантай хамтарч захирах билээ? Аминч нийгэмдээ мундаг удирдагч байсан. Түүгээр захируул. Харин надад зүгээр л Таны хүмүүст үйлчлэх ажил өгөөч” гэлээ.

Гэтэл Жэйлин түүнд: “Аминч Аугаа их танхимын ард байгаа. Тэрбээр тал газар амьдарч, ландшафтын ажил хийнэ. Мөн сонгогдсон гадаад хотуудад ландшафтын ажил хийнэ. Харин чи Намайг болон Миний хүмүүсийг хайрлах хайрынхаа улмаас захирагч болно. Чиний гэвчээр, үнэнч байдал, даруу чанар чамайг энэ хүндэтгэлд зохистой болгосон. Эртний бичээс дэхь Үгийг минь санахгүй байна уу? “Өөрийгөө өргөмжлөгч нь даруулгатай болж (хүндэтгэл, шагнал хүртсэн хүмүүсээс доод хэргэмтэй болж), харин өөрийгөө даруусгагч нь (өөрийнхөө талаар даруу бодолтой явж, үүнчлэн үйлддэг) нь өргөмжлөгдөнө (өндөр цол хэргэмтэй болно)”¹⁴ гэдэг. Чи Надтай хамт захираад зогсохуй, Би чамд Миний гэр болох Хааны ордны хажууд, их далайн эрэг дээр сүр жавхлант гэр бэлдсэн байгаа. Гол ус, далайн давалгааны дуу чимээнд хайртайг чинь би мэднэ. Тиймээс чиний хүсэл, тааллыг биелүүллээ. Би итгэмжтэй зарцынхаа зүрхний хүслийг биелүүлдэг” хэмээн айлдав.

Өгөөмөр юу хэлэхээ үнэндээ мэдсэнгүй.

Гэтэл Жэйлин: “Чи хотын арван дүүргийн захирагч болно. Чамтай хамт Миний арван нэгэн захирагч Аффабелийн 120 дүүргийг захирна. Чи эдгээр сэнтийд суугаа далан долоон дэд захирагчийн хамт Надтай гар нийлэн ажиллана. Бусад захирагч нар боловсрол, үйлдвэрлэл, зугаа цэнгэл, урлаг тэргүүтэй олон талбарыг хариуцан ажилладаг болно. Миний Аав, Миний Бие, Миний далан долоон захирагч нар Аффабелийн хамаг амьдралыг авч явдаг болно. Харин чи Миний иргэдийг Надтай холбодог, итгэл хүлээсэн зөвлөх, холбоочин минь болно.

Чи Надтай хамт энэ хотод захираад зогсохгүй, бусад далан долоон дэд захирагчийн адил гадаад далай дахь хотуудыг бас удирдах болно. Би чамаар Бенгилла тивийн хорин хотыг захируулна. Чи тэр тивийн ерөнхий сайд болно. Тэндхийн иргэд ажлаа чамд тайлагнаж, харин чи ажлаа Надад тайлагнана.

Жэйлин эдгээр үгийг Өгөөмөрт хэлж байхад, арын эгнээнд зогсох Цэвэр санаа ангийнхаа охиноор үнэн голоосоо бахдаж байсан ч, нөгөөтэйгүүр хаанчлалын төлөө бусдад нөлөөлж чадах байсан ч, юу ч хийлгүй дэмий цалгардуулсан хайран боломжийнхоо төлөө үнэн голоосоо харуусч байв. Тэр Жэйлинтэй мөр зэрэгцэн ажиллах тэдгээр дэд захирагч нарын нэг байж болох л байсан. Аффабелд орж чадсандаа хязгааргүй талархавч, Энделд үрлэгдсэн богинохон хугацаа нь 130 жилийнх нь амьдралыг шийдчих юм чинээ санаагүй ажээ.

Тэгтэл хаан харуулдаа: “Ялагчийн титэм, захирагчийн очирт таягийг аваад ир” хэмээн тушаав.

Жэйлин тэдгээрийг аваад, титмийг нь Өгөөмөрийн тэргүүн дээр тавиад: “Сайн байна, Миний итгэмжтэй зарц. Чи Миний даалгасан өчүүхэн зүйлд итгэмжтэй байсан тул чамайг арван дүүрэг, хорин хотын захирагчийн хэргэмээр шагна”¹⁵ гэлээ.


Тэгээд Өгөөмөрт очирт таягийг гардуулаад: “Өдгөөгөөс чамайг Өгөөмөр биш, Нандин Ялагч гэж нэрлэнэ. Учир нь “Ялан ялсаар, эцсээ хүртэл Миний хүслийг гүйцэтгэдэг хүнд би дүүрэг ба үндэстнүүдийг захирах эрх мэдлийг өгнө. Би Ааваасаа эрх мэдлийг хүлээн авсантай адил тэр тэднийг төмөр таягаар захирах болно” хэмээн Би Энделийн иргэдэд өмнөөс хэлсэн бус уу?” гэлээ.

Жэйлин ширээ рүү очоод хамгийн сүүлийн зүсэм жимсийг аваад, Нандин Ялагчид өгөөд: “Миний найз бас хамтран зүтгэгч минь, Амийн модны энэ жимсийг ид” гэв.

Нандин Ялагч жимсийг идтэл, юутай ч зүйрлэшгүй энэ амтат жимс түүнийг бүхлээр нь хуу цэвэрлэж, ариутгахыг яг л бусад шигээ мэдэрчээ. Тэгээд бодол нь улам гүн хайраар хальж, үйлчлэх хүсэл нь урьд өмнө хэзээ ч төсөөлж байгаагүй хэмжээгээр тэлжээ. Тэр Эндел дэхь бүхий л зовлон, хар муу бодлоосоо цэвэршиж, бүх юмс цоо шинэ болов. Баяр хөөр, аз жаргал, итгэл найдвар бадарч байлаа. Нандин маань Жэйлин рүү хараад инээмсэглэв. Тэгтэл гэнэт дотроос нь гижигдэн, бөөн баяр олгойдож, Жэйлин тэр хоёр учиргүй хөхрөлдлөө. Энэ бол насан үүрдийн түншлэлийн эхлэл байв.

Жэйлин Өгөөмөрийг сэнтий рүүгээ дагуулж очоод: “Нандин Ялагч аа, эргээд гэр бүлээ хар” хэмээлээ.

Нандин Ялагч тэнгэрийн дуу мэт нүүргэлсэн их алга ташилтын зүг эргэж харав. Танхим дүүрэн дуу хөгжим, бүжиг наадам. Урьд нь хэний ч шүүх дээр ийм юм болж байсангүй. Агаар мандлаар



дүүрэн хөөр баяр, цэнгэлийн амьсгал. Нандин Ялагч энэ их хайрын илбээнд нүүр дүүрэн мишээсээр. Гэтэл хаан түүний мөрөөр гэврээд цангинасан дуугаар: “Сайн байна, Миний итгэмжит сайн зарц. Эзэнийхээ баяр хөөрт тавтай морил!”¹⁷ хэмээн айлдав.

Ийнхүү манай аугаа хаан Жэйлин, түүний зарц нарын хийгээд Аффабелийн түүх амар сайхандаа жаргажээ.

Заавар ба Сэрэмжлүүлэг

Энэ бүлгээрээ бид ариун хүмүүсийн шүүх ямар байхыг зах зухаас нь үзлээ. Жинхэнэ Христийн Шүүх сэнтийн сүр жавхлан, яруу алдрын дэргэд манай түүх хаа ч хүрэхгүй гэдгийг ахин дахин сануулъя. Гэхдээ түүх маань Бурханы хаанчлалын маш олон үнэнийг дүрслэн харуулсан болно.

Аффабелийн үйл явдал, үзэгдлүүд нь хөдлөшгүй үнэн биш, харин өрнөх бодит үнэнийг дүрслэн ухааруулах зорилготой гэдгийг ойлгоорой. Жишээлбэл бид Есүсийн сургаалт үлгэрээс тухайн түүхээр хэлэх гэсэн Есүсийн гол санааг л авдгаас биш, түүхэнд гарч байгаа жижиг сажиг, туслах хэсгийг нь өлгөж аваад, ороогдож унаад байдаггүй.

Миний бие энэхүү түүхээрээ Христийн мөнхийн хаанчлалтай холбоотой гол үнэнийг ухаж ойлгуулах гэж тун их хичээлээ. Номоо дуусгасан хойноо та Аффабелийн түүхээ дахин уншбал, Бичээсийн хэсгүүдийг бүр ч нарийн ухаарах буй за.

ТЭНГЭР

*Миний хувьд би зөв шударгаар Таны нүүрийг харна
Би сэрэхдээ Таны дүр төрхөнд сэтгэл хангалуун байна.*
— Дуулал 17:15

Одоо зөвт хүмүүсийн шүүлгийг үзье. Итгэгч бус хүмүүс Хайдас нэртэй газар түр хоригдоод, дараа нь мөнхийн гэр болох Галт нуурт хаягдах шиг, нас барсан итгэгч хүмүүс ч хоёр газар очно. Миний одоо ярих гэрийг ихэнх хүмүүс тэнгэр гэдэг ч, бичээс тэнгэрийн Иерусалим гэдэг юм. Зөвт хүмүүсийн эцсийн гэр нь ч бас Иерусалим хэмээгдэх боловч, энэ нь газар дээр байрлах юм. Энэ нь эцсийн шүүхийн дараа тэнгэрээс бууж ирэх хот бөгөөд Шинэ Иерусалим хэмээгдэх болно. (Илчлэл 21:2)

Дээд Иерусалим

Харин та нар Сион уул, амьд Бурханы хот, тэнгэрлэг Иерусалим уруу, баярын цугларалт дахь үй түмэн тэнгэрэлч нар, тэнгэрт бүртгэгдсэн анх төрөгсдийн чуулган, бүгдийн Шүүгч Бурхан болон төгс болгогдсон зөвт хүмүүсийн сүнс уруу ирсэн. Мөн шинэ гэрээний Зууч Есүс уруу болон Абелынхаас илүү дээр, ярьдаг, цацагдсан цус уруу ирсэн. (Еврей 12:22-24)

Тэнгэрийн Иерусалим буюу “Дээд Иерусалим” (Галат 4:26-аар үзнэ үү) нь манай Аффабелийн түүхэнд гарсан хот юм. Энэ хот нь Сион нэртэй уулан дээр баригдах бөгөөд тэнд Аав, Хүү, үй олон тэнгэрэлч нар аж төрөх юм. Тэнд бас ерөнхий чуулган ба анх төрөгсдийн чуулган Хуучин гэрээний ариун хүмүүсийн хамт болон Христийн нэвтрүүлсэн хүмүүсийн хамт байрлана.

Тэр хотод бас “зөвт хүмүүсийн сүнс төгс болгогдсон” гэж байгааг анхаараарай. Тэгвэл бичээч шагналдаа тэнцсэн Хуучин ба Шинэ гэрээний ариун хүмүүсийг аль хэдийнээ жагсааж хэлчихсэн тул эдгээр хүмүүс нь хэн бэ?

Бид Бурханы Сүнсээр дахин төрөөд, цоо шинэ бүтээл болсныг санаж байна уу? Сүнс маань Христтэй адил болон төгс болгогдсон бөгөөд бид Түүний дотор байгаа. Тус ишлэлд бичээч хүний бие, сэтгэлийн тухай яриагүй зөвхөн сүнсний тухай өгүүлжээ. Би л хувьдаа энэ нь газар дээр Есүсийн төлөө үйлчилж байгаа итгэгчдийн тухай ярьсан гэдэгт итгэдэг. Бодоод үз! Еврей номын бичээч биднийг “Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олж, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд зоримгоор очигдоо” (Еврей 4:16) хэмээн ятгажээ. Нигүүлслийн сэнтий нь Бурханы хотын төвд байрлах бөгөөд энэ урилгыг газар дээр байгаа бидэнд өгчээ. Яг одоо газар дээр байгаа олон хүн залбирлаараа сэнтийн өрөө рүү байнга нэвтэрдэг учраас, тэнд хэдийнээ танил болсон биш үү?

Бид бол сэтгэлтэй сүнснүүд. Сэтгэл гэдэг нь өдгөө маханд амьдарч байгаа оюун ухаан, хүсэл, мэдрэмжийн нэгдэл юм. Бурханд жинхэнээсээ мөргөн хүндэтгэх цорын ганц арга нь “сүнс ба үнэнээр” (Иохан 4:24) юм хэмээн Есүс айлдсан. Паул ч: “Хүүгийнх нь сайнмэдээнд сүнсээрээ миний үйлчилдэг Бурхан Өөрөө, та нарыг хэр их тасралтгүй дурсдагийн маань гэрч юм” (Ром 1:9) хэмээн цохон тэмдэглэсэн. Учир нь бидний сүнс Бурханы дүр төрхөөр бүтээгдээд, бид дахин төрсөн учраас, Бурханд мөргөн хүндэтгэх хэрэгцээ, хүсэлтэй цагтаа Есүсийн цусаар болон Ариун Сүнсний хүчээр Бурханы сэнтийн өрөө рүү нэвтрэх эрхтэй болсон юм.

Тэнгэрт зочилсон нь

Дээд Иерусалим нь яг одоо гурав дахь тэнгэрт байрлаж байгаа. Энэ нь элч Паул үхэхийнхээ өмнө зочлоод ирсэн бодит газар юм. Тэрбээр ийнхүү бичжээ:

Сайрхах нь ашиггүй ч, зайлшгүй байна. Учир нь би Эзэний үзэгдэл болон илчлэлүүдийн тухай хэлэх гэсэн юм. Би Христ

дотор нэгэн хүнийг мэднэ. Тэр арван дөрвөн жилийн өмнө гурав дахь тэнгэрт аваачигдсан юм. Бие дотроо юу эсвэл биеэсээ ангид уу гэдгийг нь би мэдэхгүй, Бурхан мэднэ. Би тийм хүнийг мэдэх ч, бие дотроо юу эсвэл биеэсээ ангид уу гэдгийг нь мэдэхгүй, харин Бурхан, диваажинд аваачигдсаныг нь болон хүний илэрхийлшгүй, хэлж боломгүй үгсийг сонссоныг нь мэднэ. (2Коринт 12:1-4)

Паул өөрийнхөө тухай ярьсан гэдэгтэй Библийн эрдэмтэд санал нийлдэг. Үнэндээ Шинэ гэрээний орчуулга дээр 2-аар ишлэлийг “Би Христ дотор нэгэн хүнийг мэднэ” хэмээн орчуулсан байна. Түүнчлэн Паул бие дотроо байсан уу эсвэл биеэсээ гарсан уу гэдгээ мэдээгүй ч, энэ тэнгэр нь жинхэнэ бодитой орших газар болохыг л хэлжээ. Олон хүн энэ газрыг хүмүүсийн сүнс дүүлэн нисч, умбан хөвдөг үл харагдах талбар гэж бодож явдгийг би мэднэ. Гэхдээ үгүй юм. Энэ нь гудамжтай, мододтой, ан амьтад байшин барилга, ус зэрэгтэй бодит газар юм.

Би яг л Паул шиг тэнгэрт очоод ирсэн хэд хэдэн хүнийг мэдэх юм. Гэхдээ хамгийн дуртай нэгэн түүхээ ярьмаар байна. Миний найз - пастор Грег 1979 оны 10-р сард үйлчлэлийнхээ анхны үдшээ дуусгаад гэртээ иртэл гэргий нь орилон уйлсаар, шатаараа мацаж байхыг үзээд, хэрэг бишдэнийг шууд ойлгожээ. Гэтэл түүний арван настай хүү Жастин нь усанд орж байхдаа хөл бөмбөг үзэхээр залгасан байсан жижиг зурагтаа санаандгүй татаж, устай онгоцондоо унагаад, тогонд цохиулчихсан байв.

Грег хүү дээрээ ортол, хүү нь ямар ч судасны цохилтгүй, бие нь хөрөөд хөхөрчихсөн, тархи нь ажиллагаагүй болсныг илтгэн хүүхэн хараа нь томорчихсон байжээ. Грег Лос Анжелесийн цагдаагийн газар орлогч даргаар ажиллаж байхдаа олон үхэл хагацалтай тулгарч байсан бөгөөд анхны түргэн тусламж үзүүлэхийг сурсан юмсанж. Хэрэв тэр зүгээр л цагдаа байсан бол, шууд л хохирогчийг үхсэн гэж мэдэгдээд, хүн амины хэрэг хариуцсан байцаагчийг дуудах байж.

Гэхдээ Грег залбирлын хүчинд итгэдэг байв. Тэрбээр залбирч, хүүдээ хиймэл амьсгаа хийж эхлэжээ. Хэдэн минутын дараа түргэн тусламж ирж, Грег эмнэлгийн ажлыг нь эмч нарт үлдээгээд өөрөө үргэлжлүүлэн залбирав. Тэд Жастиныг сэхээн амьдруулах гэж дөчин таван минут оролдсон нь ямар ч ахиц гарсангүй.

Зүрхний хэмнэл хэмждэг машины дэлгэц дээр шулуун зураас л гарсаар байв. Эмч нар аргаа баран, бууж өгөхдөө тулжээ.

Тэгтэл Грег: “Аав аа, надад одоо ямар ч итгэл алга. Миний итгэл цуцлаа. Гэхдээ Таны Үг өөр нэгэн итгэлийн тухай ярьдгийг би мэднэ” гэжээ. (Тэрбээр 1Коринт 12:9 дээр хэлсэн итгэлийн бэлэгийн тухай ярьж байлаа)

Гэтэл түүний толгой дээр нэг гар буух шиг мэдрэмж төржээ. Тэгмэгц сүнс дотор нь асар том эрх мэдэл, хүч босохыг тэрбээр мэдрээд хүү рүүгээ: “Есүсийн нэрээр чи үхэхгүй, харин амьдарна” гэж хашхирчээ.

Гэтэл гэнэт зүрхний хэмнэл хэмждэг машины дохио дуугаран, дэлгэц дээр нь цохилтын хөдөлгөөн гарч ирэв. Эмч нар ч бөөн баяр болон цовхчив. Тэд Жастиныг шатаар буулган, түргэний машин руу оруулахад, хүү хөх биш ягаан болж, нүд нь хэвийн, бие нь дулаацаж эхлэжээ.

Хүү нь амьд сэрүүн байгаад Грег ч уужрав. Түүнчлэн тэрбээр Бурхан юу хийснийг гэрчлэх гайхамшигтай түүхтэй болжээ. Гэхдээ тэрбээр хүүгийнх нь төлөөх тулаан дөнгөж эхлэж байсныг мэдээгүй байв.

Эмч нар хүүг комд орсон гэжээ. Нарийн шинжилгээний дараа катетерээр бөөрний эд нь шүүрч байгааг мэджээ. Өөрөөр хэлбэл бие нь хайлсан байв. Тэгээд эмч нар хүүг амьдарлаа ч, зүгээр л “ургамал” болж, нийгмийн амьдрал нь 0.01 хувийн IQ - тай гурван сартай хүүхдийнх шиг л байна гэжээ.

Гэхдээ гэр бүл нь бууж өгөхөөс татгалзан, долоон сар тулалдсны эцэст Жастин комоос сэрэв. Түүнийг сэрэх үед аав нь хажууд нь байж таараад, хүүгээ бөөн асуултаар бөмбөгдтөл, хүү нь шууд шууд хариулжээ. Жастин дунд сургуулиа дүүргэж, дараа нь Калифорнийн Их Сургууль, Библийн сургуулийг онцсайн төгссөн юм. Хүү дунд сургуульдаа ангийн дарга хүртэл хийж байсан бөгөөд өнөөдөр гэргий, хоёр хүүхэдтэйгээ аз жаргалтай амьдарч яваа.

“Аав аа, би Есүстэй хамт байсан”

Хүүгээ эмнэлгээс гараад гурав хоносны дараа Грег хүүгийнх нь царай гэрэлтэж байхыг үзээд: “Миний хүү, юу болоов?” гэтэл Жастин:

“Аав аа, би Есүстэй хамт байсан. Зурагт усанд унахад би юу ч мэдрээгүй. Маш том тэнгэрэлч миний баруун гараас бариад, биеэс минь татаад гаргачихсан. Бид нэг нүхэн гарцаар аймаар хурдтай ниссэн. Тэгээд гэрлийн хурдаар ниссээр ниссээр, тэнгэрийн нэг гудамжинд буусан” гэжээ.

Тэгээд Жастин аавдаа тэнгэрийн гудмууд нь алтан - бүр нэвт харагдахуйц, тув тунгалаг шижир алтан байсныг ярьжээ. Тэнгэрт байдаг шиг шижир алт дэлхий дээр байхгүй.

Жастин бас тэнгэрийн гудамжинд түүнийг хамгийн түрүүнд угтаж уулзсан хүмүүс нь тэдний өөд болсон хамаатнууд байсныг хэлжээ. Жастин тэдний заримтай нь хэзээ ч уулзаж байгаагүй боловч, бүгдийнх нь нэрийг хэлжээ. (Харин аав, ээж нь бол мэдэж байжээ) Түүнчлэн түүнтэй уулзсан хүмүүсийн дунд Филис гэдэг нэгэн эмэгтэй байв. Филис тэдний хөрш байсан бөгөөд Жастины ээж нь хүүгээ тогонд цохиулахаас сарын өмнө Филипсийг Есүст итгэхэд нь хамт залбирсан бөгөөд Филипс Есүст итгээд сарын дараа өөд болсон юмсанж.

Жастиныг хүмүүстэй ярилцаж байтал, гэнэт хөлийн чимээ гарч, түүнийг бүчиж байсан хүмүүс хоёр тийшээ болтол, урд нь Есүс зогсож байжээ.

Эзэн Жастиныг тэнгэрээр аялуулав. Тэр хот маш олон гудамж, байшинтай үнэхээр том хот ажээ. Цэцэгс, өвс ногоо, чулууд нь бүгд амьд бөгөөд яг л Бурханыг магтах мэт хослон дуулж байсныг Жастин ярьжээ. Цэцэг, өвсөн дээр нь гишгэлээ ч хөлд дарагдахгүй, тэр даруй буцаад л хэвэндээ орчихно. Өнгө нь ч дэлхий дээр хэзээ ч үзээгүй амьд бөгөөд тансаг ажээ. Түүнчлэн Жастин ээжийнхээ аавын бас хоёр хамаатныхаа харшийг очиж үзжээ.

Тэгж байтал Есүс түүнийг одоо буцах хэрэгтэй гэж хэлсэнд Жастин цочирдов. Жастин явахыг хүсээгүй тул Есүс түүнийг нэгэн газар авчраад, хөшгийг нь ярьжээ. Гэтэл аав нь түүнийг эргээд ир хэмээн дуудаж байхыг Жастин үзэв. Есүс Жастинд: “Тэр чиний аав учраас чамайг буцааж дуудах эрх мэдэлтэй” хэмээн айлджээ.

Түүнээс хойш Жастин аавдаа хэрэв түүнийг дахиад үхбэл, битгий дуудаарай гэж захисан тухай Грег надад ярьж билээ. Грегийн энэ түүх намайг үнэхээр баясгасан юм. Тэнгэр нь газартай зүйрлэшгүй сайхан учраас, тэнд очсон хүн бүр буцаж ирэх дургүй байдгийг би олонтаа сонссон.

Паул ч бас тийнхүү зөрчилдсөндөө, Филиппой 1:23 дээр: “Би хоёр талаас шахагдаж байна. Эндээс одож, Христтэй хамт байхыг хүсэж байна. Энэ нь хол дээр юм” гэж бичжээ. Зүгээр нэг дээр биш, харин эгнэшгүй дээр! Паул Бурханы хотод байхыг хүсэв ч, хаанчлалын төлөө газар дээр үлдэхийг сонгожээ.

Жастин бас тэнгэрт очихдоо арван настай хүү биш, насанд хүрсэн эр хүн болсон байснаа аавдаа ярьжээ. Жастинаас гадна олон хүн биднийг сүр жавхлантай биетэй болохдоо бүгдээрээ гучин гурван настай байна гэж итгэдэг. Есүс Өөрөө гучин гурван насандаа цовдлуулсан учраас, үүнийг үгүйсгэхийн аргагүй юм. Учир нь бичээс: “Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь хараахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ” (1Иохан 3:2) гэдэг.

Энэ бол миний мэдэх олон түүхийн нэг. Тэнгэр бол бодитой газар гэдгийг бичээс ч, хүмүүсийн түүх ч батладаг. Есүсийн итгэмжтэй зарц нар энэ газраас явахдаа тэр хотод очно.

Сүнс, сэтгэл, биеийн аврал

Есүсийг Эзэнээ болгон хүлээж авах эгшинд хүмүүсийн сүнс цоо шинэ бүтээл болдгийг өмнө хэлсэн. Эгшин зуур л Есүстэй адилхан болж хувирдаг. Үүнийг элч Иохан ч мэдэгдсэн: “Үүгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг.” (1Иохан 4:17) Иохан шагналаа авахаар хэдийнээ явчихсан итгэгчдийн талаар биш, харин газар дээр байгаа итгэгчдийн талаар ярьж байгааг харав уу? Бурханы Сүнсээр жинхэнээсээ дахин төрсөн хүн яг одоо энд сүнсээр төгс болгогддог.

Сүнс маань нэгэнт аврагдсан бол, сэтгэл аврагдах үйл явц эхлэнэ. Сэтгэл гэдэг нь оюун ухаан, хүсэл, мэдрэмжийн нэгдэл гэдгийг өмнө хэлсэн. Бидний сэтгэл Бурханы Үгээр хийгээд Бурханы Үгд дуулгавартай хандах хандлагаар маань аврагдаж, өөрчлөгддөг. Элч Иаков: “Хайрт ах дүү нар минь, үүнийг мэдэгтүн. Хүн бүр сонсохдоо түргэн, ярихдаа удаан, уур хилэнд хойрго байг. ...Тиймээс та нар бүх бузар байдал, хорон санааныхаа хамаг л үлдэгдлийг хаяж, дотор чинь суулгагдсан, сэтгэлийг чинь аврах чадалтай үгийг дөлгөөхнөөр хүлээж авагтун. Гэхдээ өөрсдийгөө

хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг” (Иаков 1:19, 21-22) гэж хэлэхдээ, үүнийг баталгаажуулжээ. Сэтгэлийн авралын тухайд Иаков үл итгэгч биш, итгэгч хүмүүст хандаж өгүүлснийг заавал онцлох ёстой. Тэрбээр Үгийг сонсож бас дуулгавартай хэрэгжүүлэхийг цохон тэмдэглэжээ.

Сэтгэл нь хүн авралынхаа хэм хэмжээг өөрөө шийдэж чадах цорын ганц хэсэг юм. Бид Бурханы Үгийг сонсож, дагахад Бурхантай гар нийлж, энэ маань эргээд бидний сэтгэлийн авралын үйл явцыг түргэсгэдэг бол, Бурханы Үгийг үл тоох явдал нь авралын үйл явцыг маань сааруулдаг. Сэтгэлийн өөрчлөлт нь итгэгч биднийг бариандаа сайн ороход амин чухал буюу.

Эцэст нь бидний аврагдах ёстой хамгийн сүүлийн хэсэг нь бие юм. Энэ талаар Паулын хэлсэн үгийг анхааралтай үзнэ үү:

“Учир нь газар дахь гэр болох майхан маань нурах аваас бидэнд гараар баригдаагүй, тэнгэрт мөнх байх, Бурханы барилга буйг бид мэддэг. Тэнгэрийн орон гэрээ өмсөхийг хүсэмжлэн, энд бид гасалцгаадаг. Бид хувцасласан байх аваас нүцгэнээр олдохгүй. Учир нь бид майхандаа байхдаа дарамтлагдан гасалдаг. Учир нь үхдэг нь амиар залигдахын тулд бид тайлахыг бус, өмсөхийг хүсдэг юм. Эдүгээ биднийг чухам энэхүү зүйлд бэлдсэн нь бидэнд Сүнсийг барьцаанд өгсөн Бурхан юм. Тиймээс бид үргэлж урамтай байдаг бөгөөд бие дотроо суухдаа Эзэнээс хол буйгаа мэддэг. Учир нь бид үзэгдэх зүйлсээр бус, харин итгэлээр алхдаг. Бид урамтай байдаг бөгөөд биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг.” (2Коринт 5:1-8)

Эдгээр үг нь биднийг үлэмж найдвараар цэлмүүлж, сэтгэлийг маань цэвэршүүлж байна. Биднийг мөнхийн биетэй болно гэдгийг Паул цухас дурьдаад өнгөрөөгүй, харин тогтон ярьжээ. Паул бас: “Учир нь муудах нь үл муудахыг өмсөх ёстой бөгөөд үхдэг нь үхэшгүйг өмсөх ёстой” (1Коринт 15:53); Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалтай нь ч адил байдалд холбогдох болно (Ром 6:5); Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь харахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ” (1Иохан 3:2) хэмээн тус тус хэлсэн байдаг.

Есүс үхлээс амилуулагдсныхаа дараа ямар биетэй байлаа?

Бидний бие аврагдахдаа яг л тийм болно. Түүнийг амилсан өглөө булшны дэргэд болсон явдлыг үзье. Булш хоосон байхыг хамгийн түрүүнд Магдалын Мариа мэдээд, Эзэнийхээ биеийг хулгайд алдчихлаа хэмээн гашууддаг.

Тэр ингэж хэлээд эргэж харахдаа Есүсийг харсан боловч таниагүй юм. Есүс түүнээс —Эмэгтэй, чи юунд уйлна вэ? Чи хэнийг хайна вэ? гэж асуув. Түүнийг цэцэрлэгч байна гэж бодоод тэр Түүнд —Эзэн, хэрэв та Түүнийг зөөсөн бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв.
(Иохан 20:14-15)

Есүс жирийн хүнээс ялгараагүй. Тэр зөгнөлт киноны харь гаригийн гийчин шиг харагдаагүй. Гэхдээ Мариа Есүсийг амьд гэдэгт итгэж зүрхлээгүй учраас, таниагүй юм. Учир нь Мариа Есүсийг харгис хэрцгийгээр алуулж, дараа нь оршуулагдахыг нүдээр үзсэн. Тиймээс Мариа Есүсийг өөртэй нь ярихад танилгүй, цэцэрлэгчтэй эндүүрчээ.

Есүс зүгээр л хүн биетэй байсан. Гэхдээ Мариа зүгээр сүнс харчихсан уу эсвэл Есүс яг бодитой биетэй байсан уу? Хожим Есүс дагалдагч нартаа үзэгдэх үедээ энэ асуултад бат хариулдаг. Есүс дагалдагч нартаа:

“Та нар юунд сандарч, зүрхэнд чинь эргэлзээ төрнө вэ?
Миний гар, Миний хөлийг хараач. Энэ чинь Би Өөрөө байна.
Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа
Над шиг яс, мах байдаггүй юм” (Лук 24:38-39) гэсэн байдаг.

Есүс яс, махтай байж! Тиймээс бид ч яс, махтай байна. Гэхдээ Есүс цусны талаар хэлээгүй байгааг анзаарав уу? Учир нь Түүний цус Бурханы өршөөлийн суудал дээр цацагдсан юм. Тиймээс би л хувьдаа өдгөө Түүний судсаар Бурханы сүр жавхланта амь урсаж байгаа гэдэгт итгэдэг.

Есүс мөн хоол идсэн. “Тэд баярлан гайхсандаа итгэж ядан байхад нь Есүс тэднээс —Та нарт идэх юм байна уу? гэж асуухад, тэд хэсэг хайрсан загас Түүнд өгөв. Тэр загасыг авч, тэдний өмнө иджээ.” (Лук 24:41-43)

Есүс дагалдагч нарынхаа дэргэд нэг удаа бус, харин дахин хоёр

удаа идэж уусан тухай гардаг. Эхнийх нь Эммау руу явах замдаа таарсан эрчүүдийн гэрт идсэн бол, нөгөөх нь Тэрбээр далайн эрэг дээр 11 дагалдагчдаа өглөөний ундыг нь бэлтгэж өгөх үедээ идсэн юм. Тиймээс бид мөнхийн биедээ идэж уух нь байна.

Есүс сүр жавхланта биедээ яг л жирийн хүн шиг ярьж, дуулж, явж, барьсан ч, нөгөөтэйгүүр бас хана нэвтлэж, нүр ирмэхийн зуур алга болж чадсан!

Та: “Тэр яс махтай атлаа хана нэвтлэж, нүд ирмэхийн зуур алга болсон гэж үү?” хэмээн асуубал, би танд “Яг тийм” гэж хариулна.

“Долоо хоногийн эхний өдөр тэр өдрийн үдэш, шавь нар нь иудейчүүдээс айснаас үүдээ түгжсэн байв. Есүс ирээд тэдний дунд зогсож, тэдэнд —Амар амгалан та нарт байх болтугай гэв.” (Иохан 20:19)

Есүс Томасаас Өөрийнх нь гар, хавиргыг барьж үзэхийг хүссэн. Тэгэхээр Есүс яахын аргагүй яс, биетэй байжээ. Хаалга хаалттай байхад, Есүс яаж дагалдагч нарынхаа дунд гэнэт гарч ирэв? Зүгээр л хана нэвтлэж орж ирээд, яг л түүн шигээ гэнэт алга болчихсон. Эммау хүрэх замдаа Есүстэй таарсан эрчүүд Түүнтэй талх хувааж идэхдээ “...тэдний нүд нээгдэж, Түүнийг танив. Есүс нүдэнд нь харагдахгүй алга болжээ.” (Лук 24:31)

Бид ч бас амилуулагдсан биедээ алга болоод өөр газар гарч ирж чаддаг болно. Шинэ тэнгэр, шинэ газарт бид ийм аргаар л хол газрыг туулдаг болох нь. Ингэж чаддаг байхаас өөр аргагүй. Учир нь бусад галактик руу аялах тухай ярилгүй, зөвхөн Бурханы хотын тухай л ярихад, энэ хот нь уртаашаа бас өргөөшөө 2254 км юм. Есүс мөн дагалдагч нартайгаа дөч хоног хамт байгаад дараа нь тэнгэр өөд өргөгдсөн шиг, бид ч бас агаарт дүүлж чаддаг болно. Жастин болон тэнгэрт очоод ирсэн өөр олон хүний хэлснээр хүн алхаж, хөвж бас нүд ирмэхийн зуур өөр газар шилжиж чаддаг болох ажээ. Жастин Есүстэй аялж байхдаа заримдаа зүгээр алхсан бол, заримдаа аль нэг газар руу чөлөөт нислэг хийж, хөвжээ.

Христийн мянган жилийн хаанчлал

Бид Бурханы хотын нүүлгэн шилжилтийг анхаарах ёстой. Гэхдээ эхлээд үүнээс өмнөх үйл явдлыг үзье. Чуулганы эрин үеийн төгсгөлд долоон жилийн их зовлон болно. Хууль ёсгүй хүн

буюу антихрист илчлэгдэн гарч ирээд, олон хүнийг мэхлэнэ. Тэр өөрийгөө Бурханаас дээр өргөмжилж, олныг өөртөө мөргүүлнэ. Тэр ариун хүмүүсийг хавчиж, олон үндэстэн Бурханы эсрэг харанхуйлан тэрслэнэ.

Энэ үеэр Эзэн ариун хүмүүсийнхээ төлөө ирнэ. Энэ явдал 7 жилийн өмнө, дундуур, төгсгөлд болно гэж хүмүүс янз янзаар итгэдэг. Харин би энэ тухай ярихгүй. Учир нь хэзээ болох нь чухал биш, харин бэлэн байх нь л чухал юм.

Паул чуулганы “шүүрэлтийн” талаар Шинэ гэрээнд хэд хэдэн удаа ярьсан байдаг. Жишээлбэл:

“Учир нь, Эзэн Өөрөө тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу ба Бурханы бүрээнээр тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христ дотор үхэгсэд эхлээд амилна. Дараа нь амьд үлдсэн бид тэдэнтэй хамт агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.” (1Тесалоник 4:16-17)

Энэ бол Христийн хоёр дахь ирэлт биш юм. Учир нь энд Христ дэлхий дээр ирэлгүй, харин үүлэн дунд итгэмжтэй хүмүүстэйгээ уулзаж байна. Хоёр дахь ирэлт нь 7 жилийн зовлонгийн төгсгөлд Есүс цагаан морио хөлөглөөд, үй олон ариун хүмүүсээ багтаасан тэнгэрийн их цэргээ удирдаад ирэх үед л болно. (Иуда 14-ийг үзнэ үү)

Антихрист, хуурамч эш үзүүлэгч, дэлхийн удирдагч нар, үндэстнүүдийн цэргүүд Эзэнтэй хийгээд Түүний их цэрэгтэй дайн хийхээр босно. Есүс тэднийг ганц өдрийн дотор илдээрээ хөнөөгөөд, тэнгэрийн шувууд тэдний махыг иднэ. Үүнийг Кармел уулаас Иерусалимын зүүн өмнө зүг рүү сунасан Мегиддо талын хаа нэгтээ болох Армагеддон тулаан гэдэг. (Илчлэл 16:16; 19:11-21)

Энэ тулааны үеэр антихристтэй нийлж Эзэний өөдөөс босохгүй маш олон хүн дэлхий даяар байна. Эдгээр хүмүүс амьд үлдэхээр барахгүй, дараагийн үе буюу Христийн мянган жилийн хаанчлалд аж төрнө гэж маш олон теологичид үздэг. Тэд улс улсаа үлдэж, Христийн даяар хаанчлалд захирагдах болно. Тэд жирийн л биетэй байж, үржин олширч газар дэлхийг дүүргэсээр байна.

Үндсэндээ зовлонгийн он жилүүдийн дараа газар дээр хоёр төрлийн хүмүүс суурьших ажээ: Армагеддон тулаанаас амьд үлдсэн хүмүүс болон Есүстэй хамт эргэж ирсэн ариун хүмүүс. Ариун хүмүүс Хаан Есүстэй адил сүр жавхлантай биетэй байх бөгөөд

газар дээр Түүнтэй хамт захирах ажээ. Энэ хоёр бүлэг хүмүүс яаж хоорондоо харилцахыг ойлгож ядах юмгүй. Яг л Есүс амилсныхаа дараа дагалдагч нартайгаа харилцаж байсан шиг л харилцана. Сүр жавхлантай ариун хүмүүс нь жирийн хүмүүстэйгээ ярьж, явж, идэж, ууж нөхөрлөнө.

Энэ үеэр Сатан ба түүний хамсаатнууд мянган жилийн турш хүлэгдэх учраас, дэлхий даяар буюу үнэндээ ертөнц даяар энх тайван тогтохыг Бичээс хэлсэн. Тэр үед бүх үндэстэн бөөн бөөнөөрө Бурхан руу эргэх учраас ямар ч дайн, буруу шүүлт, үзэн ядалт, ичгүүр, гэмт хэрэг, өвчин зэрэг нь байхгүй байна. Эш үзүүлэгч Мика энэ тухай бичжээ:

“Эцсийн өдрүүдэд ЭЗЭНий өргөөний уул нь Уулсын тэргүүнээр тохоогдон, Толгодын дээгүүр өргөгдөнө. Ард түмнүүд түүнд цутгана. Олон үндэстэн ирээд, “Ирцгээ, ЭЗЭНий уул, Иаковын Бурханы өргөө уруу явцгаая. Тийнхүү Тэрээр бидэнд замаа зааж, Бид жимээр нь алхах юм” гэгцээнэ. Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭНий үг Иерусалимаас гарна. Олон ард түмний хоорондохыг Тэр шүүж, Хүчирхэг, холын үндэстнүүдийн дунд шийдвэр гаргах болно. Тэгээд тэд илдээ анжисны хошуу, Жадаа хадуур болгон давтана. Үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй, Дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй. Хүн бүр усан үзмийн ба инжрийн модныхоо дор сууна. Хэн ч тэднийг үл айлгана. Учир нь түг түмдийн ЭЗЭНий ам айлдав.” (Мика 4:1-4)

Улс үндэстнүүд Бурханы хуулиар амьдрах учраас, даян дэлхий цэцэглэн хөгжиж, санхүүгийн аюулгүй систем тогтоно. Гайхамшигтай цаг ажээ!

Аугаа их цагаан сэнтийн шүүх

Мянган жилийн төгсгөлд Сатан шоронгоос түр суллагдана. Түүнд явж, үндэстнүүдийг мэхлэх зөвшөөрөл олгогдоно. Үүнд сүр жавхлантай биетэй ариун хүмүүс багтахгүй, зөвхөн Армагеддоныг давж гараад, Мянганы хаанчлалын үеэр улс үндэстэнд төрж үржсэн, жирийн биетэй хүмүүс багтана.

Урван тэрслэгчид нэгдэн нийлээд, дайн хийхээр Иерусалимыг бүслэхэд, тэнгэрээс Бурханы гал бууж, тэднийг устгана. Диавол

“хүхэрт ба галт нууранд хаягдан” мөнхийн мөнхөд өдөр шөнөгүй тарчилна. Тэр дахиж хэзээ ч суллагдахгүй.” (Илчлэл 20:7-10)

Үүний дараа шууд Аугаа их цагаан сэнтийн шүүх болно. Хайдас Адамын үеэс эцсийн тулаан хүртэлх үе үеийн үхэгсдийг гаргаж өгнө. Бие даагч, Мэхлэгдэгч, Бүрэг, Дүр эсгэгчийн нэгэн адил Хуучин гэрээний цагт Иехувагийн гэрээнд ороогүй бүхэн, Есүсийн эзэний эрх мэдэлд захирагдаагүй бүхэн Хааны өмнө зогсож, тайлангаа тавьж, шүүгдэнэ. Амийн номд нэр нь бичигдээгүй бүхэн Сатантай болон түүний хамсаатнуудтай хамт Галт нуурт хаягдана.

Шинэ тэнгэр, шинэ газар

Урьдын тэнгэр, газар галаар цэвэрлэгдэхэд (2Петр 3:10-13-ыг үзнэ үү), шинэ тэнгэр, шинэ газар бий болно. Элч Иохан “Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож, тэнгис үгүй болов” гэж бичсэн байдаг. (Илчлэл 21:1)

Дараа нь тэрбээр газар дээр мөнхөд тогтохоор тэнгэрээс бууж ирэх шинэ Иерусалимыг дүрслэн хэлжээ. Энэ хотыг Адамаас авахуулаад Христийн хоёр дахь ирэлтээр алдрыг хүлээн авсан, Эзэний төлөөсөөр олдсон хүмүүс дүүргэх учраас, Хурганы гэргий буюу сүйт бүсгүй гэжээ. Иохан Шинэ Иерусалимыг ерөнхийд нь ингэж дүрслэсэн байна:

“Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр Сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ. Түүнд Бурханы алдар байлаа. Гялбаа нь үнэт чулуу мэт бөгөөд болор мэт тунгалаг, хаш чулуу шиг байв. Тэр нь асар том өндөр хэрэмтэй бөгөөд арван хоёр хаалгатай, хаалганууд дээр нь арван хоёр тэнгэрэлч байлаа. Тэдгээрийн дээр Израилийн хөвгүүдийн арван хоёр овгийн нэрс бичигдсэн байв. Зүүн талд нь гурван хаалга, хойд талд нь гурван хаалга, өмнө талд нь гурван хаалга, баруун талд нь гурван хаалга байх аж. Хотын хэрэм нь арван хоёр суурьтай агаад тэдгээрийн дээр Хурганы арван хоёр элчийн арван хоёр нэрс байлаа. Надтай ярьсан тэнгэрэлчид хот болон хаалгануудыг, мөн хэрмийг нь хэмжих алтан шугам байв. Хот нь дөрвөлжин бөгөөд урт нь өргөнтэйгөө адил аж. Тэнгэрэлч хотыг шугамаараа хэмжихэд урт, өргөн,

өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байлаа. Тэнгэрэлч хотын хэрмийг хүний хэмжээсээр хэмжихэд зуун дөчин дөрвөн тохой болов. Хэрмийг хаш чулуугаар хийсэн бөгөөд хот нь шил мэт тунгалаг шижир алт ажээ. Хотын хэрмийн сууриуд нь төрөл бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэгджээ. Эхний суурь нь хаш, хоёр дахь нь индранил, гурав дахь нь гартаам, дөрөв дэх нь маргад, тав дахь нь мамгартаам, зургаа дахь нь нал, долоо дахь нь хашиг, найм дахь нь биндэръяа, ес дэх нь молор, арав дахь нь мана, арван нэг дэх нь оюу, арван хоёр дахь нь ягаан болор байв. Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэгбүр нь нэг цул сувд байсан бөгөөд хотын гудамж нь шил мэт тунгалаг шижир алт байв.” (Илчлэл 21:10-21)

Энэ бол дэлхийд урьд хожид үзэгдээгүй, биширч алмайрмаар баян, тансаг, гэрэлт хот ажээ. Цэврийн цэвэр тэр хотод ширхэг ч завхрал оршихгүй.

“Тэр надад Бурханы болон Хурганы сэнтийнээс гарах болор мэт гялалзсан, амийн усны голыг үзүүлсэн нь гудамж дундуур урсаж байв. Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байв. Тэнд цаашид ямар ч хараал байхгүй болно. Мөн Бурхан ба Хурганы сэнтий тэнд байж, зарц нар нь Түүнд үйлчилнэ. Тэд Түүний царайг харна. Түүний нэр тэдний духан дээр байх болно. Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд дэнгийн гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй болно. Тэгээд тэд үеийн үед хаанчилна.” (Илчлэл 22:1-5)

Бид Бурханы царайг үзнэ гэдгийг Бичээс маш тодорхой хэлснийг тэмдэглэнэ үү. Мосегийн хүсэн тэмүүлсэн ч, үзэж чадаагүйг бид үзэх нь байна. Юутай хосгүй завшаан бэ!

Түүнчлэн амийн модны навчис нь улс үндэстнүүдэд эдгэрэл авчирна гэсэн байгааг анхаарна уу. Үүнээс маш сонирхолтой асуулт ургана. Тэр хотод ариун хүмүүс оршин суух тул хэн улс үндэстнүүдийг бүрдүүлэх вэ? Мөнхийн мөнхөд амьдрах ариун хүмүүс нь хэн бэ? Энэ үед жирийн биетэй хүмүүс бас байх юм уу? Тэгвэл үүнд Исаиа хариулжээ:

“Харагтун, Би шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээнэ. Урьдын юмс санагдахгүй, бодол санаанд ч буухгүй. Харин Миний бүтээх зүйлд үүрд баярлан баясагтун. Харагтун, Би баяр хөөрийн төлөө Иерусалимыг, Баяслын төлөө ард түмнийг нь бүтээнэ. Би Иерусалимд мөн баярлан ард түмэндээ баясна. Тэгээд тэнд уйлах, орилох дуу цаашид сонсогдохгүй.” (Исаиа 65:17-19)

Харин дараа нь Исаиа Шинэ Иерусалимын гаднах хүмүүсийн тухай өгүүлжээ:

Тэнд цөөн хоногтой нялхас ч, Өдрүүдээ гүйцээгээгүй ахмад хүн ч байхгүй. Зуу наslaад үхсэнийг нь залуугаараа гэж үзнэ Зуу хүрээд үрэгдсэн нь нүгэлтэн гэж тооцогдоно. Тэд гэр барьж, түүн дотроо сууна. Тэд бас усан үзэм тариалж, үр жимсийг нь иднэ. Бусдыг суулгах гэж тэд барихгүй. Бусдад идүүлэх гэж тэд тарихгүй. Харин ард түмний минь өдрүүд модны нас шиг боллоо Сонгосон хүмүүс минь Гарынхаа бүтээлийг удаан эдэлнэ. Тэд дэмий хоосон ажиллахгүй, Зовлонгийн төлөө хүүхэд төрүүлэхгүй. Учир нь тэд ба хойч үе нь ЭЗЭНээр ерөөгдсөн хүмүүсийн үр удам билээ. Тэднийг дуудахаас өмнө Би хариулж, тэднийг ярьж байхад нь Би сонсох цаг ирнэ. Чоно хургатай хамт бэлчин арслан үхэр мэт сүрэл идэх бөгөөд шороо нь могойн хоол болно. Бүх ариун ууланд минь тэд ямар ч муу, хор хөнөөл үйлдэхгүй” гэж ЭЗЭН айлдаж байна.” (Исаиа 65:20-25)

Олон хүн энэ хэсгийг Христийн мянган жилийн хаанчлалын үе гэж ташаа үздэг. Гэвч энд шинэ тэнгэр, шинэ газрын тухай яригдаж байгаа нь тодорхой байна. Элч Иохан, Исаиа хоёрын бичээсийг аль алийг нь шалгаж үзэх юм бол, тэр үеэр хотын гадна хүмүүс аж төрөн суухыг харж болно. Тэд ертөнцийн амар амгалан, хөгжил цэцэглэлийн үеэр өөр өөрсдийнхөө гэрийг барин аж төрөн суух ажээ. Тэд ариун хотод Есүсийн Өөрийн биеэр хэдийнээ бэлтгэсэн орд харшид аж төрөн суух ариун хүмүүс биш ажээ (Иохан 14:2-4-ийг үзнэ үү).

Тэдгээр хүмүүс үр хүүхэд төрүүлнэ гэснийг бас анхаарна уу. Энэ ч бас ариун хүмүүсийн хувьд боломжгүй юм. Учир нь сүр жавхлантай биетэй ариун хүмүүс гэрлэхгүй учраас, үр хүүхэд төрүүлэхгүй гэдгийг Есүс тодорхой хэлсэн.

“Амилалд тэд гэрлэх ч үгүй, нөхөрт ч гарахгүй, харин тэнгэр

дэх тэнгэрэлч нартай адил болох юм.” (Матай 22:30) Үүнийг Жастин ч тэнгэрийн аялалынхаа дараа батлан хэлсэн байдаг.

Тэдгээр үндэстнүүд шинэ газар дээр суурьшиж, газар тариалан, ургац, барилгажилтыг хөгжүүлнэ. Тэд Адам хийгээд түүний үр сад нүгэл үйлдээгүй байсан бол, үйлдэх байсан шиг ямар ч саадгүй үржин олширч, газрыг дүүргэнэ.

Энэ бүхнийг ямар логикоор тайлбарлах вэ? Нэг арга нь - мянган жилийн хаанчлал эхлэх үед бидний эцсийн дайсан үхэл устгагдах учраас (1Коринт 15:26), жирийн хүмүүсийн амьдрал уртсана гэсэн үзэл бодол явдаг. Есүс сүнслэг ба махан биеийн үхлийн хараалыг устгасан. Тиймээс энэ хүн төрөлхтөн магадгүй мянган жилийн хаанчлалыг туулж гарсан байж болох.

Мянган жилийн төгсгөлд жирийн биетэй хүмүүст түр суллагдсан Сатаныг дагаж, Бурханы өөдөөс тэрслэхгүй байх аваас, мөнх амьдрах энэ бэлэгийг батлан амласан байж болох. Тиймээс дуулаач “...Тиймээс ард түмнүүд өнө мөнхөд Таныг магтана” (Дуулал 45:17) гэсэн байх. Энэ таамаглалыг нэг аргаар тайлбарлаж болно: тэднийг Адам, Ева хоёрыг нүгэлд унахаас өмнө амьдарч байсантай адил хүмүүс гэж үзэж болох юм. Адам үхэхээр биш, харин мөнхөд амьдрахаар бүтээгдсэн. Тэр дуулгаваргүй зангаасаа болж л энэ бэлэгээ алдаж, угсаа дээрээ үхэл доройтлын хараалыг авчирсан юм.

Шинэ Иерусалимд гагцхүү Христийн авран сэргээсэн, сүр жавхлант биетэй хүмүүс л амьдран сууна. Гэхдээ жирийн биетэй хүмүүс ч тэр хотоор зугаалж, үр жимсээс нь хүртэж, Эзэнийг магтаж чадна гэдгийг Бичээс хэлсэн. Үүнийг Илчлэл 21:24-26 дээрх Иоханы бичвэрээс харж болно:

“Үндэстнүүд тэр гэрлээр алхацгааж, газрын хаад тийшээ алдраа авчирна. Хотын хаалганууд өдөр хэзээ ч хаагдахгүй. Учир нь тэнд шөнө гэж үгүй. Тэд үндэстнүүдийн алдар хүндэтгэлийг тийш авчирна.” (Илчлэл 21:24-26)

Эхэнд хүн нүглийн өдөөлтөд унаснаасаа болж сүнсээр болоод биеэр үхэж, эцэстээ мөнхөд үхэх шийтгэл хүлээсэн. Гэхдээ энэ алдаа нь хүнийг газар дээр амьдруулах гэсэн Бурханы анхдагч мөнхийн төлөвлөгөөг устгаагүй юм.

Хүний дуулгаваргүй байдлаас болж Бурхан Өөрийнхөө дизайныг бүр мөсөн устгах гэж үү? Үгүй. Бурхан хүний ялагдлыг Христийн аврал сэргээлтээр ерөөл болгон хувиргаж, нүгэлд унасан хүн төрөлхтнийг эцэстээ шинэ газар дээр хүн төрөлхтнийг захирах сүр жавхлантай тэнгэрлэг хүмүүс болгожээ. Энэ нь бидэнд Есүсийн: “Сайн байна, сайн зарц минь. Чи маш бага юманд итгэмжтэй байсан тул арван хот захирах эрх мэдэлтэй боллоо” (Лук 19:17) гэсэн үгийг ойлгуулж байгаа юм. Эдгээр нь Мянган жилийн хаанчлалын үеийн бөгөөд шинэ газрын мөнхийн эрин үеийн хотууд байж болох биш үү?

Хүн нүгэлд унаагүй байсан бол, Бурхан газрын хэрэг явдлыг мөнхийн мөнхөд хамтран захирах ажилдаа туслуулахаар сүр жавхлантай бүлэг хүмүүсийг гаргаж ирэхгүй байх байсан. Тэр үүнийг мөнхийн цэц ухаанаар урьдчилан харсан бөгөөд энэ шалтгаанаар Есүсийг “Дэлхийн сууриас эхлэн Алагдсан хурга” (Илчлэл 13:8) хэмээн цоллосон буюу.

Мянган жилийн хаанчлал, шинэ газрын мөнхийн эрин үе эхлэсний дараа “мөнхөд амьдрах жирийн хүмүүсээр дэлхийг дүүргэх” Бурханы анхдагч зорилго биелэх болно. Есүсийн “Таны хаанчлал ирэг. Тэнгэрт шигээ газар дээр биелэх болтугай” (Матай 6:10) гэсэн үг төгс биелэх юм. Тэнгэрт Жастины харсан шинэ өнгө, Бурханыг магтдаг амьд ургамал, хадад, төгс архитектур, амьд ус зэрэг нь бүгд газар дээр байна. Үнэхээрийн төгс дэлхий байна!

Исаиа энэхүү шинэ газрын эрин цагийн талаарх үгээрээ эш үзүүлгийн номоо өндөрлөжээ:

“Миний бүтээх шинэ тэнгэр, шинэ газар Миний өмнө зогсох мэт Та нарын үр удам ба нэр чинь ч зогсоно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Шинэ сараас шинэ сар хүртэл, Амралтын өдрөөс Амралтын өдөр хүртэл Бүх махбод Миний өмнө мөргөхөөр ирнэ” гэж ЭЗЭН айлдаж байна. “Дараа нь тэд гарч ирж, Намайг эсэргүүцэгч хүмүүсийн хүүрийг үзнэ. Учир нь өт хорхой нь үхэхгүй, гал нь унтрахгүй. Тэд бүх махбодод жигшил болно.” (Исаиа 66:22-24)

Хэдийгээр аймаар боловч, бид мөнхийн мөнхөд нэг газар очоод, Сатаныг болон түүний тэнгэрэлч нарын бас Эзэний өөдөөс тэрслэсэн хүн төрөлхтний аймшигт хувь тавиланг харах

боломжтой байна. Магадгүй энэ нь бүх бүтээлд нүгэл, тэрслэлийн аймшигт үр дагаварыг байнга сануулах гэсэн Бурханы цэц ухаан ч байж болох. Бодоод үз: Сатаныг хэн ч өдөөгүй байхад тэр тэрслэсэн. Тиймээс хэрэв Бурхан энэ үзэгдлийг бүх бүтээлийнхээ өмнө мөнхийн мөнхөд үзүүлэн болгобол, Люцифер болоод түүний тэнгэрэлч нарын унасан аймшигтай нүгэлд унахаас сэргийлэх хүчтэй айдас бүх бүтээлд орших болно.

Сүр жавхланта биетэй ариун хүмүүс Бурханы Шинэ Иерусалим хотод аж төрнө. Тэд Мянган жилийн хаанчлалын өмнө Христийн шүүх сэнтийн өмнө Мөнх Хаанд үйлчлэх хэргэм зэргийн мөнхийн шагналаа хүлээн авна. Харин энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй үзье.

ХРИСТИЙН ШҮҮХ СЭНТИЙ

Тийн атал та юунд ах дүүгээ шүүнэ вэ? Бас та юунд ах дүүгээ басамжилна вэ? Бид бүгдээрээ Бурханы шүүх суудлын өмнө зогсох болно шүү дээ. Тийнхүү бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно.
— Ром14:10, 12

Бид бүгдээрээ Христийн шүүх сэнтийн өмнө зогсоно.” Паул итгэгч, үл итгэгч - ер нь хэний тухай ярина вэ? Эдгээр бичээсийг агуулгаас нь нягтлаж үзбэл, Паул итгэгч хүмүүст хандсан нь ямар ч эргэлзээгүй байна. Бид нэгэн өдөр хариуцлага хүлээх учраас, итгэлт нэг ахан дүүсээ шүүх юмуу ад үзэх нь Христэд итгэгчдийн хувьд байж болошгүй, ноцтой зүйл гэдгийг Паул хэлжээ.

Тиймээс зөвхөн үл итгэгч хүмүүс биш мөн Христэд итгэгчид ч газар дээрх амьдралынхаа тайланг тавихаар Бурханы шүүхийн өмнө зогсох юм. Коринтод бичсэн захидалдаа Паул энэ талаараа үргэлжлүүлэн ярьсан байдгийг бид өмнөх бүлгээрээ үзсэн:

“Бид урамтай байдаг бөгөөд биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг. Тиймд ойр ч, хол ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ. Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. Иймээс бид Эзэнээс эмээхүйг мэдэж, хүмүүсийг ятгадаг. Бид Бурханд ил болсон. Мөн та нарын мөс чанарын дотор ч бид ил болсон гэж би найддаг.” (2Коринт 5:8-11)

Энд ч Паул нүгэлтнүүдийн шүүхийн тухай бус, харин итгэгчдийн шүүхийн тухай ярьж байгаа нь тодорхой байна. “...

Биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг” гэсэн үг нь Паулын сонсогчид хэн болохыг ямар ч эргэлзээгүй болгож байна. Үл итгэгч хүн биеэ орхихдоо хэзээ ч гэртээ харьж, Эзэнтэй байхгүй, харин шууд л Хайдас руу шилжүүлэгдэж, эцэстээ мөнхийн гэр болох Галт нуурт хаягдана.

Бурханлаг бус хүмүүсийн шүүхийг Аугаа их цагаан сэнтийн шүүх гэж нэрлэдэг бөгөөд дээрх ишлэлд хэлсэн итгэгчдийн шүүлтээс бүр хожуу болохыг дахин хэлье.

Ер нь өмнөх бүлэгт сурсан зүйлээ маш товчхон сэргээн давтъя. Есүс газар дээр тэнгэрийн их цэргээ дагуулсаар эргэж ирээд, антихристийг бут цохин, Сатаныг шоронд хийгээд, мянган жилийн турш Өөрийнхөө хаанчлалыг Иерусалимд тогтооно. Үүний дараа Сатан ёроолгүй гаваас түр суллагдаж, улс үндэстнүүдийг мэхлэх зөвшөөрөл авна. Дараа нь тэнгэрийн гал тэднийг залгиад, диаволыг мөнхийн мөнхөд Галт нуурт шиднэ. Тэгээд Хайдас бүх бурханлаг бус, үл итгэдэг хүмүүсийг гаргаж өгөөд, тэд Аугаа их цагаан сэнтийн өмнө шүүгдэхээр зогсоно. Есүс үүнийг яллагдагсдын амилалт гэсэн байдаг. (Иохан 5:29-ийг үзнэ үү) Амийн номд нэр нь бичигдээгүй бүхэн Галт нуурт хаягдах болно.

Нөгөөтэйгүүр итгэгчдийн шүүх нь Аугаа их цагаан сэнтийн шүүхээс бүр өмнө болно. Бичээс цагийг нь нарийн хэлээгүй ч, энэ нь чуулган үүл өөд өргөгдөхөөс Христийн мянган жилийн хаанчлал эхлэхийн хооронд л болох ёстой. Тэгэхээр энэ хоёр шүүхийг ойролцоогоор мянгахан жил л тусгаарлаж байна. (Энэ тухай харин Аффабелийн түүхд яриагүй байгаа)

2Коринт 5:10 дээр Ром 2-аар бүлгийн үгийг давтан: “Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой” гэжээ. Ром 14 дээр ч, 2Коринт 5 дээр ч шүүх сэнтий гэж хөрвүүлсэн үг нь бема гэдэг Грек үг байгаа. Үүнийг Стронгийн тайлбар тольд “шат, хөлийн гишгүүр, өндөр тавцан, шүүх (шударга ёсны танхим)”¹ гэж тайлбарлажээ. Харин ЮүБиЭс хураангуй тольд “Шүүх сэнтий нь Ромын эзэнт гүрний хотын шүүх суудал байсан. Паул энэ дүрслэлээр Христийн шүүх ажлыг дүрслэсэн юм”² гэжээ. Үүнээс үзбэл, итгэгчдийн шүүхийг Христийн шүүх сэнтий гэж үзэх нь байна.

Христийн шүүх сэнтий нь Бурханы тэнгэрлэг шүүх юм. Аав нь бүх шүүхийг Хүүдээ өгснийг Бичээс мэдэгддэг. (Иохан 5:22)

Есүс Христ бидний Аврагч төдийгүй, Шүүгч бөгөөд тун удахгүй Өөрийнхөө гэр бүлийг шүүх юм. Шүүхийн анхдагч утгыг хамгийн энгийнээр тодорхойлбол, байцаалтын дараа хүний “төлөө юмуу эсрэг гаргах шийдвэр” гэж хэлж болно.

Газар дээрх богино амьдралдаа хийсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэдгээ чуулганы маш олон хүмүүс мэддэггүй. Аврагдсан л бол шүүгдэхгүй гэж олон хүн буруу ташаа бодож явдаг. Үнэхээр Есүсийн цус биднийг хаанчлалаас салгах байсан бүхий л нүглээс цэвэрлэсэн ч, бид итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарсан - үйлдсэн сайн, муу зүйлийнхээ төлөө хариуцлагаа хүлээнэ.

Мөнхийн тогтоол

Христийн шүүх сэнтийгээс бидний талаар гаргах шийдвэр нь хэзээ ч завсарлагдахгүй, өөрчлөгдөхгүй, өнө мөнх хүчинтэй байх мөнхийн шийдвэр юм.

Нэгдүгээр бүлгээрээ бид өнө мөнх гэж юу болохыг ойлгох гэж оролдсныг санаж байна уу? Иаков энэ дэлхий дээрх зуурдын амьдралыг уур манан гэсэн. (Иаков 4:14) Тэрбээр ийм маягаар хүний наяс зуун жилийн амьдралыг өнө мөнхтэй харьцуулжээ. Хэрэв тэр бидний өнөөгийн тооны ухааныг эзэмшсэн байсан бол, илүү нарийн дүрслэх байсан байх. Би тооны оюутан байхдаа юуг ч хязгааргүйгээр хуваахад хариу нь тэг гардгийг сурсан юм.

80 жил хуваах нь хязгааргүй (өнө мөнх) = 0

эсвэл

100 жил хуваах нь хязгааргүй (өнө мөнх) = 0

Хязгааргүй тоогоор хуваасан эсвэл харьцуулсан ямар ч хязгаартай тоо нь тэг болно. Та газар дээр хичнээн удаан амьдарч болно. Бүр зуун тавь насласан ч, энэ нь өнө мөнхтэй харьцуулахад тэг юм. Энэ нь Есүс Христэд итгэдэг хүнийхээ хувьд энэ тэг цонхонд хийж байгаа бүхэн нь бидний өнө мөнхийн амьдралаа хэрхэн өнгөрөөхийг маань шийднэ гэсэн үг юм. Хүн Христийн загалмайд хийгээд Түүний аврагч нигүүлсэлд хэрхэн хандснаараа хаана өнө мөнх байхаа шийддэг. Харин итгэгч хүнийхээ хувьд энэ дэлхий дээр хэрхэн амьдарснаараа өнө мөнхөд хэрхэн амьдрахаа шийднэ.

Манай түүхийн Аминч болон Аугаа их танхимын араар зогсож байсан хүмүүс Эндел дэхь богино хугацаагаа дэмий үрлэгдсэндээ асар их гашуудсныг санаж байна уу? Тэд Эндел дэхь таван жилийнхээ амьдралын дийлэнх хугацааг Жэйлинд өгөхийн оронд амин хувийнхаа төлөө л зарцуулжээ. Уг нь тэдэнд Жэйлиний дэргэд, Жэйлингтэй хамт мөнхийн мөнхөд ажиллаж амьдрах боломж байсан ч, тэд энэ завшаанаа цалгардуулсан учраас, мөнхийн мөнхөд өөрийнхөө хүчин чадлаас хавьгүй дор байдалд амьдрах ёстой болсон юм. Тэд сургуулийнхаа дараах Эндел дэхь богино амьдралдаа дуртай ч байсан байж болно, дургүй ч байсан байж болно. Даанч харамсалтай нь одоо тэдний хувь тавилан нэгэнт шийдэгджээ. Тэдний 130 жилийн амьдрал Эндел дэхь тавхан жилээ хэрхэн амьдарснаар нь шийдэгдэв. Зуун гучин жилийг таван жилтэй харьцуулаад үз. Харьцангуй урт хугацаа шүү. Зарим хүн газар дээр бараг л ийм урт насладаг. Аминч тэргүүтэй тэдгээр хүмүүс Эндел дэхь амьдралаа дуусгахаасаа өмнө үүнийг бодолцсон бол, тэс өөрөөр л амьдрах байсан байх.

Хэдийгээр Аффабел түүхийн энэ жишээ нь аймшигтай боловч, бидний ярьж байгаа бодит үнэний дэргэд юу ч биш юм. Тиймээс өөр нэгэн жишээ үзье. Ингэж төсөөлье. Танд нэг хоног өгөгджээ. Тэгээд тэр ганц хоногийг яаж өнгөрөөхөөс чинь таны дараагийн мянган жилийн амьдрал шалтгаална. Мянган жил гэж ямар хугацаа болохыг ухраан төсөөлөх гээд үз. Тэр нь Америк улс мэндлэхээс ч, Кристофор Колумб шинэ ертөнцийг нээхээр далайд гарахаас ч, тэр бүү хэл Норман Английг булаан эзлэхээс ч өмнө эхлэсэн цаг хугацаа юм.

Мянган жил гэдэг маш урт хугацаа. Гэтэл таны мянган жилийн хугацаанд хүртэх шагнал чинь - эзлэх байр суурь, эзэмших мэргэжил, хамтран ажиллах хүмүүс, амьдрах орчин, аж төрөх байшингийн чанар чанасаа, үзэгдэх орчин тэргүүтэй юмс чинь тэр ганц хоног хэрхэн амьдрахаас чинь шалтгаалах ажээ.

Та байдгаараа хичээхгүй гэж үү? Та яаж амьдрах бол? Одоогийнхоосоо өөрөөр амьдрах уу? Чухалчилдаг юмсынхаа байрыг өөрчлөх үү? Эзэнээ үг дуугүй, бүрэн дагахгүй гэж үү? Түүний үгийг илүү анхааралтай уншиж, илүү хичээнгүй дагахгүй гэж үү? Хүмүүст өөрөөр хандахгүй гэж үү? Амьдралдаа өөрчлөх ёстой юмс чинь дуусахгүй байгаа биз дээ? Гэхдээ л энэ нь бидний ярьж байгаа бодит үнэний дэргэд бас л юу ч биш юм. Учир нь

ганц хоногийг (мянган жилтэй дүйцүүлэн) 365,000 - д хуваахад тэг биш, харин хязгаартай тоо болно.

Жаахан цаашаа үзье. Тэгвэл тэр ганц хоногийг хэрхэн өнгөрөөхөөс чинь таны дараагийн сая жилийн амьдрал шийдэгдэнэ гэж бодъё л доо - эд хөрөнгө, ажил, ажлын хамт олон, аж төрөн суух байр сав, хотхон, унах машин зэрэг чинь шийдэгдэнэ! Сая жилийг төсөөлөх гээд үз. Чадахгүй байх. Учир нь хүн төрөлхтөн дэлхий дээр зургаан мянга гаруй жил л амьдарч байна. Тэгвэл сая жил нь энэ хугацаанаас 150 дахин урт хугацаа байх нь. Энэ нь үл хүрэх тоо болно. Гэхдээ энэ ч бас бидний ярьж байгаа бодит үнэний дэргэд юу ч биш юм. Учир нь нэг хоногийг (сая жилтэй дүйцүүлэн) 365,000,000 - д хуваахад тэг биш, хязгаартай тоо гарна. Тэрбум, триллион жилийг авч үзсэн ч, ганц хоногтой харьцуулахад бас л хязгаартай тоо гарна.

Тиймээс бид газар дээр хичнээн урт амьдарсан ч, энд амьдрах хугацаа маань өнө мөнхтэй харьцуулахад бас л тэг юм. Магадгүй иймээс л Паул биднийг дээд шагналаа авахын төлөө улайран амьдрахыг ятгасан юм биш байгаа? Коринтод бичсэн захидалдаа Паул тэмцээнд оролцож байгаа тамирчин нь ялахын төлөө л явдгийг хэлжээ:

“Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар ялахын тулд гүйцгээ. Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй, харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог.” (1Коринт 9:24-27)

Паулын хэлснээр, бид хэзээ ч үгүйрч мууддаггүй, мөнхийн шагнал хүлээж авах ганц зорилгын төлөө амьдарч байгаа юм. Энэ амьдралд бид ялахын төлөө гүйж байна. Харин үүнийг туйлын мятрашгүй сахилга баттай, биеэ хянан захирдаг, ганц хараатай байж л хийнэ.

Миний амьдрал спорттой салшгүй холбоотой. Би Америкийн Теннисний Нийгэмлэг, Залуусын Дэйвис Цом, ЭнСиЭйЭй-ийн Нэг теннис салбарт тоглодог байхдаа, өдөр шөнөгүй бэлтгэл хийдэг

байлаа. Өдөр бүр дасгалжуулагчтайгаа болон багийнхантайгаа хамгийн багадаа зургаан цаг тоглож, зуу зуун төрлийн цохилт гүйцэтгэнэ. Тэгээд тамирчин хүний сэтгэл зүйн хат хүчний талаар ном уншина. Үүнээс гадна хүнд жин өргөж, гүйж, дээс тоглож, харааны төвлөрлөө тогтоохын тулд жонглердох зэрэг маш олон төрлийн дасгал гүйцэтгэдэг байв. Миний энэ улайрсан зорилгоос болж ээж маань бүр “орыг чинь теннисний талбай дээр зөөгөөд тавьчихна шүү” гэж сүрдүүлж байсан удаатай. Би теннисээр амжилтанд хүрэхийн төлөө зорилгод маань өчүүхэн төдий садаа хийх бүх төрлийн үйл ажил, спортоос зайлсхийдэг байлаа. Юуны төлөө тэр вэ? Ялах гэж, аварга болох гэж, шилдэг нь болох гэж, шилдэг болсныг маань гэрчлэх шагналыг авах гэж тэр.

Гэхдээ хаанчлалд жаахан өөр л дөө. Хаанчлалд бид өөр хоорондоо биш, өөртэйгээ л өрсөлддөг бөгөөд хийсэн бүхнээрээ Есүст таалагдах нь бидний зорилго юм. (2Коринт 5:9) Бид Бичээсийг анхааралтай уншихдаа, Эзэн маань биднийг хүнтэй харилцахдаа, аливааг мөрдөж мөшгихдөө, цаг заваа зарцуулахдаа, бусдад мөнхийн нөлөө үзүүлэхдээ, Хаанчлалд ба бусдад өгөхдөө, бусдыг уучлахдаа яагаасай гэж хүсдгийг олж мэднэ. Энэ талаар дараа дэлгэрэнгүй ярина. Яг одоогоор хамгийн чухал нь ялахын төлөө амьдрах ёстойг л тогтоож аваарай!

Олон төрлийн шагнал

Итгэгчдийн хүлээж авах мөнхийн шагнал, хэргэм зэрэг нь ялгаатай байхаас гадна олон төрөл байхыг Бичээс хэлдэг. Тухайлбал хамаг юмаа галд хуйхлуулаад, өөрөө амь мөлтөс аврагдахаас авахуулаад мөнхийн мөнхөд Христийн дэргэд хаанчлах хүртэл шагнал байна. (1Коринт 3:15; Илчлэл 3:21)

Хүмүүс амьдралаа шатаалгаж, алдах гэдэг үгсийг сонсохоороо цэрвэдэг. Тэнгэрт ийм юм байж болно гэдэгт тэд итгэж яддаг. Гэхдээ Бичээс Өөрөө үүнийг маш тодорхой хэлсэн.

Эдгээр ишлэлийг хуваалцахаасаа өмнө би эхлээд Бичээс хувь хүмүүсийн амьдралыг барилга барихтай зүйрлэдгийг хэлмээр байна. Түүнчлэн чуулганыг ч нэгэн цул барилга юмуу сүм гэдэг. Аль аль зүйрлэлд нь биднийг өөрийнхөө амьдралыг ч, Бурханы чуулганыг ч барьж байгуулж байгаа барилгачид хэмээн

тодорхойлсон юм. Би ч бас номоо дуусан дуустал энэ зүйрлэлийг хэрэглэнэ. Тэгэхээр IКоринт 3:9-15 дээр Паул:

“Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн.Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй.Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана” хэмээн тодорхой мэдэгджээ.

Бид хэрхэн барихаа өөрсдөө шийддэг бөгөөд амьдралаа байгуулахдаа, алхам тутмаа хоёр чухал сонголт хийдэг: нэг бол махан биеийг хангадаг түр зуурын материалаар (мод, өвс, дэрс) барих эсвэл дахин төрсөн сүнстэйгээ хөл нийлэн амьдарч, Бурханы мөнхийн Үгийг дагах (алт, мөнгө, үнэт чулуугаар барих). Харин хэрхэн барьж, хэрхэн амьдарсан маань Бурханы оршихуйн галаар л ил болно.

Бидний ажил үйлс төдийгүй, бодол, сэдэл, санаа маань ч ил болно. Тиймээс л итгэгчид бид “сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай” (Еврей 4:12) Бурханы Үгийг чих тавин сонсож, анхаарч, зүрхэндээ хадгалах ёстой юм. Бидний зүрхийг Бурханы Үг шиг өвчиж чадах зүйл үгүй.

Хэрэв бид хүний учир шалтгаан, логик, сэтгэл зүй, цэц ухааныг сонсоод байвал, бодол, зүрхний сэдэл маань цаг зуурын юмст автах бөгөөд харин бид үүнийгээ Шүүх танхимд ортлоо мэдээгүй явсан Аминч шиг огт гадарлахгүй явж байж болох. Тиймээс л Есүс бидэнд:

“Илчлэгдэхгүй байхаар халхлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. Иймд та нар сонссон зүйлээ

нягтлагтун. Хэнд байна, түүнд ихээр өгөгдөнө. Хэнд байхгүй байна, түүнээс байгаа гэж санагдсан нь хүртэл авагдана” (Лук 8:17-18) хэмээн анхааруулжээ.

Бидний сонсож, анхаарч байгаа зүйл нь зүрхэнд маань тунаж, дотоод бодол, зорилгыг маань бүрэлдүүлээд, эргээд биднийг амьдралаа хэрхэн байгуулахыг маань шийддэг. Бид Бурханы Үгд үнэхээр анхаарах ёстой. Учир нь Бурханы Үг бидний замын гэрэл юм. Бурханы Үг байхгүй бол, та харанхуйд замаасаа төөрдөг хүн шиг замаасаа гарна. Нэг хэсэгтээ тогтлоо ч, эцэстээ алдуурч одох нь баталгаатай.

Харин нэгэнт замаа алдсан хүн амьдралаа түр зуурын юмсаар босгох санаандаа улам л автана. Тэгээд түүн дээр Бурханы Үг тусах хүртэл тэрбээр юу ч харахгүй. Үүнийг Паул ч хэлсэн: “Харин бүх зүйл гэрлээр илчлэгдэхдээ харагддаг. (Ефес 5:13)

Төөрсөн хүнд хоёр зам бий. Нэгдүгээрх нь буюу илүү дээр сонголт нь бид Бурханы Үгийг сонсоход (номлол сонсох, үгийг унших, удирдагч, найз нөхдөөсөө сонсоход), Үг бидний ухамсартай ярьдаг. Иймээс л Бурханы Үгээр тогтмол хооллох нь амь насанд өлзийтэй юм. Хэрэв бид ухаантай бол, бодол, сэдэл, далд санаагаа тэр даруй гэмшиж, уучлал эрнэ. Гэвч нүглээ ахин дахин хийсээр байгаад, ухамсар маань мохой болсон бол, Бурханы Үгийг сонсох хэцүү болно. Харин ухамсар маань бүр идэгдэж дууссан бол, Бурханы Үгийг сонсох бараг л боломжгүй юм. Тиймээс Бичээс ухамсраа цэвэр байлгахыг байнга хэлдэг. (Сургаалт үгс 4:23; 2Тимот 1:3) Бид ухамсраа хамгаалж, тунгалаг байлгавал, зүрхэнд маань хийгдэж байгаа Бурханы амьд Үгийн ажлыг ойлгож чадна.

Харин хоёр дахь сонголт нь Шүүх сэнтийн өмнө хамаг сэдлээ онгичуулах юм. Энэ тун мунхаг сонголт шүү. Ийм юм болбол, бид хүртэж чадах байсан шагналаа алдана. Тиймээс та Бурханы Үгийн зэмлэлийг эсэргүүцэх нь ашигтай юу гэж өөрөөсөө асуу. Эсэргүүцэх тусам зүрх чинь хатуурч, маш том мэхлэлийн нөхцөлд орно. Бид өөрийнхөө нөхцлийг хэзээ ч ухаарахгүй бөгөөд энэ нь Шүүх сэнтийн өмнө Бурханы алдрын гэрлээр л илчлэгдэнэ.

Мөнхийн ирээдүйдээ бэлтгэх

Амьдралын маань шүүхээр бүх юм ил болно. Бүгд үзэгдэж, ил тод болно. Тиймээс л Паул Шүүх сэнтийг “Эзэнээс эмээх хатуу айдас” гэсэн юм. Шүүхээр бидний санаа, сэдэл, бодол, үг, үйлдэл - бүгд нарийн шалгагдана. I Коринт 3:9, 12-15 дээр Паул барих ба шүүх талаар маш хатуу үг хэлжээ:

Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн. ... Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана.”

Та яахыг би мэдэхгүй. Харин би Шүүх сэнтийн өмнө амь мөлтөс аврагдмааргүй л байна шүү. Бид мөнхийн хувь тавилангийн талаар ярьж байгааг бүү мартаарай.

Хүмүүс ямар их цочирдохыг төсөөлж байна уу? Манай түүхийн гол дүрүүдээс Өгөөмрөөс бусад нь тийм нөхцөлтэй тулгарч, тийм байдалд орно чинээ санаагүй. Өгөөмрөөс бусад нь анхнаасаа л мэдэж байх ёстой байсан үндсэн доктриндоо нухацтай хандаагүй.

Энэ дэлхийн ухаантай хүмүүс байнга л ирээдүйдээ бэлтгэж байхыг би хардаг. Тэд сайн ажилтай болохын тулд сайн сурдаг. Тэгээд ажил дээр гараад тогтвортой амьдралын төлөө орон байртай болохын төлөө зүтгэдэг. Түүнчлэн хадгаламж, тэтгэврийн сан нээнэ. Зарим нь илүү мөнгөө ашигтай зүйлд хөрөнгө оруулна. Тэд насныхаа бөгсөн дээр юугаар ч дутахыг хүсээгүйдээ, бэлтгэлээ базаадаг. Хэрэв хүмүүс тэтгэврийн насандаа бэлтгэж байгаа эдгээр ухаалаг хүмүүс шиг өнө мөнхдөө бэлтгэдэг байсан бол, тийм аймшигтай асуудалд орохгүй байх байсан. Тэд чуулганы олон хүмүүстэй адилгүй, үүндээ анхаарч, айж явах байсан.

Тиймээс би танд нэгэн зохиомол жишээ өгье. Таныг тэтгэвэртээ гардаг өдөр нийгмийн даатгалын сан дампуурсан тул та тэтгэвэргүй үлдэж, таны мөнгийг хадгалж байсан банк

дампуурсан тул хамаг хадгаламж чинь шатаж, байшин чинь түймэрт өртсөн тул та бүх хөрөнгөө үнс болохыг харсаар, өмссөн хувцастай л үлджээ гэж бодъё.

Амьдрал дээр ийм явдал болдог бол юутай эмгэнэлтэй. Гэтэл Шүүх сэнтийн өмнө зарим итгэгчид яг ингэнэ гэдгийг Паул байдгаараа анхааруулсан буюу. “Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана.” (1Коринт 3:15) Бид тэтгэвэрийн насандаа бэлтгээгүй, харин өнө мөнхийн төлөө бэлтгэж байгааг хаанчлалын цэц ухаантай нэгэн нь ухаарах буй за!

Ухаантай гэдэг нь мөнхийн ирээдүйдээ бэлтгэдэг хүмүүс юм. Тэд зорилготой хүмүүс бөгөөд газар дээрх амьдралаараа мөнхийн хувь тавиландаа бэлтгэж байгаагаа мэддэг. Ингэснээрээ тэд хамаг юмаа үнс болтол нь шатаалгахын оронд Бурханы хаанчлалд сүр жавхлантай орно. Петр энэ ингэж хэлсэн:

“Тиймээс ах дүү нар аа, дуудлага ба сонголтоо бататгахын тулд бүр ч илүү хичээнгүй бай. Учир нь та нар эдгээрийг үйлдэж л байвал хэзээ ч бүдрэхгүй. Ингэснээр бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн мөнх хаанчлалд хангалттай орох болно.”
(2Петр 1:10-11)

Эзэн нь ч тэднийг “Сайн байна, итгэмжтэй, сайн зарц. Чи цөөхөн юмд итгэмжтэй байсан тул Би чамайг олон юмыг захируулна. Эзэнийхээ баяр хөөрд ор” (Матай 25:21) гэсээр угтана.

Эзэн саяхан надад нэг үзэгдэл үзүүлсэн юм. Би Бурханы хотоор жагсаж яваа ялагчдыг үзэв. Тэднийг алтан гудмаар алхахад нь хоёр талаар нь эгнэж зогссон эрчүүд, эмэгтэйчүүд баяр хүргэн хурайлж байлаа. Хаан Есүс хот даяар харагдахуйц өндөр тайзан дээр зогсоно. Итгэмжтэй цэргүүд Есүст дайныхаа олзыг өргөн барихаар шатаар өгсөх үед хүмүүс баярлан хөөрч байв. Эзэн маань тэр цэргүүдэд: “Сайн байна” хэмээн айлдах мэт үзэгдэнэ.

Тэгтэл Эзэн надаас: “Чи Надад хураасан ургацаа авчрахаар яваа эдгээр цэргүүдийн нэг байхыг хүсч байна уу эсвэл замын хажуугаар эгнээд хурайлж байгаа хүмүүсийн нэг байхыг хүсч байна уу?” гэж асуухыг би зүрхэндээ мэдрэв. Үүнийг сонсоод би ч дуудлага, сонголтоо улам батжуулсан юм. Амьдралаа шалгуулах үедээ би Эзэнийхээ өгсөн хүч чадлыг талаар болгочихоод Түүнийг

гуниглуулахыг хүсэхгүй. Би Эзэнээ баярлуулмаар байна.

Түүнчлэн авчирсан ургацаараа Аавыгаа баярлуулаасай гэсэндээ, энэ үнэнийг өөрийнхөө цаг үед аж төрж байгаа, Бурханд хайртай бүх хүнд мэдүүлэхээр шийдсэн юм. Харин ийм сүр жавхлантай угтуулах эсэхээ бид өөрсдөө л шийднэ. Энэ талаар бид дараа дараагийн бүлгээрээ ярина.


Ирэх

Тэгэхээр, дараа дараагийн бүлгээрээ бид чухам ямар талбар дээр шүүгдэж, шагнуулах талаар ярина. Хэдийгээр бүгдийг нь нэгт нэгэнгүй ярих цаг байхгүй ч, хамгийн чухал сэдвээ заавал хөндөнө. Бүгдээрээ цаашдаа өнө мөнхөд үнэ цэнэтэй байх амьдрал бүтээн байгуулахын тулд эхлээд маш сайн суурь тавья.

Эцэст нь Петрийн доорх үгийг нэгт нэгэнгүй анхааралтай уншиж, сайтар чагнаад, үүгээр сурсан зүйлээ батжуулаарай. Петрийн үгд таны сурсан зүйлсийг улам амилуулах түлхүүр үг, хэллэг олон бий. Түүнчлэн эдгээр үгс нь биднийг цаашдын сэдэвт маань ч бэлтгэнэ:


“Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон ... Яг энэхүү шалтгааны улмаас та нар бүхий л хичээл зүтгэлээр, итгэл дээрээ сайн чанарыг, сайн чанар дээрээ мэдлэгийг, мэдлэг дээрээ өөрийгөө захирахуйг, өөрийгөө захирахуй дээрээ тэвчээрийг, тэвчээр дээрээ итгэл сүсгийг, итгэл сүсэг дээрээ ах дүүсэг энэрлийг, ах дүүсэг энэрэл дээрээ хайрыг хамтагта. Та нарт эдгээр нь байгаад, нэмэгдсээр байвал, энэ нь Эзэн Есүс Христийг маань мэдэхэд та нарыг ашиггүй, үр жимсгүй байлгахгүй ... Тиймээс ах дүү нар аа, дуудлага ба сонголтоо бататгахын тулд бүр ч илүү хичээнгүй бай. Учир нь та нар эдгээрийг үйлдэж л байвал хэзээ ч бүдрэхгүй. Ингэснээр бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн мөнх хаанчлалд хангалттай орох болно. Тиймээс хэдийгээр та нар эдгээр зүйлсийг мэдэх бөгөөд эдүгээ өөрсдөд чинь байгаа үнэнд батажсан байлаа ч гэсэн би та нарт эдгээрийг ямагт сануулж байх болно. Би энэхүү асар дотор байхдаа та нарыг сануулгаар сэрээхээ зөв гэж үзэж байна.”

(2Петр 1:3, 5-8, 10-13)



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: БҮЛЭГ 8-10

1. Алфавелийн шүүхийн хамгийн содон эгшин нь иргэд шинэ нэртэй болсон явдал байх. Христ дээр ирэхээсээ өмнө та хэн байсан, хэрхэн байсан, Есүс таныг хэн болгож өөрчилснийг бодоорой. Таны түүх өнөөдрийг хүртэл хэрхэн өрнөсөн бэ?
2. Итгэгчид энэ амьдралдаа олиггүй амьдарснаасаа болоод асар их гарз хохирол амссан ч гэсэн, тэнгэрт бид нулимс бүрээ арчуулж, аугаа ихээр баярлана гэдэгт та итгэж байна уу?
3. Таны бодлоор Өгөөмөр шүүгдэхдээ чухам ямар чанараараа бусдаасаа онцгойрсон бэ? Түүний ямар үлгэр жишээнээс бид суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой вэ?
4. Есдүгээр бүлэгт ярьсан, тэнгэрийн талаарх Библийн аль нэг дүрслэлд та гайхсан уу?
5. Аравдугаар бүлэгт “Үнэхээр Есүсийн цус биднийг хаанчлалаас салгах байсан бүхий л нүглээс цэвэрлэсэн ч, бид итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарсан - үйлдсэн сайн, муу зүйлийнхээ төлөө хариуцлагаа хүлээнэ” гэсэн мэдэгдэл бий. Энэ үгийг сонсоод танд юу гэж бодогдсон? Одоо юу гэж бодогдож байна?



ᠰ-ᠢ ᠬᠡᠵᠢ

БУРХАНД ЗОРИУЛСАН ГЭР

*Та нар ч гэсэн Сүнс дотор Бурханы орших газар болохоор
Христ дотор хамтдаа байгуулагдаж байна.*
— Ефес 2:22

Итгэгчдийн шүүхийг хоёр том ангилж болно. Нэгдүгээрт - Бурханы хаанчлалыг байгуулахад дуудлага, бэлэгээрээ оруулсан хувь нэмэр. Хоёрдугаарт - хувь хүний болоод өөрийнхөө амьдралыг хэрхэн байгуулсан. Бусдын амьдралыг байгуулах талд бидний хүмүүст үзүүлсэн нөлөө орох бол, хувийнхаа амьдралыг байгуулах талд Христэй адил зан чанартай болохын тулд Бурханы нигүүлсэлтэй хэрхэн гар нийлж ажилласан маань орно. Хоёр дахь нь Бурханы Үгд үзүүлэх хариу үйлдлийн маань дайвар бүтээгдэхүүн юм. Гэхдээ аль ч тохиолдолд бидний үг, бодол, сэдэл шалгагдах болно.

Тэгэхээр, эхлээд Бурханы хаанчлалын бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмрийн шүүлтийн талаар авч үзье.

“Чи Миний төлөө юу хийж чадах вэ?”

Хаанчлалыг байгуулах чадвар маань тэр чигээрээ Ариун Сүнсэнд хэр дуулгавартай байхаас л шалтгаална. Учир нь бид Есүс Христийн туламжгүйгээр мөнхийн үнэ цэнэтэй юу ч бүтээж чадахгүй. Дуулал 127:1 дээр “ЭЗЭН гэрийг барьж байгуулахаас нааш Түүнийг байгуулагчид дэмий хөдөлмөрлөнө” гэдэг бус уу? Бид Бурханы Сүнснээс тусгаар, өөрийнхөө хүчээр хөдөлмөрлөж болох ч, өнө мөнхөөр жинлэж үзбэл, энэ нь шүүх сэнтийн өмнө ямар ч үнэ цэнэгүй үнс болохыг дээрх ишлэл хэлжээ. Тиймээс мэдэж ав.

Бурхан Өөрт нь чөлөө завгүй үйлчилж байгаа Хуучин гэрээний хүмүүст:

“ЭЗЭН үүнийг айлдаж байна. “Тэнгэр болбоос Миний сэнтий, Газар болбоос Миний хөлийн гишгүүр билээ. Надад зориулж та нар ямар сууц барих юм бэ? Миний амрах газар гэж юу байх вэ? Энэ бүх юмсыг Миний мутар бүтээсэн бөгөөд Энэ бүхэн байдаг болжээ” гэж ЭЗЭН тунхаглав. “Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй, Үгэнд минь чичирдэг нэгнийг л Би анхаарна” (Исаиа 66:1-2) хэмээн айлджээ.

Товчхондоо Бурхан: “Би бол Бурхан. Та нар Намайг хэн болохыг мэдэж байна уу? Та нар Намайг наад ажлаараа гийгүүлнэ гэж бодоо юу?” гэж л айлджээ. Бурханы хэрэгцээг хангаж гийгүүлнэ гэж хэлэх нь шоргоолжнууд хүнд: “Бид чамд байшин барьж өгье” гэж хэлэхтэй л адил юм. Үнэхээр инээдтэй! Бид тэр аугаа, баян, сүрдмээр Бурханд өөрийнхөө хүчээр үйлчилж, таалагдана гэж байхгүй. Үнэндээ Бурхан биднээр огт дутахгүй.

Дараа нь Бурхан даруу, гэмшдэг, Бурханаас айж, дуулгавартай дагадаг хүмүүсийг таалдгаа хэлжээ. Бурхан тийм хүмүүст Өөрийнхөө өргөө гэрийг байгуулах үйлст гар бие оролцох завшаан олгодог. “Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний Сүнсээр” (Зехариа 4:6) гэдэг. Ариун Сүнстэй гар нийлж байгаа хүмүүс л жинхэнэ үр дүн бүтээдэг. Тэр цагт л түүний хүч хөдөлмөр талаар болохгүй.

Хамтран зүтгэгч

Би нэгэн зог тусмаар үнэнийг хэлье - Бурхан хэдийгээр аймшигтай бөгөөд гайхамшигтай Нэгэн боловч, эхэнд газар дээрх Өөрийн эрх мэдлээ хязгаарлан, энэ цэнхэр гаригийн бүх эрхийг хүнд гардуулжээ. Тиймээс хожим хүн Бурханыг хязгаарлах болов.

Энэ үг таныг цочоох байх. Гэхдээ үүнийг батлах Бичээс олон бий. Абрахамын үр удам “Израилийн Ариун Нэгэнийг хязгаарласан” (Дуулал 78:41). Бас Есүс Өөрийнхөө ард түмний сүнслэг удирдагч нарт “Ингэж та нар уламжлан авсан ёс заншлаараа Бурханы үгийг хөсөрдүүлдэг “ (Марк 7:13) гэсэн.

Бид Бурханы хүссэн зорилгыг биелүүлэхийн тулд Бурхантай гар нийлж ажиллах үүрэгтэй. Харин Бурхан өнө мөнхөд амьдрах, Есүстэй адилхан дүр төрх, зан чанараар баталгаажсан хүмүүсийг бий болгох зорилготой. Ийм учраас л Бурхан биднийг Өөрийнхөө хамтран зүтгэгчид гэдэг:

“Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн” (1Коринт 3:9)

Шинэ гэрээ мөнхийн хөдөлмөрийг ургацын юмуу барилгын ажилтай байнга зүйрлэдгийг та мэдэх байх. Яагаад ургацын талбай гэж? Яагаад гэвэл ургацын талбай гэдэг нь Бурханы хаанчлал өсөн тэлж байгаа тэр газар юм. Ариун хүмүүс газар дээр хаанчлалыг байгуулж байхад, тэнгэр тэр аяараа уухайлан дэмжиж байна. Тэгвэл яагаад барилга гэж? Яагаад гэвэл Бурхан Өөртөө байнга оршин суух өргөөг хүсдэг бөгөөд бид бол Түүний оршин суух газраа урлаж байгаа амьд чулуунууд нь юм.

Петр “Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун” (1Петр 2:5) гэсэн. Паул “Та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ. Түүний дотор бүх барилга холбогдон Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна” (Ефес 2:20-21) гэсэн. Тиймээс үндсэндээ бид бусдыг авралд хүргэж, сургаж, үйлчлэх замаар энэ дэлхий дээр Бурханы сүр жавхлант сүмийг буюу өргөө гэрийг барьж байгаа ажээ. Хүн бүр нэн түрүүнд өөрөө цэвэр, амьд чулуу байх ёстой. Харин үүнийхээ дараа бусад амьд чулуудыг Бурханы сүр жавхлант өргөө гэрт тааруулж, нийлүүлэх барилгачин болох ёстой. Учир нь хожим бид хаанчлалын болоод хувийнхаа ажлыг хэрхэн гүйцэтгэсэнээ тайлагнах болно.

Бурханд зориулсан гэр

Би хэрвээ хувийн байшин барьдаг байсан бол, хамгийн түрүүнд загвараа гаргана. Байшингаа яаж угсарч, ямар материалаар барихаа зурна. Гэхдээ ажил үүгээр дуусахгүй. Аль гүйцэтгэгчийг хэзээд нь

оруулж ирэхээ мэдэх нь барилга угсралтын амин чухал хэсэг гэдгийг барилгачин бүр мэднэ. Гүйцэтгэгч нар гэдэг нь араам угсрагч, цутгагч, сангийнхан, плита наагч, цахилгаанчин тэргүүтэй үй олон ажилчид юм. Тэд бол барилгын ажлыг яг гардан гүйцэтгэдэг хүмүүс. Тэдний дарааллыг зөв зохицуулахгүй бол, ажил замбараагаа алдана.

Хэрэв гүйцэтгэгч ажлаа муу хийх юмуу товлосон цагтаа дуусгахгүй бол, барилгачин түүнийг халаад өөр хүнийг хөлслөнө. Шинэ ажилчин ирээд, өмнөх гүйцэтгэгчийн хийсэн муу ажлыг нураагаад бүгдийг шинээр хийнэ. Барилгачин муу ажилчныг халсан ч, тухайн ажлаа заавал дуусгана.

Түүнчлэн барилгачин хүн хувийнхаа байшинг бариулахдаа, гүйцэтгэгч нараа ёстой л шилж сонгодгийг би харсан. Тэрбээр гүйцэтгэгч нараас хамгийн шилдэг барилгын материал, хамгийн шилдэг ажлын гүйцэтгэлийг шаардана. Бас ажлын явцыг нь ч нарийн няхуур хянана. Тэгвэл Бурхан Өөртөө зориулж захиалгаар байшин бариулж байна. Гэхдээ Бурханы байшин нь хүмүүсээс бүтсэн хот юм.

Хүмүүс бид алдартай байшинд нэр өгдөг. Жишээлбэл Английн хатан хааны ордныг Буркингамын ордон гэнэ. Америкийн ерөнхийлөгчийн гэрийг Цагаан ордон гэнэ. Бас тийм сайн мэдэхгүй барилгууд ч байна. Жүжигчин Фелис Калвертын гэрийг Хиил Хаус гэнэ. Жүжигчин, найруулагч Чарльс Айван Вансын гэрийг Оак Лодж гэнэ. Зохиолч Чарльс Дайерсын гэрийг Олд Воб гэнэ. Гэхдээ алдартай байр байшинд нэр өгдөг энэ заншлыг Бурхан хүнээс ч урьдаар эхлүүлсэн байжээ. Бурхан яг одоо баригдаж байгаа Өөрийнхөө мөнхийн гэрийг Сион гэдэг.

“Учир нь ЭЗЭН Сионыг сонгож, Орших газраа хэмээн Түүнийг хүсэв. Мөнхөд амрах газар минь энэ болой. Үүнийг хүссэн тул Би энд амьдран сууна.” (Дуулал 132:13-14)

Хэрэв та хувийн байшин бариулж явсан бол, энэ нь ямар зугаатай ажил болохыг мэдэх байх. Та бушуухан шиг л гэртээ нүүж орохыг тэсэн ядан хүлээнэ.

1990 оны дундуур Лиза бид хоёрт яг ийм завшаан тохиосон юм. Манайх Флоридагийн Орландод аж төрж байтал хувийн сууц барьдгаараа алдартай Роберт гэдэг барилгачин бидний үйлчлэлийг үнэлж хүндэтгэсэндээ: “Би танайд байшин барьж өгмөөр байна” гэсэн юм. Манайх тэр үед умгар байшинд амьдарч

байсан болохоороо асар өндөр үнэ хэлэх байх гэж айв. Гэтэл тэр хүн: “Би Бурханы шагналын төлөө барьж өгье” гэсэн юм. Тэгээд биднээс нэг ч төгрөгийн ашиг аваагүй билээ.

Үүнээс өмнө манайх хоёр ч байшинтай байж үзсэн байлаа. Жижигхэн, угсармал байшин учраас, загварын хувьд авах юм байхгүй. Тэгтэл тэр ярианаас хэдэн өдрийн дараа Роберт манай умгар гэрт хүрч ирээд, хоолны ширээн дээр хуудас цаас гаргаж тавиад: “Мөрөөдлийнхөө байшинг зур!” гэж хэлсэнийг би хэзээ ч мартахгүй.

Лиза бид хоёр зүгээр л хөшчихсөн. Ёстой л зүүдэнд ч оромгүй явдал байлаа. Гэтэл эхнэр маань шууд л зурж эхлэв. Аргагүй шүү дээ - энэ боломжийг өчнөөн жил мөрөөдсөн хүн чинь. Араас нь би ч ажилдаа орлоо. Үнэхээрийн зугаатай ажил байсан бөгөөд бид хүссэн байшингийнхаа загварыг гаргаж байна гэхээр бүр ч зугаатай байв. Юунд ч баригдахгүй.

Дараа нь бидний хуудас цаасан дээр эрээцсэн мөрөөдлийн байшин мэргэжлийн архитектор, дизайнеруудын гар дээр очив. Хэдэн өдрийн дараа Боб байшингийн маань бэлэн болсон хар зургийг үзүүлэхэд, бид ч ажил эхлэх өдрийг тоолж эхлэсэн юм.

Робертын ажилчид газар хагалаж эхлэсэн өдрөөс байшин баригдаж дуусах хүртэл Лиза бид хоёр барилгын талбай дээр өдөр бүр - заримдаа бүр өдрийн хоёр очдог байлаа. Бид ихэд догдлон, байшингийн дараагийн үе шатыг тэсэн ядан хүлээнэ. Шинэ байшиндаа нүүж орох гэсэн хүсэл догдлолоос минь болоод, тэр хэдэн сар яг л хэдэн жил шиг, өдөр хоног нь яг л сарууд шиг удаан санагдаж байлаа. Хуудас цаасан дээр сараачсан мөрөөдөл маань нүдэн дээр минь цогцлон босохыг харax нь итгэхийн аргагүй гайхамшигтай байв!

Бурхан ч мөрөөдлийнхөө гэрийг барихдаа яг л бид хоёр шиг догдлон баярладаг гэдэгт би итгэдэг. Гэхдээ Бурхан хэдэн сар биш, хавьгүй удаан хүлээж байна. Үнэндээ Бурхан дэлхийн суурь тавигдсан цагаас л үүнийхээ биелэлийг харуулдан хүлээж байна. “...Учир нь ЭЗЭН Сионыг босгон байгуулж, Цог жавхлангийнхаа дунд үзэгдэнэ” (Дуулал 102:16), “Үзэсгэлэнгийн дээд болох Сионоос Бурхан гэрлээ цацруулж байна.” (Дуулал 50:2)

Бурхан хэдэн мянган жил ажиллаж байна. Тэрбээр хүнийг дэлхий дээр төрүүлэхээсээ ч өмнө үүнийгээ төлөвлөсөн байжээ. Хэдийгээр Бурхан үүнийг хүсээгүй бас төлөвлөөгүй боловч, хүн Өөрийнх нь итгэлийг хөсөрдүүлэхийг мэдэж байжээ. Тэрбээр

бүхнийг урьдаас мэдэж байсан учраас, авран сэргээгдсэн хүмүүсээр Сионыг байгуулахаар төлөвлөжээ.

Бурхан энэ бүхнээ сууриас болон булангийн чулуу болох Есүс Христээс эхлэсэн. Есүсийн тухай Бурхан Аав нь “Үзэгтүн. Би Сионд нэгэн чулууг, Шалгагдсан, үнэт, бат суурилуулсан суурийн булан чулууг тавина. Түүнд итгэгч нь үл тэвдэнэ” (Исаиа 28:16) гэжээ. Бурхан Аав нь хүн төрөлхтнийг бүтээхээсээ ч өмнө өргөө гэрээ урлан төлөвлөсөн учраас, Есүсийг “Дэлхийн сууриас эхлэн Алагдсан Хурга (Илчлэл 13:8) хэмээн нэрлэсэн бол, Петр “Ертөнцийн сууриас өмнө Тэр урьдаас мэдэгдсэн боловч цаг хугацааны төгсгөлд та нарын төлөө илчлэгдэв” (1Петр 1:20) гэжээ.

Есүс суурь бөгөөд булангийн чулуу төдийгүй бас ахлах Барилгачин юм. Есүс даалгавраа хөсөрдүүлээгүй - төгс гүйцэтгэсэн. Есүс цовдлуулахаасаа өмнө “Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав” (Иохан 17:4) хэмээн Аавдаа залбирсан байдаг.

Бурхан Аав гэрийнхээ бүхий л загварыг гаргахдаа, Есүсийг зохих цагт илгээхээр товлосон байжээ. (Галат 4:4) Тэгээд дараа нь бусад гүйцэтгэгч нарын ажлыг хуваарилаж өгчээ. Бусад гүйцэтгэгч нар нь та бид юм. Гэхдээ өмнө хэлсэнчлэн, бид гүйцэтгэгч нар төдийгүй бас Бурханы байшингийн барилгын материал билээ. Паул “Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм” (Ефес 1:4) гэсэн. Энд байшингийн материалын талаар ярьж байгаа бөгөөд тэр амьд чулуунууд нь бид юм.

Бурхан түүнчлэн биднийг гүйцэтгэгч нараар сонгож авсан. Учир нь “...бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ” (Ефес 2:10) гэдэг. Бурхан бидний хийх ажлыг урьдаас бэлтгэсэн гэж байгааг тэмдэглэнэ үү. “Бидний даалгаврыг дэлхийн сууриас өмнө төлөвлөсөн” гэдэг үг Бичээс дээр байдаггүй ч, тийм байх боломжтой. (Еврей 4:3) Гэхдээ нэг л зүйл тодорхой - бидний гүйцэтгэгч байх даалгавар нь биднийг төрөхөөс өмнө товлогдсон байжээ. Үүнийг Давид ч хэлсэн: “Төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан. Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад Бүгд номд тань бичигдсэн байжээ.” (Дуулал 139:16)

Биднийг эхийнхээ хэвэлд бүрэлдээ ч үгүй байхад амьдралын маань ажил урьдаас товлогдсон байжээ. Үүнийг “... Эхийн

хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө Би чамайг мэдэж байсан” хэмээн Иеремиа ном дээр ч хэлдэг. (Иеремиа 1:5) Мөн элч Паул ч хэлсэн: “Харин эхийн хэвлийд байхаас минь сонгон тусгаарлаж, нигүүлслээрээ дуудсан Тэрээр намайг таалж, Хүүгээ миний дотор илчилснээр Түүнийг би харийнхны дунд тунхагладаг юм. Тэр даруй би мах цустай хэнтэй ч зөвлөсөнгүй... .” (Галат 1:15-16) Энэ бүх гэрчлэл нь бид төрөхөөсөө ч өмнө нэгэн даалгаврын төлөө тусгаарлагдсан гэдэг Давидын үгийг бататгаж байна.

Би танд нэгэн гайхмаар үнэнийг дуулгая: Бурхан таныг төрж амжаагүй байхад таны тухай ном бичсэн бөгөөд таныг нэг ч хоноогүй байхад, тэр номд амьдралын чинь эгшин бүр бичигдсэн байжээ. Тэгэхээр хамгийн гол нь бид өөрт төлөвлөгдсөн зүйлсээ биелүүлэх эсэхэд л хамаг асуудал оршино. Соломон:

“Бурханы хийсэн болгон үүрд мөнхөд үлддэгийг би мэдлээ. Түүнд нь нэмэх буюу түүнээс нь хасах юу ч байхгүй аж. Бурхан ийн үйлдсэний учир нь хүмүүс Түүнээс эмээхийн тулд юм. Юу байж байсан, тэр нь одоо ч байж байна. Ирээдүйд буй болох нь аль хэдийнээ байсан. Бурхан өнгөрснийг ийнхүү хайдаг байна” (Номлогчийн үгс 3:14-15) гэсэн.

Энэ Бичээстолон зүйлийг хэлжээ. Нэгдүгээрт - Бурханд төлөвлөгөө бий. Үүний биелэлийг юу ч зогсоож чадахгүй, хүмүүс үүн дээр юу ч нэмэрлэж чадахгүй. Гэхдээ одоо биелж байгаа юмс нь өмнө Бурханы бодолд байсныг Соломон хэлжээ. Ирээдүйд гүйцэтгэгдэх зүйлсийг ч Бурхан бүр өмнө төлөвлөжээ. Гэхдээ бид гүйцэтгэсэн зүйлсийнхээ төлөө л хариуцлага хүлээнэ! Бид Бурханы товлосон зүйлсийн дотор явсан уу? Даалгавраа бантан болгосон уу эсвэл бүр хөсөрдүүлсэн үү? Бидний ажлыг өөр хүн дахиж гүйцэтгэсэн үү?

Яг одоо би маш чухал мэдэгдэл хиймээр байна. Хүн бүрт тэнгэрлэг дуудлага бий. Хүн бүр Бурханы гэрийн мастер төлөвлөгөөний чухал хэсэг. Тиймээс бид үнэнийг мэдэх ёстой:

Дуудлагын тал дээр та юу хийснээрээ биш, харин юу хийхээр дуудагдснаараа шүүгдэнэ!

Нэгэн жишээ хэлье. Шүүх сэнтийн өмнө Есүс нэг иймэрхүү юм хэлж магадгүй: “Сайн мэдээ дэлгэрүүлэгч Андерсон, наашаа

гарч ирээд, газар дэлхий дээр чамд хариуцуулсан ажлынхаа тайланг тавь.”

Андерсон Есүсийн өмнө чичирсээр гарч ирээд: “Эзэнтэн минь, та нягтлан Андерсон гэх гэсэн байлгүй дээ? Би чинь насаараа өөрийнхөө фирмд нягтлангаар ажилласан хүн. Би чинь олон чуулган, төрийн бус байгууллага үүсгэн байгуулсан хүн. Тэдгээр үйлчлэлүүд Таны хаанчлалд олон сүнсийг оруулсан. Та намайг хүнтэй эндүүрсэн болтой!” гэнэ.

Гэтэл Эзэн түүнд: “Үгүй ээ, Би чамайг төрөхөөс ч өмнө Азийн олон хүнийг Над руу дагуул гэж дуудсан. Тэд одоо хаана байгааг тайлагна. Чи Миний үгэнд орсон бол, өдгөө Миний хаанчлалын төлөө хураасан ургацынхаа хариуд үлэмж шагнал авах байлаа. Гэтэл чи Намайг дагаагүй учраас, одоо чиний бүх ажил шатаагдана” хэмээнэ.

Эсвэл өөр нэгэн хүнийг Есүс дуудаад: “Нягтлан Жонс, наашаа гарч ирээд, Миний дуудлагыг хэрхэн биелүүлснээ тайлагна” гэж хэлнэ. Нөгөө хүн мөн л тэвдэж бэмбэгнэсээр урагш гараад: “Эзэн минь, Та намайг пастор гэх гэсэн байлгүй дээ? Би чинь 900 гишүүнтэй чуулганы пастор хүн. Би тэр чуулганыг тэгээс эхлэсэн” гэж хэлтэл, Эзэн:

“Үгүй ээ, Би чамайг нягтлангаар нийгэмд ажиллаж, Миний олон чуулган, үйлчлэлийг Надаас хүлээж авсан даалгавраа амжилтай гүйцэтгэхэд нь дэмжих хүчирхэг фирмийг байгуулаасай гэж хүссэн. Чи Намайг хичээнгүй хайсан бол, Би чамд энэ хүслээ харуулах л байсан. Тийнхүү тэдгээр үйлчлэлээр мөнхөд өөрчлөгдсөн хүмүүс чиний хөдөлмөрийн үр шим болж, чи сүнс бүрийн төлөө шагнуулах байсан юм. Харин чи одоо хийсэн зүйлийнхээ төлөө юу ч авахгүй. Учир нь чи Намайг дагаагүй.

Түүнчлэн Би чамайг одоо чуулган хийдэг хотод чинь биш, харин зэргэлдээх хотын чинь нэгэн чуулганд угтагчийн ахлагчаар томилсон. Хэдийгээр тэр чуулган таван зуухан хүнтэй байсан ч, гишүүд нь нийгэмдээ хүчтэй нөлөө авчирсан. Хэрэв чи Намайг дагасан бол, хорин мянган хүнийг авралд хүргэж, Миний дуудсан энэ биеийн чухал хэсэг болох байсан учраас, тэр хүмүүс шууд чиний үйлчлэлийн үр жимс болох байв. Гэтэл чи тэнд байгаагүй. Тиймээс одоо тэр хорин мянган хүний төлөө ямар ч шагнал авахгүй” гэж хэлнэ.

Харин одоо би яг жинхэнэ түүх ярьж өгье. Манай үйлчлэлийн зөвлөлд Америкийн зүүн өмнөд нутгийн маш мундаг нэгэн

чуулганд пастораар үйлчилдэг миний нэг сайн найз байдаг юм. Тэрбээр 1991 онд чуулганаа 22 хүнтэй эхлүүлээд, одоо 4000 гаруй гишүүнтэй болжээ. Хүмүүс нь Бурханы Үгд үнэхээр хайртай учраас, би ч тэднийд очиж номлох дуртай байдаг. Тэр чуулганд хүмүүс бөөн бөөнөөрөө аврагдаж, дагалдагч болдог.

Тэдний чуулган тогтмол залбирал, хүчирхэг номлол, хүч хөдөлмөрөөр асар хурдан өсч, олон гишүүнээ багтаах маш сайхан сүмийн барилга барьжээ. Хэдэн жилийн дараа найз маань цал буурал үстэй, дэгжин хувцастай нэгэн эрхэм чуулганд нь ирэх болсныг анзаарчээ. Тэр хүн цуглаанаа нэг ч тасладаггүйгээр барахгүй, байнга нулимс дуслуулж суухыг найз маань ажиглахдаа тэр нь баярын нулимс биш болохыг мэдэрчээ.

Гэтэл нэг удаа нөгөө эрхэм тэр чуулганы туслах пастортой уулзаад, 1981 онд Эзэнээс яг тэр хотод чуулган эхлүүлэх үг авснаа бас түүнээс хэдэн өдрийн дараа байгуулах чуулганаа зүүдэндээ үзсэнээ ярьжээ. Бүр дэндүү тод зүүдлэсэн учраас, мэргэжлийн хүн хөлслөн харсан барилгынхаа загвар зургийг гаргуулсан юмсанж. Тэгж байтал яльгүй эсэргүүцэлтэй тулгарч, чуулган эхлүүлэх ажлаа хойшлуулжээ. Үүнийхээ дараа нэг хэсэг янз бүрийн хотоор аялан үйлчилсээр, эцэстээ бизнесийн ертөнцөд тухлаж авсан байна.

Ингэж яриад тэрбээр өврөөсөө нямбайлан эвхсэн цаас гаргаж ирээд, 1981 онд зуруулсан чуулганых нь барилгын зураг болохыг тайлбарлажээ. Туслах пастор зургийг нээж хараад, золтой л ухаан алдчихсангүй. Тэр зураг нь найзын маань бариулсан, өдгөө тэдний цуглаж байгаа чуулганы байр дүрээрээ мөн байв. Найз маань тэр эрхмийг тайтгаруулах үйлчлэл хийсэн ч, тэрбээр энэ явдлыг хэзээ ч мартаггүй хэмээн тайтгарахаас татгалзжээ. (Мэдээж Бурхан түүнийг насаар нь яллах биш, харин алдаанаасаа суралцаж, өсч, үлдсэн амьдралаа Өөрт нь үр нөлөөтэй үйлчлэхэд зориулаасай л гэж хүссэн байгаа)

Хэдэн жилийн өмнө би энэ талаар нэгэн том чуулганд заасан юм. Цуглааны дараа ихэд цочирдож, гоморхсон нэгэн пастор манай багийн нэг гишүүнтэй уулзаад: “Жон үүнийг жинхэнээсээ хэлээгүй байлгүй дээ, айн?” гэжээ.

Гэтэл манай багийн гишүүн түүнд: “Жинхэнээсээ байлгүй яхав. Энэ чинь Бурханы Үг шүү дээ. Та яагаав?” гэжээ.

Тэгтэл тавь гаруй насны тэр пастор: “Би залуу байхдаа Филиппинд амьдарч, тэдний төлөө үйлчилж байна гэж маш тод зүүдлэсэн. Дэндүү тодорхой зүүдлэсэн учраас, би нэг л өдөр тэнд очно гэдгээ шууд мэдсэн. Гэхдээ хэзээ ч яваагүй. Тэгээд одоо энэ чуулгандаа 30 жил үйлчилж байна” хэмээн ярьжээ.

Тэгэхээр нь манай гишүүн: “Тэгээд та одоо яая гэж бодож байна?” гэтэл пастор юу ч хэлэлгүй, яваад өгчээ.

Жилийн дараа тэр пастор манай багийн гишүүнтэй холбогдоод, пасторын ажлаа өгч Филиппинд ирээд, хачин сайхан байгаагаа дуулгажээ. Тэрбээр: “Би амьдралдаа анх удаа яг өөрийнхөө хийх ёстой юмаа хийж байгаа юм шиг санагдаж байна” гэж хэлсэн гэдэг.

Энэ үнэнийг батлах өөр нэгэн түүхийг би хуваалцмаар байна. Саяхан миний нэг найз намайг Тэнгисийн цэргийн тусгай хүчний нэгэн албан тушаалтантай уулзуулахаар оройн зоогт урьсан юм. Тэрбээр одоо ч албаа хааж байгаа учраас, түүний жинхэнэ нэрийг нууцлаад, Паул гэдэг зохиомол нэр өгье. Би түүний ер бусын гэрчлэлийг бүтэн хоёр цаг ангайсаар сонсож билээ.

Паул хорьхон настайдаа Библийн хоёр жилийн коллежийг дүүргээд, чуулганыхаа залуусын хэлтэст ажиллахаар дадлага хийжээ. Гэтэл дадлагынхаа хоёр дахь жилийнхээ зун Паул цуглааныхаа нэгэн охинтой унтсан хэрэгт оржээ. Паул: “Жон, би тэр охинтой унтаагүй. Үнэндээ тэр надад огтхон ч таалагддаггүй байсан! Гэхдээ чуулганы удирдлага тэр хар мэдээнд итгэхээр барахгүй намайг нэр нүүргүй, чадваргүй, хэн ч биш болгож хоослоод, надаас юу ч асуулгүй, зүгээр л хөөчихсөн” гэж хэлсэн юм.

Дараа нь Паул: “Гэхдээ энэ явдал намайг Бурханд улам л наалдуулсан. Тэгээд нэг удаа залбирч байтал, Бурхан надад: “Би чамайг үйлчлэлд дуудаагүй. Би чамайг цэрэгт дуудсан” гэж маш тодорхой хэлсэн” гэж яриу.

Паул Арми, Усан цэрэг, Агаарын хүчинд элсэхээр очсон ч, бүгд орон тоо гүйцсэн гээд аваагүй аж. Ганцхан Тэнгисийн цэрэг л сул орон тоотой байв.

Паулыг бүртгэсэн Тэнгисийн цэргийн офицер Паулд тэнгисийн цэрэгт хийж болох ажлын жагсаалтыг танилцуулсан ч, нэг нь ч Паулын сэтгэлд хүрээгүй учраас, тэрбээр жаахан гонсойжээ. Гэтэл нөгөө офицер шинэ элсэгчээ алдчихгүйг хичээсэндээ,

Тэнгисийн цэргийн зарим нэг шинэ хөтөлбөртэй танилцуулжээ. Тэгээд “тусгай хүчин” гэж хэлэх үед Паул энэ бол түүний дуудлага мөн гэдгийг шууд мэдээд, тэр даруй гэрээ байгуулав.

Гэтэл мөнөөх офицер Паулын зүрхийг үхүүлэх гэсэн шиг дэлхий дээрх хамгийн хүнд цэргийн сургууль болох тусгайгийн энэ бэлтгэл сургуулийг маш цөөхөн хүн л дүүргэдэг бөгөөд тэдний ангиас нэг ч хүн тэнцээгүйг хэлжээ. Гэхдээ Паул Бурханы дуудсан аялалд орсондоо догдлон хөөрч байлаа. Тэрбээр яг үүний төлөө л төрснөө мэджээ.

Гэтэл хэд хэдэн ноцтой бэрхшээл үүсэв. Нэгдүгээрт - Паул сэлж чаддаггүй байлаа. Тиймээс залбираад л сурахаас өөр аргагүй байв. Хоёрдугаарт - байдлыг улам сонирхолтой болгох гэсэн шиг тэрбээр багадаа чихнийхээ сүвийг нээлгэх олон удаагийн мэс засалд орсон бөгөөд тухайн үед ч чихэндээ гуурс тавиулсан байжээ. Үүнээсээ болж чихэндээ багахан ус оруулахад л тэсэхийн аргагүй өвдөж, аюултай халдвар авдаг байв. Гэхдээ Паул Бурханы дуудлага бол хэн дуртайд нь амархан олддог боорцог биш гэдгийг мэддэг байжээ.

Паул сэлж сурсаар бас чихнийхээ төлөө уйгагүй залбирсаар байв. Усны бэлтгэл сургууль амаргүй байсан ч, Паул бууж өгсөнгүй. Ийнхүү хүнд бэрх дөрвөн сарын дараа Паул сэлж сурахаар барахгүй, ямар ч гүнд нэг ч зовиургүй шумбадаг болжээ! Тэр төгс эдгэрч, тусгай хүчний аялалаа үргэлжлүүлэхэд бэлэн болов.

Паул хүнд бэрх эсэргүүцэл, бэрхшээлийг даван туулж байж хөтөлбөртөө тэнцээд, дайн тулаанаар амь нэгтэй болсон цэрэг эрсийн эгнээнд элсжээ. Түүний “Хуурай газар, Агаар, Далайн тусгай хүчинд” 14 жил алба хаахдаа үзсэн Бурханы гайхамшгийн талаарх гэрчлэлийг нь сонсоод, миний хамаг биеийн шар үс босч байв.

Би тэр орой Бурханы аугаа хүнтэй сууж байгаагаа мэдсэн юм. Гэхдээ тэрбээр индрийн ард зогсохоор дуудагдаагүй ажээ. Тэрбээр улсдаа цэргийн алба хааж, цэргийнхэнд хүрэх хүчин чадалтай хүн байв. Өнөөдөр Паул “Хуурай газар, Агаар, Далайн тусгай хүчний” цэрэг биш, харин командлагч болсон. Тэрбээр өөрт төлөвлөгдсөн сайн үйлсдээ хөл тавихын төлөө Бурханаар замаа засуулжээ.

Гэтэл олон хүн Паул шиг амьдралгүй, хувь тавилангаа гэснийг би зөндөө сонсдог бас хардаг. Би хорь гаруй жил даян дэлхийн чуулганд үйлчлэхдээ, миний л харахын туслах пастор байх ёстой тэргүүн пасторуудыг, бүтэн цагаар үйлчлэх ёстой

бизнесмэнүүдийг, бизнес хийж байх ёстой пасторуудыг олонтаа харсан. Бизнесээ өөрөө хөгжүүлж чадахгүй байх гэж айсандаа, бусдад зарагдаж яваа бизнесмэнүүдийг харсан. Бусдыг даргалахыг хүссэндээ өрөөлийн юманд итгэмжгүй хандах хүмүүсийг харсан.

Бурханы хүслээс гадуур гэрлэж, дуудлагаа нураах хүмүүсийг харсан. Бусдын нөлөөгөөр дуудлагаасаа няцан ухрах хүмүүсийг харсан. Зугаа, спорт, мөнгөний тачаалд олзлуулан замаасаа гарсан хүмүүсийг харсан. Энэ жишээ дуусахгүй. Гэхдээ нөхцөл байдлаасаа үл хамааран - хамгийн гол нь тэд үүнээсээ болж Бурханы гэрийг байгуулах мастер төлөвлөгөөнийхөө хэсгийг биелүүлж чадаагүй ажээ.

Энэ үнэхээр хатуу үнэн. Гэхдээ хэн ч ийм харамсалтай төгсөх албагүй юм. Бурхан бидний түүхийн зохиолч учраас, үүнийг биелэл болгохын төлөө бидэнд зам зааж чадна. Тиймээс та яг одоо: “Тэгвэл гүйцэтгэгч хүнийхээ хувьд би юу хийхээр дуудагдсанаа яаж мэдэх вэ?” гэж асуух ёстой. Энэ чухал асуултыг дараагийн бүлгээрээ ярья. Түүнчлэн замаасаа гарсан хүн яаж буцаж зам дээрээ гарах талаар ч ярилцана.

БУРХАНААР ДУУДАГДСАН

Учир нь Бурханы бэлэгүүд ба дуудлага нь буцалтгүй ажээ.
— Ром 11:29

Хүн тэр байтугай бурханлаг, сайн гэмээр зүйлст олзлуулан Бурханы төлөвлөгөөнөөс төөрч болдог гэхээр олон хүнд аймаар санагдаж байгаа байх. Ойлгож байна! Гэхдээ бид бүтэлгүйтэл шийтгэлээс айхаар биш, харин Бурханаас эмээхээр дуудагдсан гэдгийг бүү мартаарай. Эзэнээс эмээхүй нь биднийг “Та нар баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, араас чинь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэх үгийг чих чинь сонсоно” (Исаиа 30:21) хэмээн айлдсан Нэгэний зөвлөгөө дор байлгадаг. Тиймээс одоо Бурханы захиалгын гэрийг барьж байгаа барилгачин хүнийхээ хувьд өөрийнхөө байх ёстой байрыг яаж мэдэхийг сурья.

Нэгдүгээрт:

Та Бурханыг үнэн голоосоо эрэн хайсан уу?

Хувь тавилангаа биелүүлж яваа эсэхийг нь асуухаар хүмүүс: “Биелүүлмээр л байна. Гэхдээ би дуудлагаа мэдэхгүй!” гэдэг. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байж болох юм. Хамгийн түрүүнд өөрөөсөө: “Би Бурханыг үнэн голоосоо эрэн хайсан уу?” гэж асуу. Бурхан Өөрийг нь итгэлээр хичээнгүй эрэн хайж байгаа хүнийг шагнадаг (Еврей 11:6) гэж хэлснээс биш, эргэлзээ гайхшралаар хайж байгаа хүнийг шагнана гэж хэлээгүй. Бурханаас хариулт авахаар үнэн голоосоо хайж байгаа хүн газар дээр юу хийхээр төрснөө мэдэх л болно.

Би Пердю Их Сургуульд оюутан байхдаа итгээд, шууд л надад хандсан Бурханы хүслийг эрэн хайж эхлэсэн юм. Би инженерийн оюутан байсан бөгөөд нэг семестр алгасаад л IBM компанид

дадлага хийдэг байлаа. Бурханыг дагах хүслээс маань гадна намайг дуудлагаа мэдэхэд асар их нөлөөлсөн зүйл нь аврагдснаас минь хэдэн сарын дараа болсон нэгэн явдал байв. Манай компаний арваад эрчүүд албан өрөөндөө нэгнийхээ гучин найман жил компанидаа ажилласны ойг тэмдэглэж байлаа. Тэгээд л ярилцаж байтал нөгөө хүн: “Би гучин найман жилийн турш өдөр бүр энэ компанид ирэхдээ дургүй хүрдэг!” гэж хэлэх нь тэр. Гэтэл надаас бусад нь бүгд л толгой дохицгоов. Би шоконд орлоо.

Тэр архагуудын нэг нь ч өөр үг дуугараагүйд шинэков - би үнэхээр гайхав. Тиймээс: “Та үзэн яддаг байсан юм бол, яагаад гучин найман жил хийсэн юм бэ?” хэмээн асууж орхитол, сайхь эр над руу харснаа:

“Энэ чинь ажил шүү дээ” гэсэн юм.

Тэгсэн би ч бас ажилдаа дургүй болж эхлэв. Аав маань инженер байсан болохоороо инженерийг сайн цалинтай, баталгаатай ажил гэдэг байв. Гэтэл тэр явдал миний үзэл бодлыг өөрчилсөн юм. Би: “Хөрст дэлхийд төрсөн учраа биелүүлэхэд минь ямар ч мөнгө, баталгаа, юу ч саад хийхгүй” хэмээн хатуу шийдэв. Би дуудлагаа заавал олж авахаар шийдэж, үүнийхээ төлөө дараагийн алхмаа хийлээ.

Бурханыг хайвал Тэр бидний амьдралын ерөнхий зураглалыг харуулдгийг би анх итгэсэн цагаасаа л ойлгосон юм. Өөрөөр хэлбэл Бурхан эхэнд нь төгсгөлийг чинь харуулна. Бурхан Иосефийг хүүхэд байхад нь л хожим аугаа удирдагч болж, аав, ах нараараа үйлчлүүлэхийг зүүдэнд нь харуулсан. Гэхдээ энэ нь олон жилийн дараа биелсэн. Мосе Израилийг удирдана гэдгээ мэдсэн. Гэхдээ энэ явдал дөчин жилийн хойно биелсэн. Давид залуу хүү байхдаа л хаан болохоо мэдсэн. Гэхдээ олон жилийн дараа хаан болсон.

Тиймээс би Пердю сургуулийнхаа инженерийн ангийг дүүргээд, Харвардад бизнесийн удирдлагаар магистр хамгаалаад, Америкийн аль нэг том корпорацид өндөр албан тушаал хаших төлөвлөгөөтэй байлаа. Сайхан эхнэртэй, жилд хэд хэдэн удаа амарчихдаг, Бурханд арван хувиа өргөчихдөг болно. Би Бурханд ийм маягаар л үйлчилнэ гэж бодож байлаа.

Гэхдээ Бурханыг эрэн хайх тусам, би үйлчлэлд улам л татагдаж байв. Яг үйлчлэлд нь дурлаагүй ч, Бурханыг дуулгавартай дагах нь сэтгэл ханамж, үр дүн авчирдаг гэдгийг би мэдэхтэйгээ

байлаа. Тэгэхдээ Бурханы хэлсэн бүхнийг юу ч байсан дагана гэж шийдсэнээс хойш Бурхан намайг юунд дуудсанаа ерөнхийд нь харуулж эхлэсэн юм.

1980 - аад оны эхээр Бурхан надад Өөрийг нь дуулгавартай дагасаар байвал, нэгэн цагт Бурханы Үгээр олон улс үндэстэнд нөлөөлнө гэдгийг хэдийн харуулсан байлаа. Мэдээж энэ үг намайг ангайлгасан болохоор, би үүнийг боломжгүй гэж шийдсэн юм. Би үйлчлэлийн талбарт нэг ч танилгүй, жижиг хотын жирийн хүү байлаа.

Бурхан Иосефт, Давидад харуулсан шигээ надад ч бас амьдралын маань эцсийн бүтээгдэхүүнийг харуулсан боловч, хэрхэн хүрэх алхмыг нь харуулаагүй юм. Тиймээс бид “яаж” гэдэг шалтгааныг хайж давхилгүй, итгэл дээрээ зогсох шаардлагатай болдог. Бид Бурханы хэлсэн зүйлд дуулгавартай байж, зорилго руугаа хөдлөх ёстой. Гэхдээ дараагийн алхам маань биднийг зорилго руу минь биш, тэс өөр зүг рүү төөрүүлэх мэт санагдах үе зөндөө бий. Тухайлбал Иосеф зүүдлэснийхээ дараа арваад жил боол явсан нь ямар ч логикгүй алхам шиг харагдана. Тиймээс л бидэнд: “Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ Бүү түшиглэ, өөрийнхөө ойлголтод.Түүнийг мэдэхэд зам бүхэн чинь байг Тэрээр зам харгуйг чинь шулуутгана” (Сургаалт үгс 3:5-6) хэмээн айлдсан буюу.

Коллежийнхоо төгсгөлийн жил бусад оюутнууд Талархлын баяраар 4 хоног гэртээ харьчихсан хойгуур би дотуур байрандаа үлдсэн юм. Тэгээд мацаг барин Бурханд залбиран, амьдралд маань хандсан Бурханы хүслийг эрэн хайв. Хэдэн сарын дараа Бурханаас дараагийнхаа чиглүүлгийг хүлээн авсан ч, энэ нь үйлчлэлээс тэс өөр чиглэл шиг харагдаж байлаа. Үйлчлэх гэж байгаа хүн чинь уг нь Библийн сургууль руу л явмаар. Гэтэл Эзэн намайг инженерийн ажлын ярилцлагад ор гэсэн юм. Тиймээс л Бурхан биднийг өөрийнхөө ойлголтод бүү түшиглэ гэдэг.

Би янз бүрийн компанитай уулзсан ч, Техасын Даллас хот дахь Роквелл Корпорацид ажиллах ёстойгоо шууд мэдэв. Энэ бүхэн ямар ч авцалдаагүй санагдаж байлаа. Учир нь тэнд нэг ч Библийн сургууль байхгүй. Надад газар газраас нийт арван гурван ажлын санал ирж, тэдгээрийн зарим нь Библийн сургуультай хотууд байснаас гадна бүгд Роквеллээс өндөр цалин санал болгосон ч,

Бурхан намайг Роквел руу л чиглүүлж, би ч Бурханыг дагасан юм.

Далласт нүүж ирээд, чуулганд ортол, Эзэн намайг тэр чуулганд суулгагд гэж тушаав. Тэгээд би тэр чуулганд суулгагдснаараа өсч, тэр зам намайг өдий хүргэсэн билээ.

Хоёрдугаарт: Та аль нэг газар суулгагдсан уу?

Энэ бол хүмүүс амьдралд нь хандсан Бурханы хүслийг мэдэж чаддаггүйн хоёр дахь шалтгаан юм. Тэд нутгийн чуулганд суулгагддаггүй. Бурхан бидэнд “ЭЗЭНий өргөөнд тэд суулгагдаж Бурханы маань хүрээнүүдэд тэд цэцэглэнэ” (Дуулал 92:13) гэдэг.

Өөрсдийгөө Бурханы өргөөнд буюу нутгийн чуулганд суулгадаг хүмүүс Бурханы талбайд цэцэглэнэ. Бурханы талбай нь нэг талаараа Христийн Шүүх сэнтий юм. Тиймээс хэрэв бид нутгийн чуулганд бат суулгагдсан бол өнөөдөр ч, хожим шүүгдэхдээ ч цэцэглэнэ. Бурхан ингэж л бүтээсэн.

Хүмүүс биш, Эзэн чуулганыг байгуулдаг. Есүс: “Энэ хадан дээр Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй” (Матай 16:18) гэсэн. Босгох (байгуулах) гэдэг үгийг анхаарна уу. Есүс Өөрөө энд байхгүй байж, яаж чуулганыг байгуулах вэ? Хариулт нь: Өөрийнхөө бие болох биднээр дамжуулан! Тиймээс л Тэр биднийг хамтран зүтгэгчид гэдэг. Тэр бидэнд нигүүлсэл, чадвар, бэлэгээ өгсөн бөгөөд Тэр биднийг ер бусын хүчээрээ хангадаг. Гэхдээ ингэхийн тулд Түүнд ажлыг нь гүйцэтгэх дуулгавартай, захирагддаг савнууд хэрэгтэй. Тэгэхээр “Бид Түүний үгэнд орсондоо чуулганд явж байна уу эсвэл хувийнхаа эрх ашгийг бодсондоо чуулганд явж байна уу?” гэдэг чухал асуулт ургана.

Есүс нутгийн чуулгануудад салбарласан ганц л даяар чуулгантай. Үүнийг батлах олон жишээний нэг нь Илчлэл номд гардаг Ефес, Смирна, Пергам, Туайтер, Сардис, Филадельф, Лаодик хэмээх нутгийн долоон чуулганд айлдсан Есүсийн үг юм.

Бичээс түүнчлэн чуулганыг Христийн бие гэдэг. Даяар чуулган нутгийн чуулган болж салбарладаг шиг, Христийн бие ч нутгийн биесд хуваагдана.

Эзэн бол Өөрийнхөө хүмүүсийг байршуулдаг Нэгэн юм. Паул:

“Харин эдүгээ Бурхан Өөрөө хүссэнчлэн эрхтэн тусбүрийг биед байрлуулжээ” (1Коринт 12:18) гэсэн. Энэ үг таныг цочоож магадгүй. Гэхдээ Аль чуулганд явахаа бид мэддэг юм биш, Бурхан мэддэг!

Бодоод үз. Хүмүүс ихэнхдээ чуулганаа сонгохдоо, Бурханаас хүслийг нь асуулгүй, харин дэлгүүрээс хоол хүнсээ сонгож байгаа юм шиг л сонгодог. Гэхдээ хэрэв та Түүний биеийн зөв байршилд байхгүй байвал, яаж хувь тавилангаа биелүүлэх билээ? Хүний биеийн эд эрхтэн бүр Бурханы ур загвараар уран нарийн холбогдсон байдаг. Гар нь өвдөгнийхээ нүдтэй залгагдчихсан байвал, хэцүүднэ. Тиймээс бид аль нэг хот руу нүүж, цуглаанд нэгдэхдээ Бурханы санаа бодлыг асуух ёстой. Хүн бүр нутгийн чуулганд хамрагдах үүрэгтэй.

Эдүгээ та нар Христийн бие бөгөөд тус тусдаа эрхтнүүд нь юм.

Бурхан чуулганд нэгдүгээрт элч нар, хоёрдугаарт эш үзүүлэгч нарыг, гуравдугаарт багш нар, дараа нь гайхамшиг үйлдэхүй, дараа нь эдгээх бэлгүүд, туслахуй, удирдахуй ба олон төрлийн хэл ярихуйг тавьжээ. (1Коринт 12:27-28)

Паул нутгийн чуулганы үндсэн хэсгийг жагсаан танилцуулжээ. Тэрбээр сунжирсан урт жагсаалт гаргаагүй ч, итгэгч бүр яг л хүний биеийн эрхтнүүд шиг Христийн биеийн хэсэг бөгөөд амин чухал үүрэгтэй байдгийг бид Шинэ гэрээний бусад ишлэлээс ч харж болно. Таны биеийн хөл, нүд, бөөр зэрэг эд эрхтэн биеэсээ салбал, ажиллагаагүй болдог шиг, бид ч Христийн биеийн дотор байхгүй бол ажиллагаагүй болно.

Гэтэл харамсалтай нь нутгийн чуулганууд аймшигтай эрэмдэглэгдснээс болж, Есүс Христийн үйлчлэл бүрэн утгаараа нийгэмд хүрч чадахгүй байна. Нутгийн чуулган яагаад тахир татуу болчихов? Голдуу үр нөлөөгүй удирдагч нараас болж биш, харин итгэгч нар нь толгой мэдэн, тусдаа амьдардаг болсон учраас тэр юм. Хэрэв миний нүд эсвэл хөл эсвэл ул бие дааж амьдарлаа гэвэл юу болох уу? Гэхдээ энэ байдлыг үл харгалзан, Бурхан дэлхий даяар ажлаа хийсээр байгаа нь гайхамшигтай юм.

Анхны чуулганыг харах юм бол, өсөлт нь зүгээр л тэсэрч байсан:

Тэд, элч нарын сургаалд мөн нөхөрлөлд, талх хуваалт, залбиралд өөрсдийгөө зориулдаг байлаа. Хүн бүрд айдас байлаа. Учир нь элч нараар [Иерусалимд] олон гайхамшиг, тэмдэг үйлдэгдэж байв. Итгэсэн бүгд хамтаараа байцгаан, бүх юм нь нийтийнх байв. Хэн нэгэнд хэрэгцээ гарах үед эзэмшил, өмч хөрөнгөө худалдаж, түүнийгээ бүгдэд тэд түгээдэг байлаа. Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж, талархал хийгээд өгөөмөр зүрхээр хооллоцгоон, Бурханыг магтаж, хамаг ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн, аврагдагсдыг тэдэн дээр өдрөөс өдөрт нэмэгдүүлж байлаа. (Үйлс 2:42-47)

Итгэгчид нутгийнхаа чуулганд суулгагдсан байсныг харж байна уу? Тэд хамтдаа магтаж, үг сонсож, нэгэн алсын хараан дор хамтдаа амьдарсан. Үүний ачаар чуулган эрүүл бойжсон. Хүмүүс нутгийнхаа чуулганаар дамжуулан Эзэнд үйлчилж, энэ үйлчлэл нь гэр бүлүүдэд нь ч нөлөөлжээ.

Учир нь анхны итгэгчдийн хувьд чуулганы салшгүй хэсэг байх нь тэдний амьдрал байжээ. Яваандаа зарим бэлбэсэн эмэгтэйчүүлд хоол хүрээгүйгээс болж асуудал үүссэн. Элч нар нутгийн итгэгчдийн биеийг цуглуулаад, удирдагч нар Үгийн үйлчлэлээ цалгардуулж, тогоо шанаганы асуудалтай хутгалдах нь зөв биш гэдгийг хэлжээ: “Тиймээс ах дүү нар минь, Сүнс болон мэргэн ухаанаар дүүрэн, нэр хүнд бүхий долоон эрийг та нар дундаасаа сонго. Тэгээд энэхүү үүргийг тэдэнд хариуцуул.” (Үйлс 6:3)

Удирдагч нар: “Бидэнд сайн дурынхан хэрэгтэй байна. Цаг заваа зориулан, тэдгээр настай эмэгтэйчүүлд хоол хүнс хүргэх хүн байна уу?” гэж хэлээгүй байгаа биз. Бүх итгэгчид чуулгандаа суулгагдаж, үйлчлэлд зориулагдсан байжээ. Би л хувьдаа хүн бүр битүүхэндээ энэ үйлчлэлд сонгогдчих юмсан хэмээн горьдож байсан байх гэж боддог. Гэтэл долоон эр сонгогджээ...

Тэгээд тэднийг элч нарын өмнө ирүүлэхэд тэд залбирцгааж, гараа тэдэн дээр тавив. Бурханы үг түгэн тархсаар Иерусалим дахь дагалдагчдын тоо үлэмж ихээр нэмэгдсээр байсан бөгөөд тахилч нараас маш олноороо энэхүү итгэлд дуулгавартай болж байлаа. (Үйлс 6:6-7)

Элч энэ долоон эр дээр гар тавьсан. Энэ тосолгоо нь индрийн үйлчлэл, гэрийн бүлэгт заах, магтаал хүндэтгэл удирдах, үйлчлэлийн аянд явах тосолгоо биш, зүгээр л чуулганы бэлбэсэн эмэгтэйчүүд л хоол хүнс хувааж өгөх үйлчлэл байсан. Ёстой гайхмаар!

Гэхдээ долоон эр бие дотроо энэхүү нэг их ач холбогдолгүй гэмээр үйлчлэлээ хийж эхлэх үед Иерусалимд Бурханы Үг түгэн тархаж, дагалдагч нарын тоо үлэмж үржжээ. Энд нэгэн гайхамшигтай баримт байна. Үйлс 1-5-р бүлэгт Иерусалимын чуулганы өсөлтийг хэд хэдэн удаа нэмэх үйлдлээр дүрслэсэн байдаг. Жишээлбэл:

Ийнхүү түүний үгийг хүлээн авагсад баптисм хүртэцгээв. Тэр өдөр гурван мянга орчим хүн нэмэгджээ. (Үйлс 2:41)

Бурханыг магтаж, хамаг ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн, аврагдагсдыг тэдэн дээр өдрөөс өдөрт нэмэгдүүлж байлаа. (Үйлс 2:47)

Эзэнд улам олон хүн итгэж, эрэгтэй, эмэгтэйчүүд олноороо тогтмол нэмэгдэж байлаа. (Үйлс 5:14)

Гэтэл нэг өдөр итгэгчид нь хүн бүр чуулгандаа үүрэг хариуцлагатай болохоо ухаарчээ. Нэгдүгээрт - бусдадаа Сайн мэдээг тунхаглаж, номлох ёстой. Хоёрдугаарт - нутгийн чуулганд үүрэг хүлээх ёстой.

Бүх итгэгчид Есүсийн амилсан гайхамшигт түүхийг ярих ёстойгоо ухаарсан явдлыг Үйлс 5:42-6:1 дээр бичсэн байдаг: “Тэгээд өдөр бүр сүм дотор бас айлаас айлд зааж, Есүс бол Христ гэдгийг тунхаглахаа эс зогсоов. Шавь нарын тоо олширсон (үржсэн) өдрүүдэд...”. Тэр үед зурагт, радио, интернет байгаагүй тул Петр айл бүрт очиж номлож чадахгүй байсан. Тиймээс итгэгч бүр өөрийнхөө хөршид Есүс Христийн Сайн мэдээг хүргэх ёстой байв. Харин үүний дараа чуулган нэмэх үйлдлээр биш, харин үржих үйлдлээр өсчээ. Ингэж Үйлс номд анх удаа үржлээр өссөн түүх гардаг.

Гэхдээ үржлийн динамик нь үүгээр зогсоогүй. Итгэгчид бүгд чуулгандаа үйлчилж эхлэсний дараа (тухайлбал бэлбэсэн

эмэгтэйчүүдэд хоол хүнс хүргэх эрчүүдийн үйлчлэл зэрэг) дагалдагч нарын тоо зүгээр нэг үржээгүй, харин бүр замбараагүй үржсэн гэжээ. Замбараагүй үржил нь замбараагүй өсөлт юм.

Тэгвэл би танд нэмэгдэх өсөлт болон замбараагүй үржлийн ялгааг хэлж өгье. Жишээлбэл сар бүр Эзэн рүү 10,000 хүнийг дагуулдаг пастор байжээ. Энэ нь яахын аргагүй хүчирхэг үйлчлэл мөн. Гэхдээ бүх дэлхийд хүрэхэд тэр пасторт ямар хугацаа хэрэгтэй вэ? Хариулт нь 50,000 жил бөгөөд энэ нь хүн төрөлхтний дэлхий дээр амьдарч байгаагаас найм дахин урт хугацаа гэсэн үг юм. Тэгэхээр, энэ ямар ч боломжгүй!

Тэгвэл замбараагүй үржлийн жишээ хэлье. Та хоёр хүнийг Эзэн дээр авчраад, нутгийн чуулгантай холбож өгчээ. Гэтэл дараагийн сар нь тэр хоёр чинь хоёр хүнийг Эзэн дээр авчирчээ. Дараагийн сар нь нөгөө дөрөв чинь яг адилхан зүйл хийж, дараагийн сар нь нөгөө найм чинь дор бүрнээ хоёр хүнийг Эзэн дээр авчран, нутгийн чуулганд суулгажээ. Энэ загвар үргэлжилсээр байвал, дэлхийн хүн амыг Сайн мэдээгээр байлдан дагуулахад хэр хугацаа шаардлагатай гэж бодож байна? Ердөө л гучин гурван сар. Тийм ээ, гурав ч хүрэхгүй жил! Энэ бол замбараагүй үржил.

Тэгэхээр одоо та Библийн үгийг ойлгож байна уу?

“Ингэсээр Азид суурьшсан бүх иудей, грекүүд хоёр жил өнгөрөхөд Эзэний үгийг сонсоцгоожээ.” (Үйлс 19:10)

Бүх хүн ам! Бичээс бүх гэж хэлсэн л бол, бүх хүн гэсэн үг юм. Бид хотын тухай биш, бүхий л орон нутгийн тухай ярьж байна. Тэдэнд хиймэл дагуул, зурагт, олон нийтийн хэрэгсэл, машин, дугуй ч байгаагүй. Энэ бол замбараагүй өсөлт.

Ийм өсөлтийг үзэхийн тулд итгэгчдийн эрүүл бие шаардлагатай. Харин итгэгчдийн эрүүл бие нь нутгийн чуулганд суулгагдаж, үйлчилдэг итгэгчдээс бүрдэнэ. (бэлбэсэн эмэгтэйчүүдийг хооллох, угтах, машины зогсоол дээр зохицуулах, мэндчилэх, шоронгийн үйлчлэл, хүүхдийн үйлчлэл гэх мэт үйлчлэлүүд) Үйлчилдэг хүмүүс нь бас ажиллаж амьдардаг газрынхаа хүмүүст хүрч, тэднийг нутгийн чуулганд суулгажээ. Есүс биднийг зүгээр нэг итгэгчдийг биш, харин дагалдагч нарыг бий болгоорой гэсэн. Бид сайн мэдээгээр итгэсэн хүмүүст Есүсийн тушаасан бүхнийг

(Матай 28:20) зааж өгөхийн тулд тэднийг чуулгандаа суулгах ёстой. Хүмүүсийг Христийн дотор төгөлдөршүүлэхэд, нутгийн бие бүхлээрээ бүхий л бэлгээрээ ажиллах ёстой.

Хамгийн гол нь чуулган дотор суулгагдах ёстой. Тэнд л бид цэцэглэнэ. Та анзаарсан бол, бэлбэсэн эмэгтэйчүүлийг хүнсээр хангах үйлчлэлд сонгогдсон долоон эрийн нэг нь Филип байгаа. Гэтэл хожим нь Үйлс номд түүнийг Сайн мэдээ дэлгэрүүлэгч Филип гэсэн байдаг. Тэгэхээр тэрбээр одоо олон хотыг хамарсан өргөн хүрээний үйлчлэл хийдэг болжээ. “Маргааш нь бид явж, Кайсарид хүрч ирээд мөнөөх долоогийн нэг болох сайнмэдээ тунхаглагч Филиппийн гэрт очиж, түүнтэй хамт байлаа.” (Үйлс 21:8)

Хэдийгээр Филип одоо мундаг Сайн мэдээ дэлгэрүүлэгч болж, Эзэнээр өөр хот руу шилжүүлэгдсэн ч, олон түмэн түүнийг бэлбэсэн эмэгтэйчүүдэд үйлчилдэг долоон эрийн нэг гэдгээр нь мэдсээр байжээ. Филип анх нутгийн чуулганд үйлчилснийхээ ачаар л амьдралынхаа дуудлагад хөл тавин оржээ. Би хүмүүст: “Та аугаа зүйл хийхээр дуудагдсан байж болно. Гэхдээ нутгийн чуулганд суулгагдахаас нааш хэзээ ч зүй ёсоороо өсч төлөвшихгүй” гэж хэлдэг юм.

“ЭЗЭНий өргөөнд тэд суулгагдаж Бурханы маань хүрээнүүдэд тэд цэцэглэнэ” (Дуулал 92:13) гэдгийг дахиад хэлье. Суулгагдах гэдэг үгийг бодоод үз. Хаанчлалын үйл ажлыг ойлгохын тулд үр ба ургацын хуулийг ойлгох ёстой. Үр, хөрс, ургацын зарчмыг ойлгоогүй хүн Түүний бүх сургаалт үлгэрийг ойлгохгүйг Есүс дагалдагч нартаа хэлсэн байдаг. (Марк 4:13)

Товчхондоо Бурханы хаанчлал нь тэрчигээрээ ийм ажээ:

Тэр —Бурханы хаанчлал нь газарт үр цацаж байгаа хүнтэй адил юм. Шөнө нь унтаж, өдөр нь боссоор, үр яаж урган өсөж байгааг тэр өөрөө ч мэдэхгүй. Газар эхлээд өөрөөсөө үрийг соёолуулж дараа нь түрүүг, тэгээд боловсорсон тариаг бий болгодог. Харин үр боловсормогц, ургац хураах цаг болсон тул тэр даруй хадуур хүргэнэ гэв. (Марк 4:26-29)

Надад атга үр байжээ гэж бодъё. Бүгдээрээ л миний мэдэхгүй жимсний модны үр. Харин ямар үр болохыг нь би зөвхөн тарьж ургуулснаараа л мэднэ.

Бурхан хүн бүрийн дотор урьдаас төлөвлөсөн дуудлага,

үүнийгээ биелүүлэх бэлэг суулгасан байдаг. “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ.” (Ефес 2:10) Учир нь Бурханы бэлгүүд ба дуудлага нь буцалтгүй ажээ.” (Ром 11:29) Бидний дуудлага, бэлэг нь анхандаа үр хэлбэртэй байдгийг Есүс хэлсэн. Би өөрийгөө чуулганд тарьбал, Бурханаас өгөгдсөн хувь тавиландаа хүрнэ. Үгүй бол, амьдрал дахь бэлэгээ Бүтээгчийнхээ хүссэн юмст биш, өөр юмст хэрэглэнэ. Тиймээс дэлхийн жишгийн дагуух амжилтад бүү мэхлэгд. Та бэлэгээр амжилттай байж болох ч, Эзэнийхээ төлөвлөгөөний дагуу хэрэглээгүй байх боломжтой.

Жишээлбэл: хүмүүсийг нус нулимстай нь хутгатал мундаг ярьдаг хүмүүс байдаг. Уг нь энэ бэлэг нь тэдэнд Бурханыг алдаршуулж, хүмүүсийг Бурханы зүрх хүслийн араас явуулахын төлөө өрдөхөөр өгөгджээ. Гэхдээ тэд аврагдаагүй, чуулганд суулгагдаагүй учраас, хэзээ ч хувь тавилангаа биелүүлж чадахгүй.

Энэ бол амьд ахуйдаа Есүс дээр хэзээ ч ирээгүй хүмүүсийн жишээ юм. Гэтэл Есүст зүрхээ өгсөн боловч, чуулганд тогтмол явдаггүй хүмүүс бас бий. Тэд ч бас суулгагдаагүй учраас хаанчлалын дээд дуудлагаа биелүүлж чадахгүй. Тэд чуулганаас гадуурх хүмүүст нөлөөлөхөөр дуудагдаж, үүнийгээ ч мундаг хийж байж болох ч, чуулганд суулгагдсан бол хавьгүй хүчирхэг нөлөө авчрах байжээ.

Эсвэл хүн бэлэгээ зөв гэж үзсэн арга ухаанаараа хэрэглэж болох ч, модыг тарьж ургуулахаас нааш тэр модны төрлийг (хэлбэрийг, дүрсийг, хүчийг) олж мэддэггүй шиг, та нутгийн чуулганд суулгагдахаас нааш Бурханаас өгөгдсөн хувь тавилангаа олж мэдэхгүй. Энэ бол хүний биш, Бурханы ур ухаан юм.

Итгэгчдийн өөр нэгэн түгээмэл алдаа нь чуулганаас чуулган руу нүүх явдал юм. Өнөөдөр эрчүүд, эмэгтэйчүүд чуулганыхаа нэн ялангуяа удирдлагад дургүйцбэл, шууд явдаг. Удирдлагынхаа хэв маягт дургүй, өргөлөө авч байгаа хэлбэрт нь дургүй, мөнгөө зарцуулж байгаа аргад нь дургүй гэнэ. Эсвэл пасторынх нь номлол таалагддаггүй, пастортайгаа уулзаж чаддаггүй, пасторыгаа дотор нь орсон юм шиг мэддэг, бусад гишүүд нь таалагддаггүй, өөрийг нь тоосонгүй гэсэн гомдлоор явдаг. Тэд бэрхшээлтэй нүүр тулж, найдвараа хадгалахын оронд асуудалгүй газар руу зугтдаг.

Гэхдээ үнэндээ Есүсээс өөр төгс пастор юмуу чуулганы гишүүн байхгүй. Тэгвэл Барууныхан бид яагаад асуудалтайгаа нүүр тулж, шийдвэрлэхийн оронд зугтана вэ? Бид өөгүй удирдлага, гишүүнтэй чуулганы эрэлд чуулганаас чуулган руу нүүсээр явна.

Гэхдээ Бурхан биднийг суулгасан газраас чөтгөр биднийг гомдоож, зайлуулахыг хүсдэг. Дайсан таныг зайлуулж дөнгөбөл, санаандаа хүрлээ гэсэн үг. Харин хэрэв та ямар ч том зөрчил дунд хөдлөхгүй бол, дайсны санааг нурааж, Бурханы төлөвлөгөөг биелүүлнэ.

“ЭЗЭНий өргөөнд тэд суулгагдаж Бурханы маань хүрэнүүдэд тэд цэцэглэнэ” гэдгийг битгий мартаарай. Хэрэв та аль нэг ургамлыг гурван сар тутам шилжүүлэн суулгаад байвал, юу болох вэ? Байнга шилжүүлэн суулгаснаас болж, цочроонд орж, үндэс нь муудаж, хүчин чадалдаа тултал ургаж, цэцэглэж чадалгүй үхнэ.

Олон хүн дуудлагаа биелүүлэхээр хичээхдээ, чуулганаас чуулган руу нүүдэг. Бурхан өөрийг нь хаана суулгасныг мэдэхгүй хүн байнга гомдол гаргана. Ямарваа зүйлийг яг тэдний хүссэнээр хийхгүй бол, тэд удирдагч нараа буруутгаад л, гомдоод л яваад өгнө. Тэд өөрийнхөө алдаа дутагдлыг ч харахгүй, энэ дарамтаар дамжуулан Бурхан тэднийг цэвэршүүлж байгааг ч ухаарахгүй. (Энэ явдал зөвхөн үйлчлэлд биш, гэрлэлт, ажлын газар тэргүүтэй бүхий л харилцаанд гардаг)

Тэгвэл Бурханы хэлсэн ургамал, моддын жишээнээс сурцгаая. Хөрсөнд суулгагдсан жимсний мод аадар бороо, халуун нар, шуурганд цохиулна. Тэгтэл тэр залуу мод хүний хэлээр: “Намайг эндээс аваач! Халуу шатдаггүй, салхи, шуургагүй сайхан газар тавиач!” хэмээн үглэжээ.

Цэцэрлэгч модны хүслийг биелүүлбэл, модыг аврах биш алж орхино. Халуун нар, аадар, шуурганд моддын үндэс хөрс рүү улам шигдэж бэхэждэг. Бэрхшээлийн ачаар л мод маш тогтвортой болно. Хатуу ширүүн нөхцөл нь моддыг амьдрах өөр эх үүсвэр рүү тэмүүлэхэд хүргэдэг. Нэг л өдөр тэд ямар ч шуурганд ажрахгүй үр жимсээ өгдөг, саглагар бүдүүн модод болно. Тиймээс л бид Бурханы зөвшөөрсөн бэрхшээлээс зугтах ёсгүй юм.

Гуравдугаарт: Та чөдөртэй байна уу?

Хүмүүс дуудлагаа мэдэж чаддаггүйн сүүлийн шалтгаан нь чөдөртэй явах юм. Хүмүүс дэндүү их ачаатай учраас, гүйлтээ дуусгаж чадалгүй, замаасаа гардаг.

Паул өөрийнхөө талаар: “Гэвч би Бурханы нигүүлслийн сайнмэдээг гэрчилж, Эзэн Есүсээс хүлээн авсан үүрэг, албаа гүйцээхийн тулд өөрийн амиийг юман чинээ бодолгүй явж ирсэн” (Үйлс 20:24) гэжээ. Паул юу хийхээ ч мэдэж байсан, үүнийгээ дуусгах ёстойг ч мэдэж байсан. Яаж мэдсэн бэ гэж үү? Яг л Есүс шиг, яг л Петр шиг. (2Петр 1:14-ийг үзнэ үү) Яг л Бурханыг эрэн хайж, өөрсдийгөө чуулганд суулгаж, тэвчсэн хүмүүс шиг. Бурханы хүслийг Өөрийнхөө амиас дээр тавьдаг хэнд ч Бурхан хүслээ илчилдэг. Энэ бол сүүлийн түлхүүр: Бид Бурханд амьдралаа бүрэн өргөхдөө л дуудлагаа мэдэж бас биелүүлнэ.

Үүнийг Сайн мэдээнээс харж болно. Нэгэн өдөр Есүс нэг хотоос нөгөө рүү аялаж явжээ. “Тэднийг замд явж байтал нэгэн хүн Түүнд —Би Таныг хаа ч явсан дагая” гэв. (Лук 9:57)

Тэр хүн энэ үгээ тун баяртайгаар, халуун сэтгэлээр, үнэн голоосоо хэлжээ. Тэрбээр Есүсийг эцсээ хүртэл дагахыг хүсэв. Гэтэл Есүс энэ их баяр хөөрийн цаадах далд сэдэл, зүрхнийх нь урхийг олж харжээ. Тэр хүнд хувь тавилангаа биелүүлэхэд нь ачаа байгааг Есүс мэдээд: “Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр байдаг ч Хүний Хүүд толгой хоргодох газар ч үгүй” (Лук 9:58) гэжээ.

Тэр хүн баталгаатай амьдралд дуртай нэгэн байв. Магадгүй сайн ажилтай, сайхан гэртэй, тэтгэврийн хадгаламжтай байсан байх. Гэтэл Есүс тэр хүний амьдралын баталгааг нь хөндөөд, Өөрт нь толгой хоргодох орон байр ч байхгүйг хэлжээ.

Тэгмэгц нөгөө хүн бас дэргэд нь байсан хэсэг хүмүүс бага багаар гэдрэг ухарсаар, арилж одохоосоо өмнө: “Есүс ээ, ерөөсөө би Таны цуглаанд угтагч хийж, магтаалын багт тоглож, чуулганд ирж байгаа настай хүмүүсийн машиныг зогсоол дээр байршуулах үйлчлэл хийе” гэсэн байх. Есүсийн хатуухан үгийн дараа тэр хүний нөгөө их сүр дуулиан намжиж, Есүст үйлчлэх бадруун сэтгэл нь унтарчээ. Тиймээс тэр хүнээр “ахлуулсан” олон хүн Есүст амьдралаа зориулалгүй, зүгээр л сэтгэлээрээ дэмжиж явахаар шийджээ.

Тэгтэл Есүс Өөрийг нь дагахыг хүссэн өөр нэг хүн рүү хараад: “Намайг дага” гэв. Тэр хүн зөвшөөрсөн ч: “... Эзэн, эхлээд явж эцгээ оршуулахыг минь надад зөвшөөрөөч” гэжээ.

“Гэтэл Есүс —Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла” хэмээв. (Лук 9:59-60)

Ямар аймаар хатуу үг вэ! Зарим хүн Есүсийг мэдрэмжгүй, харгис гэх байх. Гэхдээ бид тэр үеийн соёлыг ойлгох хэрэгтэй. Тэр үед ууган хүү нь өөд болсон аавыгаа оршуулбал, дүү нараасаа хоёр дахин их өв хүртдэг ёстой байжээ. Харин ууган хүү нь аавыгаа оршуулахгүй бол, удаах хүү нь хоёр дахин их хувийг хүртдэг байсан гэж эрдэмтэд хэлдэг.

Тиймээс тэр хүн мөнгөө л боджээ. Тэгээд сайхан амьдрах хүслээсээ болоод яваандаа Есүсээс холдох байсан биз. Тэр хүнээс Бурханы төлөвлөгөөн дээр биш, мөнгөн дээр суурилсан шийдвэр л гарна.

Эзэний хатуу үгийг сонсоод тэрбээр бусдынхаа адил алхам алхмаар ухаарсаар зугтаж одохдоо, Есүст нэг иймэрхүү юм хэлээ байх: “Есүс ээ, ерөөсөө Та манай хотод цуглаан хийбэл, би зохион байгуулж өгье. Эсвэл найрал дуунд дуулах юмуу бөмбөр тоглоё. Танд бол үнэгүй хийж өгнө шүү.” Эзэний хатуу үгийн дараа түүний болоод өөр олон хүний Есүсийг дагах халуун хүсэл унтарчээ.

Тэр хүн Есүсийг дагахгүй гэж хэлээгүй, дагана гэсэн. Гэвч түүний гол алдаа нь “гэхдээ эхлээд” гэдэг үгд нь байсан юм. Тэрбээр эхлээд амьдралаа баталгаатай болгочихоод, дараа нь Есүсийг дагахаар тооцоолжээ.

Амьдралд нь хандсан Бурханы төлөвлөгөөг мэдэж, биелүүлэх гэж байгаа хүн юуг ч Бурханы хүслээс дээр тавьдаггүй. Өөрийнхөө хүслийг тэргүүнд тавьснаасаа болж Бурханы үгэнд орохоос ухарч байгаа олон итгэгчдийг би харсан. Тэд дуудлагаа алдсан нь харамсалтай. Тэдний оронд өөр хүн гарч ирээд ажлыг нь гүйцэтгэдэг. Тийм хүмүүс Шүүх сэнтийн өмнө яаж шүүгдэх бол?

Буцаад түүх рүүгээ оръё. Тойрог улам л жижгэрсээр. Гэтэл бас нэг хүн Есүсийг дагадаг “баатар” болов:

“Эзэн, би Таныг дагана. Эхлээд гэрийнхэнтэйгээ салах ёс

гүйцэтгэхийг Та зөвшөөрөөч гэхэд харин Есүс — Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харагч хэн боловч Бурханы хаанчлалд үл тэнцэнэ гэж айлджээ.” (Лук 9:61-62)

Энд ч бас “эхлээд” гэдэг үг гарч байгааг анхаарна уу. Тэр хүн гэр бүлдээ эсвэл найзууддаа юмуу найз охиндоо жигтэйхэн хайртай болтой. Уг нь тэр зүгээр л тэдэндээ Галилын Хүнийг дагах болсноо дуулгачихаад ирье л гэсэн. Гэхдээ Түүний гэр бүлтэйгээ тогтоосон энэ үй зайгүй харилцаа нь л хожим Есүст үйлчлэхэд нь саад болох учраас, Эзэн түүнийг хаанчлалын төлөө үйлчлэхэд тэнцэхгүй гэдгийг нь түс тас айлджээ.

Тэр хүн ч бас олонхитой хамт гэдрэг ухарсаар, явахаасаа өмнө: “Есүс ээ, би олон нийттэй харилцах тал дээрээ сайн. Би Таны үйлчлэлийн зөвлөх болоод Танд маш сайн ажилчид олж өгч болох юм. Бас хэрэв Та манай хотод цуглаан хийх юм бол, би зохион байгуулж өгье. Цуглааны чинь бүх угтагчдын багийг би ахлая. Хүсбэл би өөрөө ч Таны бие хамгаалагчаар үйлчилж болох юм. Та холбогдоорой!” гэсэн байх.

Түүний хамт Есүсийг дагахаар хөөрцөглөж байсан бөөн бөөн хүмүүс ч тарцгааж, дал гаруй л хүн үлджээ. Анх магадгүй мянган хүн байсан байх. Гэхдээ хүмүүс баталгаатай амьдрал, мөнгө, харилцаа гэсэн чөдрөөс болж, Өөрийг нь дагаж, хувь тавилангаа биелүүлж чаддаггүйг Есүс шууд гаргаж илчилсний дараа бүгд алга болжээ. Мэдээж зугаа цэнгэл, Бурханы хүслээс гадуурх юмст дурлах зэрэг өөр олон чөдөр байгаа ч, эдгээрийг ерөнхийд дээрх гурван хэсэгт ангилж болно.

Сайн мэдээг уншиж байхад, шинэ бүлэг рүү орох шилжилтээс болоод олон хүн Лукын дараах чухал мэдэгдлийг анзааралгүй өнгөрдөг. Гэхдээ Лук ном нь анхандаа нэг л үргэлжилсэн захидал байсныг сануулмаар байна. Яваандаа л чуулган уншиж, эш татахад хялбар болгох үүднээс бүлэг, шүлгээр зүйчилж өгсөн юм. Тэгэхээр Лук ингэж хэлжээ:

“Дараа нь Эзэн өөр далан хүнийг томилж Өөрийн очихоор яваа хот, газар бүрд тэднийг хоёр хоёроор нь урьдчилан илгээв. Тэр тэдэнд айлдахдаа — Ургац арвин ч ажилчид нь цөөн байна. Тиймээс ургацдаа ажилчид явуулахыг ургацын Эзэнээс гуйцгаа.” (Лук 10:1-2)

Энд ишлэлд маш олон зүйл гарч байна. Нэгдүгээрт - “дараа нь” гэдэг үгийг анхаарна уу. Тиймээс бид юуны дараа гэж асуух хэрэгтэй. Тэгвэл Есүс Өөрийг нь бүчиж байсан бөөн бөөн хүмүүс тарж яваад, “Би Таныг ямар ч үнээр хамаагүй дагана!” гээд шийдчихсэн цөөн хэдэн хүн үлдсэний дараа юм. Тэд баталгаатай амьдрал, мөнгө, харилцааны талаар Есүс юу гэж ярихыг сонссон ч, эдгээрээс болж Бурханы доторх хувь тавилангаасаа няцахыг хүсээгүй.

Дараа нь Есүс магадгүй үлдэж хоцорсон хэдхэн хүн болох далан шинэ гишүүнээ томилжээ. Шинэ гэрээнд томилох, сонгох гэдэг үгс нь ижил утгаар хэрэглэгддэг. Томилогдсон хүн нь сонгогдсон хүн бөгөөд сонгогдсон хүнийг томилдог байв. Есүс Матайн Сайн мэдээний хоёр хэсэгт яг адил мэдэгдэл хийсэн юм. Хэрэв Есүс нэг үгийг нэг номон дээр давтаж хэлсэн л бол, бид үүнийг нь заавал анхаарах ёстой. “Учир нь олон хүн дуудагдсан ч, цөөн хүн сонгогдсон.” (Матай 20:16, 22:14)

Олон хүн дуудагддаг. Хэдэн хүн гэж? Яг үнэндээ бүгдээрээ! Итгэгч хүн бүр амьдралдаа дуудлагатай, үүнийгээ биелүүлэх бэлэгтэй байдаг. Гэхдээ маш цөөхөн хүн л дуудлагаа биелүүлэхээр томилогдсон юмуу сонгогдсон байдаг. Яагаад цөөнхийг л томилдог юм бэ? Яагаад гэвэл маш цөөхөн хүн л амьдралынхаа дуудлагыг биелүүлэхийн төлөө амин хувийнхаа хүсэл, баталгаа, мөнгөний тачаал, зангуутай харилцаагаа хаях зүрхтэй байдаг.

Есүс: “Ургац арвин ч, ажилчид цөөн байна” (Матай 9:37) хэмээн айлдсныг анхаараарай. Бурхан “бүх хүн аврагдаж, үнэний мэдлэгт ирээсэй гэж хүсдэг” (1Тимот 2:4) учраас, манай үеийнхэнд Сайн мэдээ хүрэхгүй байгаа нь Бурханы буруу биш юм. Үүний төлөө Бурханы Шүүх сэнтийн өмнө бид л хариуцлага хүлээнэ. Бид дуудлагаа биелүүлбэл, шүүгдэхгүй. Харин янз бүрийн чөдрөөсөө болж дуудлагаа биелүүлэхгүй бол, хатуухан л шүүгдэх байх даа.

Та өөрийгөө: “Би ганцаараа юу хийж гийгүүлэхэв дээ” гэж бодож байна уу? Гэхдээ таны элэг: “Би энэ том биеийн өчүүхэн эрхтэн, намайг хэн ч хардаггүй. Тиймээс би хийхээр бүтээгдсэн юмаа биш, өөрийнхөө хүссэн юмыг хийлээ” гэж хэлбэл юу болох вэ? Элэггүй бие том асуудалд орно. Эсвэл уушги, хөл чинь ингэж хэлбэл яах уу? Биеийн бүх эд эрхтэн амин чухал байдаг шиг, чуулганы гишүүн бүр ач холбогдолтой юм.

Нэгэн чухал баримт хэлье. Есүс Бурханы гэрийг барьж байгаа

гүйцэтгэгч нараас тун цөөхөн нь л хувь тавилангаа биелүүлнэ гэж хэлсэн. Итгэгч хүн бүр барилгачин байх дуудлагатай ч, маш цөөхөн нь л барилгаа барьж дуусгах ажээ. Тэгэхээр Шүүх сэнтийн өмнө дийлэнх итгэгчид сүр жавхлантай шагнал авах биш, алдагдал хүлээх нь байна.

Энэ тун муухай мэдээ. Гэхдээ сайхан мэдээ байна аа: та одооноос бүгдийг шинээр эхлэж болно. Өвдөг дээрээ сөхрөөд, өнөөг хүртэл янз бүрийн уяа чөдрөөс болж танд хандсан Бурханы хүслийг дагаж чадаагүйдээ Бурханаас уучлал эрээд, дараа нь алхам алхмаар урагшил. Хорьдугаар зууны аугаа Сайн мэдээ дэлгэрүүлэгч Смит Уиглесворт тавин насандаа л үйлчилж эхлэсэн гэдэг. Тиймээс та оройтоогүй байна.

Хожим Бурханы Шүүх сэнтийн өмнө шатчихгүй, сайн амьдрал байгуулахын тулд: Нэгдүгээрт- Бурханыг итгэлээр хай. Хоёрдугаарт - Бурханы заасан нутгийн чуулганд суулгагдаад, нутгийн биеийн удирдлагад дуулгавартай захирагд. Гуравдугаарт - амьдралынхаа уяа чөдрөөс сал. Юу танд уяа чөдөр болж байгааг Бурхан харуулна. Тиймээс таны сэтгэл, биеэс гогдоотой тэдгээр уяаг тасар татах Бурханы сэлмийг гуй. Бурханы нигүүлсэл таныг чөлөөлнө.

Бүрэн шагнал¹

Дараагийн бүлэгт орохоосоо өмнө хамгийн сүүлд нэг үг хэлье. Бурханы өргөө гэрийг барих ажилд оролцож эхлээ ч үгүй эсвэл барьж байгаад хаячихсан хүн олон бий. Тэд энэ дэлхийн баялаг, нөлөө, хүч, таалал, хүнд таалагдах гэсэн тачаал зэрэг эцэстээ үгүйрч алга болох зуурдын юмст сатаардаг. Битгий мэхлэгд, битгий төөр, битгий замаасаа гар. Зам дээрээ бай. Танд Христийн дотор хийх ёстой ажил байна. Та ажлаа дуусгах ёстой.

Олон хүний хэсэг хугацааны эсвэл насан туршийн ажил тэсэхгүй, үнс болох учраас Бурханы мөнхийн өргөө гэрийн нэгээхэн хэсэг болж чадахгүй. Аймаар байгаа биз?

Энэ нь ямар чухал болохыг ойлгуулах үүднээс, би шинэ байшин бариулсан түүхээ дахин нэг сөхье. Би өдөр бүр барилгын талбай дээр очдог байсан учраас, гүйцэтгэгч нартай ч сайхан танилцав. Тэд намайг “номлогч” гэнэ.

Намайг очиход ажилчид асид рок хөгжмөө бархируулсаар угтдаг байв. Тэгээд намайг хармагцаа, нэг нь гүйж очоод хөгжмөө унтраачихна. Тэд Бурханы юмсыг хүндэтгэж байгаад нь би баярладаг байлаа. Бид сайхан яриа дэлгэж, энэ маань ч надад тэдэнд үйлчлэх завшаан болдог байв.

Нэгэн удаа нэг гүйцэтгэгч нь ямар ямар мундаг барилга дээр ажиллаж явснаа ярихдаа, үнэхээр гэрэлтэж байж билээ. Тэр том бүтээн байгуулалтад гар бие оролцсон завшаан нь түүнд асар их сэтгэл ханамж, бахархал авчирсан нь илт байв. Тэрбээр хүнд хүчир хөдөлмөрлөсөндөө харуусах нь бүү хэл, харин ч хүмүүсийн хараа булаам барилга барьж, ач тус хүргэсэндээ нүүр бардам, жаргалтай байсан юм.

Жишээлбэл Вашингтон Ди Си дэхь Цагаан ордныг барьсан барилгачдад ямар байдаг бол? Хүү, охин нь сургуулиаа тарж ирээд, аавдаа хичээл дээрээ улсынхаа хамгийн алдартай байшингийн талаар сурснаа бас тийшээ сургуулиараа аялах болсноо баяртайгаар зарлажээ.

Гэтэл яг тэр байшинг барилцсан гэдгээ хүү, охиндоо хэлэх тэр барилгачин аавд хичнээн баяр бахдалтай байх бол? Тэрбээр хүүхдийнхээ сургуультай хамт аялахдаа хичнээн догдлох бол? Америкийн ерөнхийлөгчийн амьдардаг энэ мундаг байшинг аав нь барилцсан гэдгийг ангийнхандаа бахархалтайгаар дуулгах хүүхдээ хараад тэр аавд ямар байхыг төсөөлж байна уу?

Бид ч бас тэгнэ. Гэхдээ бид нэг л өдөр нурж үгүйрэх байшин дээр ажиллаагүй, харин мөнхийн мөнх даяар ертөнцийн төв байх өргөө гэрийг барьж байна. Тийм ээ, эш үзүүлэгч Микагийн үгийг сана: “Олон үндэстэн ирээд, “Ирцгээ, ЭЗЭНий уул, Иаковын Бурханы өргөө уруу явцгаая. Тийнхүү Тэрээр бидэнд замаа зааж, Бид жимээр нь алхах юм” гэцгээнэ. Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭНий үг Иерусалимаас гарна.” (Мика 4:2)

Даяар ертөнцийн бүх хэрэг явдал энэ өргөөг тойрон өрнөнө. Эндээс л бүх бүтээлийг засаглах цэц ухаан, хууль ундарна. Тэгээд энэ өргөө нь арван триллион жилийн дараа ч анх байгуулагдсан шигээ л үзэсгэлэнтэй хэвээрээ байна.

Эцсээ хүртэл итгэмжтэй байсан нэгэн аугаа үйлчлэгч бий. Тэрбээр жар гаруй жил итгэмжтэйгээр үйлчлээд, шинэ мянган эхлэхээс өмнө шагналаа авахаар Эзэн рүүгээ явсан юм. Түүнийг

явснаас жилийн дараа би Мидвестийн томоохон чуулганд зочилтол, тэдний магтаалын удирдагч нь надад өөрийнхөө үзсэн маш тод зүүдээ ярьж билээ. Тэрбээр тэнгэрт очоод, нөгөө мундаг үйлчлэгчтэй уулзаж л дээ. Гэтэл үйлчлэгч нүүр дүүрэн мишээсээр: “Энд миний бодсоноос хавьгүй сайхан юм аа” гэж хэлжээ.

Тэд үнэний талаар, үйл явдлын талаар ярьсаар явснаа, үйлчлэгч эргэж хараад Сион дахь өөрийнхөө хийсэн ажлыг заажээ. Тэр нь маш том ажил байв. Түүний итгэмжтэй байдлын үр нөлөө нь түүний бодож, мөрөөдөж явснаас ч өргөн цар хүрээтэй байсан бөгөөд яг нүднийх нь өмнө ил байжээ. Барилгачид гар бие оролцсон байшин барилгаа надад үзүүлсэн шиг, тэр үйлчлэгч ч өөрийнхөө бүтээсэн үйл хэргээ заажээ. Ямар аугаа мөнхийн шагнал вэ!

Та өөрийнхөө бүтээсэн үйл хэргийг мөнхийн мөнхөд үр хойчдоо төдийгүй, Бурханы Сион гэдэг өргөө гэрийг бишрэхээр ирсэн үй олон улс, үндэстэнд харуулна гээд л бод. Хүмүүс мөнхийн мөнхөд Бурханы өргөө гэрийн гоо үзэсгэлэнг бишрэх бүрийдээ таны хийсэн үйл хэргийг ярина шүү дээ.

Тэгвэл нөгөө талаас та сайн дуусгаж чадаагүй учраас харуулж үзүүлэх ширхэг ч юмгүй сууж байвал, яах уу? Таны хөдөлмөрийг үзэхээр ирсэн өвөг дээдэс, үр саддаа үзүүлэх юмгүй, гар хоосон сууж байвал яах уу? Үндэстнүүд таны ажлыг үзэхээр ирсэн ч, таны хувь нураагдаж, тэр хэсгийг чинь өөр хүн хийсэн учраас, мөнхийн мөнхөд үзүүлэх юмгүй сууж байвал яах уу?


Паул юу гэж хэллээ?

“Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана.” (1Коринт 3:14-15)

Энэ бол үнэхээр мөнхийн гарз, маш харамсалтай үнэн. Найз минь, таныг ингээсэй гэж би ёстой хүсэхгүй. Бурхан ч хүсэхгүй. Та ч ингэх албагүй. Бурхан танд Сионыг барих нигүүлсэл өгсөн. Элч Иохан:


“Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна” (2Иохан 8) гэж хэлсэн.

Эзэн Өөрөө хүүхэд нэг бүрээ Түүний өргөө гэрийг барьсныхаа төлөө бүрэн шагналаа авах боломжтой байхаар бүтээсэн. Таны хүчин зүтгэл хэзээ ч талаар болохгүй, хуучрахгүй, орлуулагдахгүй. Та Бурханы нигүүлсэлд найдаж, үргэлжлүүлэн байгуулсаар байвал, мөнхийн мөнхөд мянга мянган тэнгэрэлч, хүмүүсээр бишрүүлэх болно.



ТАВДУГААР ХЭСЭГ: БҮЛЭГ 11-12

1. Бурхан биднээр, бидний ажлаар дутахгүй ч, бидэнтэй хамтарч ажиллахыг хүсдэг гэдгийг бид мэднэ. Энэ нь Бурханы талаар, Бурханы хаанчлалын талаар бас бидний талаар юу илчилж байна?
2. Дуулал 139:16 дээр “Бурхан биднийг төрөхөөс ч өмнө амьдралыг маань дүрслэсэн ном бичсэн” гэдэг. Бурхан бидэнд зориулж ямар түүх бичсэнийг яаж мэдэж болох вэ?
3. Сайхан амьдарлаа ч, дуудлагаа алдах боломжтой (магадгүй тун амархан байх). Та яг одоо Бурханыг эрэн хайж эхлэхийг хүсч байгаа ч, нэг л зориглож өгөхгүй байна уу? Юу таныг айж, урам алдахад хүргэж байна?
4. 12-аар бүлэгт амьдралаа Бурханы хүсэлтэй зэрэгцүүлэх гурван түлхүүрийн талаар ярилцсан: Бурханыг үнэн голоосоо хайх, нутгийн чуулганд суулгагдах, уяа чөдрөөсөө суллагдах. Таны хувьд аль нь хамгийн тулгамдсан асуудал вэ? Үүнийгээ яаж өөрлөх вэ?
5. Өнө мөнхлөлд бид нэг бол бүрэн шагнуулна эсвэл хагас дутуу шагнуулна эсвэл огт шагнуулахгүй. Таны хувьд бүрэн шагнал гэж юу вэ?



᠔-ᠦ ᠬᠡᠴᠡᠭ

ҮРЖИЛ

*Хураагч хөлсөө хүртэж, мөнх амийн үрийг цуглуулж байна.
Тийнхүү тариачин тариа хураагчийн хамт баярлах болно. Учир
нь “Нэг нь тарьж, нөгөө нь хураана” гэсэн үг үнэн юм.*

— Иохан 4:36-37

Таригч, улагч нь нэг юм. Тэд тусбүрдээ зүдэл зүтгэлийнхээ дагуу шагналаа авах болно. (1Коринт 3:8)

Бурханы гэрийг барьж, хаанчлалд итгэмжтэй үйлчилж байгаа хүмүүс нь гайхамшигтай, мөнхийн бэлэг хүлээж авна. Хүн бүр ажил хөдөлмөрийнхөө дагуу хувьчлан шагнуулна. Хүн бүр өөрийн гэсэн үүрэг хариуцлагатай ч, дуудлага маань “мөнхөд нөлөөлөгдсөн амьдрал” гэсэн нэг л үр дүн төрүүлнэ.

Олны өмнө сая сая хүний амьдралд нөлөөсөн үйлчлэгч нар л тэнгэрийн эхний эгнээнд зогсоод, хамгийн том шагнал авна гэж олон хүн итгэдэг. Гэхдээ энэ худлаа юм. Бурхан хүн шиг шагнадаггүй. Бурхан дуулгавартай зөвт үйлсээр нь л шагнадаг. Бурхан хүний жишгээр шагнадаг байсан бол, үйлчлэлийн төв нь бизнес болно. Гэтэл ийм байдаггүйг сүүлийн хоёр бүлэгт үзсэн. Бурхан бидний дуудлагын дагуу - Тэр биднийг юу хийхээр хүчирхэгжүүлснээр л шүүж, шагнадаг.

Нигүүлслээр хүчирхэгжүүлсэн

Паул МЭ 56 онд буюу үйлчлэлээ дуусгахаасаа арваад жилийн өмнө өөрийгөө хамгийн дорд элч гэжээ. (1Коринт 15:9) Чуулганы түүхийг мэддэг хүмүүст энэ нь хачин санагдмаар. Учир нь Паул бараг дэлхий даяар хүрч, тухайн цаг үеийнхээ хэнээс ч илүү

хаанчлалын төлөө амьдарсан юм. Тиймээс Паул тухайн үеийнхээ хамгийн аугаа элч байсан гэдэг нь эргэлзээгүй. Тэгтэл тэр өөрийнхөө тухай ингэж хэлж байдаг? Хэтрүүлээд байна уу?

Гэхдээ Бичээсийг бичдэг хүн худлаа ярих боломжгүй учраас, Паул хэтрүүлээгүй. Ариун Сүнс түүнд үнэхээр итгэсэн зүйлийг нь л бичихийг зөвшөөрнө: “Харин Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон. Түүний надад үзүүлсэн нигүүлсэл хоосон байгаагүй. Харин ч би тэд бүгдээс илүү зүдэж зүтгэсэн юм. Гэхдээ би биш, харин надтай хамт байдаг Бурханы нигүүлсэл билээ.” (1Коринт 15:10)

Паул өөрийгөө бусад элч нараас хавьгүй ихийг гүйцэлдүүлсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн атлаа бас өөрийгөө хамгийн дорд нь гэжээ. Үүнийг “Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон” гэдэг үг тайлбарлана. Паул өөрийгөө өөрөөр нь дамжуулж Бурханы үйлдсэн үйлсээс тусад нь үзжээ. Бурханы өгсөн чадвараас давуулж юмуу Түүний дуудлага дээр ямар нэг юм нэмж чадахгүй гэдгээ Паул маш сайн мэдэж байсан. Үүнийг нигүүлсэл гэдэг ганц үгд базаж хэлжээ. Яг энэ динамик бүх итгэгчдийн дуудлагад хамаатай.

Би өөрийнхөө үйлчлэлийн тухай ярья л даа. Миний бичсэн номууд өдгөө дэлхийн ер гаруй хэл дээр орчуулагдаж, сая сая хувиар борлуулагдаж, үй олон хүний амьдралыг өөрчилсөн гэрчлэл авчирсан юм.

Заримдаа хүмүүс надтай хувьчлан уулзаад, номоо яаж бичдэгийг минь аминчлан асуудаг нь надтай инээдтэй санагддаг. Учир нь Бурханы нигүүлсэл амьдралд маань ил болохоос өмнө би Англи хэл дээрээ нойл байсан юм чинь. Хоёр нүүр юм бичих гэж хэдэн цаг зууралдаж, дэвтрийн хагасыг үрж байж, ганц параграф бичдэг байсан бол, одоо өөрөө л урсаад байдаг. Гэхдээ яг үнэндээ миний номуудыг Хэн бичдэгийг би мэдэхийн дээдээд мэднэ. Би бол зүгээр л анхны уншигч нь юм.

Нэг удаа би үндэсний телевизээр гарч, номуудынхаа тухай яриу. Гэтэл ярилцлагын явцад хөтлөгч маань миний номын талаар биш, миний тухай л асуугаад байлаа. Би үүнд нь дургүй байсан тул Ариун Сүнснээс сэм тусламж хүссэн юм.

Тэгтэл удалгүй бидний яриа завсарлаж, Ариун Сүнсний хэлсэн үгийг дамжуулах тун таатай боломж олдов. Би: “Бурханы хийсэн болгон үүрд мөнхөд үлддэгийг би мэдлээ. Түүнд нь нэмэх буюу

түүнээс нь хасах юу ч байхгүй аж. Бурхан ийн үйлдсэний учир нь хүмүүс Түүнээс эмээхийн тулд юм. Юу байж байсан, тэр нь одоо ч байж байна. Ирээдүйд буй болох нь аль хэдийнээ байсан. Бурхан өнгөрснийг ийнхүү хайдаг байна” (Номлогчийн үгс 3:14-15) гэсэн Соломоны үгийг ишлээд, дараа нь ингэж хэлсэн юм:

“Дэлхий даяар Бурханы дуудлагыг биелүүлж яваа, нэр нь үл мэдэгдэх, үй олон пастор, үйлчлэгч нар байгаа. Зарим нь зайдуу бөглүү газар 300 орчим хүнтэй чуулганыг хариулж яваа бол, зарим нь ядуу буурай улс орнуудад үйлчилж яваа. Тэд амьдралаа илгээлтийн талбарт тариалсан. Зарим нь нийгмийн ад шоо болсон хүмүүсийн төлөө амь насаараа дэнчин тавин үйлчилж яваа. Зарим нь бизнесийн ертөнцөд итгэмжтэй үйлчилж яваа гээд л тоочоод л байвал, тоочоод л байна. Тийм хүмүүс танай нэвтрүүлэгт оролцож чадахгүй байж болох ч, хийхээр дуудагдсан юмсдаа цэвэр сэдлээр дуулгавартай байсныхаа төлөө тэнгэрийн эхний эгнээнд зогсох л болно.

Миний хувьд Бурхан намайг олон хүний амьдралыг өөрчлөөрэй гэж энэ ажлыг даалгасан. Магадгүй тиймээс ч та намайг нэвтрүүлэгтээ урьсан байх. Гэхдээ би Бурханы дуудлага дээр нэг ч юм нэмж, өргөтгөж, баяжуулж, өөрийнхөө хүчээр хөгжүүлж чадахгүй. Тэгэх юм бол, холион бантан хутгана - харин би үүнээс айж байна!”

Тэгтэл уур амьсгал тэр дороо чухал болоод л явчихав. Өөрөө олон улсын үйлчлэл хийдэг хөтлөгч эр миний үгийг ойлгоод, үлдсэн хугацаандаа зөвхөн үйлчлэлийн маань талаар л яриулж билээ.

Энэ үнэн бүгдэд хамаатай. Та гэрийн эзэгтэй, ээж байж болно эсвэл нутгийнхаа чуулганд хүүхэд асрахаар эсвэл зуучлан залбирахаар дуудагдсан байж мэднэ. Та үүнийгээ эцсээ хүртэл итгэмжтэй хийсэн бол, дуулгавартай байдлынхаа төлөө томоор шагнуулна. Эсвэл та чуулганыхаа шоронгийн үйлчлэлд үйлчилж, бизнесийн ертөнцөд нөлөөлж, үйлчлэлийн ажлыг ихээр дэмжиж байхаар дуудагдсан байж болох. Үүнийгээ эцсээ хүртэл цэвэр сэтгэлээр итгэмжтэй хийсэн бол, сая сая хүнийг Эзэн дээр авчирсан алдартай сайн мэдээ тараагч шиг л шагнуулна.

Би л хувьдаа тэнгэрийн эхний эгнээнд маш олон ээж, бизнес хийдэг хүмүүс, жирийн ажилчид зогсож Эзэнээсээ бүрэн шагналаа авна гэдэгт итгэдэг.

Газар дээрх Бурханы арми

Есүс Христийн чуулган нь газар дээрх Бурханы арми юм. Бид бүгдээрээ даалгавраа гүйцэлдүүлэх цол, бэлэгийн байр суурьтай. Хэдэн жилийн өмнө Эзэн гэргийг маань сэрээгээд, Сүнс доторх аугаа их цэргийг харуулсан юм. Үүрийн дөрвөн цаг болж байсан ч, гэргий минь тэр даруй намайг сэрээгээд, юу харснаа хэлж билээ.

“Жон, тэр зэвсэгт хүчинд хүн бүр өөрийнхөө цол хэргэм, байр суурь, үүрэгт ажлыг мэдэж, төгс жагсаалаар алхаж байсан. Бас цол болгонд нээлттэй байр суурь байсан бөгөөд хүмүүс тийшээ дэвшиж байсан. Чи бид хоёр үйлчлэлийн хоёр газар руу хөдлөсөн. Бид хаашаа явахаа бие биеэсээ асуугаагүй. Бүгдээрээ Эзэнээ харж байсан учраас, төгс эвслээр алхаж явсан” хэмээн Лиза маань ихэд догдлон ярьж билээ.

Тэгэхдээ Лизагийн нэг үг нь л намайг зог тусгасан юм: “Хэн нь ч хэнийхээ байранд шуналгүй, бүгд Эзэний бүтээж өгсөн байр сууриндаа сэтгэл хангалуун үйлчилж байсан.” Ойлгож байна уу? Цэргүүд нэгнийхээ үйлчлэлийн байр сууринд агаархалгүй, өөрийнхөө байранд хөдөлмөрлөхдөө сэтгэл хангалуун, баяртай байжээ.

Яг үүгээр захиалгын байшингаа үргэлжлүүлэн дүрслэе. Бичээс: “Мэргэн ухаанаар гэр орон сүндэрлэж Бодрол ухаанаар тэр чухамдаа тогтдог” (Сургаалт үгс 24:3) гэдэг. Бид хоёр төрлийн цэц ухаанаар барилгаа барьж болно. Нэг цэц ухаан нь дээрээс бол, нөгөө нь доороос юм.

“Та нарын дунд хэн чинь мэргэн агаад ухаалаг вэ? Тэр нь биеэ зөв авч яван, мэргэн ухааны дөлгөөн зангаар үйлсээ харуул. Хэрэв зүрхэнд чинь гашуун атаархал ба хувиа хичээсэн зорилго байх аваас бүү бардамна, үнэний эсрэг худал бүү ярь. Энэ мэргэн ухаан бол дээрээс бууж ирдэг нь биш харин газрынх, төрөлхийнх бөгөөд чөтгөрийнх юм. Учир нь хаана атаархал ба хувиа хичээсэн зорилго оршиж байна, тэнд замбараагүй байдал болоод аливаа муу муухай юмс байдаг.” (Иаков 3:13-16)

Бид сайн юм хийж байж болно. Гэхдээ энэ нь атаархал, амин хувийн эрх ашгаар хөтлөгдөж байгаа бол, бид бичээсийн бус, махан биеийн, чөтгөрийн сэдлээр үйлдэж байгаа бөгөөд энэ нь яавч шагнуулахгүй.

Вебстер атаархлыг “хангалуун бус байх мэдрэмж юмуу өрөөлийн давуу тал, амжилт, эзэмшил гэх мэт зүйлст шунаглах”¹ хэмээн тайлбарлажээ. Бид Бурханы дуудлагыг дэлхийн нүдээр харбал, зайлшгүй атаархана. Паулын амьдралын даалгаварт атаархдаг номлогч нар байжээ. Паул ч энэ тухайн бичсэн: “Зарим нь үнэндээ атаархал, өрсөлдөөнөөс болж Христийг тунхагладаг байхад зарим нь бас сайн санаанаас тунхагладаг билээ.

Сайнмэдээг хамгаалуулахаар намайг томилсныг тэд мэдээд Христийг хайраар тунхагладаг. Нөгөө нь чин сэтгэлээсээ бус өрсөлдөх хүслийн үүднээс Христийг тунхагладаг. Ингэхдээ тэд хүлээстэй намайг шаналгана гэж бодож байна.” (Филиппой 1:15-17)

Тэдгээр үйлчлэгч нар Бурханаас өгөгдсөн өөрийнхөө дуудлагыг голж, Паулын амжилтыг хүсчээ. Харин амиа эрсэн амбици нь энэ атаархлыг нь улам бадраажээ. Амбици бол аливаад хүрэх гэсэн хүчтэй хүсэл эрмэлзэл юм. Гэхдээ амиа эрсэн болоод ирэхээрээ төвдөө бусдыг биш, өөрийгөө залдаг. Харин энэ сэдэл нь эмх замбараагүй байдал, эсэргүүцлийг үүдээж, хамаг л ёрын юмст нээгддэг.

Гэтэл бурханлаг цэц ухаан нь амиа эрсэн амбициар биш, хаанчлалын төлөөх халуун сэтгэлээр асдаг. Энэ нь Эзэний төлөвлөгөөгөөр хөдлөж, хүслээр чиглүүлэгддэг. Иаков энэ цэц ухааныг “Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй” (Иаков 3:17) гэсэн.

Бурханы цэц ухаан нь хамгийн түрүүнд цэвэр юм. Өөрөөр хэлбэл гаднаа бурханлаг дүртэй атлаа дотроо амиа бодсон, хоёр нүүртэй, атаархуу биш. Энэ нь Эзэндээ итгэмжтэй байж, Түүний даалгаврыг баяр хөөр хэмээн хүлээн авдаг. Хамгийн аугаа нь болох биш, харин дуудлагадаа үнэнч байх нь л үүний гол зорилго. Бурханлаг цэц ухаан нь биднээр байна уу, хүнээр байна уу - хаанчлал л өсөн тэлж байвал, баярладаг.

Бурханлаг цэц ухаан нь өөр дээрээ биш, ямагт бусад дээр төвлөрдөг. Энэ нь амар тайван, хэрүүлгүй, дарамтгүй, шүүмжгүй, ноёрхолгүй бөгөөд бусдыг бурханлаг байдал дотор алхаж, хувь тавилангаа биелүүлж байхыг харах нь л үүний сэдэл юм. Үйлчлэлд хайртай бөгөөд бусдыг тэвчдэг хүмүүс байдаг бол, хүмүүст хайртай бөгөөд үйлчлэлээ хүмүүст үйлчлэх зэмсэг

гэж хардаг хүмүүс байна. Хоёр дахь нь бурханлаг цэц ухаанаар хөдөлдөг хүмүүс юм.

Бурханлаг цэц ухааны өөр нэг шинж нь захирагдах юм. Дуудлагадаа сэтгэл хангалуун байгаа хүн Бурханы томилсон чиглүүлэг, эрх мэдэлд үг дуугүй захирагддаг. Бид ч Бурханы өргөө гэрийг барих том зурагаа харж, харин ажлыг маань ганц л Архитектор, Дизайнер, Барилгачин авч явна. Тэрбээр эрх мэдэл, чадвар, даалгавраа Чуулганыхаа хувь хүмүүст тараан даалгадаг. Харин өөрийнхөө хүлээж авсан хувьд захирагдсаар байсан хүмүүс л Шүүх сэнтийн өмнө том шагнуулна. Чуулганаа салган бутаргасан туслах пастор, даргаасаа цалин авдаг атлаа өөрийнхөө бизнесийг эргэлдүүлдэг ажилтан зэрэг нь хийсэн юмдаа амжилт олсон байлаа ч, шүүхийн үеэр маш том гарз үзнэ.

Үр дүнд бүү хууртагд. Бид Бурханы эрх мэдлийг эсэргүүцсэн ч, гайхамшигтай үр дүнд хүрч болно. Мосег аваад үз. Эзэн түүнд чулуунд хандан тушаабал, ус гарна хэмээн айлдсан. Мосе үгэнд нь ороогүй. Тэр уурлаж, чулууг цохисон. Гэхдээ л гурван сая хүнийг цөлд хангалттай ундаалах ус гарсан. Хүмүүс: “Пөөх, Бурхан ч Мосегийн үгээр юм аа! Мосе ямар хүчтэй юм бэ!” хэмээн шивэр авир хийсэн байх.

Гэхдээ тэднийг ууж дууссаны дараа Бурхан Мосег хувьчлан дуудаад, үгэнд нь ороогүй учраас, Амлагдсан газар орохгүйг нь хэлдэг. Мосе гайхамшигт үр дүнд хүрсэн үү? Хүрсэн. Гэхдээ амжилтыг үр дүн биш, дуулгавартай байдал тодорхойлдог. Бурханлаг цэц ухаан нь Эзэнээс эмээх айдаст үндэслэж, Бурханы хүслийг юу юунаас дээгүүр тавьдаг. Бурханаас эмээдэг нь Түүний эрх мэдэлд бүрэн захирагддаг.

Манай Лизагийн нөгөө үзэгдэл рүү эргэж орёе. Тэр өглөө Лиза надад “Жон, бүх дайчид яг адилхан царайтай байсан” гэж хэлж билээ. Өөрөөр хэлбэл нүүргүй цэргүүд байжээ. Энэ нь Бурханд “супер од” гэсэн байр суурь байдаггүйг харуулж байгаа юм. Үүнийг ойлгох нь биднийг чуулган дахь бусдын байр сууринд шунах юмуу илүү дээд байр сууринд очихын төлөө эрх мэдлийн өөдөөс тэрслэхээс сэргийлнэ. Суулгагдсан нөхцөлд л бидэнд дэвшил ирнэ.

Өөр өөр төвшин

Сайн мэдээнд Шүүх сэнтийн талаарх хоёр өөр үнэнийг дүрслэсэн хоёр төстэй сургаалт үлгэр байдаг. Тэдгээр нь талант ба минагийн сургаалт үлгэр юм. Талантын тухай эхний сургаалт үлгэр нь бүх итгэгчдэд яг ижил төвшний дуудлага ба бэлэг өгөгдсөн талаар өгүүлдэг.

Есүс: “Энэ нь холын аянд гарахдаа зарц нараа дуудаад, эзэмшилээ тэдэнд даатгаж буй нэгэн хүнтэй адил билээ. Нэгэнд нь тэр тав, нөгөөд нь хоёр, өөр нэгэнд нь нэг талантыг тусбүрд нь чадварынх нь дагуу өгчээ. Тэгээд аянд гарч гэнэ” (Матай 25:14-15) гэж ярьжээ.

Холын замд гарсан хүн нь Есүсийг төлөөлж байгаа бол, харин зарц нар нь биднийг төлөөлж байгаа юм. Талант нь мөнгөний хэмжүүр мөн. Гэхдээ энэ нь сургаалт үлгэр учраас талант нь өөр юмыг л төлөөлсөн байх учиртай.

Миний хувьдаа итгэж явдаг нэг магадлал нь талант нь бидний дуудлага ба бэлэгийн төвшин байх. Жишээлбэл, зарим хүний үйлчлэлийн төвшин үндэстнүүдэд хүрдэг бол, заримынх нь хотуудад, заримынх нь чуулганыхаа доторх гэрийн бүлэгт хүрдэг. Зарим зохиолчид нь сая сая хүнд хүрдэг бол, зарим нь мянга мянган хүнд, зарим нь зуу зуун хүнд хүрдэг. Зохион байгуулах чадвартай нэг хүн үйлчлэлийг мега чуулганы төвшинд аваачдаг бол, зарим нь арай бага хэмжээний чуулган авч явах чадвартай байна. Зарим бизнес эрхлэдэг эрэгтэй, эмэгтэйчүүдийн бизнес нь хаанчлалд хэдэн зуу, мянган ашиг авчирдаг байхад, зарим нь хаанчлалын төлөө хэдэн тэрбумын өргөл өгдөг бизнестэй байдаг.

Тэгэхээр, дээрх сургаалт үлгэрт хоёр чухал санаа байна. Нэгдүгээрт - бүх зарц нар хувь хүртсэн. Энэ нь чуулганд дуудлагагүй (бас бэлэггүй) хүн гэж байхгүйг хэлж буй. Хоёрдугаарт - зарц бүрт чадварынх нь дагуу өөр өөр төвшний дуудлага ба бэлэг өгөгдсөн. Гэхдээ бидний чадварыг Бурхан бидэнд өгдгийг бид санах ёстой. Бичээс: “Үнэндээ хэн чамайг илүү гээв? Чи байгаагаа хүлээж аваагүй гэж үү? Үнэхээр хүлээж авсан юм бол аваагүй юм шиг чи юунд сайрхана вэ?” (1Коринт 4:7) гэж хэлсэн тул, бид өөрөөрөө сайрхах явдалгүй.

Энэ сургаалт үлгэрт гарч байгаа тавдугаар төвшний дуудлага, бэлэгтэй хүн хүчин зүтгэлээ хоёр дахин үржүүлж чаджээ. Хоёр таланттай хүн ч ялгаагүй. Энэ нь Бурхан бидэнд бэлэг өгдөг ч гэсэн, Түүний хүссэн өгөөжийг бүтээхийн тулд бид хамтран зүтгэх ёстой гэсэн үг юм.

Гэтэл нэгдүгээр төвшний дуудлага, бэлэгтэй хүн өөрийнхөө итгэмжлэлийг ач холбогдолгүй гэж үзээд, эзнийгээ шударга бус, утга учиргүй, хатуу ширүүнээр нь дууджээ. Магадгүй тэр: “Надад яахаараа бусдаас багыг өгдөг билээ? Тэд яахаараа үндэсний хэмжээнд, хотын хэмжээнд ажилладаг билээ? Тэд яахаараа номлох, дуулах, бичих авьяастай, харин би авьяасгүй байдаг билээ? Яахаараа миний компани бусад шиг өргөдөг болтлоо өөдлөдөггүй билээ?” гэж бодсон байх. Тэгээд тэр бэлэгээ нуугаад, дуудлагаа биелүүлээгүй. Тэрбээр бэлэгээ өөрийнхөө төлөө юмуу хаанчлалд ямар ч хэрэггүй замаар хэрэглэжээ.

Хожим эзэн нь эргэж ирээд, зарц нартайгаа тооцоо хийв. Хүлээж авсан хувиа хоёр дахин өсгөсөн хоёр зарц яг адилхан үгээр сайшаалгасан: “Сайн байна, итгэмжит сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулья. Эзнийхээ баяр баясгаланд ор.” (Матай 25:21) Тавдугаар төвшний хүн хоёрдугаар төвшний хүнээс илүү магтаал хүртээгүй. Учир нь тэд яг адилхан итгэмжтэй, хичээнгүй байсан. Энэ нь дахиад л Бурхан биднээс өгөгдсөн зүйлдээ л итгэмжтэй байхыг шаарддаг болохыг илчилж байна.

Харин ганц таланттай хүнийг эзэн нь хатуу донгодож, өгөгдсөн хувийг нь аваад, өмнөх хоёрын нэгэнд нь өгдөг. Итгэмжтэй хоёр хүн илүү ихийг олсон бол, итгэмжгүй зарц асар их гарз хохирол үзжээ.

Би үүнийг сонсоод, 1992 онд Эзэн надад ном бичих даалгавар өгсөн явдлыг санаж билээ. Би сонссон зүйлээсээ болоод золтой л инээд алдчихаагүй! Би англи хэлд дургүй. Хэн нэг хүн намайг ном бичнэ гэсэн бол, би хөхрөөд, хөөгөөд гаргах байсан байх.

Гэхдээ арван сарын дараа хоёр долоо хоногийн зайтай хоёр эмэгтэй надад нэг ижил эш үзүүллэгийн үг хэлсэн юм: “Жон, хэрэв чи Бурханы өгсөн зүйлийг бичихгүй бол, Бурхан үгээ өөр хүнд өгнө. Харин чи дуулгаваргүй байсныхаа төлөө шүүгдэнэ.” Би айсандаа итгэлээр алхам хийсэн бөгөөд эцэстээ юу болсныг та мэдэх байх. Хэрэв би дуулгавартай дагаагүй бол, энэ номуудыг өөр хүн бичээд, харин би өөрт өгөгдсөн бэлэгээ алдах байжээ.

Хүлээж авсан зүйлээ үржүүлэх

Хүн дуудлага юмуу бэлэг дээрээ юу ч нэмж болохгүйг бид дэлгэрэнгүй ярьсан. Тэгвэл одоо итгэгч хүн бүр байгаа зүйлээ үржүүлэх талаар ярья. Минагийн сургаалт үлгэр нь дээрх талантын сургаалт үлгэртэй төстэй боловч, зарим талаараа тэс өөр юм. Есүс:

“Тэрээр —Нэгэн сурвалжит хүн хаанчлалыг хүлээн аваад буцаж ирэхээр алс холын орныг зорьжээ. Тэр арван боолоо дуудаж, тэдэнд арван маанэ өгөөд “Намайг буцаж иртэл эдгээрийг эргэлдүүл” (Лук 19:12-13) гэж ярьжээ.

Мина нь талант шиг мөнгөний хэмжүүр юм. Гэхдээ энд хүн бүрт ижилхэн нэг нэг л мина өгөгджээ. Тиймээс мина нь бидний дуудлага, бэлэгийн төвшинг төлөөлөөгүй, харин Бурханы Үгийн үнэн, бидний суурь итгэл, зүрхэнд цутгасан Бурханы хайр, итгэгч хүн бүрт өгөгдсөн гэрээний ерөөлийг төлөөлнө. Хэнд ч илүү дутуу өгөгдөөгүй, хүн бүрт яг ижилхэн хэмжээ өгөгджээ.

Энэ сургаалт үлгэр нь Христийн дотор итгэгч хүн бүрийн эзэмшдэг зүйлийн тухай өгүүлэх ажээ. “Бүх юм та нарынх тул хэн ч хүмүүсээр бүү сайрхаг” (1Коринт 3:21), “Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дор тэнгэрлэг оршихуй дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн.” (Ефес 1:3) Эдгээр ерөөл нь Христ дотор биднийх боловч, тэдгээрийг газар дээр бодитой харуулах нь бидний итгэл юм. Тийнхүү бидний дуулгавартай байдал, залбирал, өргөл маань тэдгээрийг үржүүлдэг. Тиймээс л Есүсийг төлөөлсөн язгууртан нь биднийг төлөөлсөн зарц нартаа: “Намайг иртэл бизнес хийгээрэй” гэжээ. Бид өгөгдсөн зүйлээ аваад, Бурханы алдрын төлөө үржүүлэх ёстой юм.

Одоо зарц нарын ажлын дүнг харна уу:

“Мөнөөх хүн хаанчлалаа хүлээн авсны дараа буцаж ирэв. Тэгээд мөнгө өгсөн боолууд нь хэр эргүүлснийг мэдэхээр тэднийг дуудуулж гэнэ. Эхнийх нь ирж “Эзэн, таны нэг маанэ арван маанэ болсон” гэхэд тэр түүнд “Сайн байна, сайн зарц минь.

Чи маш бага юманд итгэмжтэй байсан тул арван хот захирах эрх мэдэлтэй боллоо” гэжээ. Хоёр дахь нь ирж, “Эзэн, таны нэг маанэ таван маанэ болсон” гэхэд тэр түүнд мөн “Чи таван хот захирах эрхтэй” гэлээ. Өөр нэг нь ирж, “Эзэн, үзэгтүн, би таны нэг маанээг алчууртаа боогоод хав дарчихсан” гэжээ. (Лук 19:15-20)

Язгууртан сүүлийн хүнийг зад загнаад, минаг нь аваад, ганц минагаа арав болтол үржүүлсэнд хүнд өгөөд: “Би та нарт хэлье. Хэнд байна, түүнд илүү ихээр өгөгдөнө. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс хураагдана” (26-р ишлэл) хэмээн айлджээ.

Энэ сургаалт үлгэрт Есүс арван зарцын гурвынх нь л тухай өгүүлсэн. Зарц бүр ганц минагаар эхлэсэн ч, нэг нь арав дахин өсгөсөн бол, нөгөө нь тав дахин, гурав дахь нь нэг ч өсгөөгүй. Түүнчлэн шагнал нь ч тухайн зарцын бизнесийн ашгаас шалтгаалан, ялгаатай байна. Тэдний хэдэн хот захирах нь амжилтынх нь дагуу шийдэгджээ.

Хүлээж авсан зүйлээ үржүүлж байгаа арга зам маань бидэнд Мянган жилийн хаанчлалаар болон шинэ тэнгэр, шинэ газар дээр хичнээн эрх мэдэл даалгагдахыг шийднэ. Итгэмжтэй хүмүүс Христтэй хамт захирна. Гэхдээ бүгд тэгш эрх мэдэлтэй байхгүй. Хичээл зүтгэл маань Эзэнтэйгээ мөнхийн мөнхөд захирах захиргааны цар хүрээг шийднэ. Бид бүгдээрээ нэг цэгээс, тэнцүү минатай гараагаа эхлэж байгаа учраас, чуулганд үйлчилдэг итгэмжтэй гэргий, ээжүүдэд хэдэн зуу, мянган хүнийг Есүс рүү дагуулдаг Сайн мэдээ дэлгэрүүлэгч хүнтэй яг ижилхэн боломж бий.

Энэ сургаалт үлгэр нь хүн бүр өөрийнхөө минаг хэд дахин үржүүлж чадахыг харуулж байна. Бид Бурханы хаанчлалыг хүссэнээрээ их юмуу бага байгуулна. Сонголт нь биднийх. Үнэндээ зарим талаараа бид хязгааргүй боломжтой. Та энэ үгд эгдүүцэж магадгүй. Гэхдээ жишээгээр тайлбарлая. Би олон жишээ хэлж чадах ч, цөөхөн нь л таны зүрхэнд сүнсний энэ зарчмыг ойлгуулах байх. Жишээгээ ярьж эхлэхээсээ өмнө элч Петрийн үгийг харцгаая:

“Бурханыг болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин

бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон.” (2Петр 1:2-3)

Нигүүлсэл бидний амьдралд үржиж чадна. Иаков: “Тэвч Тэр илүү их нигүүлсэл өгдөг. Тиймээс “Бурхан бардмыг эсэргүүцэж харин дарууд нигүүлсэл өгдөг” (Иаков 4:6) гэсэн. Нигүүлсэлээр л бид хаанчлалд ач тустай ямар нэг юм хийж чадна. Энэ чадвар нь Бурханыг дотно таньж мэдэхээс шалтгаална. Тиймээс л итгэгч бүр Бурхантай цаг гарган, уулзаж байх ёстой. Бид залбирах, Бичээс унших, зөв ном унших, тосолгоотой үг сонсохдоо Ариун Сүнсний болон Түүний илчлэлийг сонсох ёстой. Үүнийг хийх үед бидний амьдралд биднийг илүү ихийг хийлгэх чадвартай нигүүлсэл үрждэг.

Бурханыг болон Түүний арга замыг дотно таньж мэдэх тусам, илүү үр нөлөөтэй болдгоо би мэднэ. Ямар ч иргүй сүхээр өдөржин ганц мод цавчиж болно. Гэхдээ сүхээ ирлэчих юм бол, яг ижил эрч хүчээр өдөрт таван мод цавчиж болно. Нигүүлсэл бидний амьдралд үржихээр ийм л юм болдог. Бид хавьгүй үр дүнтэй хөдөлмөрлөдөг.

Би нэгэн удаа Техасын Далласт ижил хүйстний парад дээр Сайн мэдээ дэлгэрүүлсэн юм. Тэр төөрсөн хүмүүст өдөржин Есүсийн тухай ярьсан ч, тэд намайг эвэртэй туулай шиг л үзэв. Зарим нь байдгаараа хичээж байгаа намайг хүн ч гэж тоосонгүй. Надад яг л хана мөргөөд байгаа юм шиг эсвэл цементэн дээр үр суулгах гээд байгаа юм шиг санагдаж байлаа.

Тэгтэл Эзэн надад: “Намайг хар. Би чамд яахыг заая” гэв. Тэгээд хагас цагийн дотор Эзэн намайг янз янзын хүмүүс рүү хөтлөөд, юу ярихыг минь зааж өгсөн юм. Миний хэлсэн үгс одоо л нэг юм сууж эхлэв. Тэгээд гурван хүн Есүст амьдралаа өгсөн юм. Ариун Сүнснийг харж, зүрхэнд минь хэлсэн үгийг нь сонссоноороо, би хүчин зүтгэлээ үржүүлсэн юм.

Би үүнийг амьдралын тал бүр дээр хардаг. Бурханы Үгээр өсөх тусам, би бага цагт ихийг амжуулахыг бүр сайн сурч, цаг, өдөр, сарыг минь хэмнэдэг үнэний замыг олж мэдсэн юм. Залбирал маань ч, Бурханы оршихуй ч, хүмүүст үзүүлэх нөлөө ч хүчирхэгжив. Бичээс ч үүнийг амласан:

“ЭЗЭНээс эмээхүй нь Мэргэн ухааны эхлэл. Ариун Нэгэнийг мэдэх нь ухаарал. Учир нь өдөр хоног чинь надаар уртсах. Амьдралын он жилүүд чамд нэмэгдэх.” (Сургаалт үгс 9:10-11)

Энэ хэсэгт хоёр зүйлийг амлажээ. Урт нас ба амьдрах хугацааг үржүүлэх. Хоёр дахь нь бас л урт нас гэсэн утгатай биш шүү. Тийм байсан бол, ямар ч утгагүй болно. Гэтэл энэ нь үнэндээ яг адилхан хугацаанд илүү ихийг гүйцэтгэх чадварын талаар ярьж байгаа юм. Үүнийг өөр нэгэн хэсэгт дүрслэсэн байдаг: “Амьдралын чинь хоног жилийн урт Амар тайвныг эд л чамд нэмнэ.” (Сургаалт үгс 3:2) Тус ишлэлийн бичээч нь яг л Петрийн дээрх үг шиг Бурханы үгд наалдах тухай ярьжээ. Тэгвээс урт нас төдийгүй, урт өдрүүд өгөгдөнө гэж байгааг анхаарна уу. Бурханы үгийг сонсож, анхаарах нь бидний цаг хугацааг уртасгадаг.

Өгснөөрөө үржинэ

Бурхантай танилцсан хүн бүр баяртайгаар өгөөмрөөр өгдөг болно. Учир нь Бурхан маш өгөөмөр Бурхан юм. Тэр бидэнд хамгийн аугаа бэлэг болох Хүүгээ өгсөн. Есүсээс илүү үнэтэй юм энэ дэлхийд үгүй. Бурхан хэзээ ч хагас дутуу, хямдхан бэлэг өгдөггүй. Бурхан гэр бүлдээ үй олон охид хөвгүүдийг авчрах ургацыг хүссэндээ Есүсийг өгсөн бөгөөд ургац бүрэн хураагдаж дуусаагүй байна.

Итгэлээр өргөх нь өөрт байгаагаа үржүүлэх өөр нэгэн баталгаатай арга зам мөн. Бурхан Аав нь Есүсийг бидэнд өгөхдөө мөнхийн ач холбогдолтой үйлс бүтээсэн шиг, бидний өргөл ч өнө мөнх тогтох өөрчлөлтийг бүтээдэг. Есүс: “Би та нарт хэлье. Шударга бусын эд баялгаар өөрсдөдөө анд нөхөдтэй бол. Ингэснээр эд хөрөнгө чинь үгүйрэх цагт, тэдгээр нь та нарыг мөнх нутагт хүлээн авах юм” (Лук 16:9) гэсэн. Зүй зохистой хэрэглэгдсэн бидний мөнгө зарлагдаж дууссан хойноо ч тэнгэр дэхь болон Шинэ Иерусалим дахь бидний амьдралд нөлөөлж чадах юм. “Энэ нь “Тэр тараасан, ядууст өгсөн. Түүний зөвт байдал мөнхөд байна” гэж бичигдсэнчлэн байх юм.” (2Коринт 9:9)

Ядуу гэдэг нь мөнгөгүй хүнийг биш, харин сүнсээр ядуу хүмүүсийг хэлсэн юм. Сая сая доллартай хүн ч сүнсээр ядуу байж болно. Жишээлбэл Заккай гэдэг хүн байна. Есүс үүрэг даалгаврынхаа тухай “Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм” (Лук 4:18) хэмээн ярьсан байдаг. Дараа нь Есүс хотод очоод,

тэндхийн хамгийн баян хүнийг олоод олны өмнө “Закхай, хурдал, бугаад ир. Өнөөдөр Би танайд очих ёстой” (Лук 19:5) гэжээ. Заккай хотынхоо хамгийн баян хүн байсан ч бас хамгийн ядуу нь байв. Өөрөөр хэлбэл түүнд Бурхан хэрэгтэйг тэр хэн хэнээс илүү ухаардаг байжээ. Есүс санхүүгээр баян ч, Бурханы Үгээр дутаж яваагаа сайтар ухаарсан хүмүүст үйлчилдэг байсан.

Есүсийн ажлыг хийж, Бурханы үгийг ядууст тунхаглаж, заахаас үйлчлэл эхлэдэг. Бурханы ажлыг санхүүгээр дэмжих нь мэдээж мөнхөд орших үйлс юм. Таны их юмуу бага мөнгө өгч байгаа чинь хамаагүй. Бурханаас өгөгдсөн үр байхад л хаанчлалыг байгуулах хүчин зүтгэл чинь үржинэ.

Бэлэг хэрхэн үрждэг вэ? Алимны үрийг аваад үз. Тэр үрийг тарьбал, эцэстээ сагс дүүрэн алимтай болно. Гэхдээ үүнээс чухал нь тэдгээр алим нь бүр ч их үр авчирна. Хэрэв тэр бүх үрийг тарих юм бол, бүр ч их ургац авчирна. Бидний санхүү яг л ийм журмаар явагддаг. Паул Коринтынхонд өргөлийн талаар юу хэлснийг үзнэ үү:

“Тэгэхлээр ийм байна. Харам таригч нь харам хураана. Өгөөмөр таригч нь өгөөмөр хураана. Хүн бүр дурамжханаар бус, албадлагаар бус зүрхэндээ байгаачлан өгөгтүн. Учир нь уриалгахнаар өгөгчийг Бурхан хайрладаг.” (2Коринт 9:6-7)

Ургац маань тарьсан хэмжээнийхээ пропорциор л өснө. Тариалах нь Бурханы шийдсэнээр биш, харин бидний шийдсэнээр байгааг үзээрэй. Хэрэв бид итгэл дотор зорилготой байгаад, өгөөмөр байхыг хүсбэл, бидний өргөл үлэмж үржинэ: “Тариачинд үр, идэх талхыг ханган өгдөг Тэрээр тарих үрийг чинь хангаж, үржүүлэх бөгөөд зөвт байдлын чинь ургацыг нэмэгдүүлнэ.” (2Коринт 9:10)

Яг л дөнгөж сая ярьсан алимны жишээ шиг Эзэн бидний үрийн санг нэмэгдүүлнэ. Бид байгаа зүйлээ зүгээр л тарьбал, илүү их үртэй болно. Ийм маягаар бид агуулах дүүрэн үртэй болж, бусдыг ерөөх чадал маань ч нэмэгдэнэ.

Бидний өргөлөөр дамжуулан, Бурхан мөн зөвтийн ургацыг нэмэгдүүлнэ. Одоо хамгийн сонирхолтой нь! Бид өргөлөөрөө дамжуулж нөлөөлсөн хүмүүсийнхээ амьдралаар мөнхийн шагналаа өсгөж чадна! Тэгэхээр, үндсэндээ бид сургаалт үлгэрийн эрчүүд шиг минагаа өсгөж байгаа юм.

Бусадтай түншлэх

Ийнхүү бидэнд буцааж төлж чадахгүй, гачигдсан хүмүүст өгөх өглөг маань энэ амьдралд төдийгүй, шүүхээр ч бидэнд шагнал авчрах ажээ. Хаанчлалыг байгуулахаар хүчин зүтгэлээ үржүүлэх ажлыг бид сайн мэдээний хамтран зүтгэгч нараараа дамжуулан хийж чадна. Паул өөрийнх нь үйлчлэлийг санхүүгээр дэмжсэн Филиппой хотын итгэгч нарт юу хэлснийг үзнэ үү:

“Гэсэн ч та нар зовлонгоос минь хуваалцахдаа сайн байсан. Сайнмэдээний анхан үед, намайг Македониос явсны дараа авах өгөхийн хэрэгт ганцхан та нараас өөр нэг ч чуулган оролцоогүйг филиппойчууд та нар өөрсдөө бас мэдэж байгаа. Тесалоникт ч хүртэл та нар нэгээс илүү удаа надад хэрэгтэй юмыг маань илгээсэн.” (Филиппой 4:14-16)

Паул Филиппой хотын итгэгч нарыг үйлчлэлийнхээ түншүүд гэжээ. Түншлэл гэдгийг “Тодорхой нэгэн зорилгын төлөө харилцан зөвшилцсөн хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагаар нэгдэн нийлсэн хувь хүмүүс, бүлгүүдийн хоорондын харилцаа”² хэмээн тодорхойлжээ. Бурханаас өгөгдсөн, эрүүл харилцаа нь хувь хүний ганцаараа хийж чадахааргүй юмсыг гүйцэтгэх чадвартай болгодог.

Өмнө хэлсэнчлэн, Есүс биднийг даян дэлхийд хүрч, бүх үндэстэнд зүгээр нэг итгэгчдийг биш, харин дагалдагч нарыг төрүүл гэсэн. Энэ даалгавар нь итгэгч хүн бүрт хамаатай. Гэхдээ бүх итгэгчид ургац хураахаар явчихбал, хэн тэднийг араас нь санхүүжүүлж, дэмжих болж байна? (Тиймээс л Бурхан хүн нэг бүрт өөр өөр дуудлага өгдөг) Бурхан үйлчлэлүүдэд тэнгэрээс мөнгө асгах юмуу тэнгэрэлч нараараа мөнгө зөөнө гэж хэзээ ч хэлээгүй. Харин ч Бурхан Өөрийнхөө биед бусдад өгөх завшааныг олгосон бөгөөд үүнээс түншлэл бий болдог.

Бурхан үйлчлэлийн бэлэгтэй хүмүүсийг олонд хүргэхийн тулд дуудаж, томилдог. Өмнө хэлсэнчлэн, Бурхан энэ зорилгоо биелүүлэхээр зарим хүнд онцгой бэлэг, чадвар, тосолгоо өгдөг. Тэрбээр энэ даалгавраа бүгдэд биш, чуулганыхаа тодорхой хүмүүст өгдөг. (Ефес 4:11) Харин чуулганыхаа үлдсэн хэсэгт Бурхан өөр чухал зорилгоо даалгасан. Үүнд ажиллах, мөнгө олох, цалин авах, өөрийнхөө хүрээний хүмүүст Сайн мэдээ хүргэх зэрэг

ажил орно. Гэхдээ хэрэв та бүтэн цагаар ажилладаг бол, яаж олон хүнд хүрэх билээ? Тэгвэл үүнийг түншлэл шийднэ.

Та хүнд ач тустай нэгэн бүтээгдэхүүн хийжээ. Гэхдээ үүнийгээ сард ганц хоёр ширхэгээр л үйлдвэрлээд байвал, бүхэл бүтэн хот, улс, дэлхийн хэрэгцээг хангаж чадахгүй. Тэгвэл та зорилгодоо хүрэхийн тулд таны бүтээгдэхүүнийг хэдэн мянгаар нь үйлдвэрлэн тарааж чаддаг компанитай түншилнэ. Тухайлбал сард нэг хоёр хүнд сайн мэдээ хүргэж, дагалдагч бэлтгэдэг хүн түншлэлээр дамжуулан хэдэн мянган хүнд хүрдэг болно. Тэгэхээр, та энгийн нэг түншлэлээр дамжуулан авьяас бэлэг, хүчин зүтгэлээ үр дүнтэй үржүүлэх нь байна.

Энэ зарчим Филиппойчуудад хэлсэн Паулын үгд ч бий: “Би бэлгийг нь эрж байгаа юм биш, харин та нарын үнэлгээнд нэмэгдэж буй үр ашгийг эрж байна. (Филиппой 4:17)

“...Та нарын үнэлгээнд нэмэгдэж буй үр ашгийг” гэсэн үгийг анхаараарай. Филиппойчууд Паулын амьдралд санхүүгээр туслаж, түншилснээрээ хүмүүсийн сүнснийг аварч, тэднийг сургах ажлаар нь дамжуулан хүчин зүтгэлээ үржүүлжээ. Тэд зуурдын юмаар мөнхийг ашгийг олж, үр дүнгээ үржүүлжээ.

Та ийм түншлэлийн харилцаанд орбол, “дансан дахь ерөөлийн ургацаа нэмнэ” гэж Паул хэлжээ. Энэ бол таны тэнгэрийн данс юм. Та Христийн Шүүх сэнтийн өмнө зогсохдоо, өөрийн биеэр нөлөөлсөн хүмүүсийнхээ төлөө шагнуулаад зогсохгүй бас Бурханы томилсон үйлчлэгч нартай тогтоосон түншлэлээрээ дамжуулан хүрч, сургасан сая сая хүний төлөө ч шагнуулна. Тиймээс л Бичээс бидэнд: “Талхаа усны гадаргуу дээр хая! Учир нь олон хоногийн хойно чи түүнийгээ буцааж олно шүү дээ. Өөрт ногдсоныг долоо юмуу найм хуваа. Учир нь дэлхий дээр ямар гай гамшиг тохиолдохыг чи мэдэхгүй шүү дээ” (Номлогчийн үгс 11:1-2) гэдэг.

Бурханаар томилогдсон үйлчлэлд (бас нутгийн чуулганд) тогтмол өргөснөөрөө, тэдний үйлсээр дамжин та ч бас хамтран зүтгэж байгаа юм. Та тэдний түнш учраас, тэдний ажил үйлс болгоны салшгүй хэсэг болно. Тэгэхээр, хөрөнгө оруулах тусам, улам л их шагнуулна гэхээр сайхан байгаа биз дээ?

Бурхан бэлэгийг чинь хэмжээгээр нь биш, харин тарих итгэмжтэй байдлаар чинь шүүнэ. Бурхан Аав зүрхний бэлэгийн чанарыг л хардаг. Тэрбээр мөнгөн дүнг биш, зүрхийг нь ерөөж хайрладаг. Жишээлбэл хүн сар бүр гучин мянган төгрөг үйлчлэлд өргөж байвал,

Бурхан мөнгийг нь биш, бэлэгийг нь илүүд тооцох болно. Учир нь тэр хүн илүү гарснаа биш, харин илүү гарган байж өгчээ. Гэтэл өөр нэг хүн сар бүр сая төгрөг өргөлөө ч, энэ нь түүний хувьд юу ч биш байж болно. Тэр ямар ч золиос, төлөөс гаргаагүй. Аль аль нь л Бурханд сайхан бөгөөд үнэ цэнэтэй ч, Бурхан гучин мянган төгрөг өгсөн хүнийг л ихийг өгсөнд тооцно. Яг үүнийг хоёр задгай зэс зоос өгсөн бэлбэсэн авгайн түүх дүрслэдэг. (Марк 12:41-44)

Бурхан гэхдээ бидний бэлэгийг энэ амьдрал ч үржүүлдэг гэдгийг маргаж болохгүй. Энэ урсгал нь биднийг бүр ихийг өгөх чадвартай болгоно. “Харамгүйгээр тараах хүн арвижих. Хэт гамнах хэрнээ ядуу тарчиг болох.” (Сургаалт үгс 11:24) Бодоод үз. Таны хөрөнгө оруулалт мөнхөд өсөөд зогсохгүй, энэ дэлхийд ч өсч, таныг улам олон хүнд хүрэх чадвартай болгоно. Энэ тойрог тасралтгүй шинэчлэгдэн тэлсээр байдаг.

Хорин хоёр жилийн өмнө миний таньдаг хэсэг бизнесмэнүүд ярилцаад, бизнесийнхээ тодорхой хувийг Сайн мэдээний үйлчлэлд зориулахаар шийдсэн юм. Тэдний энэ ажил өчүүхнээр эхлэсэн боловч, жил өнгөрөх тусам өссөөр байв. Тэд ч тууштай түншилсээр, өргөсөөр байлаа. Тэд байгуулагдсан цагаасаа эхлэн арван хоёр жилийн турш сайн мэдээний үйлчлэлд 120 сая доллар хандивлажээ. Тэд минагаа хаанчлалын зорилгын төлөө үржүүлжээ.

Гэтэл амжилттай бизнестэй боловч, ашгаасаа маш өчүүхэн хувийг чуулгандаа өгдөг эрчүүд, эмэгтэйчүүд чуулганд зөндөө бий. Нийгэм тэднийг амжилттай гэж үздэг ч, Эзэн тэднийг хэрхэн дүгнэх бол? Сая саяын хөрөнгөтэй тэдгээр хүмүүс минагаа нуусан хүн шиг л шүүгдэнэ. Тэд өөрт өгөгдсөнөө хаанчлалын төлөө үржүүлээгүй ажээ. Тэд бол өнө мөнхөөр хөтлөгдөөгүй хүмүүс юм.

Саяхан би манай үйлчлэлийг хааяа хааяа дэмждэг нэг бизнесмэнтэй гольф тоглосон юм. Тараад тэр намайг зочид буудалд хүргэж өгөхдөө: “Жон, би тавь хүрлээ. Энэ компанийг есөн сая долларын хөрөнгөтэй компани болгох гэж ясаа цайтал ажиллалаа. Бизнес маань ч тогтож, эхнэр хүүхдийн маань амьдрал ч баталгаажлаа. Тийм байтал би дараагийн арван жил бизнесээ гуч, дөчин саяд хүргэх гэж зүдрэх хэрэг байна уу?” гэж хэлсэн юм.

Би түүнийг өөрийгөө Бурханы гэрийг барилцаж байгаа чухал хүн гэдгээ мэдэхгүй байгааг ойлгов. Тэр намайг л хаанчлалын чухал хүн гэж харснаас биш, өөрийнхөө үнэ цэнийг хараагүй ажээ.

Тэгэхээр би тэр дор нь түүний асуултыг асуултаар хариуллаа: “Хэрэв намайг “Би ясаа цайтал ажиллаж, арван долоон ном

бичиж, арван нэгэн сая км аялж, хэдэн мянган номлол номлолоо. Одоо үйлчлэл маань ч тогтож, эхнэр хүүхдийн маань амьдрал ч баталгаажлаа. Тийм байтал би яах гэж дахиж ном бичиж, аялж, номлох хэрэгтэй гэж?” гэж хэлбэл, Есүс яах бол?”

Тэрбээр инээд алдаад: “Би л чиний оронд байхыг хүсэхгүй дэг” гэж хэлэв.

Тэгэхээр нь би түүнд: “Гэхдээ чи дөнгөж сая тэгж л хэллээ шүү дээ!” гэлээ.

Тэгээд түүнд жаахан бодох хугацаа өгөөд: “Есүс намайг хаанчлалаа байгуулаарай гэж бичиж, номлох бэлэг өгсөн. Харин чамд хаанчлалаа дэмжих мөнгийг олох бэлэг өгсөн. Чи цэгүүдээ холбоогүй байна. Яг л хөл минь намайг очиж номлох ёстой хүмүүс дээр минь аваачихгүй бол, ам маань хийх ёстой ажлаа хийж чадахгүй шиг, хэрэв чи ажиллахгүй бол, би хийх ёстой ажлаа хийж чадахгүй” гэсэн юм. Найз маань зог тусав.

Зургаан сарын дараа түүнтэй яриад, аж байдлыг нь асуутал, тэрбээр: “Жон, зургаан сарын өмнө хэлсэн чиний үг надаас салахаа больсон. Гэхдээ мэдээж сайн утгаараа. Би илүү ихийг өгөхийн тулд улам хичээж байгаа шүү” гэж хэлсэн юм. Би түүний даруу байдалд хайртай.

Гэтэл бас Лиза бид хоёрын нэг танил манай чуулганд суулгагдаж, хэрэгтэй гэсэн газар маш идэвхитэй үйлчилдэг байв. Тэрбээр чуулганд бүтэн цагаар үйлчлэхээр биш, харин бизнесийн ертөнцөд дуудагдсанаа мэддэг байлаа. Тэр хүн 90 хувиа өргөөд, арван хувиараа амьдарна гэсэн зорилго тавиад зорилгодоо хүрсэн ч, арван хувиараа тансаг машин хөлөглөж, тансаг байшинд амьдрах чадалтай байсан юм. Хаанчлалын түншлэл нь түүний бизнесийг цэцэглүүлж, арван хувийг нь өсгөжээ. Тэрбээр “бага юмд итгэмжтэй хүмүүс ихийг хүлээн авна” гэсэн Есүсийн зарчмыг хэрэгжүүлсэн байна.

Түншлэх өөр нэгэн шалтгаан нь бидэнд ач тус хүргэсэн үйлчлэлийнхээ ачийг хариулах юм. Паул: “Бид та нарт сүнслэг зүйлсийг тариад та нараас махбодын юмсыг хураавал энэ нь дэндүү их гэж үү? Хэрэв бусад нь та нарынхаас хуваалцах эрхтэй бол бид тэднээс ч илүү бус уу? Хэдий тийм боловч бид энэ эрхээ ашиглаагүй. Бид өөрсдөө Христийн сайнмэдээнд ямар ч саад учруулахгүйн тулд бүхнийг тэвчдэг” (1Коринт 9:11-12) гэжээ.

Жирийн амьдрал дээр ч ийм байдаггүй гэж үү? Найз чинь танд бэлэг өгсөн бол, та өөр хүнд баярлалаа гэж хэлэхгүй, өөрийг чинь ерөөсөн найздаа л талархана. Бурхан зориуд түншлэлийг ийм байдлаар бүтээсэн. Учир нь олон хүнд Сайн мэдээг хүргэх хэмжээгээр санхүүгийн хэрэгцээ өснө. Тиймээс хэрэв бид үйлчлэлийн ач тусыг хүртсэн бол, эргээд санхүүгээр дэмжих нь зүйтэй (хувь нэмэр маань нөгөө бэлбэсэн авгайн хоёр задгай зэс зоос шиг байсан ч хамаагүй).

Филиппой 4:18-19 дээр Паул:

“Тэвч би бүгдийг хүлээн авч хангагдсан. Би Елафродитоос та нарын юмсыг хүлээн аваад дүүрэн байна. Бэлэг чинь Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр юм. Миний Бурхан алдар дахь баялгаараа Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр чинь хангана” гэсэн.

Бурхан баялгаараа хэрэгцээ бүрийг нь хангана гэсэн амлалт нь Бурхантай үйлчлэл дээр түншилдэг хүмүүст өгөгдсөн юм. Та арван хувиа өргөж, үйлчлэл дээр түншилдэг бол, Бурханы бат амлалт дээр зогсож байгаа юм. Та юугаар ч дутахгүй.

Залбирлаар дамжин үржих

Үржих өөр нэгэн арга зам нь залбирал юм. Санхүүгээр үйлчлэлийг дэмжиж үрждэг шиг, бид хувь хүн, гэр бүл, чуулган, хот, улс үндэстний төлөө залбирахдаа тэдний амьдралыг мөнхөд өөрчилж, тэр хүмүүстэйгээ энэ амьдралд уулзахгүй байлаа ч гэсэн, хожим тэнгэрт заавал уулзана. Мөн үйлчлэлүүдийн төлөө залбирснаар хүмүүсийн амьдралыг өөрчилж чадна. Манай үйлчлэлд ч санхүүгийн болоод залбирлын түншүүд байдаг. Залбирлын түншүүд маань Мессенжер Интернэйшнэлийн төлөө өдөр тутам залбирдаг хүмүүс юм.

Хүмүүс надад: “Би таны төлөө өдөр бүр залбирдаг шүү” гэж их хэлдэг. Тэдний хэн нь үнэн голоосоо, хэн нь зүгээр л хэлж байгаа нь шууд мэдэгдэнэ. Чин сэтгэлээсээ зуучлан залбирдаг хүмүүст би: “Бидний хувьд үүнээс том тус байхгүй!” гэж хэлдэг. Үнэхээр ч тийм! Хүмүүс залбирвал, бид илүү олон хүний амьдралыг илүү жинтэй өөрчилнө. Залбирал бас хүмүүсийг Бурханы ажлыг санхүүгээр дэмжихэд хөдөлгөдөг. Тиймээс хэрэв би санхүүгийн түнш,

залбирлын түнш хоёрын аль нэгийг сонгох болбол, мэдээж эхлээд залбирлын түншийг нь сонгоно. Гэхдээ аль аль нь чухал юм шүү.

Үйлчлэлээр дамжин үржих

Үржих өөр нэг арга нь үйлчлэх юм. Лиза бид хоёр байгууллагынхаа ажилтнуудад биднээр дамжин амьдрал нь өөрчлөгдсөн хүн нэг бүрийн төлөө Шүүх сэнтийн өмнө шагнуулна гэдгийг нь байнга хэлдэг.

Би үүнийг тулаанаас эргэж ирсэн дайчиддаа хэлдэг Давидын үгээс ойлгосон юм. 1Самуел 30 дээр Давид Амалекчуудыг нэхэж очоод, Израилийн хуарангаас дээрэмдсэн бүгдийг нь эргүүлж авчирдаг түүх бий. Тэгээд Давид дайчидтайгаа хамт хуарандаа эргэж иртэл, Давидтай хамт явсан эрчүүд нь хуарандаа үлдсэн эрчүүдтэйгээ олзоо хуваахыг хүсдэггүй. Тэр үед Давид ингэж хэлдэг:

“Ийм хэргийн тухайд та нарын хэлэхийг хэн сонсох вэ?
Тулалдаанд явсан хүмүүсийн хувь нь ачаа барааны дэргэд
байсан хүмүүсийн хувьтай адилхан. Тэд адилхан хуваах ёстой
гэж хэлэв. Тэр өдрөөс хойш Давид үүнийг израильчуудад зарлиг
тогтоол ба шийдвэр болгосон нь эдүгээ хүртэл мөрдөгдөж
иржээ.” (1Самуел 30:24-25)

Давид бол Христийн төлөөлөл юм. Тэгэхээр “Тэр өдрөөс хойш Давид үүнийг израильчуудад зарлиг тогтоол ба шийдвэр болгосон нь эдүгээ хүртэл мөрдөгдөж иржээ” гэдэг мэдэгдэл нь Есүс, чуулган хоёрын харилцаанд ч хэрэгжинэ гэж би ойлгодог. Шүүх сэнтийн өмнө тухайн үйлчлэлийн үнэлгээ нь гагцхүү удирдагчид очих биш, харин хэдийгээр яг тулааны талбарт гараагүй ч, арын албанд итгэмжтэй үйлчилсэн, өгсөн, залбирсан хүмүүст бас очно.

Хандлага чухал

Шагнал авах эсэхийг маань шийдэх нэг чухал тал нь бидний хандлага юм. Үйлс сэдлээр урагшилдаг бол, сэдэл нь хандлагаар урагшилдаг. Исаиа 1:19 дээр Бурхан “Уриалгахнаар та нар дагах аваас Уул газрын сайныг иднэ” хэмээн амлажээ.

Нэг хэсэг Бурхан, бид хоёрын харилцаа нэг л явцгүй болчихсон юм. Би цуглаанаар ч, пасторынхаа номлолоор ч ерөөгдөхгүй

байсан тул амьдрал минь ангаж байв.

Би тэр найман мянган хүнтэй чуулганд пастортайгаа ойр дотно хамтран ажиллаж байсан ч, түүнээс алхам тутмаа өө сэв хайдаг болчихсон байлаа. Гэтэл нэг өглөөний залбирал дээр Бурхан надад: “Чиний наад байдалд пастор чинь биш, чи өөрөө хариуцлагатай” гэх нь тэр.

Би зог туслаа: “Би яасын?”

Гэтэл Эзэн надаас Исаиа 1:19-р ишлэлд юу байдгийг асуув. Би ч дээрх ишлэлийг цээжилчихсэн учраас шууд хэлтэл Эзэн надад: “Харав уу? Чи өлслөө гэж байна. Тэр чинь үнэн. Газрын шимийг хүртэхгүй байгаа юм чинь аргагүй шүү дээ” хэмээн айлдлаа.

Тэгэхээр нь би биеэ өмөөрөн: “Пасторынхаа хэлсэн бүгдийг биелүүлдэг над шиг дуулгавартай хүн байхгүй!” гэх ухааны юм хэлтэл Эзэн:

Би “дуулгавартайгаар дагах аваас гэж хэлээгүй, харин дуртайяа дагах аваас” гэсэн. Дуулгавартай байдал үйлдэлтэй холбоотой, харин хүсэл нь хандлагатай холбоотой. Гэтэл чиний наад хандлагад авах юм алга!” гэсэн юм.

Тэгээд Эзэн намайг хэдий жигтэйхэн дуулгавартай харагдав ч, шүүмжилдэг, гомдоллодог, шүүдэг хандлагаараа үйлчлэх сэдлээ сүйтгэж байгааг минь илчлэв.

Би ч тэр даруй буруугаа ойлгон гэмшсэн бөгөөд дараагийн цуглаан дээр шууд л зулай дээрээс минь тэнгэр мишээсэн юм. Би дахиад л Бурханаар дүүрээд явчихав. Тэгээд пасторынхаа номлолыг сонсож байхдаа, харласан дотроосоо болж хэдэн сар алдаж өнгөрөөсөн зүйлээ бодоод, харуусан уйлж суусан юм. Үүний дараах нь би: “Та нар бүх зүйлд дуулгавартай байдаг эсэхийн нотолгоог чинь мэдэхийн тулд би ийнхүү бичлээ” (1Коринт 2:9) гэсэн Паулын үгийг Ариун Сүнсний ухаарлаар голдоо ортол ойлгож билээ.

Бурхан биднийг Өөрийнх нь хүсэлд захирагдах хүсэлтэй эсэхийг шалгадаг ажээ. Би энд Есүс биднийг чөлөөлөх гэж үнийг нь төлсөн юмсаар дайсан биднийг бөмбөгдөж байхад нь хүлцэнгүй явах талаар яриагүй байна. Бид дайсныг итгэл, залбирал, Бурханы Үгийн тунхаглалаар эсэргүүцэх ёстой. Би энд Бурхан биднийг явуулахыг хүсдэг замд хандах өөрсдийнхөө хандлагын талаар ярьж байна. Паул: “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай” (Филиппой 2:5) гэжээ. Есүс Аавынхаа бэлдсэн аягаас дуртай дургүй уугаагүй, харин сайн дураараа уусан юм. Тиймээс л Паул бидэнд

“оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгд” (Ефес 4:23) гэжээ.

Яагаад? Яагаад гэвэл хандлага нь сэдлэд нөлөөлдөг бөгөөд Шүүх сэнтийн өмнө бид зөвхөн үйлсийнхээ төлөө биш, харин түүний цаадах сэдлийнхээ төлөө шагнуулна.

“Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө (ямар зорилго, сэдлээр үйлдсэн, ямар ололтод хүрсэн, ажил үйлсээ гүйцэтгэхийн тулд юунд цаг зав, өөрийгөө, анхаарлаа зориулсныг нь харгалзан үзсэн хойно) биеэрээ хариугаа (цалингаа) авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой.” (2Коринт 5:10)

Бурханд дуртай дургүй үйлчилсэн болж байгаа хүмүүсийг харахаар гол харламаар. Тэрбээр өнө мөнхийн хараагаа алджээ. Ажиллах нь ажиллаж байгаа ч, нэг л их зовсон хандлагатай, амиа бодсон, атаач сэдэлтэй хүн. Нэгэн цагт гал халуунаар эхлэж байсан хүмүүс чухам энэ шалтгаанаас болж л амьдралаа таагүй дуусгадаг. Тиймээс л бидэнд: “Хэн чинь ч Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд болон аливаа гашуун үндэс урган хор учруулж, түүгээр олноороо бузарлагдахгүйн тулд сэрэмжил” (Еврей 12:15) гэжээ.

Олноороо бузарлагдахгүйн тулд гэж байгааг анхаараарай. Энэ ямар үнэн үг болохыг миний бие гуч гаруй жил үйлчлэхдээ харсан бөгөөд үнэхээрийн зүрх зүсмээр байдаг. Хайртай хүмүүс маань буруу хандлагаа засаагүйгээсээ болж бүдэрч бүтэлгүйтээд, шагналгүй хоцроосой гэж хүсээгүй л бол, тэднийг хорсолд автахаас нь сэргийлэх үүднээс байнга сануулж сэрээх ёстой бид.

Эргий бид хоёр энэ тал дээр ялангуяа хүүхдүүд, ажилчиддаа маш их анхаардаг. Бид бүтэн цагаар аялж үйлчлэхээр дуудагдсан учраас, хөвгүүд маань бие дааж амьдарч сурсан юм. Гэхдээ бид хөвгүүдээ нигүүлслээс хоцроосой гэж мэдээж хүсэхгүй. Тиймээс байнга урамшуулж, хандлагыг нь хамгаалж, хүчтэй байлгадаг.

Нэг удаа би хөвгүүдээ суулгаж байгаад: “Аав, ээж хоёр нь сард олон өдөр аялдаг. Яагаад гэвэл Бурхан бидэнд ингээрэй гэж хэлсэн. Бурхан аав, ээж хоёрыг нь Өөрийнхөө алдрын төлөө хүмүүсийн амьдралыг өөрчилж, Түүний хаанчлалыг байгуулаасай гэсэндээ томилсон.

Та дөрөв Бурханы энэ дуудлагад хоёр янзаар хандаж болно. Нэг бол Бурхан аав, ээжийг чинь та нараас аваад, та нарт бусад хүүхдүүдтэй адил жирийн сайхан амьдрал өгөөгүй гэж гомдож

болно. Эсвэл аав, ээжийгээ Бурханы зорилгын төлөө мянга мянган хүний амьдралд илгээхдээ - ийм замаар өөрсдийгөө ч үйлчилж байна гэж харж болно. Хэрэв ийм хандлагатай байвал, та дөрөв аврагдсан хүн бүрийн төлөө Шүүх сэнтийн өмнө шагнал хүлээж авна. Харин Бурхан аав, ээжийг чинь та нараас булаачихсан гэж харж байгаа бол, та дөрөв бидний үйлчлэлээр аврагдаж, өөрчлөгдсөн хүмүүсийн төлөө ямар ч шагнал авахгүй. Тиймээс хөвгүүд ээ, хандлага хамгаас чухал болохыг хэзээ ч бүү мартаарай!” гэж хэлсэн юм.

Тэд миний үгийг ойлгосон учраас, байнгын аялалын маань талаар хэзээ ч гомдоллоогүй юм. Үнэндээ Лиза бид хоёрыг аль нэг газар уригдах бүрий хөвгүүд маань дэмждэг. Хөвгүүд маань Бурханд хайртай бөгөөд бүгдээрээ л манай байгууллагад үйлчилдэг. Манайх үнэхээр дотно сайхан гэр бүл. Энэ бүхэн Бурханы л нигүүлсэл билээ. Үүний ачаар хөвгүүд маань хар багаасаа л минагаа үржүүлж сурсан юм.

Би ажилчиддаа ч яг ингэж хэлдэг: “Та нар ажлаа зүгээр ажил гэж бодож байгаа бол эцэстээ ядарч, хорсож, Шүүх сэнтийн өмнө юу ч хүлээж авахгүй. Харин мянга мянган хүнийг аварч өөрчлөх завшаан гэж харж байгаа бол, өдөр бүр илгээх ном бүрээр, хариулах имэйл бүрээр, олон нийтийн сүлжээгээр холбогдож байгаа хүн бүрээр, хурал цулаан бүрээр энэ үйлчлэлээр Бурханы хийлгэхийг хүссэн Бурханы ажлын амин чухал хэсэг болж байгаа учраас, яг л ар талд үлдсэн Давидын дайчидтай адил юм.” Тэд маань ч миний үгийг тэр дороо ойлгодог, мундаг хандлагатай хүмүүс. Би удирдагч хүнийхээ хувьд тэдэнд энэ хандлагаа сахин хамгаалсаар байх амийн үгийг хэлэх ёстой ч, эцсийн дүнд өөрийнхөө хандлагын төлөө хувь хүн өөрөө л хариуцлагатай юм.

Аугаа хандлага нь бидэнд минагаа үржүүлж, сайн дуусгахад туслана. Бурханы өргөө гэрийг захиалгаар барих аугаа ажилд гар бие оролцох их завшаан та бидэнд олджээ. Тиймээс таны ажил хичнээн өчүүхэн харагдаж байсан ч, чухал бус ажил гэж байдаггүйг бас үр нөлөөтэй байх эсэхээ та өөрөө шийднэ гэдгийг бүү мартаарай. Би л хувьдаа таныг яг л элч Иохан шиг “Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна” (2Иохан 1:8) гэсэн хандлагатай байгаасай гэж хүснэ.

ХУВЬ ХҮНИЙ НӨЛӨӨ

Харин чи миний сургаал, төлөв байдал, зорилго, итгэл, уужим сэтгэл, хайр, тэвчээр, хавчлага, зовлонг дагасан.

—2Тимот 3:10

Бусдын амьдралд аль хэр нөлөөлснөөрөө бид өнө мөнхлөлд нэг бол шагнуулна эсвэл гарз амсана. Энэ нь зөвхөн үйлчлэлд биш бас хэрхэн амьдарч, бусдад хандсан хувийн амьдралд ч хамаатай.

Бид бусдыг хэрхэн үзсэнээрээ нэг бол таатай хандана, нөгөө бол таагүй хандана. Хэрэв бид хүмүүсийг дорд үзбэл, тэдний хэрэгцээнд хөнгөн хуумгай хандаж, доош нь хийнэ. Хэрэв бид хүмүүсийг үнэлбэл, бүх сэтгэл, хайраараа амьдралыг нь байгуулж бэхжүүлнэ.

Хэрэв бид хүмүүсийг эх үүсвэр гэж хардаг бол, өөрийнхөө хүсэл, хэрэгцээ, хүслэнг хүмүүсээс дээгүүр тавьж тэднийг ашиглана. Хэрэв бид хүмүүсийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн ер бусын үнэтэй, цэнэтэй гэж хардаг бол, өөрөө хохирсон ч хамаагүй тэднийг ерөөнө. Энэ бол Христтэй адилхан зан чанар.

Амиа бодсон цайз

Би Христийг мэдэхээсээ өмнө аймаар амиа бодсон хүн байлаа. 1979 онд Есүст итгэсний дараа Ариун Сүнс миний амиа бодсон цайзыг нурааж эхлэсэн юм. Тиймээс эхний арван жил нилээд юм болсон.

Нэг цайз маань бэлгийн тачаал байлаа. Порнод нэг л өдөөгдчихбөл, бараг эсэргүүцэж чадахгүй. Ийнхүү зургаан жил зөрчилдсний эцэст 1985 онд мацаг барьсан дөрөв дэхь өдрөө чөлөөлөгдсөн юм. Чөлөөлөгдсөний дараа оюун санаа маань шинэчлэгдэж эхлэв.

Тэгээд он жил өнгөрөх тусам би тачаалынхаа эх үндсийг олж мэдсэн юм. Зүрхэнд минь Бурханы хайр тэлсээр, хүмүүсийг үнэлэх үнэлэмж маань ч өссөөр байлаа. Тэгээд би хуучин донтолтынхоо асар хүчтэй аминч чанарыг ухаарсан юм. Би эмэгтэй хүнийг порнографийн буюу тачаалын нүдээр харахдаа, түүнийг зүгээр л миний дурыг хангах зориулалттай махан бие гэсэн үзэл маань миний зүрхэнд нутаглажээ.

Тэр цагаас хойш эмэгтэй хүн бол Бурханы дүр төрхөөр бүтээгдэж, алдар хүндэтгэлээр титэмлэгдсэн бүтээл гэдгийг ухаарах илчлэл миний дотор батжив. Урьд нь би энэ үнэнийг мэддэг байсан ч, эд эсээрээ биш, тархиараа л мэддэг байжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам, би Бурханы өөрчлөгч хүчийг бодитоор харсан юм. Сүүлдээ би самбар, сэтгүүлийн нүүр, зурагтын дэлгэцнээс порнографийн дүр зураг харахдаа, халдлагад өртсөн мэт санагддаг болж билээ. Есүсийн амиараа хайрласан тэр хүнийг зүгээр л нэг мах болгож байгаад сэтгэл минь өвддөг болсон юм. Энэ илчлэлийг хүлээж авсны дараа эмэгтэй хүнийг харах нүд минь эрс өөрчлөгдөж билээ.

Чуулганд ч хүртэл эмэгтэй хүнд зохисгүй хандах явдал гардаг нь харамсалтай. Тэднийг доош хийж, дутуу үнэлж, тэр бүү хэл нүд үзүүрлэдэг. Энэ бол адгийн явдал. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бол Бурханы хаанчлалын эрх тэгш өвлөгчид бөгөөд эрчүүд хүчтэй савынхаа хувьд (энэ нь хүчтэй сэтгэлтэй юмуу зүрхтэй гэсэн үг биш, харин хүчтэй биетэй гэсэн үг юм) эмэгтэйчүүдийг өөрөөсөө дээр тавьж, хүндэтгэх ёстой. Эрчүүд эмэгтэйчүүдийг хүндэтгэж, үнэлж, цэнэж, хамгаалж, барьж байгуулахыг эрэлхийлэх ёстой. Нөхрүүд та нар нэгдлийн тэргүүн мөн. Тэргүүн гэдэг нь хаанчлалд эхнэр хүүхдээ эзэгнэн дарлана гэсэн үг биш, харин гэр бүлийнхээ төлөө амиа зориулан үйлчилнэ гэсэн үг. Тэргүүнчлэлийг гэргийгээ дээрэлхэх явдал гэж ойлгодог хүн гэргийгээ барьж байгуулдаггүй, нурааж сүйтгэдэг. Та үүнийхээ төлөө Шүүх дээр хариуцлага хүлээнэ.

Хүлээн зөвшөөрөгдөх хүсэл

Бурханы илчилж өгсөн миний өөр нэгэн аминч зан нь бүр ч зальхай дүртэй байлаа. 1980 - аад оны дундуур би 400 ажилтантай чуулганд үйлчилдэг байв. Чуулган маань үндэсний хэмжээний

мянга мянган чуулганд хүрч ажилладаг, найман мянга орчим хүнтэй том чуулган байлаа.

Тэр үед би үнэнтэй нүүрэлдэхээс айж, асуудлаас аль болох зугтдаг хүн байв. Хүмүүст аль болох эелдэг, зөөлөн хандана. Тэгээд бүр худлаа байсан ч хамаагүй хүмүүст зөвхөн сайхан үг л хэлнэ. Түүнийхээ ачаар би “хамгийн сайхан зантай залуу” нэрийг зүүв.

Тэгтэл нэг удаа залбирч байтал Бурхан: “1Коринт 13 дээр Би хаана нь хайрыг сайхан зантай гээд хэлчихсэн байна?” гэж асуух нь тэр.

Би жаахан гайхаад: “Хаана ч биш” гэж хариуллаа.

Тэгтэл Бурхан: “Хүү минь, чи хүмүүст худлаа байсан ч хамаагүй сайхан юм хэлдэг шалтгаанаа мэдэх үү?” гэх нь тэр.

Би ч: “Үгүй, би бодож байсангүй” л гэлээ.

Гэтэл Бурхан шууд: “Чи тэдэнд таалагдахаа больчих вий гэхээс айдаг. Тэгэхээр, чиний хайрын төв тэд байна уу, чи өөрөө байна уу? Чи хүмүүст хайртай л бол, тэд дуртай байна уу, дургүй байна уу хамаагүй үнэнийг л хэлнэ. Тэдний дургүйг хүргэсэн ч хамаагүй, өөрсдийнх нь сайн сайхны төлөө үнэнийг л хэлэх болно” гэсэн юм.

Тэгэхэд л би сайхан зангийн баг зүүсэн аминч чанараа таньж билээ. Тэр зовиуртай үнэн ил болов. Би өөрөө амьдрахын тулд хүмүүсийг ашиглажээ. Бусдад таалагдах гэсэн сул талаа тайтгаруулах гэсэндээ би хүмүүст туслах биш, таалагдахыг л зорьжээ.

Тиймээс л үй олон үйлчлэгч нар Бурханы Үгийн зөвхөн эерэг талыг заадаг. Тэд анхааруулдаггүй, засдаггүй, зэмлэдэггүй. Тэд гишүүдээ жинхэнээсээ хайрлахын оронд гишүүдээ гомдоочихгүй, чуулганаа цөөлчихгүй байхад л анхаардаг.

Ийм хайрын төв нь үнэндээ өөрөө юу эсвэл өрөөл үү? Нүдээ боочихсон хавцал руу явж байгаа хүнийг бид зогсоохгүй юу? Гэхдээ яг ийм хуурамч хайрын үйлчлэгч нар яг амьдрал дээр адгуусаас ч дор авирладаг. Тэд зөөгч, хүргэгч зэрэг үйлчилгээний ажилтнуудыг дорд үзнэ. Тэдний олны нүднээс далдуурх амьдрал нь хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ? Тэд чинь уулзсан хүн нэг бүртээ хэрхэн нөлөөлснийхөө төлөө хариуцлага хүлээнэ шүү дээ.

Сайхан зантаас адсага аашт

Энэ илчлэлийг ойлгосны дараа зүү маань нөгөө тал руугаа дүүжигнэж, би адсага шиг ааштай номлогч болов. Би хүмүүсийн

мөнхийн сайн сайханд санаа тавьж, хайрлах биш, үнэнийг л шүтэх болов. Тэгээд чуулган руугаа галлаж гарна. Одоо амиа бодсон зан маань хэлбэрээ өөрчилжээ. Яг л “Шүтээнүүдэд өргөгдсөн тахилын тухайд гэвэл бид цөм мэдлэгтэй гэдгээ мэднэ. Мэдлэг ихэрхүүлдэг бол хайр босгодог. Хэрэв хэн нэгэн өөрийгөө ямар ч зүйлийг мэддэг гэж боддог бол тэрээр мэдэх ёстойгоо мэдээгүй л байна” (1Коринт 8:1-2) гэдэг үгийн сонгодог жишээ.

Одоо эргээд санахад, аялан үйлчлэлийнхээ эхэн үед намайг номлочихоод явсны дараа миний тарьсан хог новшийг цэвэрлээд үлддэг байсан пасторуудыг бодоод сэтгэл минь өвддөг. Би л тэдний нэг байсан бол, Жон Бивэрийг чуулгандаа дахиж хэзээ ч урихгүй байсан. Гэтэл шал түүхийгээрээ байгаа намайг гололгүй, Бурханд болоод Түүний хүмүүст үйлчлэх чин хүслийг минь олж харсан тэдгээр удирдагч нарт хязгааргүй баярлалаа.

Тэр үед би хүмүүст бялдуучлахаа больж, улаан нүүрэн дээр нь үнэнийг хэлж байсан ч, Бурханы надаас хуулж хаяхыг хүсч байсан аминч чанар л зүсээ хувирган ажиллаж байжээ.

Хэдэн жилийн дараа нэгэн алдартай пастор намайг нэр нөлөө бүхий хэдэн удирдагч нарт шүүмжилжээ. Энэ тухай би гурван тивээс сонссон юм. Тэгээд эхлээд асар их цочирдож хилэгнэсэн ч, гомдол намайг Бурханаас улам л хөндийрүүлнэ гэдгийг ухаарч байв. Гэхдээ тэр хүний дайралтаас болоод эцэстээ би Бурханд улам наалдаад, миний хэзээ ч мэдэрч мэдэж яваагүй хайраар намайг дүүргэхийг гуйсан юм.

Тэгтэл тэр бүх хугацаанд Бурхан зүрхэнд минь Түүний үнэт хүмүүсийг хайрлах хайрыг төлөвшүүлсээр байсныг би мэдээгүй билээ.

Энэ үеэр Эзэн надад амьдралыг минь орвонгоор нь эргүүлсэн нэгэн илчлэл өгсөн юм. Та намайг их л нухацтай үг хэлэх нь гэж бодоо байх. Гэхдээ тэр нь маш энгийн үг байсан юм. Магадгүй яг нарийн бодоогүй хүнд инээдтэй ч санагдаж мэднэ. Бурхан надад: “Халбага элсэн чихэр гашуун эмийг дардаг” гэж хэлсэн юм. Тэгэхэд нь би гашуун эмийг чихэрлэг зүйлтэй холиод өгбөл, гашуун нь мэдэгдэхгүй ч, эмийн үйлчилгээ нь хэвээрээ байдгийг ухаарч билээ. Тиймээс эмийг чихэртэй уувал, илүү амархан эсвэл бүр таатай ч байж болох ажээ.

Олон удирдагч надад: “Жон чи нээрээ инээлгэж байгаад л, голыг нь олоод хэлчих юм аа” гэдэг. Би энэ үгийг анх сонсохдоо

л Бурханы нигүүлслээр төлөвшжээ гэдгээ ухаарсан юм. Бурхан минь баярлалаа!

Намайг шүүмжилсэн тэр пастор уг нь намайг ерөөе гэж бодоогүй л байх. Гэхдээ тэр хүн миний амьдралын хамгийн том ерөөлийн нэг болсон юм. Бурхан заримдаа таныг Өөрийнхөө хүсэл рүү оруулахын тулд хүмүүсийн хорон ажлыг ашигладгийг бүү мартаарай. Бурхан Есүсийн хувь тавиланг загалмай дээр биелүүлэхийн тулд Иудасын урвалтыг ашигласан. Иосефийн зүүдийг биелүүлэхийн тулд ах нарынх нь хорон явуулгыг ашигласан.

Бурханы хайр бол бидний зорилго

Тэгэхээр хүмүүсийг хэрхэн үзэх нь маш чухал ажээ. Бурханы хайр, халуун сэтгэлийг амьдралдаа ургуулдаг хүн бусдыг доош нь ч, дээш нь ч хийхгүй. Өрөөлийг өөрөөсөө дорд гэж үзэх нь шүүмжлэл, шүүлтийг маань өрдөж, харгис хатуу занг дэвэргэдэг. Ром 14:10, 12 дээр Паул Ромчуудад юу гэж хэлснийг үзнэ үү:

“Тийн атал та юунд ах дүүгээ шүүнэ вэ? Бас та юунд ах дүүгээ басамжилна вэ? Бид бүгдээрээ Бурханы шүүх суудлын өмнө зогсох болно шүү дээ. Тийнхүү бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно.”

Итгэгч хүн “бие биеэ хайрла” гэсэн хоёр дахь чухал тушаалыг үл тообол, Паулын саяын хэлсэн зайлшгүй урхинд орж, бусдыг дээрээс хялайж эхлэнэ. Нэн ялангуяа Сүнсний үр жимсгүй, дан Библийн мэдлэгтэй хүн яг ингэдэг.

Бичээс Бурханыг хайр гэсэн. Гэхдээ хайр нь Бурхан биш юм. Энэ нь том ялгаатай. Бурханы зан чанар, арга зам, зорилго нь хүний мэддэг хайрын тодорхойлолтод багтахгүй. Учир нь хүн Есүсийг мэдэхээс нааш хайрыг мэддэггүй. Есүс бол хайрын мөн чанар юм.

Бас “Бурханд хайр бий” гэдэг үг Бичээст байхгүй. Бурханд хүч бий, бэлэг бий, эрх мэдэл бий. Гэхдээ Есүс л хайрын жинхэнэ мөн чанар юм. Тиймээс бид Есүсийн чанараар дахин төрсөн учраас, Түүнтэй адилхан байх ёстой. Тиймээс л Паул:

“Хэрэв би хүмүүсийн болон тэнгэрэлч нарын хэлээр ярилаа ч надад хайр үгүй бол би хий нүргэлэх харанга, хангинах цан аж. Хэрэв би эш үзүүлдэг мөн бүх нууц болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр үгүй бол би юу ч биш. Хэрэв би бүх өмч хөрөнгөө тараан өгч, биеэ шатаахаар тушаасан ч надад хайр үгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм” (1Коринт 13:1-3) гэжээ.

Хайр бидний хэлээс үүсээгүй. Бид хүнд хайртай гэж хэлчихээд тэс өөрөөр үйлддэг. Хайр бидний үйлсээс ч төрөөгүй. Дээрх ишлэлд Паул биднийг хайрыг дээд зэргээр төлөөлдөг юмсыг ч (хамаг юмаа ядууст өгч, биеэ золиословч) ямар ч хайргүй хийж чаддаг гэжээ. Тэгэхээр, жинхэнэ хайр зүрхнээс л төрдөг аж.

Хайртай учраас бусдад тэвчээртэй зөөлөн хандана. Сайхан сайханд нь баясан, дэвжин дээшлэхийг хүснэ. Өөрөөрөө сайрхаж, бардах бүхнээс зайлсхийнэ. Дураараа шаардахгүй, тэвчээр алдаж цухалдахгүй. Биднийг хорлосон ч, өс саналгүй уучилж, өрнөөс нь чөлөөлнө. Шударга бус юманд баясалгүй, нигүүсэл үнэнийг мөшгинө. Хүмүүст итгэл алдарч, бууж өгөлгүй, үргэлж хамгийн сайнд нь итгэнэ. Буруу нь батлагдахаас нааш бусдыг гэмгүйд тооцож, гэмтэй хүнийг ч гэмшиж сэргэнэ гэдэгт найдна. Итгэл найдвараар дүүрч, хаанчлалын ашиг, бусдын сайн сайхны төлөө ямар ч бэрхшээлийг тэсч гарна. Эцэст нь хэлэхэд: бид бусдыг бурханлагаар бойжуулах ёстой. Харин бурханлаг бойжилт нь Христтэй адил болж, амьдралд нь хандсан Христийн хүслийг биелүүлснээр л бий болно.

Олны хайртай удирдагч

Хэдэн жилийн өмнө би хайрт найз Жэк Валласынхаа оршуулгад оролцсон юм. Тэрбээр Мичиганы Детроитод Детроит Уорлд Аутрич нэртэй олон үндэстний чуулганыг үндэслэн байгуулсан бөгөөд арван жилийн дотор дөрвөн мянган гишүүнтэй болгосон юм. Жэк маань Зимбабвед сайн мэдээний аянд номлохоор онгоцноос дөнгөж буугаад л зүрхний шигдээс болжээ.

Жэкийн оршуулгад мянга мянган хүн оролцов: Америкийн өнцөг булан бүрээс ирсэн үйлчлэлийн удирдагч нар, нийгмийн удирдагч нар, том том корпорацийн тэргүүд, жирийн ажилчид, гудамжны

хүмүүс, түүн ажиллуулдаг ээжүүд. . . Түүний чуулган ийм л олон хүнд хүрчээ. Түүнчлэн Жэктэй сайхан нөхөрлөж явсан зочид буудал, рестораны эзэд зэрэг Есүсийг мэддэггүй хүмүүс ч ирэв.

Гэхдээ би тэр ирцэд огт гайхаагүй юм. Жэк бид хоёр чуулганаас гадуур маш их уулзаж нөхөрлөдөг байлаа. Жэкийн уулзсан хүн бүртээ хандаж байгаа хандлага нь намайг үнэхээр бишрүүлдэг байв. Тэрбээр хүн бүрийг яг л үнэт эрдэнэ шиг үзнэ. Би анхандаа түүнийг жүжиглээд байна уу л гэж боддог байлаа. Гэтэл Жэк надад Бурханы хувьд энэ бүх хүмүүс ямар нандин болохыг учирлан тайлбарлах үед миний тэр тэнэг бодол засарсан юм. Жэк уулзсан хүндээ зүгээр л эрхэм нандин сэтгэгдэл төрүүлдэггүй, харин яг жинхэнээсээ эрхэмлэн нандигнадаг байв.

Оршуулгын ёслол дөрвөн цаг хагас үргэлжилсэн юм. Түүнтэй ойр дотно явсан хэд хэдэн удирдагчаас Жэкийг дурсахыг хүссэнд, дөрөв таван хүн босч үг хэлсний дараа нэгэн алдартай удирдагч босоод: “Уг нь би өөрийгөө л Жэкийн хамгийн сайн найз гэж бодсым сан!” гэж хэлээд бөөн инээдэм болж билээ.

Жэкийн хувьд бид бүгдээрээ л хамгийн сайн найз нь байсныг бид мэдэж байлаа. Тэр мундаг удирдагч Сайн мэдээний аян, зурагтын нэвтрүүлгээрээ хүмүүсийг байлдан дагуулахаас гадна амьдрал дээр уулзсан хүн бүртээ гүн сэтгэгдэл үлдээж, нөлөөлж чаддаг байсан юм. Жэк бэлэг, дуудлагадаа итгэмжтэй байгаад зогсохгүй, амьдралынхаа талбар бүрт минагаа үржүүлж чаджээ.

Үй олон хүнд нөлөөлсөн цэвэрлэгч

Миний амьдралд хамгийн том нөлөө үзүүлсэн хүмүүс нь индрийн ард гардаггүй жирийн л хүмүүс байдаг. Тэдний нэг нь Роквел Интернэйшнэлийн санхүүгийн ажилтан Майк гэдэг залуу байлаа. Би Христэд итгээд хоёр жил болж байхдаа түүнтэй танилцсан юм. Ажил дээр бид хоёр ойролцоо суудаг болохоороо завсарлагаанаар Бурханы тухай байнга ярилцана. Түүнчлэн бид хоёр бие биеийндээ зочилж бас чуулган дээр олон цаг нөхөрлөсөн дөө. Би Майкийн Бичээсийн дагуух шударга зан, амьдралын ухааныг биширнэ. Түүнчлэн түүний гэргий, үр хүүхдээ төдийгүй уулзаж учирсан хүн бүрээ хүндэтгэж байгааг нь би гайхдаг байлаа.

Намайг Роквелээс гарч, үйлчлэгч болсны дараа Майк ч

компаниасаа гарч, хувийн санхүүгийн фирм нээсэн нь өнөөдрийг хүртэл өндөр амжилттай ажилласаар байна. Тэрбээр арван хоёр мянгаад хүнд татварын буцаан олголт, тайлан тооцоогоо гаргахад нь тусласан бөгөөд тэднээс Майкийн шулуун шударга занг үнэлсэн таван мянган хүн нь Майкийн байнгын харилцагч болжээ.

Би саяхан Майкаас хэдэн үйлчлүүлэгчдээ Есүсийн тухай ярьж өгснийг асуутал Майк “Бараг 90-ээс илүү хувьд нь байх шүү” гэж хэлсэн юм. Тэр чинь арваад мянган хүн гэсэн үг шүү дээ.

Би ч ангайлаа. Тэгээд тэднээс хэдийг нь арвал руу дагуулсныг асуутал, тэрбээр: “Хэдэн зуу байх” гэсэнээ: “Саяхан нэг Куб хүнийг Эзэн дээр авчирч, хорт хавдраасаа эдгэрэхийн төлөө залбирч өгсөн” гэж хэлсэн юм.

Майк мөн маш олон үйлчлэлийн санхүүгийн тайлан тооцоог гаргахад нь тусладаг. Манай үйлчлэл ч дөнгөж эхлэж байхдаа түүний компаниар үйлчлүүлдэг байлаа. Майк миний амьдралын дуудлагыг хараад, олон жилийн турш миний татварын буцаан олголтыг маань ямар ч үнэ төлбөргүй хийж өгдөг байсан юм. Майк ийм маягаар олон хүнд нөлөөлсөн.

Нэг удаа бид хоёр нилээд удаан ярилцсан юм. Тэгэхэд Майк надад өөрийнх нь амьдралд мартахын аргагүй нөлөө үзүүлсэн нэгэн цэвэрлэгчийн тухай ярьж билээ. Би саяхан утсаар тэр хүнийх нь тухай Майкаас асуутал, Майк асгартал уйлсаар ингэж ярьсан юм:

“Жон, миний садангийн 9 эгчийн зургаа нь галзуугийн эмнэлэгт нас эцэслэсэн. Ээж маань ч адил. Хоёр өвөө маань хоёулаа буудуулж амиа алдсан. Миний төрсөн гэр бүл үнэхээр дампуурсан. Би ч ялгаагүй тэгэх л байсан.

Гэхдээ ээж маань намайг тэжээж дийлэхгүй байсан учраас, өөр айлын халамжинд өгсөн юм. Би тэнд арваад жил амьдарсан. Гэрийн эзэн нь нутгийнхаа цаасны үйлдвэрт цэвэрлэгч хийдэг Чарли гэдэг хүн байсан. Гэхдээ түүний Есүст бүрэн зориулагдсан, шударга зан, хүмүүсийг хайрлах сэтгэл нь миний амьдрал дээрх хараалыг тасласан юм. Тэр намайг долоо хоног бүр чуулганд дагуулж яваад, Бурханы арга замын тухай зааж өгдөг байсан. Түүний нөлөөгөөр л би өнөөдөр өдий зэрэгтэй яваа. Миний охин нэгэн удаа “Миний мэдэхгүй хамгийн аугаа цэвэрлэгч” нэртэй зохион бичлэг бичсэн. Чарлигийн тухай шүү дээ!”

Та Чарлигийн тухай энэ номоос өөр газраас уншихгүй байх. Гэхдээ түүний нөлөөгөөр Майк тэр хэдэн мянган хүнд төдийгүй, надад ч нөлөөлсөн юм. Тиймээс миний үйлчилсэн сая сая хүнд ч Чарли шууд бус замаар нөлөөлсөн билээ. Минагаа үржүүлсэн тэр цэвэрлэгч нэг л өдөр аугаа шагнал хүлээж авах болно.

Үлдээх өв

Саяхан манай нэг ажилтан надад Макс Жюкс гэдэг атеист хүн, Жонатан Эдвардс гэдэг бурханлаг хүний бодитой түүхийг уншиж өгсөн юм.

Макс Жюкс гэдэг атеист хүн Бурханд хайргүй амьдарчээ. Тэрбээр Бурханд хайргүй хүүхэнтэй гэрлэсэн бөгөөд түүний удмаас 310 гуйлгачин, 150 гэмт хэрэгтэн, 7 алуурчин, 100 архичин гарч, эмэгтэйчүүдийнх нь талаас илүү хувь нь янхан болжээ. Түүний удмын 540 хүн улсад сая хоёр зуун тавин мянган долларын хохирол учруулжээ.

Гэхдээ Эзэний сайн нь ямар ч мууг давдаг учраас Түүнийг магтму! Бурханы аугаа хүн Жонатан Эдвардс Макс Жюкстэй нэгэн үед аж төрж байсан бөгөөд Бурханд хайртай бүсгүйтэй гэрлэжээ. Жонатан Эдвардсын удмын 1394 хүний амьдралыг судлаж үзтэл - тэдний 13 нь коллежийн ерөнхийлөгч, 65 нь профессор, Америкийн 3 сенатч, 30 шүүгч, 100 хуульч, 60 физикч, 75 цэргийн цолтон, 100 номлогч/илгээлтийн эзэн, 60 алдартай зохиолч, нэг Америкийн дэд ерөнхийлөгч, 80 янз бүрийн салбарын нийгмийн албан тушаалтан, 295 дээд боловсролтон гарсны дунд мужийн захирагч, хилийн чанадад суух элчин байжээ. Түүний удам угсаа улсдаа нэг ч төгрөгийн гарз хохирол учруулаагүй байна.¹

Энэ бол минагаа үржүүлсэн өөр нэгэн мундаг жишээ юм. Чарли, Майк, Жонатан Эдвардс нар үй олон хүний амьдралыг өөрчилжээ. Тэд аугаа нөлөө үлдээсэн. Гэтэл энэ нь тэдний олон нийтийн төлөөх үйлчлэлээрээ биш, хувь хүнийхээ хувьд л авчирсан нөлөө шүү дээ.

Энэ бол хүн бүрт өгсөн Бурханы завшаан билээ. Замын цагдаатай, чуулганыхаа пастортай, хүүхдүүдтэй харилцаж байгаа байдал, санхүүгээ авч явж байгаа байдал, хэл яриа зэрэг чинь

таны эргэн тойронд байгаа хүмүүст нөлөөлдөг. Та барилгачин байх уу эсвэл бүдрүүлэх чулуу байх уу?

“Тийнхүү бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно. Иймд цаашид бид бие биенээ шүүхээ больё. Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлгийн чулуу эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтүн ... Тиймд амар тайвныг тогтоодог болон бие биенээ босгон байгуулдаг зүйлсийг мөшгөцгөөе.”
(Ром 14:12-13, 19)

Паул энэ үгээ Бурханы Шүүх сэнтийтэй шууд холбожээ. Бидний амьдралдаа уулзаж учирсан хүн бүртээ үзүүлсэн нөлөө маань Сэнтийн өмнө шалгагдана гэдгийг цаг үргэлж санан хичээгээрэй. Ингэвэл бид амиа бодоод л суугаад байлгүй, ялахын төлөө зүтгэнэ.

Арван есдүгээр зуунд аж төрж байсан Ребекка Рүтер Спрингер гэдэг эмэгтэй өөд болохоосоо өмнө хэд хэдэн удаа тэнгэрт айлчилж үзсэн хүн юм. Тэрбээр буцаж ирээд “Тэнгэрийн хаалга дотор” гэдэг сонгодог номоо бичсэн бөгөөд номдоо тэнгэрт Эзэнтэй маш дотно байсан нөхрийнхөө ахтай зөндөө удаан уулзаж ярилцсан тухайгаа бичсэн байдаг. Тэрбээр ийнхүү бичжээ:

“Дэлхий дээр амьдрах хугацаандаа өдөр өдрөөр өнө мөнхийн амьдралаа барьж байгуулж байгаагаа ухаардаг бол, хүн бидний амьдрал хичнээн өөр байх бол! Эелдэг үг бүр, өгөөмөр бодол бүр, амиа хичээгээгүй үйлс бүр нь айсуу амьдрал дахь өнө мөнхийн гоо үзэсгэлэнгийн багана болдог ажээ.”²²

Бусдыг Есүс рүү дагуулах

Хүнийг Есүстэй танилцуулах нь түүний амьдралд авчрах хамгийн том нөлөө юм. Мөнхийн шүүхийг ухаарсан хүн таньдаг мэддэг бүх хүндээ авралын тухай хэлэх л болно. “Мэргэн хүн бусдыг өөртөө татах.” (Сургаалт үгс 11:30) Энэ нь Бурхан хүмүүсийн загасчин учраас, тэднийг цуглуулж, өнө мөнхөд хүлээж авдаг гэсэн үг юм.

Би шинэхэн итгэгч байхдаа уулзаж учирсан хүн бүртээ Сайн мэдээ ярихгүй л бол, байж сууж чаддаггүй байлаа. Харин дараа нь хэзээ, хэнтэй, юу ярих тал дээр Ариун Сүнсний удирдамжийг

сонсож сурсан юм. Тэгээд Есүс ч гагцхүү Аавынхаа айлдсныг л хийдэг байсныг ухаарч билээ. Бурхантай алхах үед намайг цөхрөлд хүргэж, хүмүүсийг зугтахад хүргэдэг дарамт биш, харин чөлөөтэй урсгал мэдрэгддэг.

Гэхдээ мэдээж бид энэ дэлхийгээс яван явтлаа бусдыг мөнхийн амьдрал руу дагуулахын төлөө санаа тавьсаар байх ёстой. Энэ хүслийг Бурханы хайр л төрүүлдэг. Нэг хүн аврагдахад тэнгэрэлч нар ч, Бурхан ч ер бусаар баярлан хөөрдөг. Бусдыг авралд хөтлөсөн үйлс маань ч шагналтай. Есүс: “Хураагч хөлсөө хүртэж, мөнх амийн үрийг цуглуулж байна. Тийнхүү тариачин тариа хураагчийн хамт баярлах болно” (Иохан 4:36) гэсэн.

Би гэргийгээ анхныхаа болзоон дээр Эзэн дээр авчирсан хувьтай хүн. Есүст итгэснийхээ дараа би Бурхан намайг гэрлэх хүнтэй минь учруулахаас нааш болзохгүй гэж шийдсэн юм. Бурхан Еваг Адам дээр авчирсан юм чинь над дээр ч бас авчирна гэдэгт итгэсэн.

Би Христэд итгэхээсээ өмнө олон охинтой үерхэж байлаа. Итгэснийхээ дараа ч хэд хэдэн итгэгч охинтой үерхэх гэж үзсэн ч, энэ маань Эзэнийг дагахад маань саад болоод байх шиг санагдсан юм. Тэгээд харилцаагаа таслахад сэтгэл эмзэглэж, бөөн зовлон болно. Тэгээд энэ нь тийм сайн зүйл биш гэдгийг ухаараад, цаашид охинтой болзохоосоо өмнө заавал Бурханаас асууж байж болно гэж шийдсэн юм.

Тэр үед гэргий маань жинхэнэ доргио охин байлаа. Нэг залуу түүнийг кампусынхаа хамгийн галзуу охин гэж билээ. Хамгийн галзуу нь ч юу юм - гэхдээ л олны үг ортой гэдэг. Лизатай үерхэхээсээ өмнө би хэн нэгний талаар Эзэнээс асуух тоолонд Эзэн зөвшөөрөөгүй учраас, жил хагас ямар ч охинтой үерхээгүй байлаа. Гэтэл Ариун Сүнс намайг удахгүй болох Библи судлалын зугаалгад Лизаг урь хэмээн ятгаад байх шиг санагдав. Лиза ч зөвшөөрлөө.

Зугаалгын дараа Лиза бид хоёр кампусаар зугаалж, би түүнд шөнийн 01 цаг 30 хүртэл Сайн мэдээ ярьж өгсөн юм. Лиза миний яриаг таслаад: “Би аврагдмаар байна” гэлээ. Төдөлгүй Бурхан Лиза бид хоёрыг гэрлүүлэхийг хүсч байгааг бид мэдсэн юм. Энэ миний амьдралын хамгийн оновчтой шийдвэр байсныг би үнэн голоосоо хэлнэ. Лиза байгаагүй бол, би өдий зэрэгт хүрэхгүй байсан.

Лиза маань үйлчлэлээрээ сая сая хүнд нөлөөлдөг. Тэр мундаг зохиолч, шударга ёсны төлөөх өмгөөлөгч, даян дэлхийн илтгэгч. Гэтэл хэрэв би түүнд Сайн мэдээ яриагүй байсан бол яах уу?

Түүнийг шоолох байх гэж айснаасаа болоод Есүсийн тухай ярилгүй өнгөрсөн бол яах уу? Бурхан Лиза руу өөр хүнийг явуулах байсан гэдэгт би итгэлтэй байна. Би Бурханы сонгосон шилдэг гэргийгээ алдаж, түүний сая сая хүнд хүрсэн үйлчлэлийн хэсэг болж чадахгүй байж. Бурхан минь Таны бэлэгт баярлалаа!

Үр үрждэг. Гэхдээ үр анхандаа ямар ч хэрэггүй, өчүүхэн харагддаг. Бид Ариун Сүнсний чиглүүлэг Үгд байдаг л зүйл шиг тоомжиргүй хандаж хэрхэвч болохгүй. Надад ач холбогдолгүй харагдавч, Бурханы хий гэсэн зүйлс л амьдралд маань хамгийн их үржил авчрах нь олонтаа. Бурхан таныг үржээсэй гэж хүсдэг. Бурхан таны үржлийг ч шагнаана.

Сүүлийн ятгалга

Энэ бүхэн үнэхээр ноцтой асуудал ажээ. Бид газар дээрх богино амьдралдаа хөнгөн хуумгай хандаж болохгүй. Бид Бурханы төлөвлөгөөнд дуулгавартай байх эсэхээс хүмүүсийн мөнхийн хувь тавилан шийдэгдэнэ. Хүн бүр аврагдаж, Есүстэй адил болох нь Бурханы хүсэл. Тэр хэнийг ч алдахыг хүсдэггүй.

Египетээс чөлөөлөгдсөн насанд хүрсэн Израильчууд тэр чигээрээ цөлд үхсэн. Тэдэнд тухайн үеийн хамгийн мундаг удирдагч байсан ч, тэд бүтэлгүйтсэн. Бидэнд ч мундаг удирдагч нар байдаг. Гэхдээ Мастер Барилгачныхаа төлөвлөгөөг биелүүлэх эсэх нь биднээс л шалтгаалах асуудал. Есүс: “Хаанчлалын энэхүү сайнмэдээ дэлхий даяар тунхаглагдаж, бүх үндэстэнд гэрчлэл болно. Тэгэхэд л төгсгөл ирнэ” (Матай 24:14) гэсэн. Тиймээс даалгавраа бүү хөсөрдүүл! Энэ үе болж, Есүс бараг ирчихээд байна! Бид хувь тавилангаа биелүүлэхгүй бол, Бурхан өргөө гэрээ гүйцээж барихын тулд яг л Иошуаг гаргаж ирсэн шигээ, цоо шинэ үеийнхэнийг гаргаж ирнэ. Учир нь Бурхан өргөө гэрээ дүүргэхээ хэзээний мэдэгдсэн буюу.

Бид Бурханы даалгасан хувийг үржүүлснээрээ Бурханы төлөвлөгөөн доторх өөрийнхөө хувийг хийнэ. Бүү урам алд. Өөрийнхөө хувийг өчүүхэн гэж бүү гол. Халуун сэтгэлээ бүү алд. Шинэ гэрээнд маш тодорхой харуулсан, энэ номын гол сэдэв болох тэнгэрийн хараагаа бүү алд. Танд энэ үеийнхэн найдаад зогсохгүй, танаас Есүсийн тухай сонсохоор хүлээж, таны урмын

үг хүчээр дутаж явна. Таныг мөнхийн хувь тавилан тосч байна. Гэхдээ үүнд гагцхүү Бурханы нигүүлслээр л хүрнэ. Бурхан итгэмжтэй Нэгэн!


Би танд хаанчлалын хамтран зүтгэгчийнхээ хувьд хэлж байна. Дуудлагаа биелүүлж, сонголтоо баталгаажуул. Эцсээ хүртэл гүйсээр бай. Та өнөөдрөөс хэдэн арван сая жилийн дараа эргэж хараад, хийсэн зүйлдээ баясна. Бурханы хүсэлд хэт захирагдана гэж байдаггүй юм. Тиймээс ялахын төлөө гүй!

Эцэст нь таныг ариун хүмүүсийн төлөө залбирсан Паулын чин сэтгэлийн залбирлаар зоригжуулъя:

“Бид та нарын төлөө адил, Эзэн та нарыг бие биенээ болон бүгдийг гэсэн хайранд өсгөн бялхуулах болтугай. Ингэснээр Эзэн Есүс маань бүх ариун хүнтэйгээ хамт ирэхэд бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө Тэр та нарын зүрхийг ариун чанар дор гэм зэмгүй гэж батална. [Амен]”
(1Тесалоник 3:12-13)



Бичээс дээрх мөнхийн шагналын тухай ишлэлүүд нь энэ номд багтахын аргагүй олон юм. Тиймээс мөнхийн шүүх, шагналын гол хэсгийг илчилсэн жагсаалтыг
DrivenByEternity.com/EternalRewards хаягаар орж үзнэ үү.



ТАВДУГААР ХЭСЭГ: БҮЛЭГ 13-14

1. Таны амьдралд (эсвэл амьдралын чинь төвд) нэг их ач холбогдолгүй санагддаг тал бий юу? Үүнийгээ тэнгэрийн үзэл бодлоор харбал? Таны тоодоггүй тэр өчүүхэн тал чинь яагаад Бурханд чухал байж болох вэ?
2. Дийлэнх хүн өрөөлтэй өрсөлдөх юмуу харьцуулдаг. Бид бусадтай өрсөлдөхөө болих үед Бурханы хаанчлалд хандах хандлага маань яаж өөрчлөгдөх бол?
3. Таны амьдралд аль хэр үржил явагдаж байна? Цаг, залбирал, бэлэг, эх үүсвэрээ яаж илүү сайн зохицуулдаг болох вэ?
4. Номынхоо эхэнд бид “Христийн Шүүх сэнтийн өмнө итгэл дүүрэн зогсох боломжтой” гэж ярьсан. Үүнийг 1Иохан 4:17 дээр хэлсэн. Та одоо юу хийхээ мэддэг болсон болохоор, дээрх ишлэлийн учрыг тайлбарлаж чадах уу?
5. Яаж одооноос мөнхийн нөлөөтэй амьдрал байгуулж эхлэх вэ?

ХАВСРАЛТ: ЯАЖ АВРАГДАХ ВЭ?

*Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан
Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл,
аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч,
амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.*

— Ром 10:9-10

Бурхан танд мөнхийн амжилтыг хүсдэг. Тэр танд зориулж гаргасан төлөвлөгөөндөө баясдаг. Гэхдээ хүнд хувь тавиландаа хүрэх цорын ганц зам бий: Бурханы Хүү Есүс Христийн авралыг хүлээж авснаар.

Есүсийн үхэл, амилалтаар Бурхан таныг хаанчлалдаа оруулж, хайртай хүү, охиноо болгох замыг гаргаж өгчээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн баялаг амьдралыг бэлдэж өгсөн. Та авралыг юу ч хийж, ямар ч гавъяагаар олохгүй. Аврал бол Бурханы бэлэг юм.

Тэгэхээр, энэ үнэт бэлэгийг хүлээж авахын тулд хамгийн түрүүнд Бүтээгчээсээ тусгаар, дур мэдэн амьдарснаа хүлээн зөвшөөр. (Учир нь таны хийсэн бүх нүглийн үндэс нь энэ юм) Гэмшил нь авралын амин чухал хэсэг. Үүнийг Петр Үйлс номд таван мянган хүн аврагдсан өдөр тодорхой хэлсэн: “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний оршихуйгаас ирнэ.” (Үйлс 3:19) Хүн бүр нүглийн боол болж төрснийг Бичээс хэлдэг. Энэ боолчлол нь санаатайгаар дуулгаваргүй загнасан Адамын нүглээс болсон юм. Харин гэмшлээр хүн өөрийнхөө болон худалчдын эцэг болох

Сатаны эрх мэдлээс салж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэн Есүс Христийн эрх мэдэлд захирагддаг.

Та амьдралаа Есүсийн эрх мэдэлд өгөх ёстой. Есүсийг Эзэнээ болгох гэдэг нь амьдралаа (буюу сүнс, сэтгэл, биеэ), байгаа бүхнээ, эд эс бүрээ Түүний мэдэлд өгнө гэсэн үг юм. Тэр таны амьдралыг бүрэн төгс мэднэ гэсэн үг. Ингэмэгц Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж, хаанчлалынхаа гэрэл, алдарт гаргана. Та үхлээс амь руу шилжиж, Түүний хүүхэд болно!

Та Есүсээр дамжин аврагдахыг хүсбэл, дараах залбирлыг хэлнэ үү:

Тэнгэрийн Бурхан минь, би Таны зөвт байдлын жишигт хүрэшгүй гэмтэй хүн. Би хийсэн нүглийнхээ төлөө мөнхөд шийтгүүлэх ялтай. Гэхдээ Та намайг энэ хэвээр минь орхиогүйд баярлалаа. Учир нь Та Өөрийнхөө цорын ганц Хүү Есүс Христийг миний төлөө үхүүлэхээр энэ дэлхий рүү илгээн, онгон Мариагаас төрүүлсэн гэдэгт би итгэж байна. Есүс үхсэн боловч, гурав дахь өдрөө үхлээс амилуулагдаж, одоо Таны баруун гарт миний Эзэн бөгөөд Аврагч болон сууж байгаа гэдэгт би итгэж байна. Тиймээс өнөөдөр би Есүсийн Эзэний эрх мэдэлд амьдралаа бүхлээр нь өргөе.

Есүс ээ, одоо Та миний Эзэн, Аврагч, Хаан боллоо. Ариун Сүнсээрээ амьдралд маань ирж, намайг Бурханы хүүхэд болгон өөрчлөөч. Өнөөдрөөс би урьд нь холбоотой байсан бүх харанхуйн явдлаасаа салж, өөрийнхөө төлөө биш, харин намайг амьтай болгох гэж амиа өгсөн Таны төлөө амьдрах болно.

Баярлалаа Эзэн минь. Одоо миний амьдрал бүхлээрээ Таны гарт байгаа. Та намайг хэзээ ч ичгүүрт оруулахгүй гэж амласан.

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Энэ баярт мэдээгээ бусад итгэгч нартай хуваалцаарай. Тэгээд Библи суурьтай нутгийн чуулганд явж, таныг шинэ итгэлд чинь дэмжиж туслах итгэгч хүмүүстэй холбогдоорой.

Та хамгийн гайхамшигтай аялалд хөл тавилаа. Өдөр бүр Бурхантай тогтоох харилцаа, илчлэл, нигүүлслээр өсөөрэй!

НОМЫН ЗҮҮЛТ

Бүлэг 1

1. *Webster's Encyclopedic Unabridged Dictionary of the English Language* (New York: Gramercy, 1993), s.v. "eternity."
2. *The American Heritage Dictionary of the English Language*, Fourth Edition (New York: Houghton Mifflin, 2000), s.v. "eternity." Eternity: *the state or quality of being eternal*; eternal: *existing outside of time; hence: the state of existing outside of time.*
3. Merrill F. Unger, *The New Unger's Bible Dictionary*, ed. R. K. Harrison (Chicago: Moody, 1988), BibleSoft PCStudyBible Version 4.
4. Robert Young, *Young's Literal Translation of the Holy Bible* (Grand Rapids, MI: Baker, 1986).

Бүлэг 3

1. Илчлэл 2:23
2. Лук 16:2
3. Еврей 4:13
4. Иохан 8:24
5. Үйлс 4:12
6. Иаков 2:10
7. Ефес 2:8–9 (Бурханыг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
8. Номлогчийн үгс 9:5–6
9. Сургаалт үгс 24:20
10. Сургаалт үгс 13:13
11. Магай 22:13–14
12. Илчлэл 22:14–15
13. Тит 1:16 (Бурханы нэрийг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
14. Лук 6:46
15. Магай 7:21–23 TLB (Диваажинг Аффабел гэдэг нэрээр оруулав)
16. Иаков 2:14, 17–20 (Бурханыг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
17. Езекиел 18:25, 27–28
18. Дуулал 50:16–21
19. Магай 22:13

20. Сургаалт үгс 30:12
21. Матай 24:12–13
22. 2 Петр 2:20–21 (Есүс Христийг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
23. Езекиел 18:24–27
24. Матай 24:13
25. Илчлэл 3:5
26. Сургаалт үгс 21:16
27. Матай 22:13–14
28. Еврей 10:26–27, 30–31 (Бурханыг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
29. Иаков 3:1 NLT (Чуулганыг сургууль гэж өгүүлэв)
30. Марк 9:42
31. Лук 12:45–48
32. Иуда 13
33. Матай 22:13–14
34. Илчлэл 16:5–7

Бүлэг 4

1. *The American Heritage Dictionary*, Third Edition (New York: Houghton Mifflin, 1992), s.v. “elementary.”

Бүлэг 5

1. Movie Reviews: *The Matrix*. <http://www.pluggedinonline.com/movies/movies/a0000128.cfm>. Accessed September 5, 2005.
2. Alexander Roberts and James Donaldson, eds., *The AnteNicene Fathers*. “Polycarp: Letter to the Philippians,” 10 vols. (Grand Rapids, MI: Wm. Eerdmans Publishing Company, 1985), ch. 1.
3. Alexander Roberts and James Donaldson, eds., *The AnteNicene Fathers*. “Polycarp: Letter to the Philippians,” 10 vols. (Grand Rapids, MI: Wm. Eerdmans Publishing Company, 1985), ch. 2.
4. Alexander Roberts and James Donaldson, eds., *The AnteNicene Fathers*. “Clement of Rome Letter to the Corinthians,” 10 vols. (Grand Rapids, MI: Wm. Eerdmans Publishing Company, 1985), ch. 32.
5. Alexander Roberts and James Donaldson, eds., *The AnteNicene Fathers*. “Clement of Rome Letter to the Corinthians,” 10 vols. (Grand Rapids, MI: Wm. Eerdmans Publishing Company, 1985), ch. 34.
6. David W. Bercot, ed., *A Dictionary of Early Christian Beliefs* (Hendrickson Publishers, Inc., 1998), 586.

7. Ibid.
8. Josh McDowell, *Evidence That Demands a Verdict* (San Bernardino, CA: Here's Life Publishers, 1972), 50–52.

Бүлэг 6

1. Kenneth E. Hagin, *I Believe in Visions* (Tulsa, OK: Faith Library Publications, 1984), 68–71 (second edition; tenth printing).
2. From the UBS Handbook Series. © 1961–1997 by United Bible Societies.
3. David W. Bercot, ed. *A Dictionary of Early Christian Beliefs* (Hendrickson Publishers, Inc., 1998).
4. Ibid.
5. Ibid.
6. Ibid.
7. Ibid.
8. *The American Heritage Dictionary of the English Language*, Fourth Edition. Houghton Mifflin Co., 2004 (software edition).

Бүлэг 8

1. Лук 14:12–14
2. Марк 12:43–44
3. Колоссай 1:28 (Христийг Жэйлин гэсэн нэрээр өгүүлэв)
4. Езекиел 13:10–11
5. 1 Коринт 3:12–15
6. 1 Тесалоник 2:19–20
7. Матай 12:36–37
8. Сургаалт үгс 12:14
9. Иеремиа 11:20
10. Иеремиа 17:10 (Эзэний нэрийг Жэйлин нэрээр өгүүлэв)
11. Матай 25:34–40
12. 2 Коринт 9:10
13. 2 Коринт 9:9
14. Лук 14:11
15. Лук 19:17
16. Илчлэл 2:26–27
17. Матай 25:21

Бүлэг 9

1. Энд өгүүлж буй хүмүүсийн жинхэнэ нэрийг нууцлав

Бүлэг 10

1. James Strong, *Strong's Exhaustive Concordance of the Bible* (Peabody, MA: Hendrickson Publishers, 1988).
2. *Biblesoft New Exhaustive Strong's Concordance*, (Seattle, WA: Biblesoft, Inc., ver. 4, 1994).

Бүлэг 12

1. This section was adapted from content that first appeared in my book *Relentless: The Power You Need to Never Give Up* (Colorado Springs, CO: Waterbrook Press, 2011), 217–219.

Бүлэг 13

1. *Webster's Encyclopedic Unabridged Dictionary of the English Language* (New York: Gramercy, 1993), s.v. “envy.”
2. *The American Heritage Dictionary of the English Language*, Fourth Edition. Houghton Mifflin Co., 2004 (software edition).


Бүлэг 14

1. Leonard Ravenhill, *Sodom Had No Bible* (Minneapolis, MN: Bethany House, 1971), 155.
2. Rebecca Ruter Springer, *My Dream of Heaven: A Nineteenth Century Spiritual Classic: Originally Known As Intra Muros* (Cincinnati, OH: Harrison House), 21.



ЖОН БА ЛИЗА БИВЭРИЙН АЛБАН ЁСНЫ МОНГОЛ ФЭЙСБҮҮК ХУУДАСТ ТАВТАЙ МОРИЛНО УУ!

<https://www.facebook.com/JohnBevereMongolia/>

Та дээрх хуудсанд айлчилж ЛАЙК  дарснаар энэхүү албан ёсны хуудсанд тавигдах сүүлийн үеийн бүх мэдээллийг цаг алдалгүй хүлээн авах боломжтой болох юм.

МӨН

Монгол хэл дээрх Жон ба Лиза Бивэрийн цахим ном, видео, аудио хичээл болон сонсдог номыг үнэ төлбөргүйгээр татаж авах боломжтой. Үүний тулд та дараах цахим хаягаар ороод, Монгол хэлээ сонгоход л хангалтай! Таны итгэлийн амьдралд хүч, урам, ухаан өгөх хүчирхэг эх сурвалжуудтайгаа холбоорой!
Энэ бол танд өгч буй бэлэг юм шүү!



CloudLibrary.org



Мессенжер Интернэйшнэл нь Бурханы өөрчлөгч хүчийг хувь хүн, гэр бүл, чуулган, үндэстэнд ухааруулж, бодитоор харахад нь туслах зорилготой байгууллага болно.

Энэ ухаарал нь хүчирхэгжсэн амьдрал, өөрчлөгдсөн нийгэм, дэлхий дээрх шударга бус зүйлст хариу барих эрч хүчтэй үйлсийг дагуулдаг.

Cloud Library нь даян дэлхийн пастор, удирдагч нарт зориулагдсан, төрөлх хэлээрээ танилцаж болох онлайн дижитал сургалтын сан юм.

CloudLibrary.org хаягаар орж, Жон, Лиза Бивэрийн 80 гаруй хэл дээрх сургалтын материалтай танилцаарай!

Цахим ном, видео, аудио, сургаал, сонсдог ном, Библи, сонсдог жүжиг гэх мэт...

Илүү ихийг эндээс:



**CLOUD
LIBRARY**





Эргэлзээ харьцуулалтын энэ эрин цагт өөрийгөө болон зорилгоо олж мэдэх

Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.


Шилдэг борлуулалттай номын зохиолч Лиза Бивэр “Өрсөлдөгчгүй” номдоо Бурханы хайр нь энэ бүх хязгаарыг хэрхэн тасар татдаг талаар хуваалцжээ. Та хүнээс эрэн хайгаад байдаг тодорхой, дотно харилцаагаа Бүтээгчтэйгээ тогтообол, өөрийгөө хэн болохыг жинхэнээсээ мэдэж, бусадтай өрсөлдөн барьцахаа болино. Лизагийн Библийн ул суурьтай, эш үзүүлэлт, хошин мэдрэмж, халуун сэтгэлтэй үгсээр танд ухаарал ирэг.

Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!



CloudLibrary.org хаягаас үзнэ үү!

АФФАБЕЛ – СОНСДОГ ЖҮЖИГ



Аффабел нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашир бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Аугаа их хаан Жэйлин, харанхуйн хар санаат эзэн Дагон болон Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй болон Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за.

Аффабел сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

CloudLibrary.org -оос сонсох боломжтой



**CLOUD
LIBRARY**

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТ ЛӨГ ДӨХҮЙ ЦОГЦ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ

Таны уншиж байгаа ном нь Жон Бивэрийн бичсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” цогц сургалтын материалын нэг хэсэг юм. Номоо уншиж, дагалдах DVD бүхий сургалтын материал, CloudLibrary.org хаягаас татаж авч хэрэглэхэд зориулагдсан сургалтын материалыг хэрэглэснээр та энэхүү амьдрал өөрчлөгч эрч хүчтэй сургаалын хэсэг бүрийг өөрийн болгож чадна. Зүй зохистой эзэмших аваас, энэ нь таны Христэд итгэх амьдралд нөлөөлж, Бурханы төлөө илүү ихийг хийж чадвартай болгоно.

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй цогц сургалтын материалд дараах зүйлс багтсан болно:

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй ном

- Цаасан хэвлэл бүхий ном
- PDF цахим ном

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй DVD

- Зөвхөн компьютерт уншигдах DVD дотор сургалтын материалыг тэр чигээр нь дижитал хэлбэрээр хэвлэсэн.

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй сонсдог ном:

- “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” нь Монгол хэл дээр сонсож болох 14 бүлэг бүхий MP3 форматтай сонсдог ном юм.

Өнө мөнхөөр хөтлөгдөхүй видео хичээл

- MP4 формат бүхий 6 бүлэг видео хичээл


Аффабел сонсдог жүжиг

- MP3 форматтай, сонсдог жүжиг

Нэмэлт материал:

- DVD дотор “Өрсөлдөгчгүй” ном болон Жон ба Лиза Бивэрийн бусад цахим ном бий.

ЭНЭ БҮХ МАТЕРИАЛЫГ ТАНД БЭЛЭГЛЭЖ БАЙНА!



Энэ бүх цогц сургалтын материал нь танд барих бидний бэлэг шүү! Энэхүү DVD дээрх бүх материалыг чөлөөтэй хувилж, тарааж, найзууддаа имэйлээр илгээж, хуулж, Word документ дээр копи-паст хийж, сургаалыг нь чуулгандаа илгээж, бусдын хэрэглээнд зориулж интернет дээр тавьж болно. Бурханы үгийн сайн сургаал, хүчтэй итгэлийн амьдрал дутагдаж байгаа газар бүрт хүргэж, тараагаарай.

“Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” цогц сургалтын материалын тухай нэмэлт тайлбар:

- DVD дээрх файл нь ахуйн хэрэглээнд зориулагдсан видео тоглуулагч дээр уншигдахгүй, гагцхүү компьютер, дижитал тоглуулагч дээр л уншигдана.
- MP4 видео файл нь таблет, компьютер дээр уншигдана.
- MP3 аудио файл нь аудио медиа тоглуулагч, ухаалаг утас, компьютер дээр уншигдана.
- PDF дижитал файл нь таблет, компьютер дээр уншигдана. Үүнийг хялбархан уншиж, хэвлэж, хувилж болно.

ЭНЭ МОНХООР ХОТ ЛОГДОХҮЙ СУРГАЛТЫН ДИСК



Бусад видеог дараах
хуудсаас татах, үзэх боломжтой:



Зөвхөн
компьютерт
хийж хэрэглэнэ үү.

ЖОН БИВЭР



Жон Бивэрийн энэхүү болоод бусад цогц сургалтын материал нь Мессенжер Интернэйшнэлийн үнэ төлбөргүй видео суваг дээр болон доорх цахим хуудас дээр бий.



CloudLibrary.org

Монгол болон бусад хэл дээрх материалыг
youtube.com, youku.com тэргүүтэй бүх олон нийтийн
медиа хуудсаас үзэж болно.

ӨНӨ МӨНХЛӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Та нэгэн туршилтад оролцжээ. Тэгээд дараагийн 24 цаг хэрхэн амьдарснаас чинь таны үлдсэн бүх амьдрал шийдэгдэх аж. Хийх ажил, амьдрах газар, орон гэр зэрэг чинь тэрхүү ганц өдөр хэрхэн амьдарснаар чинь шийдэгдэх гэнэ. Тэгвэл та тэр 24 цагаа яаж амьдрах вэ? Байдгаараа хичээх үү эвсэл бахь байдгаараа л үлдэх үү?

Энэ нь хэт хөөргөдсөн мэт дүрслэл боловч, үнэндээ үнэний хувьтай юм. Учир нь өнөөдрийн сонголт чинь таны мөнхийн тавиланг шийднэ.

Жон Бивэр “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номдоо нэгэн нүд нээм түүхийг арвин их Бичээсээр дэмжин, хүний газрын амьдрал нь үнэндээ түүний мөнхийн амьдралыг бүтээж байдгийг зураглан харуулжээ.

Эцсийн амьсгаа тасрахад эхлэх мөнхийн амьдрал нь зүгээр нэг эцсийн буудал биш юм. Тиймээс дэндүү оройтох хүртлээ бүү хүлээ. Өнөөдөр ч, өнө мөнхөд ч үнэ цэнэтэй байх амьдралаар амьдар.

“ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ” СУРГАЛТЫН DVD ХАВСАРГАВ



Жон Бивер, Лиза Бивер нь Мессенжер Интернэйшнэл байгууллагын үүсгэн байгуулагч нар юм. Шилдэг борлуулалттай номын зохиолч тэрбээр номоороо Бурханы найраагүй үнэнийг халуун сэтгэлээр, зоригтой заадаг билээ. Газар газрын, үндэстэн үндэстний, боломжтой боломжгүй чуулган, удирдагч нарыг Бурханы үгээр хангах нь Жоны чин хүсэл. Өнөөгийн байдлаар Жоны материал 90 гаруй хэл дээр орчуулагдан, сая сая хувиар тараагдан, даян дэлхийн пастор, удирдагч нарын гарт очоод байна. Харин гэртээ бол Жон гэргийгээ гольф руу уруу татаж, дөрвөн хүү, бэр, ач нараа халамжилдаг жирийн л нөхөр, аав, өвөө хүн билээ.



Доорх цахим хуудаснаас бусад материалуудыг татаж аваарай:
www.CloudLibrary.org



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэ номыг зохиогч БЭЛЭГЛЭЖ байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Илүү илгйг-аргээс

